

2026 ОНЫ 06 ДУГААР САРЫН 04-НИЙ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ГАЗАР

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2026 оны 06 дугаар сарын 04-ний өдөр, Пүрэв гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1-2
Хуралдааны товч тэмдэглэл:	3-25
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	26-146
Өргөн мэдүүлсэн хуулийн төслийн талаар мэдээлэх	27
Хуулийн төсөл татан авах талаар танилцуулах	28
1.Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн П.Батчимэг нарын 9 гишүүн 2025.07.03-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	30-41; 115-118
2.“Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/	41-43; 118-119
3.“Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн Б.Пунсалмаа нарын 13 гишүүн 2026.05.07-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	43-60; 119-120
4.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2026.03.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	60-100; 120-126
5.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин нарын 6 гишүүн 2026.04.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	100-111; 126-127
6.Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг нарын 7 гишүүн 2026.05.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	111-115; 127-128
7.Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт	128-145

өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг нарын 19 гишүүн 2026.05.28-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

8.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн О.Амгаланбаатар нарын 17 гишүүн 2026.05.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

145-146

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы
06 дугаар сарын 04-ний өдөр /Пүрэв гараг/-ийн
нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 67 гишүүн хүрэлцэн ирж, 53.2 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 00 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: О.Алтангэрэл, Н.Батсүмбэрэл, Б.Бейсен, Х.Болормаа, Д.Бум-Очир, Г.Ганбаатар, М.Ганхүлэг, Г.Дамдинням, Х.Жангабыл, Ц.Идэрбат, Ц.Мөнхбат, Б.Найдалаа, Б.Пүрэвдорж, Ц.Сандаг-Очир, А.Ундраа, Д.Үүрийнтуяа, Да.Цогтбаатар, М.Энхцэцэг;

Чөлөөтэй: Ж.Баясгалан, Ц.Даваасүрэн, Б.Дэлгэрсайхан, М.Нарантуяа-Нара, О.Номинчимэг, Л.Оюун-Эрдэнэ, Н.Учрал;

Эмнэлгийн чөлөөтэй: Ж.Ганбаатар, Д.Энхтуяа;

Тасалсан: Д.Амарбаясгалан, Д.Пүрэвдаваа;

Хоцорсон: С.Амарсайхан-1 цаг 50 минут, Ч.Анар-14 минут, Т.Аубакир-05 минут, Х.Баасанжаргал-23 минут, Д.Батбаяр-18 минут, Б.Батцэцэг-1 цаг 16 минут, Ж.Бат-Эрдэнэ-37 минут, Ж.Баярмаа-09 минут, А.Ганбаатар-17 минут, Д.Ганбат-45 минут, П.Ганзориг-12 минут, Л.Гантөмөр-13 минут, Т.Доржханд-40 минут, Б.Жавхлан-10 минут, Б.Жаргалан-08 минут, Ж.Золжаргал-04 минут, М.Мандхай-06 минут, Т.Мөнхсайхан-3 цаг 01 минут, П.Мөнхтулга-15 минут, Ц.Мөнхтуяа-01 минут, Н.Номтойбаяр-08 минут, С.Одонтуяа-03 минут, Р.Сэддорж-12 минут, Г.Тэмүүлэн-44 минут, Г.Хосбаяр-26 минут, Д.Цогтбаатар-55 минут, Б.Чойжилсүрэн-3 цаг 01 минут, Б.Энхбаяр-2 цаг 03 минут, Ж.Энхбаяр-3 цаг 03 минут, Р.Эрдэнэбүрэн-07 минут.

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт Улсын Их Хурлын гишүүн М.Энхцэцэг нарын 76 гишүүнээс 2026 оны 05 дугаар сарын 27-ны өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг Төрийн байгуулалтын байнгын хорооны 2026 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн хуралдааны явцад Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.5-д заасны дагуу хуулийн төслийг хэлэлцэхийг хойшлуулсан тул нэгдсэн хуралдааны хэлэлцэх асуудлын дарааллаас хасагдсан тухай мэдэгдэв.

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт 06 дугаар сарын 04-нд төрсөн өдөр нь тохиосон Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүнд Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс баяр хүргэж, эрүүл энх, аз жаргал, сайн сайхныг хүсэн ерөөв.

Өргөн мэдүүлсэн хуулийн төслийн талаар мэдээлэх

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт Улсын Их Хурлын гишүүн П.Мөнхтулгаас 2026 оны 05 дугаар сарын 27-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Эдийн засгийн байнгын хороонд хуваарилсныг мэдээлэв.

Хуулийн төсөл татан авах талаар танилцуулах

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 12 дугаар сарын 18-ны өдөр өргөн мэдүүлсэн “Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2026-2028 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах, төрийн өмчийг хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг татан авах тухай Засгийн газраас ирүүлсэн албан бичгийг Улсын Их Хуралд ирүүлснийг уншиж танилцуулав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.3-т заасны дагуу хууль санаачлагч төслөө татан авсанд тооцлоо./10:07/

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт хэлэлцэх асуудалтай холбогдуулан нэгдсэн хуралдаанаар хэлэлцэхээр тогтсон асуудлыг хойшлуулах талаар Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгээс гаргасан горимын саналыг танилцуулав.

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт хэлэлцэх асуудалтай холбогдуулан хэлэлцэх асуудлын дарааллын долоодугаарт тусгагдсан Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг хойшлуулах Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн гаргасан горимын саналаар санал хураалт явуулав.

С.Бямбацогт: Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 44

Татгалзсан: 40

Бүгд: 84

52.4 хувийн саналаар горимын санал дэмжигдсэн тул дээрх асуудлыг хойшлуулав.

Нэг.Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн П.Батчимэг нарын 9 гишүүн 2025.07.03-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын ерөнхий прокурорын туслах прокурор, Зөрчлийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах газрын дарга Б.Эрхэмбаяр, Зам, тээврийн яамны Замын хөдөлгөөний аюулгүй байдал хариуцсан шинжээч Т.Эрхэмбаатар, мэргэжилтэн А.Энхболд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, зөвлөх Г.Алтанцэцэг, референт Б.Баярсайхан, Л.Хурцбилэг нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай Хууль зүйн байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг танилцуулав.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат, Ц.Туваан, П.Батчимэг, Г.Хосбаяр нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг, Зам, тээврийн яамны Замын хөдөлгөөний аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн А.Энхболд нар хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно.” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав./11:03/

Хоёр. “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын ерөнхий прокурорын туслах прокурор, Зөрчлийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах газрын дарга Б.Эрхэмбаяр, Зам, тээврийн яамны Замын хөдөлгөөний аюулгүй байдал хариуцсан шинжээч Т.Эрхэмбаатар, мэргэжилтэн А.Энхболд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, зөвлөх Г.Алтанцэцэг, референт Б.Баярсайхан, Л.Хурцбилэг нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг танилцуулав.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно.” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав./11:07/

Гурав.“Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн Б.Пунсалмаа нарын 13 гишүүн 2026.05.07-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Барилга, барилгын материалын бодлого зохицуулалтын газрын дарга Б.Мөнхтөр, “Зам, тээврийн хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Д.Оюунболд, мөн төрийн өмчит үйлдвэрийн газрын Бодлогын хэрэгжилт, зураг төслийн магадлал, стандарт, норм, нормативын хэлтсийн дарга Э.Балт, “Барилгын хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын Барилга байгууламжийн зураг төслийн магадлал зохион байгуулах хэлтсийн дарга Г.Мөнхболд, мөн төрийн өмчит үйлдвэрийн газрын Барилга байгууламж, техникийн захиалагчийн хяналтын хэлтсийн дарга Д.Батням, Ерөнхий инженер З.Энх-Оргил нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Ё.Энхсайхан, референт С.Тэгшжаргал нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай Төсвийн байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Р.Батболд танилцуулав.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулуун, С.Эрдэнэбат, Д.Рэгдэл, Ө.Шижир, Ц.Баатархүү, Р.Эрдэнэбүрэн нарын тавьсан асуултад хууль санаалагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Пунсалмаа, ажлын хэсгийн гишүүн, Улсын Их Хурлын гишүүн Б.Мөнхсоёл, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Барилга, барилгын материалын бодлого зохицуулалтын газрын дарга Б.Мөнхтөр, “Барилгын хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын Ерөнхий инженер З.Энх-Оргил, Төсвийн байнгын хорооны дарга Н.Наранбаатар, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал нар хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно.” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав./12:01/

Дөрөв.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2026.03.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд С.Амарсайхан, Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд Д.Мөнх-Эрдэнэ, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Г.Эрдэнэбулган, мөн газрын Нийтийн эрх зүйн хэлтсийн дарга Д.Энхтөр, ахлах шинжээч Ж.Амгалан, Улсын ерөнхий прокурорын газрын Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих хэлтсийн дарга, ахлах прокурор Ч.Мөнх-Эрдэнэ, Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн бодлогын

хэрэгжилтийн газрын Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдал хариуцсан ахлах шинжээч Ш.Энхтуяа, Цагдаагийн ерөнхий газрын Хар тамхитай тэмцэх албаны дарга Э.Товуудорж, мөн албаны тасгийн дарга Б.Эрхэсбаатар, Тагнуулын ерөнхий газрын Хэлтсийн дарга Т.Энхбат, Гаалийн ерөнхий газрын Хар тамхи, мөнгө угаахтай тэмцэх хэлтсийн дарга Г.Ганзориг, Хил хамгаалах ерөнхий газрын Хилийн боомтын газрын Шалган нэвтрүүлэх хэлтсийн дарга Э.Мөнхцог, Шүүх шинжилгээний ерөнхий газрын Байгалийн ухааны шинжилгээний хэлтсийн дарга Б.Ламчин, Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөний Сэтгэц-Нийгмийн сэргээн засах төвийн зохицуулагч Б.Түмэндэмбэрэл, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн Сэтгэц нийгмийн эрүүл мэнд, гадаад харилцаа, сургалтын албаны Мансуурлын асуудал хариуцсан мэргэжилтэн, эмч С.Байгальмаа, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын зохицуулах зөвлөлийн Ажлын албаны ахлах мэргэжилтэн У.Дэлгэрхишиг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, зөвлөх Г.Алтанцэцэг, референт Б.Баярсайхан нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Хууль зүй, дотоод хэргийн сайд С.Амарсайхан, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа нар танилцуулав.

Улсын Их Хурлын дэд дарга Ж.Бат-Эрдэнэ 12 цаг 10 минутаас 13 цаг 03 минутад хуралдааныг даргалав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Алтаншагай, Д.Энхтүвшин, Х.Ганхуяг, С.Цэнгүүн нарын тавьсан асуултад Хууль зүй, дотоод хэргийн сайд С.Амарсайхан, Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд Д.Мөнх-Эрдэнэ, Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн бодлогын хэрэгжилтийн газрын Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдал хариуцсан ахлах шинжээч Ш.Энхтуяа нар хариулж, тайлбар хийв.

Үдээс өмнөх хуралдаан 3 цаг 03 минут үргэлжилж, 13 цаг 03 минутад завсарлав.

Үдээс хойших хуралдаан 14 цаг 01 минутад Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг асуулт, хариултаар үргэлжлүүлэн хэлэлцэв.

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт 14 цаг 01 минутаас 17 цаг 43 минутад хуралдааныг даргалав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга, С.Одонтуяа, Д.Ганмаа, М.Мандхай, Л.Гантөмөр, А.Ганбаатар нарын тавьсан асуултад Хууль зүй, дотоод хэргийн сайд С.Амарсайхан, Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд Д.Мөнх-Эрдэнэ, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн Сэтгэц нийгмийн эрүүл мэнд, гадаад харилцаа,

сургалтын албаны Мансуурлын асуудал хариуцсан мэргэжилтэн, эмч С.Байгальмаа нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт, Улсын Их Хурлын гишүүн Д.Ганмаа, П.Сайнзориг, С.Одонтуяа нар үг хэлэв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно.” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав./15:22/

Тав.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин нарын 6 гишүүн 2026.04.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, **хэлэлцэх эсэх**/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан хуульч Б.Эрхбаяр, өмгөөлөгч Б.Батбаяр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, зөвлөх Г.Алтанцэцэг, референт Л.Хурцбилэг нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц, Х.Баасанжаргал нарын тавьсан асуултад хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин, хуульч Б.Эрхбаяр, өмгөөлөгч Б.Батбаяр нар хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно.” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав./15:53/

Зургаа.Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг нарын 7 гишүүн 2026.05.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, **хэлэлцэх эсэх**/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Л.Хурцбилэг нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Хууль зүйн

байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Тулга нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно.” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав./16:04/

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн П.Батчимэг нарын 9 гишүүн 2025.07.03-ны өдөр өргөн мэдүүлсэн/-ийн эцсийн хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын ерөнхий прокурорын туслах прокурор, Зөрчлийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах газрын дарга Б.Эрхэмбаяр, Зам, тээврийн яамны Замын хөдөлгөөний аюулгүй байдал хариуцсан шинжээч Т.Эрхэмбаатар, мэргэжилтэн А.Энхболд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, зөвлөх Г.Алтанцэцэг, референт Б.Баярсайхан, Л.Хурцбилэг нар байлцав.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар Хууль зүйн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн санал:

С.Бямбацогт: 1.Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 13¹ дүгээр зүйлийн 13¹.2.9 дэх заалтын “, цахилгаан дугуй, цахилгаан скүүтерийг зүй зохистой ашиглах хэрэглээний соёлыг эзэмшүүлэх” гэснийг, 13¹.2.5 дахь заалтын “оршуулгын газар,” гэснийг болон 13¹.2.3, 13¹.2.4, 13¹.2.6 дахь заалтыг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 57
Татгалзсан: 40
Бүгд: 97
58.8 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 59, 60, 61, 64 дэх хэсэг болон 63.2, 63.3, 63.4 дэх заалтыг хасаж, 63.5 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, дугаарыг “62” болгон өөрчлөх:

“62.Нийтийн хэрэгцээний мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгслийн үйлчилгээ үзүүлэгч хуулийн этгээд нь эрх бүхий этгээдээс тогтоосон зогсоолын байршлаас бусад

нийтийн эзэмшлийн зам, гудамж, талбай, нийтийн амралт, зугаалга, биеийн тамирын зориулалттай газар, цэцэрлэгт хүрээлэн, авто зогсоол, ногоон байгууламж, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн орчны газрын ногоон зүлэг, хүүхдийн тоглоомын талбай, эдгээртэй адилтгах газарт тээврийн хэрэгслээ байршуулсан бол тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц үг хэлэв.

Зөвшөөрсөн: 65
Татгалзсан: 32
Бүгд: 97
67.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дууслаа.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 16 цаг 17 минутад хэлэлцэж дуусав.

“Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан/-ийн анхны хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын ерөнхий прокурорын туслах прокурор, Зөрчлийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах газрын дарга Б.Эрхэмбаяр, Зам, тээврийн яамны Замын хөдөлгөөний аюулгүй байдал хариуцсан шинжээч Т.Эрхэмбаатар, мэргэжилтэн А.Энхболд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, зөвлөх Г.Алтанцэцэг, референт Б.Баярсайхан, Л.Хурцбилэг нар байлцав.

С.Бямбацогт: Байнгын хорооноос гаргасан “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын **саналыг** дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 65
Татгалзсан: 32
Бүгд: 97
67.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 16 цаг 19 минутад хэлэлцэж дуусав.

“Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл/Улсын Их Хурлын гишүүн Б.Пунсалмаа нарын 13 гишүүн 2026.05.07-ны өдөр өргөн мэдүүлсэн/-ийн эцсийн хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Барилга, барилгын материалын бодлого зохицуулалтын газрын дарга Б.Мөнхтөр, “Зам, тээврийн хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Д.Оюунболд, мөн төрийн өмчит үйлдвэрийн газрын Бодлогын хэрэгжилт, зураг төслийн магадлал, стандарт, норм, нормативын хэлтсийн дарга Э.Балт, “Барилгын хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын Барилга байгууламжийн зураг төслийн магадлал зохион байгуулах хэлтсийн дарга Г.Мөнхболд, мөн төрийн өмчит үйлдвэрийн газрын Барилга байгууламж, техникийн захиалагчийн хяналтын хэлтсийн дарга Д.Батням, Ерөнхий инженер З.Энх-Оргил нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Ё.Энхсайхан, референт С.Тэгшжаргал нар байлцав.

“Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар Төсвийн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал:

С.Бямбацогт: 1.Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатарын гаргасан, Тогтоолын төслийн нэрийн “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх талаар” гэснийг “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний талаар” гэж, төслийн 1 дэх заалтын “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар” гэснийг “Улс, орон нутгийн төсөв, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө оруулалт /цаашид “төсвийн хөрөнгө оруулалт” гэх/-аар” гэж тус тус өөрчилж, төслийн тэмдэглэх хэсгийн “Хууль тогтоомжийн тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2, 14.3 дахь хэсэг, 25 дугаар зүйлийн 25.4, 25.5 дахь хэсэг,” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 67
Татгалзсан: 30

Бүгд: 97
69.1 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатарын гаргасан, Тогтоолын төслийн 1.1 дэх дэд заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1/төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж эхэлсэн боловч бүрэн дуусаагүй зогссон төсөл, арга хэмжээний ашиглалтад ороогүй шалтгаан, төсөвт үзүүлж байгаа үр дагавар, нөлөөллийг төсөл, арга хэмжээ нэг бүрээр судалж, холбогдох тайлан болон цаашид төсвийн хөрөнгө оруулалтаар үргэлжлүүлэх, эсхүл өмчлөлийн өөр хэлбэрт шилжүүлэх зэрэг асуудлаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналаа 2026 оны 09 дүгээр сарын 15-ны дотор Улсын Их Хуралд танилцуулах;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 65
Татгалзсан: 32
Бүгд: 97
67.0 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатарын гаргасан, Тогтоолын төслийн 1 дэх заалтын “хэрэгжүүлж байгаа” гэсний өмнө “болон Засгийн газрын гадаад зээлийн эх үүсвэрээр” гэж нэмж, төслийн 1.2 дахь дэд заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2/Засгийн газрын гадаад зээлийн эх үүсвэрээр хэрэгжүүлж эхэлсэн боловч зээлийн хэлэлцээрийн хугацаанд бүрэн дуусах боломжгүй зогссон төсөл, арга хэмжээний талаарх мэдээллийг энэ тогтоолын 1.1-д заасан тайланд тусгах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 66
Татгалзсан: 31
Бүгд: 97
68.0 хувийн саналаар дэмжигдлээ.

С.Бямбацогт: “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалтыг явуулъя.

Зөвшөөрсөн: 62
Татгалзсан: 35
Бүгд: 97
63.9 хувийн саналаар Улсын Их Хурлын тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяа, С.Цэнгүүн нарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул санал хураалтын дүнг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

Нийт 97 гишүүнээс 64 гишүүн дэмжиж, 66.0 хувийн саналаар Улсын Их Хурлын тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 16 цаг 25 минутад хэлэлцэж дуусав.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2026.03.18-ны өдөр өргөн мэдүүлсэн/-ийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд С.Амарсайхан, Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд Д.Мөнх-Эрдэнэ, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Г.Эрдэнэбулган, мөн газрын Нийтийн эрх зүйн хэлтсийн дарга Д.Энхтөр, ахлах шинжээч Ж.Амгалан, Улсын ерөнхий прокурорын газрын Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих хэлтсийн дарга, ахлах прокурор Ч.Мөнх-Эрдэнэ, Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн бодлогын хэрэгжилтийн газрын Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдал хариуцсан ахлах шинжээч Ш.Энхтуяа, Цагдаагийн ерөнхий газрын Хар тамхитай тэмцэх албаны дарга Э.Товуудорж, мөн албаны тасгийн дарга Б.Эрхэсбаатар, Тагнуулын ерөнхий газрын Хэлтсийн дарга Т.Энхбат, Гаалийн ерөнхий газрын Хар тамхи, мөнгө угаахтай тэмцэх хэлтсийн дарга Г.Ганзориг, Хил хамгаалах ерөнхий газрын Хилийн боомтын газрын Шалган нэвтрүүлэх хэлтсийн дарга Э.Мөнхцог, Шүүх шинжилгээний ерөнхий газрын Байгалийн ухааны шинжилгээний хэлтсийн дарга Б.Ламчин, Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөний Сэтгэц-Нийгмийн сэргээн засах төвийн зохицуулагч Б.Түмэндэмбэрэл, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн Сэтгэц нийгмийн эрүүл мэнд, гадаад харилцаа, сургалтын албаны Мансуурлын асуудал хариуцсан мэргэжилтэн, эмч С.Байгальмаа, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын зохицуулах зөвлөлийн Ажлын албаны ахлах мэргэжилтэн У.Дэлгэрхишиг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, зөвлөх Г.Алтанцэцэг, референт Б.Баярсайхан нар байлцав.

С.Бямбацогт: 1.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	66
Татгалзсан:	31
Бүгд:	97

68.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	65
Татгалзсан:	32
Бүгд:	97

67.0 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 64
Татгалзсан: 33
Бүгд: 97
66.0 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 65
Татгалзсан: 32
Бүгд: 97
67.0 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 63
Татгалзсан: 34
Бүгд: 97
64.9 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 64
Татгалзсан: 33
Бүгд: 97
66.0 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 63
Татгалзсан: 34
Бүгд: 97
64.9 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 62
Татгалзсан: 35
Бүгд: 97

63.9 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 62

Татгалзсан: 35

Бүгд: 97

63.9 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 60

Татгалзсан: 37

Бүгд: 97

61.9 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 64

Татгалзсан: 33

Бүгд: 97

66.0 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 64

Татгалзсан: 33

Бүгд: 97

66.0 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 62

Татгалзсан: 35

Бүгд: 97

63.9 хувийн саналаар дэмжигдлээ.

14.Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 59

Татгалзсан: 38
 Бүгд: 97
 60.8 хувийн саналаар дэмжигдлээ.

15.Байгалийн ургамлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 59
 Татгалзсан: 38
 Бүгд: 97
 60.8 хувийн саналаар дэмжигдлээ.

16.Гаалийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 61
 Татгалзсан: 36
 Бүгд: 97
 62.9 хувийн саналаар дэмжигдлээ.

17.Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 61
 Татгалзсан: 36
 Бүгд: 97
 62.9 хувийн саналаар дэмжигдлээ.

18.Гүйцэтгэх ажлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 62
 Татгалзсан: 35
 Бүгд: 97
 63.9 хувийн саналаар дэмжигдлээ.

19.Гэр бүлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 62
 Татгалзсан: 35
 Бүгд: 97
 63.9 хувийн саналаар дэмжигдлээ.

20.Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 58
 Татгалзсан: 39
 Бүгд: 97
 59.8 хувийн саналаар дэмжигдлээ.

21.Жолоочийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 62
 Татгалзсан: 35
 Бүгд: 97
 63.9 хувийн саналаар дэмжигдлээ.

22.Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 60
 Татгалзсан: 37
 Бүгд: 97
 61.9 хувийн саналаар дэмжигдлээ.

23.Зар сурталчилгааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 60
 Татгалзсан: 37
 Бүгд: 97
 61.9 хувийн саналаар дэмжигдлээ.

24.Ирээдүйн өв сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 65
 Татгалзсан: 32
 Бүгд: 97
 67.0 хувийн саналаар дэмжигдлээ.

25.Монгол Улсын Төрийн ордны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 62
 Татгалзсан: 35
 Бүгд: 97
 63.9 хувийн саналаар дэмжигдлээ.

26. Нотариатын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 63

Татгалзсан: 34

Бүгд: 97

64.9 хувийн саналаар дэмжигдлээ.

27. Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 60

Татгалзсан: 37

Бүгд: 97

61.9 хувийн саналаар дэмжигдлээ.

28. Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 62

Татгалзсан: 35

Бүгд: 97

63.9 хувийн саналаар дэмжигдлээ.

29. Тагнуулын байгууллагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 65

Татгалзсан: 32

Бүгд: 97

67.0 хувийн саналаар дэмжигдлээ.

30. Усан замын тээврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 65

Татгалзсан: 32

Бүгд: 97

67.0 хувийн саналаар дэмжигдлээ.

31. Харьяатын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 63

Татгалзсан: 34

Бүгд: 97
64.9 хувийн саналаар дэмжигдлээ.

32.Цагдаагийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 63
Татгалзсан: 34
Бүгд: 97
64.9 хувийн саналаар дэмжигдлээ.

33.Цэргийн алба хаагчийн эд хөрөнгийн хариуцлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 63
Татгалзсан: 34
Бүгд: 97
64.9 хувийн саналаар дэмжигдлээ.

34.Шуудангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 63
Татгалзсан: 34
Бүгд: 97
64.9 хувийн саналаар дэмжигдлээ.

35.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 65
Татгалзсан: 32
Бүгд: 97
67.0 хувийн саналаар дэмжигдлээ.

36.Тариалангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 63
Татгалзсан: 34
Бүгд: 97
64.9 хувийн саналаар дэмжигдлээ.

37.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 65
 Татгалзсан: 32
 Бүгд: 97
 67.0 хувийн саналаар дэмжигдлээ.

38.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн шинэчилсэн найруулгыг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 65
 Татгалзсан: 32
 Бүгд: 97
 67.0 хувийн саналаар дэмжигдлээ.

39.Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 65
 Татгалзсан: 32
 Бүгд: 97
 67.0 хувийн саналаар дэмжигдлээ.

40.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 65
 Татгалзсан: 32
 Бүгд: 97
 67.0 хувийн саналаар дэмжигдлээ.

41.Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 64
 Татгалзсан: 33
 Бүгд: 97
 66.0 хувийн саналаар дэмжигдлээ.

42.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 63
 Татгалзсан: 34
 Бүгд: 97
 64.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 16 цаг 41 минутад хэлэлцэж дуусав.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин нарын 6 гишүүн 2026.04.30-ны өдөр өргөн мэдүүлсэн/-ийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан хуульч Б.Эрхбаяр, өмгөөлөгч Б.Батбаяр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, зөвлөх Г.Алтанцэцэг, референт Л.Хурцбилэг нар байлцав.

С.Бямбацогт: Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 67
Татгалзсан: 30
Бүгд: 97
69.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 16 цаг 43 минутад хэлэлцэж дуусав.

Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг нарын 7 гишүүн 2026.05.14-ний өдөр өргөн мэдүүлсэн/-ийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Л.Хурцбилэг нар байлцав.

С.Бямбацогт: 1.Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 65
Татгалзсан: 32

Бүгд: 97
67.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 60
Татгалзсан: 37
Бүгд: 97
61.9 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 65
Татгалзсан: 32
Бүгд: 97
67.0 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Авлигын эсрэг хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 59
Татгалзсан: 38
Бүгд: 97
60.8 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 58
Татгалзсан: 39
Бүгд: 97
59.8 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 60
Татгалзсан: 37
Бүгд: 97
61.9 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Нийгмийн даатгалын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 60
Татгалзсан: 37
Бүгд: 97
61.9 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 60
Татгалзсан: 37
Бүгд: 97
61.9 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Төрийн албаны хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 62
Татгалзсан: 35
Бүгд: 97
63.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 16 цаг 47 минутад хэлэлцэж дуусав.

Долоо.Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг нарын 19 гишүүн 2026.05.28-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны зөвлөх Ч.Батбямба, референт Б.Баясах нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Л.Энхнасан, С.Эрдэнэбат, Ц.Туваан, Р.Эрдэнэбүрэн, Х.Баасанжаргал, Ө.Шижир нарын тавьсан асуултад хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно.” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав./17:41/

Найм.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн О.Амгаланбаатар нарын 17 гишүүн 2026.05.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул нар байлцав.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлаар Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дарга Ж.Батжаргал ажлын 5 өдрийн завсарлага авах тухай мэдэгдэж, уг асуудлаар Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт ажлын 5 өдрийн завсарлага өгөв./17:43/

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 8 асуудал хэлэлцэв.

Бусад.Улсын Их Хурлын гишүүн Ш.Бямбасүрэнгийн урилгаар Дорнод аймгийн “Дорнод СЕО бизнесийн манлайлал” төрийн бус байгууллагын гишүүд, Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн урилгаар Говь-Алтай аймгийн Тонхил сумын ерөнхий боловсролын сургуулийн 1981 оны төгсөгчид, Увс аймгийн Баруунтуруун сумын ерөнхий боловсролын 1996 оны төгсөгчид, Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрамын урилгаар Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын 1 дүгээр цэцэрлэгийн багш, ажилчид, Монгол Улсын Консерваторын 1996 оны төгсөгчид, Улсын Их Хурлын гишүүн Ц.Баатархүүгийн урилгаар Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 18, 24 дүгээр хорооны иргэдийн төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурийн урилгаар нийслэлийн ерөнхий боловсролын 141 дүгээр сургуулийн 12^а ангийн багш, сурагчид, нийслэлийн ерөнхий боловсролын Г.В.Плехановын нэрэмжит сургуулийн 9^г ангийн багш, сурагчид, Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбатын урилгаар Хөдөө аж ахуйн их сургуулийн 2006 оны төгсөгчид, Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболдын урилгаар нийслэлийн ерөнхий боловсролын “Сэнлизэ” сургуулийн 10^а, 11^а, 12^а ангийн багш, сурагчид, Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэлийн урилгаар нийслэлийн ерөнхий боловсролын 31 дүгээр сургуулийн 8^а ангийн багш, сурагчид, Улсын Их Хурлын гишүүн Ц.Тувааны урилгаар Төв аймгийн Эрдэнэ сумын Политехникийн коллежийн 2025-2026 оны олон улсын тэмцээн, уралдаанд тэргүүлсэн багш, оюутнуудын төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуягийн урилгаар нийслэлийн ерөнхий боловсролын “Эрдмийн өргөө” сургуулийн 12^ж ангийн багш, сурагчид, нийслэлийн ерөнхий боловсролын “Гурван тамир” сургуулийн 12^а ангийн багш, сурагчид, Улсын Их Хурлын гишүүн Б.Түвшингийн урилгаар Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институтын Хан-Уул дүүргийн салбарын гишүүд, нийслэлийн ерөнхий боловсролын “Эрхэт эрдэм” сургуулийн 12 дугаар ангийн багш, сурагчид, Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгийн урилгаар Америкийн Нэгдсэн Улсын иргэдийн төлөөлөл Төрийн ордон, Улсын Их Хурлын чуулганы үйл ажиллагаатай танилцав.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хуралдаан зохион байгуулах газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 6 цаг 45 минут үргэлжилж, 126 гишүүнээс 97 гишүүн хүрэлцэн ирж, 77.0 хувийн ирцтэйгээр 17 цаг 43 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Ж.БЯМБАДУЛАМ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ГАЗРЫН ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

*2026 оны 06 дугаар сарын 04-ний өдөр, Пүрэв гараг
Төрийн ордон “Их хуралдай” танхим
10 цаг 00 минут*

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

С.Бямбацогт: Улсын Их Хурлын гишүүдийнхээ өглөөний амгаланг айлтгая. 2026 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдааны ирц ирвэл зохих 126 гишүүнээс 67 гишүүн буюу 53.2 хувийн ирцтэй бүрдсэн байна. Чуулганы хуралдааныг нээснийг мэдэгдье.

Гишүүддээ мэдээлэл хүргэе. Энэ долоо хоногийн тов дараалалд тусгагдсан хэлэлцэх асуудлуудаас Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл Улсын Их Хурлын гишүүн Энхцэцэг нарын гишүүд өргөн мэдүүлсэн Төрийн байгуулалтын байнгын хорооны 06 дугаар сарын 02-ны өдрийн хуралдааны явцад Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 31.5-д заасны дагуу хуулийн төслийг хэлэлцэхийг хойшлуулсан тул нэгдсэн хуралдааны хэлэлцэх асуудлаас хасагдсан.

Төрсөн өдөр нь тохиож байгаа гишүүдийн мэдээлэл, мэндчилгээ хүргэе.

06 дугаар сарын 04-ний өдөр Улсын Их Хурлын гишүүн Саруулсайханы Цэнгүүн төрсөн байна. Улсын Их Хурлын гишүүн Саруулсайханы Цэнгүүнд төрсөн өдрийн мэнд хүргэж, Монгол төрийн эрхэм түшээ, ард түмний элч болсон танд болон таны гэр бүлд Улсын Их Хурлын нийт гишүүдийнхээ нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Өнөөдрийн чуулганд нэгдсэн хуралдаанд эртэч гишүүдээ бас танилцуулъя. Ганбатын Очирбат, Бат-Өлзийн Бат-Эрдэнэ, Лутаагийн Энханасан, Пүрэвжавын Сайнзориг, Наранцэцэгийн Алтаншагай нарын гишүүд хамгийн түрүүлж 9 цагт ирцдээ орсон байна. Баяр хүргэе.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Өнөөдрийн чуулганаар дараах 9 асуудлыг хэлэлцэнэ.

1 дүгээрт нь Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна. Улсын Их Хурлын гишүүн Пүрэвийн Батчимэг нарын 9 гишүүн өргөн мэдүүлсэн хууль байгаа.

2 дугаарт нь “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

3 дугаарт нь “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их

Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна. Улсын Их Хурлын гишүүн Бадамдоржийн Пунсалмаа нарын 13 гишүүн өргөн мэдүүлсэн хуулийн төсөл байгаа.

4 дүгээрт Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг явуулна. Засгийн газар 26 оны 03 сарын 18-ны өдөр өргөн мэдүүлсэн.

5 дугаарт нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрдлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг явуулна. Улсын Их Хурлын гишүүн Дашцэрэнгийн Энхтүвшин нарын гишүүд өргөн мэдүүлсэн хуулийн төсөл байгаа.

6 дугаарт нь Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгээ явуулна. Улсын Их Хурлын гишүүн Пүрэвжавын Сайнзориг нарын гишүүд өргөн мэдүүлсэн хуулийн төсөл байгаа.

Энэ Амгаланбаатар гишүүн хуулийн төслийн хэлэлцүүлгийг хойшлуулъя гэсэн. Хойшлуулж байгаа тийм үү? Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна. Энэ дээр гэхдээ горимын санал хурааж хойшлуулах хууль санаачлагч нь хуулийн төслөө хойшлуулах хүсэлт тавьсан байгаа.

8 дугаарт нь Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна. Улсын Их Хурлын гишүүн Пүрэвжавын Сайнзориг нарын гишүүд өргөн мэдүүлсэн.

9 дүгээрт нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг явуулна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 29.1-д Улсын Их Хурлын дарга хууль санаачлагчаас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх Байнгын хороог, хэрэв тухайн төсөл хэд хэдэн Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах бол зөвлөлтэй зөвшилцөн холбогдох болон бусад Байнгын хороог тогтоож нэгдсэн хуралдаанаар мэдээлнэ гэж заасан.

Үүний дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хуулийн төслийг холбогдох Байнгын хороонд хуваарилсан талаар танилцуулъя.

1.Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хурлын гишүүн Пүрэвбаатарын Мөнхтулга 2026 оны 05 дугаар сарын 27-ны өдөр өргөн мэдүүлснийг Эдийн засгийн байнгын хороонд хуваарилсан.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны хуралдааны дэгийн тухай хуулийн 32.1-д хууль санаачлагч хэлэлцүүлгийн аль ч шатад санаачилсан хуулийн төслөө татан авч болно. 32.3-д хуулийн төслөө татан авах тохиолдолд тухайн төсөл нь хэлэлцүүлгийн аль шатад байгаагаас үл хамааран хууль санаачлагч хуулийн төслөө татан авах тухай албан бичгийг Улсын Их Хуралд ирүүлэх бөгөөд Улсын Их Хурлын дарга нэгдсэн хуралдаанд энэ тухай танилцуулснаар хууль санаачлагч хуулийн төслөө татан авсанд тооцно гэж тус тус заасан.

Үүний дагуу хууль санаачлагчаас хуулийн төслөө татан авах тухай албан бичгийг Улсын Их Хуралд ирүүлснийг уншиж танилцуулъя.

Монгол Улсын Засгийн газар, “Тогтоолын төсөл татан авах тухай”

Монгол Улсын Их Хуралд 2025 оны 12 дугаар сарын 18-ны өдөр өргөн мэдүүлсэн “Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2026-2028 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах, төрийн өмчийг хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32-ын дугаар зүйлийн 32.1 дэх хэсэгт заасны дагуу татан авч байгаагаа үүгээр мэдэгдэж байна. Засгийн газрын 2026 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн хуралдааны тэмдэглэлийг хавсаргав. Монгол Улсын Ерөнхий сайд Учрал гэсэн бичиг ирсэн.

Засгийн газар 2025 оны 12 дугаар сарын 18-ны өдөр өргөн мэдүүлсэн “Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2026-2028 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах, төрийн өмчийг хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг татан авсанд тооцлоо.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 6.9-д нам, эвслийн бүлэг энэ хуулийн 6.6-д заасан нэгдсэн хуралдаанаар хэлэлцэхээр тогтсон асуудлыг хойшлуулах, дараалал өөрчлөх, асуудал нэмэх горимын санал гаргах бол Улсын Их Хурлын даргад нэгдсэн хуралдааны өмнөх өдрийн 17 цагаас өмнө үндэслэлээ тодорхой бичиж ирүүлнэ гэж заасны дагуу Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгээс 2026 оны 06 дугаар сарын 03-ны өдөр хэлэлцэх асуудлын тов дарааллаас хойшлуулах тухай албан бичиг ирүүлснийг уншиж танилцуулъя.

Монгол Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлэг хэлэлцэх асуудлын тов дарааллаас хойшлуулах тухай.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.3 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.9 дэх хэсгийг тус тус үндэслэн Улсын Их Хурлын чуулганы 2026 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудлын тов дараалалд орсон Улсын Их Хурлын гишүүн Амгаланбаатар нарын 41 гишүүний өргөн мэдүүлсэн Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хойшлуулж өгнө үү. Дэд дарга Жаргалан гэсэн бичиг ирсэн байна.

Одоо Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгээс гаргасан горимын саналаар санал хураалт явуулна. Гишүүд танхимдаа орж ирнэ үү. Санал хураалтдаа бэлтгэе.

Зочин танилцуулъя. Увс аймгийн Баруунтуруун сумын ерөнхий боловсролын сургуулийн 1966 оны төгсөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэндээ Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс амьдралд нь аз жаргал, эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Гишүүд санал хураалтдаа бэлтгэе. Ирцдээ орсон гишүүд чуулганы хуралдаанд хүрэлцэн ирнэ үү. Санал хураалт явуулна. Төсвийн байнгын хорооны хуралдаанд сууж байгаа гишүүд чуулганы танхимд хүрэлцэн ирнэ үү. Санал хураалт явуулчихъя. Төсвийн байнгын хороон дээр сууж байгаа гишүүдийг дуудаарай.

Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Шинэбаярын Бямбасүрэнгийн урилгаар Дорнод аймгийн “Дорнод СЕО бизнесийн манлайлал” төрийн бус байгууллагын гишүүд Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүгдийнхээ ажилд нь амжилт, амьдралд нь эрүүл энх, сайн сайхан бүхнийг Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс хүсэн ерөөе.

Гишүүдийг суудалдаа суухыг урьж байна. Төсвийн байнгын хорооны гишүүдийг бас орж ирэхийг хүсье. Санал хураалтаа явуулъя. Ирц бүртгэлийн санал хураалт явуулъя гишүүд суудлаа эзэлнэ үү. Ирц бүртгэлийн санал хураалт. Гишүүд ээ суудлаа эзэлье. Санал хураалт.

Энэ дэлгэц дээр “татгалзсан” гарч байгаа гишүүд танхимдаа орж ирье. Гишүүд санал хураалт явуулъя. Төсвийн байнгын хороо бас дуусаж байх шиг байна. Гишүүдийг хурдан оруулаарай. Суудлаа эцэслэчихье. Санал хураалтын томьёоллыг та бүхэнд уншиж танилцуулъя.

Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгээс Улсын Их Хурлын чуулганы 2026 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэхээр тогтсон асуудлыг хойшлуулах горимын санал гаргасныг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Санал хураалтад 84 гишүүн оролцсоноос 44 гишүүн буюу 52.4 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгээс гаргасан горимын саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэхээр тогтсон Улсын Их Хурлын гишүүн Амгаланбаатар нарын 41 гишүүн 2025 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр өргөн мэдүүлсэн Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг хойшлууллаа.

Хэлэлцэх асуудалдаа оръё.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэг явуулна.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Хууль зүйн байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Гончигдоржийн Уянгахишиг танилцуулна. Индэрт урьж байна таныг.

Г.Уянгахишиг: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн П.Батчимэг нарын 9 гишүүнээс 1925 оны 07 сарын 03-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2026 оны 05 дугаар сарын 28, 29-ний өдрүүдийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Байнгын хорооны 2026 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн хуралдаанаар Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулсан бөгөөд хуралдааны үеэр Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг 18 насанд хүрээгүй хүүхэд мопед, скутер унасан тохиолдолд эцэг эхэд хариуцлага тооцох зохицуулалт нь бусдын үйлдэлд хариуцлага оногдуулахгүй байх зарчимд нийцэж байгаа эсэх, скутер, мопед унаж буй хүмүүсийг авто замын баруун талаар зорчуулах охицуулалт нь том оврын тээврийн хэрэгслийн сохор бүсэд орохтой холбоотойгоор хүүхэд, залуучуудын амь нас, эрүүл мэндэд учрах аюулыг нэмэгдүүлэх эрсдэлийн талаар, хотын тулгамдсан асуудлыг шийдэх зорилгоор боловсруулсан уг зохицуулалт нь аймаг, орон нутгийн нөхцөлд нийцэх эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд Замын хөдөлгөөний дүрэмд мопедын тодорхойлолт байгаа хэдий ч скутер болон сүүлийн үед өргөн хэрэглэгдэж буй “hoverboard” зэрэг тээврийн хэрэгслийн эрх зүйн зохицуулалт хуулийн төсөлд тусгагдсан эсэх, хэл шинжлэлийн үүднээс скүүтер зэрэг шинэ нэр томъёог оруулахдаа галиглах зарчим баримталж байгаа эсэх, мөн энэ талаар хэл шинжээчтэй зөвшилцсөн эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар том оврын тээврийн хэрэгсэл хөдөлгөөнд оролцох үед унадаг дугуй, мопед, скүүтертэй зорчигчид сохор бүсэд өртөх эрсдэл өндөр байгаа тул уг эрсдэлийг бууруулах талаар бодитой, үр дүнтэй шийдлүүдийн талаар тус тус асуулт асууж хариулт авсан болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед хуралдаан даргалагчаас Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалтад заасны дагуу гүйцээн боловсруулах чиглэл өгсөн тул ажлын хэсгээс Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар 1 санал, хамт өргөн мэдүүлсэн. Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар 1 зарчмын зөрүүтэй саналыг гүйцээн боловсруул, Байнгын хороо гоор хэлэлцүүлсэн бөгөөд хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналуудыг төсөлд нэмж тусган төслийн агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр үг, хэллэг, дэс дараалал, бүтцийн шинжтэй засварыг хийж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл болон Байнгын хорооны танилцуулгыг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Хууль зүйн байнгын хорооны танилцуулгыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

С.Бямбацогт: Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя. Баатаржавын Эрхэмбаяр Монгол Улсын ерөнхий прокурорын туслах прокурор, Зөрчлийн хууль тогтоомжийг хэрэгжилтийг хангуулах газрын дарга, Баатарсүрэнгийн Батзориг Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга, Түвдэндоржийн Эрхэмбаатар Зам, тээврийн яамны Замын хөдөлгөөний аюулгүй байдал хариуцсан ахлах шинжээч, Анжимын Энхболд Зам, тээврийн яамны Замын хөдөлгөөний аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн.

Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна.

Батын Батбаатар гишүүн алга байна. Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн асуултаа асууя.

Уучлаарай би зочин танилцуулчихъя. Улсын Их Хурлын дэд дарга Бөхчулууны Пүрэвдоржийн урилгаар Говь-Алтай аймгийн Тонхил сумын Ерөнхий боловсролын сургуулийн 1981 оны төгсөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Төрийн ордонтой танилцаж байгаа иргэд та бүхэндээ Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Эрдэнэбат гишүүн асуултаа асууя.

С.Эрдэнэбат: Маш чухал хууль байгаа. Бид нар нөгөө машин зохицуулна гээд Улаанбаатар хот скүүтер, дугуй, явган хүний урсгалыг хүртэл ер нь бол зохицуулах ийм зайлшгүй шаардлага бол байгаа. Тэгэхээр хуулийн хэлэлцүүлгийн шатад энэ скүүтерийн хэрэглээ бол огцом өсөж байна. Нийгмийн хөгжил ч гэсэн маш хурдацтай хөгжиж байгаа учраас хамгийн сүүлийн гишүүдийн саналыг гүйцээн боловсруулах саналд скүүтрийг замын хөдөлгөөнд нэмэлт урсгал гаргаж явахаар болсон уу эс үгүй бол явган хүний замд зэрэгцүүлээд тусгай зам гаргаж хийхээр болсон уу гэдгийг бол би тодруулж асууя.

Тухайлбал, би бол өглөө болгон бас алхаад явдаг энэ Олимпын гудамж гээд манай хамгийн их хүмүүс алхдаг гудамж байгаа. Явган хүн, дугуй, скүүтер, тэгээд

хөгжлийн бэрхшээлтэй иргэн гээд үндсэндээ 50-аас 1 метрийн өргөнтэй зам дээгүүр бахдалцаж ядаад л өглөө, оройдоо алхацгаадаг. Бүүр ярих юм бол би өмнө 2, 3 удаа асуудал өгөөд ерөөсөө шийдэхгүй байгаад байгаа учраас хэлбэ гэж бодож байна. Хүмүүсийг явган болон явах юмыг нь дэмжих ёстой манай Эрүүл мэндийн яамны өмнө яг ний нуугүй хэлэхэд 50см зай байдаг юм. Үүдэн дээр нь 4, 5 машинаа тавьчихдаг юм байна лээ. Тэрүүгээр тэгээд скүүтертэй хүн, явган хүн, ахмад настай хүн, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс зөрж гаргах гэж маш их асуудалтай байдаг юм.

Тэгэхээр иймэрхүү байдлаар ер нь энэ явган хүн, скүүтерийг зорчих хэсгийн зохицуулагч гэдэг хүн ер нь бараг хэрэг болох юм шиг байгаа юм. Тэгэхээр энэ тал дээр хуулийн төсөлд яг зохицуулсан зүйл байна уу? Нэг талаар бол яах вэ зам руу хэрвээ гаргачих юм бол замын цагдаа нөгөө скүүтерүүдийг ингээд зохион байгуулах байдлаар зохицуулахаар байна уу яахаар байна вэ гэдгийг би бол тодруулж асуумаар байна. Хууль санаачлагч болон ажлын хэсгээс.

С.Бямбацогт: Хэн хариулах вэ? Ажлын хэсэг Уянгахишиг гишүүн ажлын хэсгийн ахлагч хариулна. Ажлын хэсэг ахалсан улсууд хуулиа бол маш сайн мэдэж байгаа шүү дээ тиймээ. Хариулъя. Уянгахишиг гишүүний микрофон өгье. Уянгахишиг гишүүн та хуруугаа уншуулаагүй, ирцдээ ороогүй байна.

Г.Уянгахишиг: Эрдэнэбат гишүүний асуултад хариулъя. Энэ Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулснаараа бол яг энэ цахилгаан скүүтрийг мопедтой адилтгаж үзэж байгаа. Өөрөөр хэлэх юм бол замын хөдөлгөөний дүрэмд унадаг дугуй, мопедтой холбоотой зохицуулалтууд бол байдаг. Өөрөөр хэлбэл замын хөдөлгөөний дүрмээр зохицуулдаг, тээврийн хэрэгсэлд ордог. Тухайн тээврийн хэрэгслийг жолоодож байгаа жолооч нь жолооч гэсэн тодорхойлолтод ороод явдаг. Энэ утгаараа энэ Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд орж байгаа нэмэлт, өөрчлөлтийн гол үр дагавар нь яг мопед яаж явдаг байсан яг тэр зарчмаар цахилгаан скүүтер явах юм.

Өөрөөр хэлэх юм бол унадаг дугуй, унадаг дугуй, мопед, унадаг дугуйн зам, унадаг дугуйн эгнээгээр, хэрэв тэр 2 байхгүй бол замын, авто замын баруун хөвөөгөөр зорчих ийм дүрэмтэй.

Мопедын хувьд бол яг жишээлбэл баруун хөвөөгөөр явах боломжгүй байгаа тохиолдолд унадаг дугуйн хувьд өөрөө хурдаа тохируулаад явдаг учраас 5км, 10км цаг хүртэл хурдтай явган хүний замаар явган хүний хэр олон байна гэдгээс хамаараад. Жишээлбэл явган хүний хөдөлгөөн их байх юм бол, ирц ихтэй байх юмбо, эрчис нь их байх юм бол явган хүний замаар явж болохгүй. Мопетын хувьд бол явган хүний замаар зөвхөн түрж явах үүрэгтэй. Энэ нь бид нар шинээр зохиож оруулж байгаа биш ерөөсөө замын хөдөлгөөний дүрэмд байдаг зохицуулалт гэсэн үг. Тэгэхээр унадаг дугуй унасан ч бай, мопед унасан ч бай скүүтер унасан ч бай явган хүний замаар бол түрж явна. Харин дугуйн зам, дугуйн эгнээгээр яваад хэрэв болохгүй бол баруун хөвөөгөөр явна. Мөн хамгаалах хэрэгслүүдийг заавал унах ёстой. Мөн заавал тогтоосон байршилд парклах буюу зогсоолд байршуулах ёстой. Хэрэв эдгээрийг хийхгүй бол нөгөө Зөрчлийн хуулиараа торгуулиа аваад явдаг ийм зохицуулалт руугаа л орж байгаа гэсэн үг.

С.Бямбацогт: Сурон бас адилхан тийм үү?

Г.Уянгахишиг: Сурон болохоороо мотоциклтой адилхан буюу тэр нь илүү хурдтай учраас зөвхөн нөгөө “А” ангиллаар зөвхөн авто замаар зорчино гэсэн үг. Сурон бол дугуйн замаар зорчих эрх байхгүй гэсэн үг. Тэгэхээр ер нь бол энэ дээр бид нар яг үүсээд байгаа асуудал бол ерөөсөө л дэд бүтэц сийн асуудал байгаа юм. Одоо энэ ингээд цахилгаан скүүтер гарч ирээд өчнөөн жил, 2, 3 жил болоход хот болон Засгийн газраас төсвийг нь батлаад энэ дугуйн замаа дугуйтай зорчигчид ч гэсэн маш их аваар осол хийж байгаа байхгүй юу. Тэгэхээр ялт ч байхгүй бид нар хүндээ ээлтэй хот болгохын тулд дугуйн зам, явган хүний замыг бол зайлшгүй засаж янзалж стандартыг нь хангуулах ёстой. Өнөөдөр авто замууд энэ стандартаа хангахгүй байгаагаас болоод энэ гэмтэл, ослууд чинь болоод байгаа байхгүй юу.

С.Бямбацогт: Эрдэнэбат гишүүн тодруулъя.

С.Эрдэнэбат: Энийгээ маш нарийн тодорхой яахгүй бол хүн ихтэй байх юм бол авто замын баруун хөвөөгөөр явна, хүн цөөтэй байх юм бол явган хүний зам дээгүүр явна гээд ингээд ярьчих юм бол энэ чинь асуудал болно. Тэгэхээр яах вэ би нэг хэсэгтээ энэ хөдөлгөөний хүмүүс дастал шийдэл тодорхой зохицуулалт ийм зүйл хийхгүй бол яг ний нуугүй хэлэхэд дугуйн зам дээгүүр чинь хүмүүс алхаад байдаг. Алхахаас ч өөр арга байхгүй. Яг ний нуугүй хэлэхэд тэр тэр нарийхан гудамжаар чинь хүмүүс багтаж явахад үнэхээр хэцүү байгаа. Энийг бол магадгүй алхаж гол гол гудамжуудаар алхаж явдаг хүмүүс бол мэдэх байх.

Тэгэхээр зүгээр нэг хэсэг замын баруун хүүгээр явна гэх юм бол тодорхой хамгаалах тэмдэглэгээ мэмдэглэгээ гэдэг юм уу ийм хашлага юу байдаг юм ингэж түр зуурын хашлага ч гэдэг юм уу ийм юм хийж өгөхгүй бол зуны хугацаанд л зохицуулах гээд байгаа шүү дээ. Зун, намрын. Өвөл бол нэг их скүүтерээр яваад байдаг хүн байхгүй. Тэр мэрийг нь зохицуулж дэд бүтцээ шийдэж байж энэ хуулиа хэрэгжүүлэхгүй бол бөөн маргаан болоод.../минут дуусав./

С.Бямбацогт: Уянгахишиг гишүүн хариулъя.

Г.Уянгахишиг: Энэ дээр болохоор түрүүн нөгөө явган хүний замаар явах чинь зөвхөн унадаг дугуйн тухайд ярьсан шүү. Яг скүүтер, мопедын хувьд бол дугуй, явган хүний замаар явахыг бүрмөсөн хориглож байгаа гэсэн үг. Яг одоо ч гэсэн зохицуулалт нь тийм байгаа гэсэн үг. Замын хөдөлгөөний дүрмээр мопедын хувьд. Тэгэхээр мопедтой адилхан учраас явган хүний замаар явахгүй. Яг энэнтэй холбоотой Эрдэнэбат гишүүний зөв. Яг энэнтэй холбоотойгоор Их Хурлын тогтоолын төсөл энэний дараагийн асуудлаар орж ирнэ. Энэ Их Хурлын тогтоолын төслөөр засгийн газар болон Нийслэлийн Засаг дарга хотын захирагчид энийг үүрэгжүүлж байгаа гэсэн үг. Тэгээд Нийслэлийн Засаг дарга хотын захирагч бол тухайн скүүтрийн түрээслүүлж байгаа хуулийн этгээдүүдтэй гэрээ байгуулах зохицуулалтыг мөн тусгаж оруулж ирж байгаа. Энэ гэрээ байгуулснаараа яг нөгөө скүүтрүүд чинь бүртгэлдээ бүртгэгдсэн юм уу, стандарт хангаж байгаа юм уу нөгөө зогсоолд байршуулах ёстой шүү. Яг энэ байршлаар явна шүү. Энэ дээр бол яг нийслэл энэ ар арга хэмжээгээ аваад явах юм. Аймгууд дээр аймгийн Засаг дарга нар.

С.Бямбацогт: Цэвэгдоржийн Туваан гишүүн асуултаа асууя.

Ц.Туваан: Бүгдэд нь энэ өглөөний мэнд хүргэе. Энэ маш чухал хууль. Батчимэг гишүүн нарын гишүүд санаачилж оруулж ирж байгаа цаг үеэ олсон зайлшгүй зохицуулалтыг нь баталж өгөх ёстой ийм хууль байгаа юм. Тэгээд энэ дээр стандарт гэдэг зүйлийг л сайн дагаж мөрдүүлэхгүй бол манайд чинь ер нь төр байгаа, байхгүй нь мэдэгдэхгүй энэ иргэдийнхээ зорчиж байгаа зам, явган хүний зам, дугуйн зам энэ тэрийг яг стандартын дагуу болгох асуудал ерөөсөө маш хойрго байгаагаас энэ асуудал үүсээд байгаа юм. Саяхан л гэхэд энэ Сэлэнгэ аймгийн Баянгол сумын эмч “Алдарт эх”-ийн одон авах гэж явж байгаад осолд орсон хүнд тусламж үзүүлж байсан. Энэ бол бас л яг нөгөө хууль зохицуулалтгүйгээс явсан зам дээр осол болсон. Тэнд тэр Баярмаа эмч ингээд тусламж үзүүлээд явж байх жишээтэй. Тэгэхээр энийгээ тэр дагаж мөрдөж байгаа Улсын Их Хурлын тогтоол дээрээ бас нарийн зааж тэгээд хойноос нь шахаж явмаар байгаа юм.

Тэгэхгүй бол манайд ерөөсөө хөдөө орон нутгаар явахаар баталсан хууль тогтоомжууд огт хэрэгжихгүй байгаа л асуудлыг маш их ярьж байна иргэд. Тэгэхээр ийм нэг хууль болчих вий гэж ингэж санаа зовж байна. Тэгэхээр энэ стандарттай холбоотой зүйл дээр бас хариулт авъя.

Нэгэнт энэ Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль ярьж байгаа учраас би бас энэ ажлын хэсгээс ялангуяа цагдаагийнхан, цагдаагийн байгууллагаас байгаа ажлын хэсгүүдээс энэ орон нутгийн зам дээр хурдны хязгаар чинь 80км цаг. Тэгээд 80км цагтай явж байгаа нэг ч хүн байхгүй бараг.

Ер нь ямар ч машин энэ хуучин стандарт яваад байгаа юм. Нөгөө бид нарын үед Оросын Холбооны Улсын 69, ЗИЛ-130, Волга энэ тэр явж байх үеийн стандарт яваад байгаа юм. Ингээд 80-тай явж байгаа хүн байхгүй дунджаар 100км цагийн хурдтай яваад байгаа юм. Энэ дээр ер нь цаашдаа ямар бодлоготой байгаа юм бэ? Тэгээд 80-аас дээш ингээд л зүгээр нэг юу хааз дээрээ хөл тавиад явахад л одоогийн техникууд чинь 100 хүрчхээд байгаа шүү дээ. Тэгэхээр ер нь энэ бодлого нь яаж явж байгаа юм бэ энэ дээр өөрчилье, баталгаатай ийм хурдны замууд дээр хурдны хязгаараа нэмэх барих гэсэн ийм зүйл явж байгаа юу? Энэ тал дээр нэг хариулт өгөөдхөөч.

2 дугаарт, энэ орон нутгийн зам дээр болон энэ хурдны замууд дээр мал их дайрагдаж байна. Энэ дээр 20 цагаас хойш малчны буруу болчихоод байгаа юм. Ингээд нөгөө малаа маллаагүй учраас нөгөө малчны мал дайрагдаж үхээд дээрээс нь бөөн төлбөр торгуульд орчихсон. Бүр 30, 40 саяын төлбөрт орчихсон ч хүмүүс ч байна. Тэгэхээр энэ дээр бол тэр машиныг чинь үнэмлэх авсан жолооч, эрүүл жолооч жолоодоод явж байгаа. Хэрвээ тэрний оронд мал биш зам дээр эвдрээд зогсчихсон мотоцикл, машинтай явган хүн байвал тэгээд 20 цаг өнгөрсөн гээд бас нөгөө талын буруу болоод явчих уу? Энэ дээр нэг бас энэ Замын цагдаагийн газрынхнаас бас хариулт авмаар байна.

Дээрээс нь энэ замууд дээр энэ нөгөө Дарханы зам хэдэн жил болж байж бид нар хийлээ одоо болтол ажил нь дуусаагүй яваад л байна. Тэгэхээр энэ дээр нэг харагдаж байгаа юм тэр замын аваар осол гарахаас хязгаарласан тэр хашлагууд стандартыг нь ер нь байна уу? Бүр ингээд бараг километр тутамд

ингээд эвдэрчихсэн, тасарчихсан ийм л хашлагууд байгаад байна. Энэ дээр нэг хариулт өгчих хүн байвал хариулаад өгөөч.

Эцэст нь Төв аймгийн Сүмбэр сумын тэр салдаг төв замаас салдгаасаа өгсүүлээд 10 гаран километр зам энэ ерөөсөө зам гэхэд зам биш бүр там болчихсон. Тэгээд энэ дээр замын энэ төсөвтэй холбоотой асуудал чинь улсын төсөв дээр байдаг хөгжлийн хөтөлбөрт оруулахаар дэмждэггүй. Одоо тэрийг ер нь бас яах ёстой юм бэ? Энэ дээр бас ажлын хэсгээс мэдэж байгаа хүн байвал нэмэлт хариулт өгөөч ээ гэдэг ийм асуултуудыг асууя.

С.Бямбацогт: Уянгахишиг гишүүн, ажлын хэсгийн ахлагч хариулъя.

Г.Уянгахишиг: Энэ дээр бол яг манай ажлын хэсэгтэй буюу өнөөдөр хэлэлцэж байгаа асуудалтай холбоотой асуултад нь хариулъя. Тэгэхээр яг саяын хэлсэнчлэн энэ замын стандартууд бол маш тодорхой тусгагдчихсан байдаг. Энэ талаар манай ажлын хэсгээс бол нарийн дэлгэрэнгүй стандартуудын мэдээллүүдийг бол нэмж өгье.

Хамгийн гол нь яг нийслэлд байгаа явган хүний зам, дугуйн зам, дугуйн эгнээ ерөөсөө стандартаа бариагүйдээ л гол нь байгаад байгаа юм. Тэгэхээр нөгөө зам хийж байх үед жишээлбэл автомашины өргөтгөх боломжгүй байгаа тохиолдолд явган хүний замаа өргөтгөх, явган хүний зам дээр дугуйн зам, явган хүний зам 2-ыг тодорхой тусгаарлагчаар ялгах, үүгээрээ аюулгүй байдлыг нь хангах энэ бүх боломжуудыг хийх буюу бүр үүрэгтэй байгаад байгаа юм. Ингээд стандартаа хангах. Тэгэхээр энийг бол маш юу хугацаатайгаар үүрэг болгоод тэгээд хариуцлагатайгаар энэ талаар дараа нь энэ бол бид нарын нөгөө өдөр тутмын алхам тутамд тохиолдож байгаа зүйл учраас ямар ч байсан хэрэгжилтийг нь хангуулаад явах дээр бол иргэд болон бүх л хотын иргэд анхаарлаа хандуулаад явчих байх гэж харж байна.

Дараагийн асуултуудын хувьд болохоор яг ажлын хэсэг дээр бол энэ асуудлыг хариуцсан хүн байхгүй байгаа. Тэгэхээр одоо ажлын хэсгээс тодорхой хэмжээний өөрсдийн боломжоороо хариулна. Гэхдээ энэ дээр бол яг тэр хариултыг өгч байгаа хүмүүс дээр бол би яг шууд 100 хувь нөгөө хариуцлага хүлээж хариулт өгөхгүй, өгөх үүрэггүй гэдгийг нь би бас тэмдэглээд хэлчихмээр байгаа юм.

Яагаад гэхээр яг нөгөө хэлэлцэж байгаа асуудалтай холбоотойгоор хариуцах албан тушаалтан, ажилтан, албан тушаалтнуудыг мэргэжилтнүүдийг дуудсан байгаа. Тэгэхээр бид нар бол нөгөө хурдны замын тухайд ч гэдэг юм уу, орон нутгийн замын тухайд ч гэдэг юм уу тэр зохицуулалтууд энэ хууль хөндөгдөөгүй учраас энэ талаар бол бас нарийн тодорхой мэдээлэл өгөх бас үүрэггүй байгаа болохоор бас ажлын хэсгийнхнийхээ өмнөөс энэ тайлбарыг хэлчихье.

С.Бямбацогт: Ажлын хэсэг хариулъя 4 дүгээр микрофон индрийн. Энхболд хариулъя.

А.Энхболд: Зам, тээврийн яамны замын хөдөлгөөний аюулгүй байдлын мэргэжилтэн Энхболд байна. Тэгэхлээр аливаа улс хурдыг тодорхойлохын тулд 3 асуудлыг нэн даруй тооцож үздэг.

1 дүгээрт нь замын хөдөлгөөнд оролцогчдын мэдлэг, хандлагын эрсдэлийн үнэлгээ.

2 дугаарт нь тээврийн хэрэгслийг зөрж өнгөрөх аюулгүй байдлын хангах хажуугийн зай.

3 дугаарт нь бол нөгөө мөргөлдөх үеийн аюулгүй хурд гэдэг ийм юмыг тооцоолдог. Тэгэхлээр энэ 19 онд бол Азийн хөгжлийн банкны судлаачид үзээд бол манай Монгол улсын замын хөдөлгөөнд оролцогчдын мэдлэг, хандлагын эрсдэлийн үнэлгээ бол орон нутгийн замд бол 70км цагийн хурдтай явахад бол бололцоотой байна гэж ийм үнэлгээ өгсөн юм. Тэгээд энэ бол яадаг вэ гэхлээр энэ замын хөдөлгөөнд оролцогчдын хувьд бол зарим хүмүүсийн хувьд бол чадвартай байж болно, мэдлэгтэй байж болно. Ерөнхийдөө массын хувьд бол нэг ийм хурдтай явахад бололцоотой байна гэсэн ийм дүгнэлт өгсөн.

2 дугаарт нь бол тэгээд хамгийн гол асуудал нь бол 2 тээврийн хэрэгсэл мөргөлдөхөд.../минут дуусав./

С.Бямбацогт: Хариулт нэмж өгье. Хариултаа гүйцээчихье.

А.Энхболд: Кинетик энергийн үйлчлэл гэж юм байдаг. Тэгэхлээр орон нутгийн замд 2 тээврийн хэрэгсэл мөргөлдөхөд бол хүн алахгүй байх ийм хурд нь бол ерөөсөө 80км цагийн хурд гэдэг юм чинь тэгээд энэнээс дээш хурдтай явах юм бол хүн үхэх магадлал нь бол 100 хувьтай л байна л гэж гэж байгаа юм. Тэгэхлээр энэ орон нутгийн замын хурд, энэ суурин газрын хөдөлгөөний хурдыг бол заавал ингэж тооцоолдог.

2 дугаарт нь бол энэ скутертэй холбоотой л ярихад бол энэ явган зорчигч замын хөдөлгөөний явган хүний замаар явахад бол скутертэй хүнтэй мөргөлдөхөд бол 10км цаг тэгээд хурдтай скутертэй мөргөлдөхөд бол ү нөгөө 10 настай хүүхдийн үхэлд хүргэх магадлал бол 85 хувьтай байна гэж үздэг байхгүй юу. Тэгэхлээр энэ хуулийн төсөл дээр бол ерөөсөө скутерийг зорчих хэсгээр явуулна, явган хүний замаар явуулахгүй гэдэг ийм хуулийн төсөл байгаа. Туваан гишүүн тодруулж асууя.

Ц.Туваан: Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудал хэлэлцэж байгаа учраас л бас нэгэнт ажлын хэсэг ороод ирчихсэн байгаа учраас тодруулаад байгаа. Тэгэхээр энэ зам дээр мал дайрагдах асуудал дээр энэ цагдаагаас хүн байгаа билүү? Сая хэлж байсан ажлын хэсэг цагдаагаас хүн байна уу? Байхгүй юу? Сая харин зарласан байхгүй юу даа. Тэгээд энэ чинь замын хөдөлгөөний яг.

С.Бямбацогт: Хэлэлцэх асуудалтай л холбоотой асуулт асууна л даа. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулж асуултаа.

Ц.Туваан: Тэгвэл энэ Зам, тээврийн яам байгаа дээр түрүүний асуулт дээр нэг юм гүйцээгээд хэлчихье. Тэр юуны Сүмбэрийн замыг та нэмээд хариулчхаач. Төв аймгийн Сүмбэр сумын замыг Зам, тээврийн яамныхан байгаа учраас.

С.Бямбацогт: Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдолгүй байна. Хариулах боломжгүй.

Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Чинбатын Ундрамын урилгаар Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын 1 дүгээр цэцэрлэгийн багш, ажилчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Өглөөнөөс үдэш хүртэл олон бяцхан үрсийн аав, ээж нь болж ажилладаг та бүхэндээ Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс баяр хүргэж, ажилд нь амжилт, амьдралд нь эрүүл энх, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Пүрэвийн Батчимэг гишүүн асуултаа асууя.

П.Батчимэг: Та бүхэнд энэ өглөөний мэндийг хүргэе. Өнөөдрийн чуулганаар энэ Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл өргөн мэдүүлсэн хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг гишүүд маань хэлэлцэж байна. Үнэхээр энэ өнөөдөр энэ сурон, скүүтер, мопед энэ орчин үеийн бичил цахилгаан тээврийн хэрэгсэл нь зөвхөн Монголд төдийгүй, нийслэл хотод төдийгүй дэлхийн олон улс орнуудад маш их түгээн дэлгэрч, хэрэглээ нь бол өдрөөс өдөрт ихсэж байгаа юм.

Манай улсад 2019 он цар тахал КОВИД-ын дараагаас эхэлж бичил цахилгаан тээврийн хэрэгсэл бол өргөн хэрэглэгдэх болсон. Үнэхээр замын хөдөлгөөнд оролцож замын хөдөлгөөний аюулгүй байдлын замын хөдөлгөөний дүрмээр зохицуулагдах аргагүй байдал үүссэн учраас энэ хэрэглээ нь өдрөөс өдөрт нэмэгдэж, түүнийг дагасан муу үр дагаврууд бий болж, осол, гэмтэл иргэд маань олон тоогоор гэмтэх ийм сөрөг үр дагаврууд үүссэн учраас миний бие энэ хуулийг 2024 оны 09 дүгээр сарын 06-нд Улсын Их Хурлын даргын 76 дугаар захирамжаар ажлын хэсэгт орж ахалж ажиллаж өнөөдөр энэ хууль эцсийн шатандаа эцсийн хэлэлцүүлэгтээ орж жил хагасын нүүрийг үзэж байгаа юм.

Мэдээж аливаа нэгэн хууль бүрэн төгс тийм хууль гэж бол ер нь бараг байхгүй л дээ. Тийм учраас энэ хуулийн төслийг анх өргөн барьж, ажлын хэсгийг ахалж байх явцад бас нэлээд хүндрэл, бас эсэргүүцэл ийм юмтай бол тулгарч байсан. Төрийн захиргааны төв байгууллага, Хууль зүйн, хууль зүйн яам, Зам, тээврийн яам, нийслэлийн удирдлагууд, Тээврийн цагдаагийн алба тухайн үед бол ер нь дэмжих талд, хуулийн төслийг дэмжих талд бол нэлээн сул ажилласан гэдгийг би бас өнөөдөр хууль санаачлагчийн зүгээс энд бас онцлон тэмдэглэхийг хүсэж байна.

Магадгүй энэ сурон, скутер, мопедын энэ хуулийг өргөн барьж хэрэгжүүлэх шатад Нийслэлийн Засаг дарга, энэ Хууль зүй, дотоод хэргийн яам, энэ Зам, тээврийн яам, энэ Тээврийн цагдаагийн алба тэднийг бол үүрэгжүүлэх ийм юунд хүрч байгаа. Замын бүтэц муу, нийслэл хот угаасаа төлөвлөлт муу, явган хүний зам өнөөдөр ямар хэцүү байдалтай байдаг вэ? Энийг дагасан энэ сурон, скутерийн хэрэглээ нэмэгдээд цаашид бүүр хэдэн мянгаараа ингээд нэмэгдэх ийм

хандлагатай болчихсон. Энийг засварлах, энэ замын асуудлыг шийдэх, төсвийг нь батлах, энэ замтай болгох асуудлыг хууль батлагдсан цагаас эхлүүлэн нэхэж шаардаж ажиллах болно гэдгийг бас энд хэлэхийг хүсэж байна.

Бичил цахилгаан тээврийн хэрэгсэл сурон, скутер өнөөдөр энэ залуус иргэдийн нэн чухал тээврийн хэрэгсэл болчихсон. Маш олон давуу талууд байгаа. Энэ нийслэл хотын агаарын бохирдлыг бууруулах, нийслэл хотын замын түгжрэлийг бууруулах, иргэд, залуучуудын ажилдаа, сургуульдаа цагтаа яваад оччих тэр цагийг хэмнэх, эдийн засаг, санхүүгийн өрх гэр бүл, хувь хүнд эдийн засаг санхүүгийн хувьд хүртэл түлхэц өгөх, нэмэр өгөх ийм тээврийн хэрэгсэл болж хөгжсөн. Ямар нэгэн энэ тээврийн хэрэгслийг сурон, скүүтер энэ мопедыг өнөөдөр замын хөдөлгөөнд оролцуулахыг болиоч ээ.../минут дуусав./

С.Бямбацогт: Асуултаа гүйцээгээд асуучихъя.

П.Батчимэг: Хориглооч ээ, бүрмөсөн замын хөдөлгөөнөөс хасаач гэсэн иргэдийн санал, гомдол маш их ирдэг. Алив энэ тал дээр бол хориглох, торгох энэ арга хэмжээнээсээ илүүтэй бид нар энэ хэрэглээг яаж нэмэгдүүлэх юм? Яаж замын хөдөлгөөнд соёлтой зөв оролцуулах юм. Энэ тал дээр энэ хуулийн төслийн гол үндсэн санаа явж байгаа. Нийгэмд тулгамдчихсан нийгэмд нэн хэрэгцээтэй шаардлага бий болсон учраас энэ хуулийн төслийг өнөөдөр манай эрхэм гишүүд баталж өгнө гэдэгт итгэлтэй байна.

Ер нь хууль санаачлагчийн зүгээс ажлын хэсэгт хандаж хэлэхэд анхны хуулийн төслийн яг хэдэн хувь өнөөдөр энэ хуулийн төсөлд тусгагдаж чадсан бэ? Хувьчлаад үзвэл ер нь яг хэдэн хувь нь орсон бол?

С.Бямбацогт: Ажлын хэсэг санаачилсан хуулийн маань хэдэн хувь нь үлдээд хэдэн хувь нь өөрчлөгдчихөв гэж ас асууж байна? Бэлдэж байгаарай. Ганбатын Хосбаяр гишүүн асуултаа асууя.

Г.Хосбаяр: Та бүхэнд өглөөний мэнд хүргэе. Орчин үеийн энэ том хотуудад байдаг энэ цахилгаан дугуй, скутер, мопед гээд энэ бас хүүхэд залуусын чухал хэрэгцээ, мөн нийгэм энэ хотын хөгжилд чухал ач холбогдолтой ийм зүйл л дээ. Тэгээд одоо энэ хуулийн төслийг харж байхад бас нэг ёсондоо таалагдахгүй зүйлүүд байна.

1 дүгээрт нь нийслэл Улаанбаатар хот энэ яг стандартын зам, талбайтай болох асуудал дээр ер нь сүүлийн жилүүдэд ямар хөрөнгө оруулалт хийсэн бэ? Цаашдаа ер нь хэр хөрөнгө оруулалт хийж, энэ яг хүүхэд, залууст хэрэгтэй энэ зүйл дээр ямар хөрөнгө оруулалт хийх вэ гэдгийг асууя.

Хуулийн төслийг боловсруулсан энэ ажлын хэсгээс асуух асуултууд байна л даа. Жишээлбэл, би өөрөө бас мопед, скутер унадаг хүн мэднэ л дээ. Одоо бол скутерийн хурд 20км цаг байгаа. Гэтэл одоо хууль батлагдсанаар 10 болчих юм байна. Тэгэхээр чинь энэ чинь бараг явган хүн алхаж байгаатай адилхан шахуу болох гэж байна. Ийм болгоод олон улсын стандарт, энэ хүүхэд залуус энэ хүмүүсийн хэрэгцээ шаардлагад нийцэж байгаа юу?

Мөн хуулийн төсөл өөрчлөгдсөнөөр бас явган хүний гарцаар унаж гарч болохгүй болчхож байгаа юм байна. Энэ өнөөдөр байгаа скүүтер чинь өөрөө унадаг дугуй шиг зүв зүгээр түрээд яваад байдаг зүйл биш шүү дээ. Энэ чинь өөрөө заавал тэр хаазыг нь өгч байж явдаг. Тэгэхээр чинь унадаг дугуй замын явган гарцаар түрээд гарч байгаа юм шиг ингэж түрж гарах техникийн боломж бол байхгүй гэж харж байгаа шүү дээ. Тэгэхээр явган хүний зам дээр явахаараа, явган хүний гарцаар гарахаараа яаж скүүтрээ түрж явах юм бэ?

Дээр нь бас авто зам, хэрвээ явган зориулалтын зам байхгүй бол авто замын хажуу хөвөөгөөр явна гэж байна. Өнөөдөр манай энэ гол гол гудамжнууд Улаанбаатарын замын чинь хажуу хөвөөгөөр тийм скутер явах, мопед явах зам байхгүй байгаа шүү дээ. Тэгэхээр энэ юмнууд дээр энэ замын стандартууд дээр нь ер нь яаж анхаарч санал авч ажилласан юм бэ? Нийслэлээс санал авсан юм уу? Энэ Эдийн засгийн хөгжлийн яам, мөн энэ цагдаа магдаагаасаа санал авч яг энэ дээр нэгдсэн ойлголцолд хүрсэн юм уу?

Ер нь энэ хуулийн төсөл батлагдахад бол миний харж байгаагаар насны хязгаар нь дээшилчхэж байна, дахиад замын стандартууд тавьчихаж байна, явган гарцаар унаж гарч болохгүй гэж байна, хурдны хязгаарыг нь доошлуулчихаж байна ингэхтэйгээ зэрэг чинь ний нуугүй хэлэхэд бараг энэ нэг скутер битгий уна шахуу бол хориглож байгаа шахуу л ийм зүйл болчхож байгаа юм биш үү? Энэ чинь өнөөдөр хүүхэд залуус, энэ хүн ам, хотынхон чинь маш их өргөн хэрэглэж байгаа ийм унаа шүү дээ. Үүгээр чинь бас зөвхөн унаж нэг газраас нөгөөд хүрэхээс гадна бас л карго, хүргэлтийн үйлчилгээнүүд үүгээр бас дамжиж явж байна гэх жишээний. Зарим хүүхэд багачууд, ахлах ангийнхан сургуульдаа явж байна, ажлаа амжуулж байна.

Мөн том хүмүүс ч гэсэндээ зөндөө л олон ажил төрлөө амжуулаад ингээд явж байна. Тэгээд энэ болгоныг чинь ингээд хурдыг нь багасгаад, замын стандартыг нь тавиад ингээд бүүр л нэг ийм хориглосон юм болчхож байгаа юм биш үү? Энэ дээр ажлын хэсэг ер нь ямар байр суурьтай байна аа?

С.Бямбацогт: Ажлын хэсэг Уянгахишиг гишүүн хариулах уу? Түрүүний Батчимэг гишүүний бас асуултад нэмээд хариулчхаарай.

Г.Уянгахишиг: Хосбаяр гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр ер нь бол бид нарт үндсэндээ 3 сонголт л байгаа. Юу гэхээр явган хүний замаараа явдгаараа буюу яг одоогийн байгаагаараа үлдээгээд нөгөө явган хүний зам дээр гарч байгаа гэмтэл хэвээрээ үлдэнэ.

2 дахь нь бол ерөөсөө тэр чигээр нь хориглох буюу Монгол, Улаанбаатар хот өөрөө дугуйн зам, дугуйн эгнээтэй болох хүртэл ерөөсөө л скүүтер явахыг хориглох.

3 дахь хувилбар бил буюу өнөөдрийн хуулиар бий болгож байгаа хувилбар нөхцөл байдал юу вэ гэхээр дугуйн замтай замаараа дугуйн эгнээгээрээ яв аа. Хэрвээ дугуйн зам, дугуйн эгнээ байхгүй бол явган хүний замаараа түрээд явж болж байна. Эсвэл авто замынхаа баруун хөвөөгөөр явж болж байна гэдэг ийм л сонголтыг өгч байгаа гэсэн үг. Тэгэхээр өнөөдөр энэ хуулиа бид нар батлахгүй бол одоо байгаа нөхцөл байдал яг хэвээрээ үлдэх буюу нөгөө явган хүний зам дээр

гараад байгаа гэмтэл, ослууд чинь байдгаараа байна. Нөгөө бага насны хүүхдүүд явган хүний замаар явж чадахгүй тэр нөхцөл байдал яг л хэвээрээ үлдэнэ гэсэн үг.

2 дугаарт яг энэ Батчимэг гишүүний асуултад хариулахад яг ингээд бичилтээсээ харах юм бол ер нь бол 50 хувь нь өөрчлөгдсөн. Гэхдээ яг энэ 50 хувийн өөрчлөлт дээр ихэнх зүйл нь юу байна вэ гэхээр замын хөдөлгөөний дүрэм дээр байгаа болон Зөрчлийн хууль дээр байгаа давхардсан заалтуудыг яг тухай тухайн зохицуулалтаар нь явуулах байдлаар өөрчилж найруулсан гэсэн үг. Тэгэхээр яг тэр нөгөө замын хөдөлгөөний дүрэмтэй давхацсан заалтууд хасагдса. Зөрчлийн хууль дээр бас давхацсан заалтууд хасагдсан гэсэн үг. Үндсэндээ агуулгын хувьд бол 3 том өөрчлөлт орсон.

Энэ нь юу вэ гэхээр 1 дүгээрт хуулийн төсөл бол зөвшөөрөл авах, цахилгаан скутерийн түрээс эрхэлж байгаа субъектүүд Зөвшөөрлийн хуулийн дагуу зөвшөөрөл авахаар орж ирсэн. Үүнийг бол бүртгэлээр буюу бүх скутерийг бүртгэлжүүлэх, нийслэлтэй гэрээ байгуулах энэ зарчмаар оруулж ирэхээр зохицуулалт өөрчлөлт оруулсан. Яагаад гэх юм бол ер нь бол Зөвшөөрлийн хуулиараа явна гэх юм бол нөгөө Зөвшөөрлийн зөвлөлийн дүгнэлт өөрөө бас байх ёстой. Зөвшөөрөл дээр бас нөгөө дагасан нөхцөлүүдийг нь бас тусгах ёстой гэдэг ийм асуудал үүсэж байсан учраас ер нь бол бүртгэлжүүлээд явах нь энэ шаардлагыг бол хангачих юм байна, гол зориод байгаа зорилгыг бол биелүүлчих юм байн. Үзэл баримтлалын хувьд бол хангалттай өөрчлөгдөхгүй юм байна гэдгийг хууль санаачлагчтай зөвлөлдөөд санал нэгдсэн байгаа.

2 дугаарт бол явган хүний замаар бага хурдтай явна гэдэг заалтыг явган хүний замаар огт явж болохгүй гэж өөрчилсөн. Яагаад гэхээр явган хүний замаар тэр бага хурдыг тохируулах, хянах боломж нь техникийн хувьд байхгүй байгаад байгаа. Тэгэхээр энэ дээр бол ажлын хэсэгт бид нар мэргэжилтнүүд болон нэмээд цаг нэмээд авчихъя.

С.Бямбацогт: Асуултаа, хариултаа дуусгая Уянгахишиг гишүүн.

Г.Уянгахишиг: Тэгэхээр яг явган хүний замаар хурдны хязгаарыг тавих техникийн хязгаарлах тэр боломж байхгүй, мөн хяналт тавих боломж байхгүй учраас энийг бол явган хүний зам дээр явуулахгүй байсан нь зүйтэй юм байна гэдэг дээр мөн хууль санаачлагчтай санал нэгдсэн.

3 дугаар хамгийн том бас нэг өөр том өөрчлөлт бол насны хязгаарыг 18 болгосон. Өөрөөр хэлэх юм бол бид нар өнөөдрийн байгаа замын аюулгүй байдлын нөхцөл байдлаа харахад яг тухайн 16-аас 18 насны хүүхэд буюу насанд хүрээгүй хүнийг авто замаар явуулах тэр аюулгүй байдал хангагдаагүй гэж үзэж байгаа учраас тэр дугуйн зам хангалттай болтол ямар ч байсан 18 наснаас дээш иргэн энэ цахилгаан скүүтер, мопедыг унаж авто замын хөдөлгөөнд оролцоно гэдэг энэ насны хязгаарыг дээшлүүлж өгсөн байгаа.

Дараагийн өөрчлөлт бол Зөрчлийн хуулиар зохицуулж байсан торгуулийн хэмжээнүүд дээр бол өөрчлөлтүүд оруулсан байгаа.

С.Бямбацогт: Зочин танилцуулъя. Монгол Улсын Консерваторын 1996 оны төгсөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та

бүгдийнхээ ажилд нь амжилт, амьдралд нь эрүүл энх сайн сайхан бүхнийг Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс хүсэн ерөөе.

Хосбаяр гишүүн тодруулж асууя.

Г.Хосбаяр: Энэ хуулийн төслийг бол дэмжиж байгаа. Энэ ийм ингэж өөрчлөлт оруулж энэ хуулийг өөрчлөх цаг нь болчихсон байгаа юм зүгээр. Гол нь яг мэдээж өнөөдөр бодит амьдрал дээр явган хүний замаар явж байгаа иргэдэд бол мопедтой, дугуйтай, скүүтертэй хүмүүс сүлжээд давхиад байх хэцүү байгаа. Тэрийг бас ойлгож байна.

Гэхдээ өнөөдөр бидний байгаа ажил амьдрал чинь өнөөдөр яг зориулалтын зам байхгүй, явган хүний замаар явахаас өөр аргагүй ийм л нөхцөлтэй байгаа шүү дээ. Тэгээд энэ дээрээ бас зарим зүйл, заалт нь болохгүй байна гэдгийг л хэлээд байна л даа.

Жишээлбэл, хурдыг бол хэт багасгасан байна. Өнөөдөр 20км цагийг 2 дахин бууруулаад 10км цаг болгочхож байна. Дээр нь дахиад машинтайгаа холилдоод яв, яг замынхаа баруун хөвөөгөөр яв гэж ингэж бол ийм боломж бол байхгүй байгаа. Дээр нь тэр явган хүний замаар юм уу, замын гарцаар, явган хүний гарцаар зам хөндлөн гарахдаа скутерээ түрж гарна гээд байх юм. Энэ ажлын хэсэгт чинь яг скутер унаж байсан хүн байсан юм уу? Скутер чинь тэгж.../минут дуусав./

С.Бямбацогт: Хариулъя. Ажлын хэсэг.

Г.Уянгахишиг: Нэмэлт асуултад хариулт өгье. Тэгэхээр яг энэ ажлын хэсэгт бол скүүтерийн түрээсийн үйл ажиллагаа эрхэлж байгаа компаниуд, мөн түүнчлэн цагдаагийн газар, прокурор, яг энэ стандартыг хангуул, Хууль зүйн яам гээд төлөөллүүд бол оролцсон. Тэгээд үүн дээр бол яригдаад энэ тухайн асуудлууд бол зохицуулагдаад явж болно гэдэг ийм хариултуудыг өгсөн.

Өөрөөр хэлэх юм бол мопед ч гэсэн түрээд гарах ёстой. Хэрвээ зам хөндлөн цагаан шугамаар гарах юм бол. Энэ чинь өөрөө замын цагаан шугамаар түрээд гарах эсвэл яг нөгөө зүүн эргэлтийнхээ дагуу автомашинтай хамтараад явах ийм боломжууд нь байгаа. Угаасаа явган хүний замаар явахаа больчихоор тэр цагаан шугамаар гарах гэдэг биш тэр дугуйныхаа замынхаа л дүрмийг баримтлаад явах ёстой шүү дээ.

С.Бямбацогт: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Зарчмын зөрүүтэй 2 санал байна. Санал хураалтын ирц. Тэгэх үү? Санал хураалтуудаа нэгтгээд 16 цагаас явуулчихъя. Санал хураалтуудаа. Дараагийн асуудалдаа оръё.

11.03 цаг.

“Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Сүхбаатарын Эрдэнэболд танилцуулна. Таныг индэрт урьж байна.

Хууль зүйн байнгын хороо зохион байгуулалтаа хийнэ үү. Эрдэнэболд гишүүн алга. Хэн танилцуулах вэ? Байнгын хорооны ажлын алба энэ бас хуралдаан зохион байгуулах энэ бэлтгэлээ хангаж бай л даа. Зохион байгуулалтаа. Улсын Их Хурлын гишүүн Пүрэвжавын Сайнзориг Байнгын хорооны санал, дүгнэлтийг танилцуулна.

С.Сайнзориг: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн П.Батчимэг нарын 9 гишүүнээс 2025 оны 07 дугаар сарын 03-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2026 оны 05 дугаар сарын 28, 29-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Байнгын хороо 2026 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн хуралдаанаараа уг асуудлыг хэлэлцсэн бөгөөд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.5 дахь хэсэгт заасны дагуу ажлын хэсгээс боловсруулсан “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж, дараах санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулж байна. Үүнд:

1.Хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр холбогдох хууль тогтоомж, Монгол Улсын замын хөдөлгөөний дүрэм, мопед, түүний төрөлд хамаарах скүүтер болон тэдгээртэй адилтгах тээврийн хэрэгслийг бүртгэлжүүлэх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож холбогдох журмыг шинэчлэн батлах;

2.Замын хөдөлгөөний аюулгүй байдлын талаарх олон нийтийн мэдээллийг нэмэгдүүлэх, мэдлэгийг нэмэгдүүлэх, хэрэглээний зөв соёлыг төлөвшүүлэх чиглэлээр сургалт, мэдээллийн ажлыг зохион байгуулах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар, мөн Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчид үүрэг болгох зэрэг асуудлыг тусгасан болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.24 дэх хэсэгт заасны дагуу тогтоолын төслийн талаар зарчмын зөрүүтэй саналын томьёолол гараагүй тул анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын саналыг Байнгын хороонд хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 52.6 хувиар дэмжсэн болно.

“Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл болон Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын гишүүд ээ,

“Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх талаар Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсан явдалд баярлалаа.

С.Бямбацогт: Сайнзориг гишүүнд баярлалаа. Ажлын хэсэг түрүүний ажлын хэсэг хэвээрээ байгаа.

Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилсан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна.

Батын Батбаатар гишүүн асуултаа асууя. Алга байна. Пүрэвийн Батчимэг гишүүн асуучихсан уу? Татгалзсан, нэрээ татлаа. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Санал хураалтыг 16 цагаас нэгтгээд явуулна. 16. Дараагийн асуудалдаа оръё.

11.07 цаг.

“Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Ренчиндоржийн Батболд танилцуулна. Таныг индэрт урьж байна.

Р.Батболд: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн Б.Пунсалмаа нарын 13 гишүүнээс 2026 оны 05 дугаар сарын 07-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2026 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн.

Төсвийн байнгын хороо 2026 оны 06 дугаар сарын 4-ний өдрийн хуралдаанаараа дээрх тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу явууллаа.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт аваагүй болно.

Нэгдсэн хуралдаанаар “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед хуралдаан даргалагчаас тухайн зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулахгүйгээр уг асуудлыг гүйцээн боловсруулах чиглэл өгсний дагуу Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалтад заасныг баримтлан зарчмын зөрүүтэй 3 саналын томьёоллоор санал хураалт явууллаа.

Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналуудыг тогтоолын төсөлд төсөлд нэмж тусган эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл болон Төсвийн байнгын хорооны танилцуулгыг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл Төсвийн байнгын хорооны танилцуулга болон зарчмын зөрүүтэй саналын томьёоллуудыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

С.Бямбацогт: Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя. Жамъяншаравын Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Батболдын Мөнхтөр Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Барилга, барилгын материалын бодлого зохицуулалтын газрын дарга, Чадраабалын Сугармаа Зам, тээврийн яамны Авто замын бодлого зохицуулалтын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, Далхаагийн Оюунболд “Зам тээврийн хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал, Эрдэнэбаярын Балт “Зам тээврийн хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын Бодлогын хэрэгжилт, зураг төслийн магадлал, стандарт, норм, нормативын хэлтсийн дарга, Ганхуягийн Мөнхболд “Барилгын хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын Барилга байгууламж зураг төсөл магадлал зохион байгуулалтын хэлтсийн дарга, Дашзэвэгийн Батням Барилга байгууламж, техникийн захиалагчийн хяналтын хэлтсийн дарга.

Улсын Их Хурлын тухай хуулийн 21.24 дэх нэгдсэн хуралдаанд мэдээлэл хийж байгаа ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орсон холбогдох албан тушаалтан үнэн зөв, бүрэн гүйцэт мэдээлэх үүрэгтэй. Худлаа мэдээлэл өгөх, гишүүдийн асуултад хариулахаас татгалзах, Улсын Их Хуралд хүндэтгэлгүй хандах зэрэг үйлдэл гаргах юм бол төрийн албаны болон бусад хууль тогтоомжийн дагуу бас арга хэмжээ авдгийг та бүхэнд хариуцлага тооцохыг бас сануулъя. Тийм болохоор Улсын Их Хурлын үйл ажиллагаанд хүндэтгэлтэй хандахыг та бүхнээс хүсье.

Зочин танилцуулъя. Танилцуулга нь ирээгүй байна. Отгоны Саранчулуун гишүүн асуултаа асууя.

О.Саранчулуун: Сайн байцгаана уу? Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх арга хэмжээн дээр Төсвийн хуульд тусгаж санхүүжүүлсэн мөртөө жилээс жилд хуваагдаж, санхүүжилт, санхүүжилт ороод байгаатай холбоотойгоор энийг нь цэгцлэх ийм агуулгатай хууль орж ирж байгаа юм байна гэж ингэж энгийнээр бол ойлгож байгаа.

Надад нэг тодруулах асуулт байгаа юм. Тэр нь болохоор улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр Төсвийн хуульд тусгаж баталсан хууль, арга хэмжээний төсөвт өртөг нэмэгдэж байгаа асуудлаар “Засгийн газарт чиглэл өгөх тухай” энэ тогтоол өөрөө энэ нөгөө урьдчилсан байдлаар нь судалгаа хийсэн байна. Энэ судалаан дээр. Энэ судалгаан дотор нь болохоор барилга угсралтын ажил болон захиалагч гүйцэтгэгч компаниудын явцын хяналт, дотоод зохион байгуулалт хангалтгүйн улмаас Улсын комисс хүлээж авахад зөрчил, доголдол илэрч акт тавихад түүнийгээ засаж хүлээлгэж өгч чадаагүйн улмаас төсөл зогсоосон байдлууд аудитын дүгнэлтээс харагджээ гэж дүгнэсэн байна.

Барилга байгууламжийн төсөлд тавигддаг норм, стандартыг хангадаггүй учраас Улсын комисст хүлээлгэн өгөх боломжгүй зогссон талаар аудитын дүгнэлтээс харж болно гэж дүгнэсэн байгаа юм. Тус тус ер нь бол дүгнэлтүүдийг нь харахаар. Тэгвэл энэ дээр миний нөгөө тодруулах гээд байгаа зүйл нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлж байгаа барилга байгууламж бүхий төсөл, арга хэмжээ хугацаандаа орохгүй саатаж байгаа, мөн анх батлагдсан төсөвт өртөг нь өөрчлөгдөж байгаа шалтгааныг судлаад ямар арга хэмжээ авахыг тусгаад оруулж ирэх ёстой юм шиг байгаа юм.

Жишээлбэл ингээд шалтгааныг нь бид нар ойлгочихлоо шүү дээ ийм ийм шалтгаанаас энэ барилга хоцорч байгаа юм байна, хойшлогдож байгаа юм байна гэдэг ч юм уу ийм асуудал гарвал энэ шалтгаан нь тодорхойлчихсон бол энийг нь яаж шийдэх юм бэ гэдэг арга хэмжээг би хараад эндээс хайгаад байгаа байхгүй юу. Тэгэхээр жишээлбэл тухайн гүйцэтгэгчийг солих, тухайн жилд багтааж дуусгаж өгч зэрэг арга хэмжээнүүдийг илүү тусгах юм уу яг ямар арга хэмжээ авч байж энэ тулгамдаад байгаа асуудлаа шийдвэрлэх юм бол гэдэг тэр процедурыг нь би тодруулмаар байгаа юм.

С.Бямбацогт: Хэн хариулах вэ? Ажлын хэсэг хариулъя. Пунсалмаа гишүүн. Хууль санаачлагч хариулъя.

Б.Пунсалмаа: Баярлалаа. Одоо бол энэ тогтоолын төслийн 3 дахь хэлэлцүүлэг нь орж байгаа юм. Энэ хэлэлцүүлэг, энэ тогтоолын төсөл батлагдсаны дараа Засгийн газар бол энэ асуудлын хүрээнд царцсан, гацсан, үр ашиггүй болсон нийт төслүүдийн нэгдсэн жагсаалтыг гаргаж өгөх юм. Тэгээд энэ жагсаалтад орсон бүх төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн асуудал, газрын, гэрээний хэрэгжилт, гүйцэтгэлийн хариуцлага, ямар асуудал үүссэн байгааг нь тухайн төсөл тус бүрээр нь тодорхой болгож ирээд энэ талаараа бол Улсын Их Хуралд бол санал, дүгнэлтийг хүргүүлэх юм. Энэ Улсын Их Хуралд хүргүүлж байгаа санал, дүгнэлт нь 2026 оны 09 сарын 15 буюу 2027 оны улсын төсөв өргөн баригдах үед энэ санал, дүгнэлтийг хүргүүлэх юм. Энэ саналыг бүгдийг нь Улсын Их Хурлын гишүүд хүлээж аваад парламентаараа нээлттэй хэлэлцүүлээд аль төслүүдийг төрийн өмчлөлд хэвээр нь үлдээж, төсвийн гүйцэтгэл, санхүүжилтийг хэрэгжүүлэх вэ, аль төслүүдийг өмчлөлийн өөр хэлбэрт

шилжүүлэх вэ гэдгийг парламент өөрсдөө бид нээлттэй хэлэлцүүлж байгаад эцсийн шийдвэрийг гаргах ийм тов дараалалтай байгаа.

С.Бямбацогт: Саранчулуун гишүүн тодруулж асууя.

О.Саранчулуун: Яагаад ингэж асууж байгаа вэ гэхээр Улсын комисс хүлээж аваад ашиглалтад орсон төрийн өмчийн бүх барилга байгууламжийн 80 хувь нь өнөөдрийн байдлаар бол барилгын стандартад тусгагдсан хүртээмжийг огт биелүүлээгүй байдаг. Тэгэхээр нөгөө хүртээмжийн шаардлага гэдэг дээр жишээлбэл юу гэдэг юм лифтний хаалга тодорхой стандартын дагуу өргөн байх ёстой. Нөгөө хүн орж гардаг хаалга, налуу зам нь рампын стандартын байх ёстой. Цонх нь бариул нь тийм байх ёстой ч гэдэг юм уу барилгын наад захын хүртээмжийн асуудлуудыг хангаагүй барилга өнөөдөр Улсын комиссоор дүгнэлт гараад ингээд ашиглалтад ороод байгаа.

Нэг том сургууль, нэг арга хэмжээ боллоо. Нэг юмны нээлт гээд л очихоор үүдэнд нь налуу замаа байгаа мөртөө дотогшоо орохоор нолийнх нь хаалга нь нөгөө тэргэнцэр орох зайгүй болчихоод байдаг. Тэгэхээр энэ тогтоолын хүрээнд аль хүртэлх асуудлыг жишээлбэл татах юм бол гэдгийг би асуумаар байгаа.

С.Бямбацогт: Төсвийн байнгын хорооны дарга хариулах ёстой. Төсвийн байнгын хорооны эрхэлсэн асуудал Төсвийн байнгын хорооны даргыг дуудъя. Ажлын хэсгээс хариулчихъя. Энэ чинь 3 дахь хэлэлцүүлэг явж байгаа шүү дээ энэ чинь . Ажлын хэсэг, Байнгын хороо хариулах ёстой. Индрийн 4 дүгээр микрофон. Хэн хариулах вэ? 4 дүгээр микрофон.

Б.Мөнхтөр: Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам Мөнхтөр. Саранчулуун гишүүний асуултад хариулъя. Тэгээд ер нь бол төсөв нэмэгдэж байгаа гол үндэслэлүүдийг бол өмнөх хэлэлцүүлгийг нэлээн тодорхой хэлчихсэн байгаа. Нөгөө томсгосон төсвөөр төсөвт суулгаад явчихдаг. Тэгээд богинохон хугацаанд ер нь бол барилгын төсвийг тухай бүр нь төсөвт суулгаж явж чадахгүйгээс болоод төсөвт өртөг нэмэгдэх инфляцад идэгдэх гээд энэ бол гол үндсэн шалтгаанууд нь бол төсөв нэгж үндсэн шалтгаанууд бол ийм байгаа. Харин Саранчулуун гишүүний асуусан тэр норм нормативтай холбоотой энэ асуудлыг бол сүүлийн жилүүдэд бол ер нь зураг төсөл, магадлалд бол ерөнхийдөө норм, нормативыг бол яс бариулаад явж байгаа.

Нэг төвөгтэй асуудал байгаа нь өмнөх юу гэдэг юм 2010 оноос өмнөх ч байдаг юм уу орон сууцууд дээр ч байдаг юм уу, үйлдвэрийн барилга байгууламжууд дээр хөгжлийн бэрхшээлтэй иргэд дээр тавигдах норм, норматив бариулахад жоохон төвөгтэй байгаа. Энэ нь өөрөө нийлээд цаг хугацаа, зардал, мөнгө шаардсан асуудал байгаа. Сүүлийн жилүүд.../минут дуусав./

С.Бямбацогт: Гүйцээгээд хариулчихъя. 4 дүгээр микрофон.

Б.Мөнхтөр: Сүүлийн жилүүдэд баригдаж байгаа барилга байгууламж дээр бол норм, нормативыг бол яс мөрдүүлээд явж байгаа. Баярлалаа.

С.Бямбацогт: Зочин танилцуулъя Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Баатархүүгийн урилгаар Нийслэлийн ЧД-ийн 18, 24 дүгээр хорооны иргэд Улсын

Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Төрийн ордонтой танилцаж байгаа нийт иргэддээ Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Батын Батбаатар гишүүн асуултаа асууя. Алга байна. Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн асуултаа асууя.

С.Эрэдэнбат: Тэгээд энэ асуудал бас чухал асуудлаа тэгээд энэ аргаа бараад л ийм тогтоол гаргаж байна гэж бодож байна. Дэмжиж байгаа. Энэ барилга бариад бүүр сурчихсан нэг хэдэн компани байх шиг байна аа. Чадахгүй байж байж баахан энд тэнд ажил авдаг, тэгээд дутуу орхиод хаядаг, тэгээд төсвийг нь нэмж авна гэдэг байдлаар тавьдаг. Тэгээд энд ер нь хариуцлага тооцсон асуудал байна уу? Улсын хэмжээнд хэчнээн ч компани хэдэн ч тендерийг авдаг бүүр ингээд нэг тендер аваад сурчихсан. Энэ чинь өөрөө цаанаа бол татвар төлөгчдийн мөнгө байж байдаг. Цаана нь иргэд, олон нийтийн байгууллага олон хүмүүс бол хохирдог ийм асуудал байж байгаа. Тийм учраас энэ дээр энэ хариуцлага тооцож байгаа юм байна уу? Компания солиод л хусаад байдаг юм байна лээ. Зарим нь бол. Хар жагсаалтад оруулдаг ийм хэчнээн компани байна вэ? Хувь хүнийх нь хувьд тэр эцсийн өмчлөгчийнх нь хувьд бол дахиж тэр тендер, бараа, үйлчилгээ авахгүй болох ийм хариуцлагын асуудлыг бол давхар оруулж ирэх хэрэгтэй гэж би бодож байгаа юм. Энэ тогтоол дээр нэмэлт оруулаад.

Тухайлбал, би сая Хөвсгөл аймаг гэхэд 100 ортой хүүхдийн эмнэлэг гээд 6 жил болж байна гэж байна. Тэгээд одоо ашиглалтад оруулахын тулд яах вэ гэхээр 3 билүү 4 тэрбум гээд нэхээд суучихсан. Тэр яг юу болж байгаа юм бэ? Хуучин эмнэлэг нь актад орчихсон учраас яаж байна вэ гэхээр байрууд түрээслээд энд тэнд нөгөө байр түрээслээд эмнэлэг нь нэг аймгийн төвөөрөө энэ бол иргэдэд асар их ачаалал, хүний амь настай хүртэл холбоотой асуудлууд бол үүсэж байгаа шүү дээ. Зориулалтын бус байрууд дээр жижиг жижиг газруудад түрээслээд. Тэгээд сая намайг очих үеэр энэ асуудлыг би шийдэж өг гээд тавьчихсан. Тэгээд магадалгаагаар оруул гэнэ юу бол гэнэ гээд ингээд ингээд тавьчихсан. Тийм учраас энэ асуудлыг бол яг хэзээ шийдэх юм бэ? Алслагдсан бүс нутаг олон хүн амтай. Хажуугаар нь энэ аялал жуулчлалын бүс юу эхлэхээр маш олон ачаалал нэмэгдэж орж ирдэг. Хөвсгөл нуур руу гэхэд олон мянган жуулчид явдаг. Гадаад, дотоодын хүмүүс хамгийн ойрхон эмнэлгийн тусламж, үйлчилгээ гэхээр Хөвсгөл аймгийн нэгдсэн эмнэлэг бол байж байдаг. Тийм учраас энэ асуудал дээр бол яагаад энэ компани зогссон юм бэ? 6 жил зогсож байна гэдэг чинь эмнэлгийн барилга шүү дээ. Энэ жилийн төсөв дээр орох юм уу, үгүй юм уу, яах юм юун дээрээ гацчихаад байгаа юм гэдэг дээр бол хариулт өгөхийг хүсэж байна.

Дээрээс нь энэ хүлээж авч байгаа энэ комиссын бүрэлдэхүүнд тухайлбал сургууль гэж бодох юм бол тэр сумын иргэд гэдэг юм уу, тэр дүүргийн иргэд гэдэг юм уу хүүхдээ сургах гэж байгаа тэр эцэг эхийн төлөөлөл нь гэдэг юм уу ийм юмыг энэ комисс момист нь оруулаад явцын хяналтыг нь хийж тавьж болдоггүй юм уу. Тэгэхгүй бол ингээд тэр ерөөсөө нүдээрээ хараагүй, биеэрээ яагаагүй тэгээд очоод нэг ажилласан болдог юм шиг байгаа юм. Тухайлбал, Хөвсгөл аймгийн Ренчинлхүмбэ сумын гэхэд бол сургуулийг нь ингээд ашиглалтад авчихса, комисс хүлээгээд авчихсан төсөв нь татагдах гээд байгаа учраас комисс нь буцаад бушуухан хүлээгээд авчихъя гээд авчихсан.

Үндсэндээ яаж байна вэ гэхээр 2 тэрбум төгрөг шаардлагатай гээд гаднын төслөөс гуйгаад сууж байна л даа. Сургуулийнх нь бараг 100 жилийн ой нь болж байдаг. Сургууль нь ашиглалтад ороогүй 7, 8 жил болж байдаг гээд гэх мэтчилэн Монгол улс орон даяар суурийг нь босгоод тавьчихсан асар их хэмжээний үр ашиггүй бараг энэ чинь моралийн элдэгдлэд ороод үндсэндээ тэр барилга байшинг үргэлжлүүлж барьсан ч гэсэн үндсэн суурь, хийц бүтээцэд нь өөрчлөлт орчихсон ийм зүйл байна. Тэгээд одоо энэ тогтоолын төслөөр бол магадгүй заримыг нь хувьчлах хүртлээ арга хэмжээ авъя гэж байна.

Тэгэхээр яг ийм шаардлагатай хэчнээн компани байгаад байгаа. Авах найдвар хэр байгаа вэ? Эс үгүй бол зориулалтыг нь өөрчлөөд эмнэлэг барих гэж байгаа дуусахгүй юм чинь тэгээд хувьчлаад оронд нь эс үгүй бол зочид буудал болгоё гэх юм уу яах юм? Тийм учраас энэ тал дээр бол манай Сангийн яам болон, Барилга хөгжлийн төвүүд энэ дээр ямар хариуцлага, арга хэмжээ авах юм бэ?

С.Бямбацогт: Наранбаатар дарга хариулах уу? Барилгын хөгжлийн, Сангийн яам 4 дүгээр микро ажлын хэсэг.

Ж.Дэлгэржаргал: Эрдэнэбат гишүүн асуултад хариулъя. Сангийн яам Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газар Дэлгэржаргал. Одоогоор бол яг хар жагсаалтын хувьд бол Тендерийн тухай хуулийн хувьд буюу яг энэ хуулийн дагуу хар жагсаалт гаргах асуудал явж байгаа. Тэгээд процесс нь бол захиалагчаас яг гэрээний үүргийн мэдээллээ ирүүлээд ерөнхий байцаагчийн дүгнэлтээр хар жагсаалт гардаг. Одоогоор 124 компани байгаа. Үүний 74 нь бол гэрээний үүргийн биелэлтээ хангаагүйгээс хар жагсаалтад орсон байна.

Хөвсгөл аймгийн хүүхдийн эмнэлэг бол 2020 онд анх 8.7 тэрбумын өртөгтэйгөөр 22 онд дуусахаар анх төсөв тусгагдчихсан. Эрүүл мэндийн яам худалдан авах ажиллагааг зарлаж гэрээ хийсэн. Захиалагчийн хяналтыг бол Барилгын хөгжлийн төв хяналт тавьж байгаа. Тэгээд үүнээс хойш төсөл дуусахгүй 23 онд ахиад 10.5 тэрбум болсон байгаа. Одоо бол санхүүж санхүүжилт дээр төсөв талаасаа бол энэ төсөл дээр олгох бол үлдэгдэл санхүүжилт байхгүй төсөл яг ингээд цацчихсан гацчихсан.

Тэгээд үлдэгдэл санхүүжилтийг бол Улсын комисс ажилласны дараа бид нар гэрээний үнийн дүнгийн 10 хувийг олгодог ийм журамтай. Комисс ажиллаагүй тохиолдолд өгдөггүй. Тийм учраас барьцаа хөрөнгийн дансанд үлдэгдэл санхүүжилт нь байгаад буцаагаад төвлөрчихсөн ийм байгаа. Одоо энэ дээр яг зураг төсвийн өөрчлөлтийг ч юм уу нэмэлт санхүүжилтийн асуудал байгаа бол холбогдох бас хуулиудаараа явдаг.

Тухайлбал, дуусах шаардлагатай нэмэлт санхүүжилтийн асуудлыг энэ эмнэлгийн барилга дээр бол тавьж байгаа 2 төрлийн хяналт буюу зохиогчийн хяналт байгаа. Өөрөөр хэлбэл, зураг төсөв зохиосон газар яг энэ ажлыг дуусахад ер нь ямар процесс хийгдэх юм, анхнаасаа ямар ажил төлөвлөөд юу дутуу байгаа дээр зураг төсвөө хийгээд Эрүүл мэндийн яам өөрөө энэ хүсэлтээ Барилгын хөгжлийн төвд хүргүүлээд Барилгын хөгжлийн төв магадлал хийгддэг. Төсөв бол төсөв талаасаа бол бид нар зөвхөн төсөв санхүүгийн хяналтыг хэрэгжүүлнэ. Тэгэхээр энэ магадлал ирээд үүн дээр аудит хийгдэж байж яг үнэхээр энэ нэмэлт

санхүүжилт гарсан, үгүй дээр тогтоогдсоны дараа л төсөв тусгах асуудал яригдана. Энэ төсөл дээр бол ингээд төсөв дээр тавих үлдэгдэл ч юм уу, зөрүү санхүүжилт бол одоогоор байхгүй байна.

С.Бямбацогт: Дүгэрийн Рэгдэл гишүүн асуултаа асууя. Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн тодруулж асууя. Хариултаа авчихъя. 4 дүгээр микрофон хариулъя.

3.Энх-Оргил: Барилгын хөгжлийн төв Ерөнхий инженер Энх-Оргил. Эрдэнэбат гишүүний асуултад хариулъя. Барилгын хөгжлийн төв бол 2018 оны 51 дүгээр Засгийн газрын тогтоолоор бол төрийн захиргааны байгууллагын 10 чиг үүргийг хэрэгжүүлж байгаа. Энэ чиг үүрэг дотор бол улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл арга хэмжээн дээр бол захиалагчийн хяналт хийх энэ үйл ажиллагаа байдаг захиалагчийн хяналтыг бол манайх бол холбогдох дүрэм, журмын хүрээнд 19 оны 180 дугаар тогтоол барилга байгууламжийг захиалагчийн хяналт хийх энэ дүрмийн хүрээнд бол хяналт тавьж ажиллаж байгаа. Гишүүдийн асуусан яг тэр Хөвсгөлийн эмнэлгийн барилгатай холбоотой ажил бол үнэн 6 жил үргэлжилж байгаа 20 онд эхэлсэн ажил. Бас КОВИД-ын үе дайрсан учраас нэмэлт ажил бол гарсан байгаа. Төсөв дээр бас зарим ажлууд бол орхигдсон. Ингээд бол нэмэлт ажлын төсөв 2024 онд хийгдсэн. Ингээд энэ төсөвт нэмэгдсэн энэ ажлын хөрөнгө шийдвэрлэгдүүлбэл ажлаа дуусгана гэх гэсэн компани бол ийм.../минут дуусав./

С.Бямбацогт: Эрдэнэбат гишүүн тодруулж асууя.

С.Эрдэнэбат: Үгүй энэ нэг барилга барихад ард түмэн бол энэ эмнэлэг хэзээ ашиглалтад орох бол гэдгийг маш тодорхой юм асуудаг. Тэгээд Сангийн яам болохоор Барилгын хөгжлийн төв нь комиссоо ажиллуулаад, комисс нь болохоор магадалгаагаа саналаа оруулаад тэгээд ноос түүж нөгөө найзыгаа аварна гэдэг шиг л ийм юм тавиад байдаг. Тэгэхээр та хэд яг яг энэ асуудлыг Сангийн яамтайгаа яриад комисс нь ажиллаагүй юм уу, магадалгаагаа хийлгээгүй юм уу, саналыг нь явуулаагүй юм уу? Тэнд чинь хүний амь нас, эрүүл мэндтэй холбоотой томоохон эрсдэлүүд гараад эхэлчихсэн байгаа энэ үед нь ингээд сууж байдаг. Тэгэхээр Барилгын хөгжлийнх нь төв нь гэдэг юм уу Барилгын яам нь ажлаа хийгээгүй юм уу, Эрүүл мэндийн яам нь ажлаа хийгээгүй юм уу, эс үгүй бол Сангийн яам нь ажиллаагүй юм уу? Та хэд яг эсрэгээрээ өөр өөдийнхөө тэр санхүүжилт чинь шийдэгдчихвэл бид нар энийг оруулах гээд байдаг, нөгөө тал нь болохоор Барилгын хөгжлийнх нь төв нь саналаа оруулаад, магадалгаагаа хийлгээд өгөх юм бол бид нар ингээд юмаа шийдье гээд байна шүү дээ. Тэгээд одоо энийг хэн хийх ёстой юм бэ?

С.Бямбацогт: 4 дүгээр микрофон ажлын хэсэг хариулъя.

3.Энх-Оргил: Түрүүн бас хэлсэн төсөв нэмэгдэж байгаа бол ер нь 4, 5-хан шалтгаан байгаа. Шинэчилсэн төсөв, нэг маягийн зураг, түлхүүр гардуулах, нэмэлт ажил, өөрчлөлтийн ажил гэсэн энэ иймэрхүү үндсэн 5 шалтгаанаар бол төсөвт өртөгт өөрчлөлт орж байгаа.

Таны асуусан ажил дээр бол магадлал бол хийгдчихсэн юм. Тэгээд одоо бол энэ төсвийн ерөнхийлөн захирагч буюу захиалагч тал өөрөө төсөвт суулгах

эсэх асуудлаа шийддэг. Барилгын хөгжлийн төвийн хувьд бол яг батлагдсан зураг төслийн дагуу бол тухай бүрд нь үе шатын хяналтаа хийгээд явж байгаа. Гарсан алдаа, зөрчил, дутагдлыг бол тухай бүрд нь бичгээр болон амаар сануулж, мөн бол бүүр үүрэг даалгавар биелүүлэхгүй бол захиалагчид бас бичгээр хариуцлага тооцуулах энэ асуудлыг бол тухай бүрд нь тавиад явдаг. Бүүр боломжгүй бол гэрээ цуцлах энэ саналыг ч хүргүүлдэг. Мөн хар жагсаалтад оруулж өгөөч гэсэн бас энэ хүсэлтээ бол тухай бүрд нь явуулж яг л дүрэм журмынхаа дагуу хяналтаа тавиад л ингээд явж байгаа.

С.Бямбацогт: Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Жамбын Батсуурийн урилгаар нийслэлийн ерөнхий боловсролын 141 дүгээр сургуулийн 12^а-ын ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Төрийн ордонтой танилцаж байгаа сургагч хүүхдүүддээ энэ өдрийн мэндийг хүргэж, сурлагын өндөр амжилт, хамгийн сайн сайхан бүхнийг Улсын Их Хурлын гишүүдээс та нэрийн өмнөөс хүсэн ерөөе. Удахгүй болох ЭЕШ-аа амжилттай өгч хүссэн сургуульдаа хүссэн мэргэжлээрээ элсэн орж, эх орныхоо хөгжилд хувь нэмрээ оруулсан хариуцлагатай хуулиа дээдэлдэг иргэн болоорой. Манай Батсуурь гишүүн энд сууж байна.

Дүгэрийн Рэгдэл гишүүн асуултаа асууя.

Д.Рэгдэл: Баярлалаа их чухал тогтоолын төсөл санаачилж оруулж ирж байгаа Пунсалмаа нарынхаа гишүүдэд би баяртай байна. Энэ их чухал асуудал байгаа юм. Ер нь сүүлийн үед хараад байхад Улсын Их Хурлын онцгой бүрэн эрхэд халдаад хуульд өөрчлөлт оруулчихдаг ийм бүтэц бий болчихоод байгаа юм. Энэ яадаг вэ гэхээр зэрэг Улсын Их Хурлын төсвийн тухай хуулиар батлагдсан, хавсралтад батлагдсан төсөл, арга хэмжээний зардал 1, 2 жилийн дараа бараг 2 дахин нэмэгдээд явчих тохиолдлууд гараад байдаг. Энд хуулийн дагуу оролцдог 2 байгууллага байна. Барилгын хөгжлийн төв, Сангийн яам 2. Тэгээд ингэж огцом огцом төсөвт өртөг нь өсөөд байдаг төсөл, арга хэмжээнд бол Улсын Их Хурал эргээд маш сайн хяналт тавихгүй бол бид нарын баталсан хуулийг өөр байгууллага үндсэндээ ингээд өөрчилчихөөд байгаа юм. Энэ бол хуулийн өөрчлөлт хийгдээд байдаг их ноцтой асуудлууд. Тэгэхээр зэрэг энэ өөрчлөлтийг бол бид нар хийх ёстой юм байна гэж энэ тогтоолтой танилцаж байхдаа харж байна.

2 дугаарт энэ угаасаа бид нар хуулийг батлахдаа цаана ямар үр дагавар ирж байна вэ гэдгийг төдийлөн сайн бодохгүйгээр баталчихдаг. Жишээлбэл, Төрийн хэмнэлтийн хууль гээд нэг хууль байдаг. Яаруу их баталсан ийм хууль л даа. Тэгээд энэ хуульд энэ худалдан авах арга хэмжээний, төсөл, арга хэмжээний гэрээ байгуулж дуусах хугацааг тухайн жилийн 5 сарын 31-нээр тасалбар болгочихсон. Тэгэхэд чинь Монгол Улсын санхүүгийн жил чинь 01 сарын 01-нээс эхлээд л 12 сарын 31-нээр тасалбар болдог. Энэ хооронд зөндөө олон төсөл, арга хэмжээ тасарчихдаг. Тэр дундаа ингэх шаардлагагүй хөрөнгө оруулалтууд байна. Тоног төхөөрөмжүүдийн хөрөнгө оруулалт гэх мэт. Энэ хуулийг ашиглаад үүгээр зөндөө хэмнэлт гаргачхаад тэгээд хамгийн харамсалтай нь энэ Төрийн хэмнэлтийн хуульдаа ингэж чөлөөлөгдсөн санхүүжилт, арга хэмжээний санхүүжилтийг төсвийн хэмнэлд тооцно гэж нэг заагаад тэгээд энэ төсвийн хэмнэлтийг зарцуулахгүй байх ёстой гээд дахиад заагаад хаячхаж байгаа юм. Тэгэхээр ингэж төсвийг хэмнэх ямар хэрэгтэй юм. Энэнийг нь зарцуулахгүй л юм

бол иймэрхүү хийдлүүд байгаад энэ дээр бас тодорхой тоглолтууд яваад байгаа нь бол сүүлийн үед олон юман дээр харагдаад байгаа юм.

Ялангуяа энэ шинжлэх ухааны салбарт 2 жилийн дараалан хийсэн хөрөнгө оруулалтаас харж байхад 5 сарын 25-нд сонгон шалгаруулалтаа хийчихдэг 5 сарын 29-нд 1 компани нь эсэргүүцээд л бичээд зөвшөөрөхгүй байна гээд өгчихдөг. 5 сарын 31-нд гэрээ хийж амжихгүй ингээд нэг махаа идэж явж батлуулсан жаахан хөрөнгө бол 2 жил дараалан ингээд буцаад татагдчихаад байгаа юм. Тэгэхээр энэ дээр бид нар нэлээн анхаарч ингэж явахгүй бол болохгүй болоод байгаа юм.

Ер нь сүүлийн үед энэ төсөл, арга хэмжээний, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг харахад шинэ төсөл, арга хэмжээний тоо цөөрөөд хуучныгаа гүйцээж санхүүжүүлэх гээд ингэж зовоод яваад байдаг. Энэ бол бараг хэвийн үзэгдэл болчихсон. Ингэснээс энэ нь юунаас болдог вэ гэхээр нэг нь бол энэ удаан хэрэгжиж байгаа төслүүд, төсөвт өртөг нь нэмэгдсэн төслүүдээс болоод шинэ төсөл арга хэмжээ орж ирдэггүй. Саяхан бид нар улсын хөгжлийнхөө төлөвлөгөөг баталсан. Тэгэхээр Эдийн засаг, хөгжлийн сайд бол бол аргаа бараад л байгаа юм л даа. Энд бол 2.2 их наяд төгрөгийн хөрөнгө оруулалт байна 27 онд. Энэ маань хуучин төсөл, арга хэмжээгээ санхүүжүүлж хүрэхгүй байна гээд байгаа юм. Энэ нь юу гэсэн үг вэ гэхээр зэрэг 27 онд бид нар шинэ төсөл, арга хэмжээ оруулж ирж болохгүй болчихоод байгаа юм.

Тийм учраас энэ шинэ, онцгой ач холбогдолтой төсөл, арга хэмжээ оруулж ирдэг арга ажлыг бодитойгоор хэрэгжүүлэхийн тулд бид нар юуны өмнө энэ удаан үргэлжилдэг төслүүд.../минут дуусав./

С.Бямбацогт: Рэгдэл гишүүн асуултаа гүйцээж асууя.

Д.Рэгдэл: Удаан үргэлжилдэг тэрнээс болоод төсөв өртөг нь нэмэгддэг. Удаан үргэлжлээгүй ч гэсэн огцом төсөвт өртөг нь нэмэгддэг энэ төсөл, арга хэмжээнүүд дээр ерөөсөө онцгой анхаарч, шалгаж, шалгалт хяналт тавьж ажиллах нь зөв байгаа юм. Зүгээр надад асуугаад байх юм алга.

Хамгийн гол нь жишээлбэл, бид нар төсөл санаачлагчдын судалгаанаас харахад 24-өөс 26 онд ингээд нийтдээ 3.09 их наяд төгрөгийн төсөл, арга хэмжээ төлөвлөгдөөд энэ нь одоо 161 хувиар төсөвт өртөг нь нэмэгдчихээд яваад байгаа юм. Тэгэхээр зэрэг анх төсөвт өртгөө тооцохдоо энэ ажлыг бол судалгаатай хийхгүй байснаас энэ болоод байна уу, эсвэл ингэж төсөвт өртөг зохиомлоор нэмэгдүүлдэг механизм ажиллаад байна уу гэдгийг тогтоомоор байгаа юм. Тэгээд энэ дээр нэг тодорхой хариулт өгөөч. Энэ юунаас болоод ингээд төсөвт өртөг огцом нэмэгдээд байдаг юм?

С.Бямбацогт: Энэ одоо чинь эцсийн хэлэлцүүлэг явж байгаа шүү дээ. Тийм болохоор Байнгын хороо, ажлын хэсэг л хариулна. Хууль санаачлагч хариулах дэггүй. Байнгын хороог төлөөлж Мөнхсоёл гишүүн хариулъя.

Б.Мөнхсоёл: Яах вэ сүүлд нь тодорхой хариулт авъя. Ер нь бол Рэгдэл гуай санаа зовсон, асуудлаа хөндөж үг хэллээ гэж ойлголоо. Адилхан саналтай. Өөрөөр хэлэх юм бол төсвийн сахилга батын асуудал маш олон жил яригдаж

байгаа. Огцом, гэнэтийн шинэ тутам сэдэв биш. Тэр утгаараа энэ тогтоол орж ирж байгаа. Өөрөөр хэлэх юм бол 2010 оноос хүртэл үлдчихсэн дуусаагүй барилгын асуудлыг шийдэхгүй бол зөвхөн Улаанбаатарт биш орон нутагт ч гэсэн дуусаагүй барилгын асуудал үнэхээр тулгамдсан эзэнгүй хөрөнгө, хайран үхмэл, хөрөнгө дутуу ийм барилга үүсчхээд байна гэдэг асуудал.

2 дугаарт, энийгээ цэгцлэнгээ хажуугаар нь Улсын хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хуулийн төсөл Засгийн газраас орж ирэх гэж байгаа. Олон сар ажиллаж байгаа маш сайн чамбай хууль орж ирнэ. Энэ дотор яг энэ төсвийн сахилга бат, төсвийн хөрөнгө оруулалтыг оновч той бөгөөд маш ийм зөв гаргаж ирэх ийм хуулийн төсөл гэсэн үг. Одоо тухайн хөрөнгө оруулалтыг эх үүсвэрээр нь ангилна эх үүсвэрээр нь. Нөгөө гадаад зээлийн өр юу энэ тэр чинь ч бүгд орно. Гадаад зээлийн эх үүсвэр, тусламж, буцалтгүй тусламж, тэгээд улсын, орон нутгийн бүх төсөв. Тэгээд төслүүдээ болохоороо бичлэс эхлүүлээд юуг мега гэх юм гэдэг хүртэл 4, 5 ангилалтай ингэж орж ирж байгаа. Ингээд цэгцэрнэ гэсэн ийм хүлээлт үүсчихсэн явж байгаа.

3 дугаарт нь өөрийн чинь хэлж байгаа үнэн. Анх оруулж ирэхдээ хөрөнгө оруулалтын төслүүдийг янз бүрийн маягаар оруулж ирчхээд тэгээд явцын дунд хөрөнгө мөнгө хүрсэнгүй, инфляц орлоо, барилгын үнэ өслөө ... гээд ингээд нэмдэг. Энэ асуудлыг бас цэгцлэхэд саяын хууль маш өндөр нөлөөтэй болно гэсэн үг. Тэгээд ер нь бол төсвийн сахилга батыг бий болгохын тулд Төсвийн тогтвортой байдлын зөвлөл гэж орж ирсэн, бий болсон. Үндэсний Аудитын газар гэж байгаа. Ерөөсөө Их Хурал дээр энэ гаргаж байгаа тайлангуудыг маш их чанартай уншаад хариуцлагатайгаар зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх ёстой. Төсвийн ерөнхийлөн захирагчид ч гэсэн үүнийг бүүр нэг үүрэг хариуцлага мэт хүлээж авах ёстой. Сахилга бат алдагдсанаас, хариуцлагагүй байгаагаас, хариуцлагын механизм байхгүйгээс өнөөг хүртэл ийм ужгирчихсан олон асуудал энэ том асуудлыг шийдэгдэж байгаа тогтоолын төсөл шүү. Баярлалаа.

С.Бямбацогт: Өлзийхүүгийн Шижир гишүүн асуултаа асууя.

Ө.Шижир: Өдрийн мэнд Рэгдэл гишүүн ээ энэ ер нь бол дуусаагүй барилга биш дуусахыг хүсээгүй барилга байхгүй юу даа. Дуусахыг хүсээгүй юм. Хүсдэггүй юм байна лээ. Яагаад ингээд жил ирэх тусам ингээд төсөвт өртөг нь нэмэгдүүлээд байх нь тухайн тендер захиалагчдад ашигтай, гүйцэтгэгчдэд ашигтай болчихож байгаа юм. Би бол энэ аж ахуйн нэгжүүдийг энийгээ мэдэж ордог юм байна гэж ойлгосон сүүлдээ. Яагаад тэр 2025 оны улсын төсөв хэлэлцэж байхад тухайн үеийн төсөвт өртөг нэмэгдсэн барилгууд гээд би өөрөө бүр яг очиж үзсэн шүү дээ Чингэлтний дүүрэгт 14 дэх жилдээ явж байгаа цэцэрлэг байна. Хамгийн урдаа 18 жил хэрэгжиж байгаа төсөл байна. 5-аас дээш жил хэрэгжиж байгаа 42 төсөл өнөөдөр Монгол Улсад байгаа. Анхны төсөвт өртгөөсөө 300 дахин нэмэгдсэн төсөв ч байна. Энэ юу вэ гэхээр энэ мөнгийг чинь нөгөө нэг хэрэглэх гээд байгаа байхгүй юу даа. Тэгэхээр энийг дуусгахыг хүсэхгүй байгаа барилгууд гэж хэлж болно.

Нөгөө талаас энэ бол авлигын хамгийн том сүлжээ. Яагаад гэхээр 2024 онд нийт 449 төслөөс чинь төсөвт өртгөө нэмэгдүүлсэн 1.6 их наяд төгрөг байгаа шүү дээ. Сонгуулийн өмнөх жил гэсэн үг. 24 оны төсөвт сууж байна гэдэг чинь сонгуулийн мөнгө гэсэн үг байхгүй юу даа. 2024 оны 1.6 их наяд. 2025 онд 971.3 тэрбум, 26 онд 805 тэрбум ингээд зөвхөн сүүлийн 3 жилээр харахад энэ чинь 3.6, 7

их наяд тэр тэрбум руу орчхож. Энэ мөнгө юу вэ гэхээр уг нь бол буцаад хөрөнгө оруулалтын мөнгө байх ёстой. Хөрөнгө оруулалтын мөнгө байж чадахгүй өмнөх төслүүдээ санхүүжүүлээд төсөвт өртгийг нь нэмэгдүүлсээр байгаад ингээд явчхаж байгаа юм. Одоо хамгийн эмгэнэлтэй нь та өөрөө шинжлэх ухааны хүн. Ерөнхий боловсролын сургуулийн барилгын дундаж хугацаа 3.3 жил байгаа шүү дээ Рэгдэл гишүүн ээ 3.3 жил. Ерөнхий боловсролын сургуулийн өргөтгөлийн барилгажилтын дундаж хугацаа 2.7 жил байгаа. Цэцэрлэгийн барилгын хугацаа 2.2 жил байгаа дундаж хугацаа. Дотуур байрны барилгажилтын хугацаа 1.8 жил байгаа. Сургууль, цэцэрлэгийн цогцолбор цогцолбор барилгын дундаж хугацаа 3.1 жил байгаа. Ингээд эднийд чинь ингээд 600 хүүхэдтэй сургууль, 100 хүүхэдтэй дотуур байр, 150 хүүхдийн цэцэрлэг гэдэг чинь ингээд 3 жил бариад байна гэж энэ чинь цаанаа ашиг сонирхлын зөрчил байхгүй юу даа.

Өнөөдөр хувийн компани өөрөө 100 хүүхдийн дотуур байр барьж байвал сайн яривал нэг зун барина шүү дээ. Үнэхээр нэг зун барина. Би бүр анх Чойжоо сайдаар нэг жишээ авч хэлж байсан шүү дээ. Төр нь ингээд сургууль, цэцэрлэгийн барилгаа 3 жил ингээд барьж чаддаггүй төсөвт өртөг нэмэгдээд байдаг. Чойжилсүрэн сайд чинь 2000 айлын орон сууцыг 1 жилийн дотор бариад байна шүү дээ гээд. Энэ чинь ингээд харьцуулаад харахаар бид нар ингээд төр юу ч хийж чадахгүй байгаа нь нэг аягүй том жишээ байхгүй юу даа.

Хамгийн харамсалтай нь энэ төсөвт өртгөө нэмэгдүүлээд байгаа энэ барилга байгууламж чинь хамгийн эхэнд боловсролын салбарт байгаа шүү дээ. Тэгээд тэр сургууль, цэцэрлэгээ хүлээж байгаа хүүхдүүдийн сурах орчин тийм хайран биш байгаа юм уу. Сургууль, цэцэрлэгтийн хүрэлцээ нь хүрэхгүй байгаа нь тэр хүүхдүүдийн эрх ашгийг хангахгүй байгаа юм уу. Бид нар чинь нэг ийм буруу тогтолцоо руугаа гүйгээд орчихсон. Тэгээд энийгээ нэг магадлан оруулсан, төсөвт өртөг нь нэмэгдсэн. Яах ч аргагүй гээд энэ бол үе үеийн Сангийн сайд нарын буруу байхгүй юу даа. Үе үеийн сүүлийн 10 жилд хэн Сангийн сайд тэд нарын буруу юм. 100 хүүхдийн дотуур байрыг 3 жилд төсвийг нь хувааж тавьдаг Сангийн сайдын буруу байхгүй юу. Хүн болгоны асуудлыг шийддэг нэг баатар болоод наадхыг чинь 3 хуваагаад тавьчихъя гээд. Нөгөөдөх нь асуудлаа шийдүүлсэн нэг хүн. Энд нь асуудлыг нь шийдсэн нэг хүнтэй болчихдог. Тэгээд үр дүнд нь тэр 100 хүүхдийн дотуур байрыг хүлээж байгаа тэр сумын хүүхдүүдийн л хохирол үүсэж байгаа байхгүй юу. Тэгээд харахаар нэг их барилга байгуулж байж барьсан нэртэй. Бид нар сүүлийн 10 жилд 1062 барилга байгуулсан. Зөвхөн сургууль, цэцэрлэгийн барилга байгуулж барьсан 70 хувийнх нь төсөвт өртөг өссөн. Энэ 1062 барилгын барилгажилтын дундаж хугацаа 3.3 жил. Сонгуулийн эхэндээ тууз хайчилдаг дараагийн сонгуулийн эхэндээ нээдэг. Би бол тэгж харж байгаа юм шууд. Энийг бол би сонгуулийн авлига л гэж харж байгаа юм.

Яахаараа сонгуулийн өмнөх жил л улсын төсөвт өртөг нь 1.6 их наядтай нэмэгддэг юм. Энэ чинь авлига л байхгүй юу. Энэ барилгууд чинь дуусахыг хүсэхгүй байна. Үргэлжлүүлээд байх сонирхолтой байна. Төсөвт өртөгийг нь нэмээд өгөх хүсэлтэй байна. Тэр үр дүнгээрээ сонгууль.../минут дуусав./

С.Бямбацогт: Хэн хариулах вэ? Байнгын хорооны дарга хариулах уу? Наранбаатар дарга хариулъя.

Н.Наранбаатар: Тэгэхээр тогтоолын төслийг санаачлагч бол зөвхөн улсын төсвийн хөрөнгө оруулалтаарх төсөл арга хэмжээний зогссон шалтгаа, төсөв нэмэгдсэн шалтгааныг судалж дүгнэлт гаргах ийм үзэл баримтлалтайгаар энэ хууль тогтоолын төслийг оруулж ирсэн. Тэгээд өнгөрсөн 7 хоногийн чуулган дээр бас Улсын Их Хурлын даргын зүгээс бас зарим гишүүдийн зүгээс бас тогтоолын төсөл дээр нэлээн нэмж өргөдөг гэсэн ийм чиглэл өгсөн.

Тухайлбал, зөвхөн улсын төсөв биш орон нутгийн төсөв мөн ТӨК/Төрийн өмчит компани/-удын төсвөөр баригдаад төсөв нь нэмэгдсэн зогссон. Дээрээс нь гадаадын зээл, тусламжаар төсөв нь нэмэгдээд зогссон. Эдгээр бүгдийг нь улсын хэмжээнд дүгнэлт гаргаад нэг бүрчлэн ингээд Их Хуралд танилцуул гээд, учир шалтгааныг нь тодруул, цаашид яах юм арга хэмжээнийхээ саналыг танилцуул гэсэн. Тэгэхээр бид тогтоолоо өргөтгөөд Байнгын хороогоор хэлэлцээд 7 сарын 1-ний дотор гэж байсан бол хугацааг нь бүүр 9 сарын 15 болгоод намрын чуулганы хугацаа хүртэл ажиллахаар ингээд оруулж ирж байгаа. Тэгээд энэ хугацаанд бол нэлээн сайн ажиллаж бүүр нэг бүрчлэнгээр нь ямар учир шалтгаанаар төсөв нэмэгдсэн юм, цаашид яах юм гэдэг саналуудаа оруулж ирэхээр анхны оруулж ирсэн төслөө нэлээн өргөжүүлээд явчихсан юм.

Тэгэхээр 9 сард энэ тайлан эргээд энэ чуулган, Байнгын хороогоор хэлэлцэгдэнэ. Тэн дээр бас нэлээн учир шалтгаан нь тодорхой болоод орж ирэх байх гэж ингэж бодож байгаа. Тэгээд Их Хурлаас бид нар цаашаа ингээд танилцуулга, санал, дүгнэлтээ танилцаад, үүрэг чиглэлээ өгөөд, хариуцлага тооцох асуудал дээр хариуцлага тооцоод ингээд явах боломжийг нь нээж өгч байгаа ийм тогтоолын төсөл байгаа.

С.Бямбацогт: Баярлалаа. Нэлээн чухал бол өөрчилсөн хөтөлбөрүүд оруулсан байна. Байнгын хороонд баярлалаа. Өлзийхүү Шижир гишүүн тодруулж асууя.

Ө.Шижир: Яг үнэн. Тэгээд нэмэх нь тэр орон нутгийн төсвөөр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрүүдийг бол багтаах зайлшгүй шаардлага байгаад байгаа юм. Бид нар улсын төсөв гээд энэ зөвхөн улсын төсвөөс санхүүжиж байгаа төслүүдийг хараад байдаг. Орон нутгийн төсвөөс чинь бас маш их төсөл, хөтөлбөр санхүүжүүлдэг. Жишээ нь “Эрдэнэс Тавантолгой” гэдэг компани хэдэн төсөл санхүүжүүлээд байгаа юм бүү мэд. Бүү мэд. Сүүлдээ энэний санхүүжилтийг “Эрдэнэс Тавантолгой” шийдвэрлэнэ. гэдэг нэг ийм юутай болчихсон.

Одоо юу болж байна вэ гэхээр нэгхэн жишээ “Эрдэнэс Тавантолгой” компанийн орлогоос нь үйл ажиллагааг нь санхүүжүүлээд “Тавантолгой түлш” гэдэг компанийг санхүүжүүлчихсэн. 1.6 их наядаар үйлдвэр барьсан. Одоо тэр үйлдвэр зогсохгүй зогсчихсон үйл ажиллагаа явуулахгүй. Тэгээд энэ чинь хайран мөнгө биш юм уу. Тэгэхээр энэ юмнууд дээр бол хяналт шалгалт хийх хэрэгтэй байна. Өнөөдрийг хүртэл улсын төсвийн хөрөнгө оруулалтаар үр дүнгүй болсон төсөл, хөтөлбөрүүд дээр хариуцлагад тооцогдсон нэг ч албан тушаалтан байхгүй Монгол Улсад. Зүгээр л татвараар цугласан иргэдийн мөнгийг хүссэн төслөө санхүүжүүлдэг ийм Засгийн газартай болчихсон байлаа шүү дээ. Энийг тэднээс санхүүжүү.../минут дуусав./

С.Бямбацогт: Үг хэлчихлээ. Нэлээн Шижир гишүүний бас хэлж байгаа саналууд нэлээн орсон юм байна өргөжиж. Цэндийн Баатархүү гишүүн асуултаа асууя.

Ц.Баатархүү: Манаачийг хэн манах вэ гэж үг байдаг. Тэгээд 1 зүйлийг би асуумаар байгаа юм. Ер нь бид нар энэ нэг ийм гарч байгаа шинж тэмдэгтэй л ноцолдоод байгаа юм. Яг учир шалтгаан нь юу юм бэ гэдгийг илүү сайн тодруулах хэрэгтэй. Тэгээд энэ тогтоол бол учир шалтгааныг нь эрэн хайсан ийм тогтоол гэж би ойлгож байгаа. Дэмжиж байгаа гэдгээ илэрхийлье. Тэгээд энэ ТЭЗҮ/техник, эдийн засгийн үндэслэл/ гэдэг зүйл үнэхээр зөв гарч уу гэдгийг энэ ТЭЗҮ-г нь хянаж байдаг газар гэж ер нь Монголд байдаг юм уу? Хэн энэ ТЭЗҮ-д нь хөндлөнгийн үнэлгээ өгдөг юм бэ? Одоо бид бол нэг хэлбэрийн хувьд улсын төсөвт мөнгө тавиулахын тулд техник эдийн засгийн үзүүлэлт байна уу энийгээ магадлалын номероо авсан уу гэдэг л зүйл байдаг. Энэ ТЭЗҮ өөрөө буруу гарсан байх, энэ буруу зурагдсан байх, мэргэжлийн биш байх, энэ эдийн засгийн нөхцөл байдалтай уялдаагүй байх гэх мэт энэ асуудлыг нь зохицуулж байдаг газар гэж ер нь байдаг юм уу гэдгийг 1 дүгээрт асуумаар байна.

2 дугаарт дахиад л учир шалтгаан. Энэ сонгон шалгаруулалт хийж байгаа Тендерийн хууль тогтоомжоо бид нар өөрчлөх болоогүй юм уу? Ямар төсөл, хөтөлбөрийг энэ үнээр нь өрсөлдүүлэх юм, ямар төсөл, хөтөлбөрийг эхлээд чанараар нь эрэмбэлэх юм бэ гэдгээ ангилах, ялгах цаг болсон байх аа. Одоо энэ Тендерийн хууль гэдэг чинь ерөөсөө энэ тендер захиалагч тэр тендерийг нь авдаг хэдхэн компанийн хоорондын үгсэн хуйвалдаан болж хувирч байна шүү дээ. Томоохон төслүүд дээр Монголын аж ахуйн нэгжүүд ороход маш хүндрэлтэй болсон. Тэгээд гадаадын аж ахуйн нэгжүүд ордог, мөнгө валют гадагшаа урсдаг, Монгол аж ахуйн нэгжүүд нь энийгээ хэрэгжүүлэх ийм боломж, Монголдоо бүтээн байгуулалт хийх боломж, Монголдоо төсвөө шингээх боломж нь бага болоод байна. Тэгэхээр энэ тогтоол бол өөрөө энийг хэрэгжүүлж байгаа тэр эх үндэс, эх ундарга, тендерийг зохион байгуулалттай холбоотой юм биш үү гэж би 2 дахь асуултаа асууя.

3 дахь асуулт бол би энэ Шижир гишүүнтэй санал нэг байгаа. Энэ ТӨК-уд ер нь хэзээ төсвөөс гадуур дур мэдэж ингээд төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэхээ зогсоох юм бэ? Энэ чинь Монгол Улс нэгдсэн төсөвтэй байдалд ТӨК-ийн төсөв гэдэг ийм тусдаа эрх барьж байгаа намуудын компаниудыг санхүүжүүлдэг, ажиллуулдаг, хүний нөөцийг нь бэлддэг ийм газар болчихлоо. Тэгэхээр одоо энэ дээр бол хууль орж ирж байгаа гэж ойлгож байгаа. Энэ асуудал цэгцрэх үү гэдгийг асууя. Хамгийн сүүлд нь энэ улсын комисс гэж нэг зантгар газар байна. Хууль биелүүлдэггүй газар чинь наад улсын комисс чинь байна.

Барилгын тухай хууль дээр энэ барилга байгууламжийн 20, 30 хувь нь ногоон байгууламж байна гэдэг. Барьж байгаа зураг нь их сайхан зураг байдаг. Иргэдэд харуулж байгаа, үзүүлж байгаа зүйл нь онцгой сайхан байдаг. Яг хачир дээрээ ширэнгэн ой босож байгаа шүү дээ. Сүүлийн 30 жил Улаанбаатар хотод ширэнгэн ой босож байна. Энэ Яармаг ямар болов? Монгол Улс үнэхээр энэ хүнд ээлгүй хот барьдгийн тод жишээ энэ Улаанбаатар хот харагдаж байна шүү дээ. Тэгэхээр энэ улсын комиссыг хэн хянаж хариуцлага тооцох юм бэ. Энэ энийг бас энэ тогтоолын төсөл дээр оруулбал яасан юм бэ гэсэн ийм асуултууд байна.

С.Бямбацогт: Сангийн яам хариулъя. Ажлын хэсэг 4 дүгээр микрофон.

Ж.Дэлгэржаргал: Баатархүү гишүүний асуултад хариулъя. Сангийн яам Дэлгэржаргал. ТЭЗҮ, ер нь улсын төсвийн хөрөнгө оруулалт 4 ангиллаар хөрөнгө оруулалт хийгддэг. Барилга байгууламж өргөтгөл, их засвар, тоног төхөөрөмж, ТЭЗҮ, зураг төсөв гээд- ТЭЗҮ-гийн хувьд, зураг төсвийн хувьд бол яг зураг төсвийн тусгай зөвшөөрөл бүхий компаниуд хийгээд холбогдох 3 хөгжлийн төв дээр магадлал гараад ингээд хянагдаад явдаг. ТЭЗҮ боловсруулах дээр бол харьцангуй хууль зүйн хувьд бол зохицуулалт маш бага, сул байгаа. Тэгээд Сангийн яам энэ дээр ч гэсэн судалгаа хийгээд хөндөөд энэ Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хууль дээр ТЭЗҮ гэж юу хэлэх юм бэ, ямар үнээр тогтоох юм, хэн баталгаажуулах юм гэдгийг бол хуулийн төсөлд тусгаад явж байгаа.

Одоо яг энэ хуулийн зохицуулалт сул учраас энэ ТЭЗҮ хэр тогтоогдсон, хэн энийг баталгаажуулахтай бол харьцангуй ийм ойлголт болоод байгаа. Одоогийн процесс дээр бол ихэнх ТЭЗҮ дээр бол Эрчим хүчний хөгжлийн төв, Барилгын хөгжлийн төв бол зарим ТЭЗҮ-үүдийг бол Сангийн яамнаас тавьсан шаардлагын дагуу хянан баталгаажуулж байгаа. Зарим салбар дээр бол эрдмийн зөвлөлөөрөө хянан баталгаажуулдаг асуудал байгаа.

Бид нарын хувьд бол яг томоохон ТЭЗҮ дээр бол заавал Засгийн газрын хуралдаанаар баталгаажуулах, хуулиудынхаа хүрээнд Их Хурлаар танилцуулах асуудлууд бол энэ шаардлагыг нь тавиад ингээд хяналт тавиад явж байгаа. Улсын төсвийн хөрөнгө оруулалт дээр бас энэ удааширч байгаа асуудлууд дээр бол бид нар хөрөнгө оруулалтууд хийхдээ шингээх чадварыг тооцоолох асуудал чухал байгаа. Одоо яг улсын хэмжээнд барилгын тусгай зөвшөөрөлтэй 4100 компани, авто замынх 780, эрчим хүчнийх нь 650 гаруй ийм компани байгаа. Эдгээрийн 20-30 хувь нь бол улсын төсвийн хөрөнгө оруулалтаар ажил хийдэг юм байна гэдэг ийм судалгаа байгаа.

Тэгэхээр нөгөө талдаа яг энэ барилгын улирал, барилгын материалын үйлдвэрлэл, ажиллах хүчин дээрээ үндэслээд энэ шингээх чадварын судалгаа хийж байж бид нар улсын төсвийн хөрөнгө оруулалтаа төлөвлөхгүй бол их хэмжээний хөрөнгө оруулалтууд батлаад байх юм бол буцаад хэрэгжихгүй байх эрсдэлүүд байгаад байгаа. Тэгээд төсвийн жилийн өөрөө харилцаа өөрөө 26, тухайн оны төсвийн жил дуусаагүй байхад ирэх оныхоо төсвийг бид нар баталдаг буюу энэ онд хэрэгжинэ, дуусна гэсэн төслүүд маань тухайн онд батлагдсан санхүүжилтээ авч чадахгүй бол автоматаар 2 жил ухардаг. Тэгээд энэ хугацаанд бол нийт төсөвт өртгийн хамгийн өндөр дүн болох барилгын материалын үнийн өсөлтийн зөрүү үүсэх ийм магадлалууд байдаг учраас яг тухайн жилийнхээ төсвийн цаглавар, барилгын улирал, шингээх чадвартайгаа нийцэж бас энэ хөрөнгө оруулалтуудаа төлөвлөх асуудал чухал байгаа.

Тендерийн хуулийн хувьд бол яг хуулийн зохицуулалт бол хөрөнгө оруулалтын ажлууд бол бид нар Төсвийн тухай хууль холбогдох журмаа бариад төлөвлөдөг. Хэрэгжилт дээр бол ингээд салбар хуулиудаар хэрэгжилт нь явдаг. Одоо худалдан авалт нь бол Тендерийн хуулиар өөр чиг үүргийн байгууллагууд зохион байгуулаад явдаг.

Хэрэгжилт, санхүүжилтийн асуудал бол Барилгын тухай хууль, Авто замын тухай хуулиараа хяналтын байгууллагууд хянаад тэгээд буцаад санхүүжилтийн харилцаа бол яг Сангийн яамнаас гаргасан журмын дагуу явдаг. Тэгэхээр энийг бүхэлд нь харж яг хууль зүйн зохицуулалт хийх асуудал байгаа. Тэгээд Тендерийн хууль бол бага үнийн саналаар явж байгаа асуудал бас.../минут дуусав./

С.Бямбацогт: Хариултаа дуусгачихъя. 4 дүгээр микрофон.

Ж.Дэлгэржаргал: Бага үнийн саналаар тендерт шалгараад байгаа нь бас чанарт нөлөөлөх яг анхны бид нар төлөвлөсөн төслийн үр дүндээ хүрэхгүй байх эрсдэл байгаа. Тэгээд олон улсад бол ач холбогдолд суурилсан ийм үнэлгээний аргачлал байдаг. Азийн хөгжлийн банкны төслүүд дээр ч юм уу илүү чанараар нь үнэлээд дараагийн шатанд нь үнээр нь шалгаруулдаг ийм зохицуулалт байдаг учраас бид нар энэ хуулийн төсөлд бас яг энэ агуулгуудыг оруулахаар ингээд судлаад явж байгаа.

С.Бямбацогт: Баатархүү гишүүн тодруулж асууя.

Ц.Баатархүү: Энэ хуульд нийцээгүй барилга байгууламж төсөл, хөтөлбөрийг хүлээж авсан энэ улсын комиссын жагсаалтыг гаргамаар байгаа юм. Тэнд үнэхээр энэ авлигын сүлжээ чинь тэнд явж байна. Үнэхээр ингээд хууль дээр заачихсан байдаг. Их Хурал бол ингээд хууль батлаад байдаг, хууль санаачлаад байдаг. Тэр хууль бол амьдрал дээр хэрэгжихгүй байна шүү дээ. Үнэхээр хууль хэрэгждэг байсан бол Улаанбаатар хотын чинь 30 хувь нь ширэнгэн ой биш хотын ой, ногоон байгууламж, хүүхдүүд, ахмадууд нь салхилах талбайтай байх байсан. Одоо бол хүүхэд, ахмад салхилах байтугай ямар ч зайгүй ийм ширэнгэн ой болж байна гэдэг бол үнэхээр тэр улсын комисс гаргасан зургийн дагуу барилга байгууламжаа хүлээж авахгүй байгаа энэ бол авлига, албан тушаалын эрсдэл энд байна гэж би бол харж байгаа.

Тэгэхээр энэ тогтоолын төсөл бол зөв юм. Энийг.../минут дуусав./

С.Бямбацогт: Үг хэлчихлээ. Равжихын Эрдэнэбүрэн гишүүн асуултаа асууя.

Р.Эрдэнэбүрэн: Өдрийн мэнд хүргэе. Пунсалмаа гишүүний санаачилсан энэ тогтоолыг дэмжиж байгаа. Ямар ч байсан энэ улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээг бас энэ анхааралд авчирч тал талаас нь яаж сайжруулах вэ гэдэг талаар ярилцаж эхэлж байгаа нь бол маш чухал зүйл юм гэж ингэж бодож байгаа юм.

Тэгээд 2, 3 асуулт ажлын хэсгээс асууна. Энэ Хэмнэлтийн хууль бол үндсэндээ бол тэр хэмнэлт гаргадаг зорилго морилгоо бол байхгүй болсон. Зорилгоосоо бол одоо ухарсан. Хэмнэлтийн хууль бол ямар хууль болсон бэ гэхлээр төсвийн хөрөнгө оруулалтуудыг яаж зогсоох вэ л гэдэг ийм л хууль болсон. Тэгээд 1 гайгүй лоббитой хүмүүсийнх нь тавиулсан хөрөнгө оруулалтууд яваад байдаг. Лобби муутай хүмүүсийнх нь 6 сарын 1 боллоо гээд ингээд хасаад хаячихдаг ийм болсон.

Тэгээд ажлын хэсгээс асуух гэсэн юм. Энэ ноднин Чойр-Мандалговийн энэ зам дээр нэг хэдэн төгрөг арайхийж байж тавиулсан энэ ямар шатад явж байна? Тендер нь болсон уу болоогүй юу юу болж байна энийг нэг хэлээд өгөх хүн байна уу? Говьд нэг говийн 4 аймгийг холбож байгаа ганц зам байгаа. Тэндээс хамаг улсын төсвийн хөрөнгө оруулалт хөрөнгөө бүрдүүлдэг. Тэгээд зам мам байдаггүй. Тэгээд энэ Чойр-Мандалговийн зам ямар шатад явж байна юу болж байна гэдэг дээр нэг хариулт өгөөдхөөч 1 дүгээрт.

Хоёрт нь энэ сая Шижирээ бол маш зөв асуудал ярьж байна л даа. Бага үнээр бол энэ улсын төсвийн хөрөнгө оруулалттай ажлуудад энэ том чадалтай компаниуд орохоо больчихсон шүү дээ. Тэр бичиг цаас хүндрэл, хүнд суртал нь дийлдэхгүй, бүтэхгүй гээд мөнгө төгрөгөө ч олж авч чадахгүй юм байна гээд. Одоо ямар компаниуд ордог вэ гэхлээр хамгийн бага үнэ өгчихье тэгээд явж байгаад нэг төсвөө нэмүүлчхэж болох байлгүй дээ гээд. Одоо бид нарт ирж байгаа хүсэлтүүдийн ихэнх нь энэ ажлын төсвийг нэмүүлж өгөөч л гэсэн ийм хүсэлтүүд байдаг. Бүх ер нь бараг 90 хувь нь байгаа байх. Тэгээд ийм байдалтай байгаа учраас энэ ажлууд чинь явдаггүй. Хэдэн жил сунгаад дуусгая гэж бодохгүй шүү дээ.

Тэгэхлээр энэ Барилгын хөгжлийн төв бол төрийн нэрийн өмнөөс л зөвлөх үйлчилгээ үзүүлж байгаа зөвлөх үйлчилгээнийхээ төлбөрийг авдаг ийм юу. Хөгжлийн төв нэг бол энэ гүйцэтгэгчээ өөрсдөө сонгодог болгох хэрэгтэй болж байгаа юм. Нэг бол энэ Фидекийн ч юунууд байдаг энэ даатгалтай зөвлөх, хувийн зөвлөх үйлчилгээнүүдийг нийтэд энэ түлхүүр хүлээлгэхээр өгдөг ийм систем рүү шилжихгүй бол энэ ажлаа энэ байдлаар яваад байх юм бол энэ хэл ам бол дуусахгүй гэж ингэж бодож байгаа юм. Тэгээд ийм 3 асуудал дээр энэ зөвлөх үйлчилгээний асуудал энэ шинэ хууль дээр судлагдаж байгаа юу? Орж ирэх гэж байгаа Сангийн яам боловсруулж байгаа юм байна гэдэг ийм 3 асуулт асуух гэсэн юм.

С.Бямбацогт: Зочин танилцуулъя. Нийслэлийн ерөнхий боловсролын Плехановын нэрэмжит сургуулийн 9^г ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Төрийн ордонтой танилцаж байгаа сурагч хүүхдүүддээ сурлагын өндөр амжилт, амьдралын хамгийн сайн сайхан бүхнийг Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс хүсэн ерөөе. Эрдэм номдоо шамдан суралцаж, анги дэвших шалгалтаа сайн өгөөрэй.

4 дүгээр микрофон ажлын хэсэг.

Ж.Дэлгэржаргал: Эрдэнэбүрэн гишүүний асуултад хариулъя. Сангийн яам Дэлгэржаргал.

Төрийн хэмнэлтийн хуулийн 5 сарын 31 бол гүйцэтгэлд буцаад төлөвлөлтийг сайжруулах гүйцэтгэлийг эрчимжүүлэх маш чухал зохицуулалт. 22 онд бид нар ер нь энэ төслүүд удаашраад байгаа шалтгааныг судалж байгаад энэ хугацааг оруулсан. Өөрөөр хэлбэл, хууль батлагдсанаас хойш 5 сараас 11 сард батлагдсанаас хойш 5 сарын 31 хүртэл бол 6-7 сарын хугацаа байгаа. Тэгээд энэ хугацаанд бол худалдан авах ажиллагаа зарлаад гэрээ хийх боломжтой байдаг.

Тэгээд үүнээс хойш бол зөвхөн гэрээтэй төслүүд явдаг учраас гүйцэтгэл сайжрах ийм зохицуулалт байдаг.

Чойр-Мандалговийн хувьд бол 26 онд 100.2км хэвтээ тэнхлэгийн замын үргэлжлэл 230.9 тэрбум дээр бол гэрээ хийгдсэн учраас хэмнэлтэд бол ороогүй байна. Гэрээ нь бол хийгдсэн байна.

Хуулийн төсөл дээр бид нар энэ зөвлөх үйлчилгээтэй холбоотой Ер нь нэг хөрөнгө оруулалтын төслийн гэрээний үнийн дүнгийн 85 хувь нь яг ийм бүтээн байгуулалт руу ордог. 10 хувь нь бол яг НӨАТ байдаг. 5 хувь нь бол зөвлөх үйлчилгээтэй холбоотой зардлууд байдаг. Тэгээд магадгүй 10 жилийн өмнөхийг өнөөдөртөө харьцуулах юм бол манай хөрөнгө оруулалтын хэмжээ бол өртгийн хувьд бол нэлээн өндөр төслүүд батлагддаг болсон учраас энэ зохицуулалт дээрээ бид нар хуулийн төсөл дээрээ төсөвт өртгийнхөө хэмжээнээс хамаараад зөвлөх үйлчилгээнд өгч байгаа зардал өөрөө харилцан уялдаатай байх 2 хувиасаа дандаа буурах ч юм уу. Нормчлолын сангийн асуудал ч гэсэн бүх төсөл дээр тогтмол ийм зардлаар авдгийг бол хөндөж оруулж ирж байгаа.

Дээрээс нь зөвлөх үйлчилгээг ер нь бол төслийн тоо олон болж байгаа, хэмжээ томорч байгаа учраас хувийн хэвшил гүйцэтгэх боломжийг нь бас нээж өгч байгаа. Нээлттэй энэ хяналтын асуудлыг тендер зарлаад захиалагчийн төрийн өмнөөс хяналт тавих байгууллага нээлттэйгээрээ яг өрсөлдөж энэ зөвлөх үйлчилгээг авдаг энэ олон улсынхаа жишиг рүү оруулах асуудлыг бас хуулийн төсөл дээр тусгаад явж байгаа.

С.Бямбацогт: Тодруулъя Эрдэнэбүрэн гишүүн.

Р.Эрдэнэбүрэн: Энэ 6 сарын 1-нээс өмнө нийт энэ хөрөнгө оруулалтын чинь хэдэн ажилд тавьчхаад хэд нь гэрээ байгуулж чадав, хэд нь гэрээ байгуулахгүй хасагдаж байна гэдэг дээр мэдээлэл байна уу?

С.Бямбацогт: Ажлын хэсэг 4 дүгээр микрофон.

Ж.Дэлгэржаргал: 5 сарын 31-ний дотор гэрээ хийгдээгүй асуудалтай бол өчигдөр Засгийн газрын хуралдаанаар бол Хэмнэлт нь тооцох тухай тогтоол яг жагсаалтаараа батлагдсан. 26 оны хувьд бол 738 төсөл хэрэгжиж байгаагийн 296 нь бол шинэ хөрөнгө оруулалт. Хууль дээр яг 296 төсөл боловчиг яг ингээд сайд бүрийн багцаар хуваарилаад багц болгохоор нийтдээ 802 гэрээ байгаа. Үүний бол 69 буюу нийтдээ 247 тэр тэрбум бол хэмнэлтэд орсон 69 төсөл. Багцаар нь ингээд аваад үзэх юм бол 200 гэрээ бол хийгдэж амжаагүй учраас хэмнэлтэд орсон байгаа.

Өртгийнх нь хувьд бол 1.1 их наяд. Тэгэхээр одоо яг 26 оны санхүүжих дүнгийн хувьд 247 тэрбум боловчиг ирэх онуудын ачаалал бас 950 тэрбумаар буурч байгаа. Тэгэхээр яг өчигдөр энэ жагсаалтаараа бол ингээд Засгийн газрын хуралдаанаар ороод жагсаалт батлагдсан байгаа. Хэмнэлтэд орсон.

С.Бямбацогт: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Зарчмын зөрүүтэй 3 санал байгаа. Тэн дээр гишүүд үг хэлж болно. Санал хураалтаа 16 цагаас нэгтгээд явуулъя. Санал хураалтыг хойшлууллаа.

Дараагийн асуудалдаа оръё. Айн санал дээр үгээ хэлнэ. Тэгээд. Энэ санал дээр зарчмын зөрүүтэй, гарч байгаа санал дээр та бүхэн үгээ хэлнэ. Дараагийн асуудал.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.

Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Сайнбуянгийн Амарсайхан танилцуулна. Таныг индэрт урьж байна.

С.Амарсайхан: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын үндэсний аюулгүй байдал эдийн засгийн тогтвортой хөгжил, хүн амын удмын сан, иргэдийн амь нас, эрүүл мэндэд ноцтой аюул заналхийлэл учруулж буй мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлттэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх эрх зүйн зохицуулалтыг шинэ шатад гаргах зорилгоор боловсруулж, хуулийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг та бүхэнд танилцуулж байна.

Монгол Улс 2020 онд Мансууруулах эм, сэтгэц нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийг анх баталснаар мансууруулах эм, сэтгэц нөлөөтэй бодисын эргэлтэд хяналт тавих эрх зүйн үндэс суурийг бүрдүүлсэн билээ.

Гэвч өнгөрсөн хугацаанд нийгэм, эдийн засаг, технологийн хөгжил, үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн арга, хэлбэр эрс өөрчлөгдөж, хар тамхи, мансууруулах бодисын хэрэглээ, хууль бус эргэлт, тэдгээртэй холбоотой гэмт хэрэг зөрчлийн гаралт тогтмол нэмэгдэж байгаа нь уг харилцааг зохицуулж буй эрх зүйн орчныг зайлшгүй шинэчлэх шаардлагатайг харуулж байна.

Тухайлбал, улсын хэмжээнд 2017-гоос 25 онд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой 2100 гэмт хэрэг бүртгэгдэж, нийт 2422 хүн холбогдсон байх бөгөөд тэдгээрийн дийлэнх буюу 86 гаруй хувийг 18-35 насны залуучууд эзэлж байна. Энэ хугацаанд 2018 зөрчил бүртгэгдэж, нийт 1976 хүн холбогдсон бөгөөд зөрчилд холбогдогчдын ихэнх нь мөн залуучууд байна.

2025 онд бүртгэгдсэн гэмт хэрэг зөрчлийн тоо өмнөх онтой харьцуулахад гэмт хэрэг 20 гаруй хувь, зөрчил 26.6 хувиар тус тус өссөн нь энэ төрлийн гэмт хэргийн гаралт тогтмол өсөх хандлагатай байгааг харуулж байна.

Сүүлийн жилүүдэд мансууруулах бодисын төрөл, хэлбэр өөрчлөгдөж, ургамлын гаралтай бодисоос гадна синтетик мансууруулах бодис болон урвуулан хэрэглэдэг эм бодисын хэрэглээ нэмэгдэх болсон бөгөөд 2017-гоос 25 онд мансууруулах эм, сэтгэц нөлөөт бодис, эм, ахуйн хий зэрэг бодис хэрэглээний улмаас нийт 49 хүн нас барсан тохиолдол бүртгэгджээ.

Мөн энэ хугацаанд 17 төрлийн мансууруулах эм, сэтгэц нөлөөт бодис урвуулан хэрэглэх эрчлэлтэй эм бодис их хэмжээгээр хураагдсан бөгөөд тэдгээрийг хэрэглээний тунгаар тооцвол ойролцоогоор 510579 хүн тун буюу ийм хэмжээтэй гарч байна.

Сүүлийн жилүүдэд дээр дурдсан нөхцөл байдал улам хүндэрч тулгамдсан асуудлуудыг харгалзан мансууруулах эм, сэтгэц нөлөөтэй бодисын эргэлтэд хяналт тавих, хууль бус эргэлттэй тэмцэх урьдчилан сэргийлэх тогтолцоог боловсронгуй болгох зорилгоор хуулийн төслийг боловсруулсан бөгөөд хуулийн төсөлд дараах голлох зохицуулалтуудыг тусгалаа. Үүнд:

1 дүгээрт, мансууруулах эм, сэтгэц нөлөөт бодисын ангилал, жагсаалтыг дотооддоо тогтооно.

Хуулийн төсөлд мансууруулах эм сэтгэц нөлөөт бодисыг хүний эрүүл мэндэд үзүүлэх хор уршиг, урвуулан хэрэглэх эрсдэлийг харгалзан ангилж, ангилал тус бүрд хамаарах бодисын жагсаалтыг Засгийн газар баталж, шаардлагатай тохиолдолд шинэ төрлийн бодисыг нэн даруй жагсаалтад оруулж хяналтад авах боломжийг бүрдүүлэхээр тусгасан.

Ингэснээр Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенцын жагсаалтад ороогүй шинэ төрлийн синтетик бодисыг ашиглан гэмт хэрэг үйлдэх, эс үгүй бол жагсаалт байхгүй гэсэн үндэслэлээр хуулийн хариуцлагаас зайлсхийх боломжийг эрх зүйн хүрээнд хумих бүрд нөхцөл бүрдэх юм.

2.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой ажиллагааг зөвхөн тусгай зөвшөөрлийн үндсэн дээр болон бусад тодорхой зохицуулалтын хүрээнд эрхэлнэ.

Энэ төрлийн мансууруулах эм, сэтгэцэд нөлөөтэй бодисыг үйлдвэрлэх, импортлох, экспортлох, ханган нийлүүлэх, тээвэрлэх, эмийн сангаар олгох, судалгаа шинжилгээний зориулалтаар, түүхий эдийн зориулалтаар зэрэг үйл ажиллагаанд тавигдах шаардлага, хориглох зохицуулалтыг тодорхой болгож, энэ төрлийн үйл ажиллагааг зөвхөн төрөөс олгосон тусгай зөвшөөрлийн үндсэн дээр ашиглахаар зохицуулалтыг тусгалаа.

3.Энэ төрлийн гэмт хэрэгт нь оногдуулах ялын бодлогыг чангатгана.

Мансууруулах эм сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар олж авах, бэлтгэх, боловсруулах, хадгалах, тээвэрлэх, илгээх, дамжуулах, худалдах, худалдан авах, шилжүүлэх, зуучлах, захиалах, хууль бус эргэлтэд оролцох, орон байр, тээврийн хэрэгслээр хангах, энэ төрлийн эм бодисыг завших, улсын хилээр нэвтрүүлэх, үйлдвэрлэх болон мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх үйлчилгээтэй ургамлыг хууль бусаар тарималжуулах, түүх зэрэг бүхий л үйлдэлд оногдуулах ял шийтгэлийн бодлогыг чангатгаж, энэ төрлийн гэмт хэргийг зохион байгуулалттай бүлэглэлээр үйлдэх, ашиг олох зорилгоор үйлдэх, хүүхдийг татан оролцуулах, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах, их онц хэмжээгээр үйлдэх зэрэг нөхцөлд илүү хүнд ял оногдуулах зохицуулалтыг тусгасан болно.

4.Эрүүгийн хуульд энэ төрлийн эм бодисын их хэмжээ, онц их хэмжээний шалгуурыг тодорхой болгохоор тусгалаа.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэгт хариуцлага тооцохдоо хэрэглэх бодисын их хэмжээ, онц их хэмжээ, түүний шалгуурыг Засгийн газраас тогтоохоор тусгасан бөгөөд ингэснээр тухайн гэмт хэргийн хүндрүүлэх нөхцөл байдлыг тодорхой тогтоож, ял шийтгэлийг ялгамжтай, илүү оновчтой хэрэглэх эрх зүйн үндэс бүрдэх юм.

5.Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, донтох эмгэгийг сэргээн засах үйлчилгээг төрөөс дэмжиж, хувийн хэвшлүүдтэй хамтран хэрэгжүүлж, мансууруулах эм, сэтгэц нөлөөт бодисын хамаарал бүхий хүнд эрүүл мэнд, сэтгэцийн нийгэм, нийгэм хамгааллын цогц үйлчилгээг ны тусламжийг үзүүлнэ.

Хуулийн төсөлд мансууруулах эм, сэтгэц нөлөөт бодисын хамааралтай иргэдийг ял шийтгэхээс илүүтэй эрүүл мэнд, сэтгэц, нийгмийн сэргээн засах үйлчилгээний тогтолцоонд хамруулах бодлогыг мөн тусгасан болно.

Тухайлбал, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хамаарал бүхий хүн сайн дураараа эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, сэтгэцийн нийгмийн сэргээн засах буюу донтох эмгэгийн эмчилгээнд хамрагдахаар хандсан тохиолдолд эрх зүйн сөрөг үр дагавар үүсэхгүй байхаар зохицуулсан болно.

Мөн донтох эмгэгтэй иргэдийг эмчилгээ, сэтгэл зүйн засал, сэргээн засах үйлчилгээнд хамруулах боломжийг нэмэгдүүлж, нийгэмд эргэн нэгтгэх, дахин гэмт хэргийг үйлдэхээс урьдчилан сэргийлэх эрх зүйн нөхцөлийг бүрдүүлэхээр холбогдох зохицуулалтыг тусгаад байна.

Хууль бус эргэлтийг сурталчилсан зар сурталчилгаа, контент бүтээгчдэд хариуцлага тооцохоор 6 дугаар бүлэгт тусгалаа.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хэрэглэхийг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх, хэрэглээг өдөөн турхирах, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл болон цахим орчин ашиглан хууль бус эргэлтийг сурталчилсан контент бэлтгэх, түгээх зэрэг үйлдэлд хариуцлага хүлээлгэх зохицуулалтыг тусгасан бөгөөд энэ нь цахим орчин дахь мансууруулах бодистой холбоотой хууль бус үйлдэл, нөлөөллийг бууруулахад чиглэж байна.

Энэхүү хуулийн шинэчилсэн найруулгын төсөл батлагдсанаар мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтийг бүрэн хяналтад авч энэ төрлийн гэмт хэрэг зөрчилтэй тэмцэх төрийн бодлогыг илүү нарийвчлан тодорхойлж, иргэдийн эрүүл мэнд, нийгмийн аюулгүй байдлыг хамгаалах эрх зүйн орчныг боловсронгуй болгох зорилготой боловсруулсан болно.

Эрхэм гишүүд ээ,

Энэ хуулийн төсөл нь Монгол хүний амь нас, эрүүл мэндийг хамгаалах, ирээдүй хойч үе болсон хүүхэд, залуучуудын эрүүл, аюулгүй орчинд өсөж хөгжих нөхцөлийг бүрдүүлэх, цаашлаад улс орны үндэсний аюулгүй байдлыг хангахад чиглэсэн эрх зүйн чухал шинэчлэл юм.

Хуулийн шинэчилсэн найруулга батлагдсанаар мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх төрийн бодлого илүү тодорхой, харилцан уялдаа холбоотой, илүү үр дүнтэй хэрэгжих эрх зүйн үндэс бүрдэж, ирээдүй хойч үеэ хар тамхи, мансууруулах бодисоос хамгаалах, аюулаас хамгаалах баталгаа бүрдэх юм.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Төслүүдийн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Салдангийн Оюунтуяа танилцуулсан. Таныг индэрт урьж байна. Уучлаарай Одонтуяа.

С.Одонтуяа: Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүдээ,

Монгол Улсын Засгийн газар 2026 оны 03 дугаар сарын 18-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг Хууль зүйн байнгын хороо 2026 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн хуралдаанаараа явууллаа.

Хууль санаачлагч мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх чиглэлээр төрөөс баримтлах бодлого, түүний зорилт, хэрэгжүүлэх үндсэн зарчмыг тодорхой болгож, мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх төрийн байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоо, нэгдмэл байдлыг хангах, мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, олон нийт, ялангуяа хүүхэд, залуучуудад мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хор хөнөөлийн талаар таниулах эрх зүйн орчныг боловсронгуй болгон мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хор уршгийн талаар олон нийтийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх, мансуурах донтой хүнд олон улсын сайн жишигт нийцсэн эрүүл мэнд, сэтгэц, нийгмийн сэргээн засах, нийгэм хамгааллын тусламж үйлчилгээ үзүүлэх, мансуурах донг эрт илрүүлэх, сайн дурын үндсэн дээр шинжилгээнд хамрагдах, эмчлүүлэх, эмчлэх, нийгэмшүүлэхэд чиглэсэн цогц арга хэмжээ авах, мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэргийн шалтгаан, нөхцөл, гэмт хэрэг үйлдэгдсэн байдлыг судлан үзэж, гэмт этгээдэд хүлээлгэх хариуцлагыг мансууруулах сэтгэцэд нөлөөт бодисын хэмжээ, үйлчлэл болон бусад объектыг талыг харгалзан ялгамжтай тогтоож, ял шийтгэлийн бодлогыг Эрүүгийн хуульд заасан шударга ёсны зарчимд нийцсэн ялгамжтай байх зэрэг зохицуулалтыг тусган хуулийн төслийг боловсруулжээ.

Хуулийн төслийн зардлын тооцоогоор хүний нөөцийн зардалд 454 сая 743 мянга 795 төгрөг, байгууллагын үйл ажиллагааны бодит чадавх, техник тоног төхөөрөмж, хэрэглэгдэхүүн, дэд бүтцийн зардалд 8 тэрбум 113 сая 657 мянган 200 төгрөг шаардлагатай гэж хууль санаачлагч үзсэн бөгөөд хуулийн төслийг d.parliament.mn цахим сайтад байршуулж, иргэд олон нийтэд саналыг авч байгаа болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Сайнзориг энэ төрлийн гэмт хэрэгт холбогдогчдын насны сегмент,

тоон мэдээлэл, хилийн тагнуулын албыг Тагнуулын ерөнхий газраас Хил хамгаалах еерөнхий газарт шилжүүлэх талаарх Засгийн газрын байр суурь, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын үндэсний жагсаалттай болох эсэх, байгалийн гаралтай болон синтетик лабораторийн аргаар гаргаж авсан мансууруулах бодисын ял хариуцлагын бодлогыг ялгамжтай тогтоосон эсэх, хэрэглэгчээ тогтоох бодлогын хүрээнд хуулийн төсөлд туссан зохицуулалтын талаар, Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа хүүхэд, залуучуудыг хамгаалах, урьдчилан сэргийлэх тусгай хөтөлбөр хэрэгжих эсэх, цахим орчин дахь эрсдэлийг хэрхэн бууруулах, хуулийн төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийн талаар, аймаг, орон нутагт эмчилгээ, урьдчилан сэргийлэх үйлчилгээ, хүртээмжтэй эсэх, албадан эмчилгээ хийхэд хүний эрхийн зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлэх, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх хууль сахиулах байгууллагуудын чиг үүргийн уялдаа холбоо, давхардлын талаар, Улсын Их Хурлын гишүүн Баярбаатар карго шуудан, илгээмжээр болон авто зам, төмөр замын тээврээр нэвтэрч байгаа ачаа, барааг хэрхэн шалгаж байгаа, мансууруулах бодисыг илрүүлэх, шинжлэх лаборатори, тоног төхөөрөмжийн талаар, электрон тамхи, түүний шингэн болон бусад эд зүйлд хувиргаж, шингээж нэвтрүүлэх оролдлогыг хэрхэн шалган тогтоож байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Номинчимэг Донтолтын эсрэг сэргээн засах, нөхөн сэргээх эмчилгээ хөтөлбөрийг олон улсын туршлагад нийцүүлж нэвтрүүлэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Баасанжаргал мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг худалдан борлуулж түгээж байгаа этгээдүүдэд баримтлах ялын бодлого, донтолттой тэмцэх, албадан эмчлэх арга барилыг зөв ойлгуулж таниулах, өсвөр насны хэрэглэгч хүүхдийн талаарх зохицуулалтыг холбогдох хуулиудтай уялдуулсан эсэх, Улсын Их Хурлын гишүүн Нарантуяа-Нара хуулийн төслийг боловсруулахад донтох эмгэгтэй иргэдийн сэтгэл зүйн асуудлыг судалсан эсэх, Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар хууль сахиулах, хэрэгжүүлэх цагдаагийн байгууллагын дотоод хяналтын зохицуулалтыг хуулийн төсөлд тусгасан эсэх, хилээр орж ирж байгаа мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хувь, хэмжээний талаар тус тус асуулт асууж, хариулт авсан.

Мөн хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Сайнзориг Донтолттой тэмцэх сангийн зарцуулалтыг зориулалтын дагуу зарцуулах эрхийг олгох, хууль сахиулах байгууллагуудын ажлын уялдаа холбоо, бүтэц чиг үүргийг эргэн эргэн харах нь зүйтэй талаар, Улсын Их Хурлын гишүүн Нарантуяа-Нара энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх туршлагатай улс орнуудтай хамтран ажиллах, туршлага судлах, Улсын Их Хурлын гишүүн Эрдэнэболд хуулийг хэрэгжүүлэх байгууллагуудын уялдаа холбоог хангах, нэгдсэн мэдээллийн сан, тоо бүртгэл, төсөв, санхүү, хариуцлагын асуудлыг ил тод, тодорхой тусгах, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд нийцүүлэх. Мөн Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар төрийн байгууллагуудын дотоод хяналтын асуудлыг анхаарах, энэ төрлийн гэмт хэргийг илрүүлэхэд төлбөрийн шилжүүлгийг мөшгөж хяналтдаа авах нь зүйтэй талаар тус тус үг хэлсэн болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.11 дэх хэсэгт заасны дагуу Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдээр санал хураалт явуулахад Байнгын хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 52.6 хувь нь үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрдлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Мал, амьтны эм тэжээлийн нэмэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гэрч хохирогчийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурах тэмцэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Байгалийн ургамлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гаалийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гүйцэтгэх ажлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гэр бүлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Жолоочийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Залуучууд дийн хөгжлийг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зар сурталчилгааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Ирээдүй өв сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Төрийн ордны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нотариатын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Тагнуулын байгууллагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Усан зам, тээврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Харьяатын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Цагдаагийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Цэргийн албан хаагчийн эд хөрөнгийн хариуцлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Шуудангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Тариалангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн дагаж мөрдөх журмын тухай, Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрдлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулсан талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг уншиж танилцуулсан Улсын Их Хурлын гишүүн Салдангийн Одонтуяа танд баярлалаа.

Зочид танилцуулъя Улсын Их Хурлын гишүүн Сүхбаатарын Эрдэнэбатын урилгаар Хөдөө аж ахуйн их сургуулийн 2006 оны төгсөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэндээ ажил, амьдралд тань хамгийн сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя. Дэмбэрэлцэрэнгийн Мөнх-Эрдэнэ Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд, Баттулгын Батбямба Хууль зүй, дотоод хэргийн Төрийн нарийн бичгийн дарга, Ганзоригийн Эрдэнэбулган Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга, Доржийн Энхтөр Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын Нийтийн эрх зүйн хэлтсийн дарга, Чалхаажавын Мөнх-Эрдэнэ Улсын ерөнхий прокурорын газрын Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих хэлтсийн дарга, ахлах прокурор, Шаравнямбуугийн Энхтуяа Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн бодлогын хэрэгжилтийн газрын Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдал хариуцсан ахлах шинжээч, Жаргалсайханы Амгалан Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын Нийтийн эрх зүйн хэлтсийн ахлах шинжээч, Энхбаатарын Товуудорж Цагдаагийн ерөнхий газрын Хар тамхитай тэмцэх албаны дарга, цагдаагийн хурандаа, Батмөнхийн Эрхэсбаатар Цагдаагийн ерөнхий газрын Хар тамхитай тэмцэх алба, хэлтсийн дарга, цагдаагийн дэд хурандаа, Төгөөгийн Энхбат Тагнуулын ерөнхий газрын хэлтсийн дарга, Гансүхийн Ганзориг Гаалийн ерөнхий газрын Хар тамхи, мөнгө угаахтай тэмцэх хэлтсийн дарга, Энхтөрийн Мөнхцог Хил хамгаалах ерөнхий газрын Хилийн боомтын газрын Шалган нэвтрүүлэх хэлтсийн дарга, дэд хурандаа, Батбаярын Ланчин Шүүхийн шинжилгээний ерөнхий газрын Байгалийн ухааны шинжилгээний хэлтсийн дарга, Жалхаасүрэнгийн Лувсанжанцан Мал эмнэлгийн ерөнхий газрын Эмийн үйлдвэрлэл, хэрэглээний асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн, Басангийн Түмэндэмбэрэл Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан Эрүүл Монгол хүн үндэсний хөдөлгөөний Сэтгэц-Нийгмийн сэргээн засах төвийн зохицуулагч, Содномын Байгалмаа СЭМҮТ-ийн Сэтгэц, нийгмийн эрүүл мэнд, гадаад харилцаа, сургалтын албаны Мансуурлын асуудал хариуцсан мэргэжилтэн, эмч, Умаахны Дэлгэрхишиг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын албаны ахлах мэргэжилтэн.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 21.24-д нэгдсэн хуралдаанд мэдээлэл хийж байгаа Засгийн газрын гишүүн, ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орсон холбогдох албан тушаалтан үнэн зөв, бүрэн гүйцэд мэдээлэх үүрэг мэдээлэх үүрэгтэй.

21.25-д нэгдсэн хуралдаанд мэдээлэл хийх, асуултад хариулах, тайлбар өгөх албан тушаалтан өөрийн танилцуулсан мэдээллийн үнэн зөвийг хариуцах бөгөөд мэдээллийг санаатайгаар нуун дарагдуулах, худал мэдээлэл өгөх, танилцуулах, Улсын Их Хуралд худал мэдээлэл ирүүлэхийг хориглоно.

21.31-д чуулганы хуралдаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүрэлцэн ирээгүй, тайлбар өгөхөөс татгалзсан, хуралдаанд оролцсон этгээд хуралдааны дэг зөрчсөн бол парламент үл хүндэтгэсэн үйлдэлд тооцож тухайн этгээдэд Төрийн

албаны тухай болон холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ гэж тус тус заасныг та бүхэнд танилцуулж байна.

Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлт, хууль санаачлагчийн илтгэл болон хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна.

Нэрс өгсөн байна. Наранцэцэгийн Алтаншагай.

Н.Алтаншагай: Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль орж ирж хэлэлцэгдэж эхэлж байна. Энэ хууль маань 2002 онд буюу өдгөөгөөс 24 жилийн өмнө батлагдаж явсан. Шинэчлэл найруулга орсон уу гэдэг дээр нэг тодруулга байна. 2017-гоос 25 оны статистик мэдээлэл байна. Энэ хугацаанд сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэгт 2500 орчим хүн холбогдсон. Үүний 50 хүртэлх хувь нь 18-25 хүртэлх насны залуучууд, мөн насанд хүрээгүй хүүхдүүд бас тодорхой хувийг эзэлж байгаа ийм статистик мэдээлэл байна.

Энэ мансууруулах бодисын хор нөлөөг залуучууд, өсвөр насныханд хүргэх, сурталчлах, таниулах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх яг ийм соён гэгээрүүлэх ажил ер нь дутмаг юм шиг санагдаж байгаа юм. Одоо энд ингээд яг хэлэлцэгдээд явах юм бол бас нэлээн ноцтой асуудлууд ч гэсэн ярих байх. Энэ хэлэлцэгдэж байгаа маань өөрөө бас нөгөө сурталчилгаа, мөн бас өөр сэдэлт болох вий гэсэн ийм болгоомжлол байна.

Ахуйн хэрэглээний газтай холбоотой энэ төрлийн, энэ чиглэлийн бас газыг хэрэглэж мансуурдаг ийм өсвөр насныхан 10 жилийн сурагчид бас байгаад байгаа юм. Энийг хэрэглэж байгаад бас амь насаа алдсан ийм тохиолдлууд байгаа. Мансууруулахын нөлөөт бодис байгалийн болон химийн аргаар боловсруулагддаг гэсэн ийм үндэс нэг ийм 2 арга байна л гэж энэ хуулийн төсөл дээр танилцуулга дээр нь байгаад байгаа юм.

Сүүлийн үед энэ лабораторийн аргаар боловсруулсан шинэ төрлийн мансууруулах сэтгэцэд нөлөөт бодисууд нэр төрөл нь өөрчлөгдөж манайд орж ирж байгаа. Энэ дээр тавьж байгаа гаалийн хяналт яг ямар байгаа вэ? Энийг илрүүлэх нөгөө багаж тоног төхөөрөмж, боловсон хүчин манайханд байна уу?

Дараачийнх нь асуулт энэ сэтгэцэд нөлөөлөх ийм бодис ургамал Монгол Улсын газар нутаг дээр ургаж байгаа энэ төрлийн хэдэн төрлийн ийм ургамал байна аа? Ам дамжаад л яригддаг. Граммаар нь зардаг, чүдэнзний хайрцагт хийгээд зардаг гэсэн ийм яриа хэлцлүүд залуучууд дунд байдаг. Тэгэхээр энийгээ яг яаж хяналт тавьдаг юм бэ? Энэ зэрлэг ургамал энэ устгал дээрээ яг ямар арга хэмжээ авч байгаа вэ?

Дараачийнх нь тодруулах гээд байгаа зүйл энэ эм, бэлдмэл нөгөө хавдартай хүмүүс, мөн бас өвчлөлтэй хүмүүс энэ хэрэглэдэг эмүүд нь энэ бас хориотой зүйл дотор орчихсон байгаа юм. Эм бэлдмэлийн. Тэгэхээр энийг яг яаж ялган ангилж байгаа вэ?

Ж.Бат-Эрдэнэ: Хариулъя. Ажлын хэсгээс хариулъя. Гаалийн газар. Мөнх-Эрдэнэ сайдын ар дээр Гаалийн газар хариулна. Өшөө Байгаль орчны яам. 4 дүгээр микрофон.

Д.Мөнх-Эрдэнэ: Алтаншагай гишүүний асуултад хариулъя. Хуулийн төслийг бол 2002 онд батлагдсан хуулийг шинэчилсэн найруулга хэлбэрээр боловсруулж оруулж ирсэн байгаа. Дагалдуулан 41 хуулийн төслийг мөн боловсруулсан гэдгийг хэлье. Энэ хуулийн бас гол боловсруулалт туссан гол концепцын өөрчлөлт бол яг энэ урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажил байгаа. Эцэг эх, сургалт, боловсрол, эрүүл мэндийн байгууллага бүх түвшинд ер нь энэ нэг энэ хар тамхины аюул заналын талаарх мэдээлэл, мэдлэг бас их дутмаг байгаа. Эцэг эхчүүдийн бас хараа хяналт, боловсролын байгууллагын бас энэ сургалтын хөтөлбөрт энэ хор хөнөөлийн талаар бас ойлгуулах, хэтэрхий бас нөгөө болгоомжилж энэ далд сурталчилгаа болчих вий гэж болгоомжилсноос болоод нөгөө талынх нь аюул нь бол ерөөсөө энэ хэвийн хүүхдүүд бас саваагүй байдаг, залуучууд саваагүй. Тийм учраас энэ 1 удаа хэрэглээд, 2 удаа хэрэглээд ингээд дараа нь больчихож болно гэсэн ийм хөнгөн, хөнгөмсгөөр найдаж, уруу татагдаж хүүхдүүд, залуучууд энд бас хэрэглэж байгаа тохиолдлууд олон байгаа.

Тийм учраас энэний аюул, энэ сэтгэц, бие махбодод үзүүлж байгаа хор хөнөөлийн талаар бол маш сайн ойлголтыг эцэг эх, энэ эрүүл мэнд, боловсролын байгууллагын түвшинд бол ойлгуулж, энэ тусгай хөтөлбөр, сургалтын арга зүй нэвтрүүлэх шаардлага байгаа гэдгийг бас энд хэлье. Тэгээд энэ талаар бол бид бас хуулийн төсөл дээрээ тодорхой зохицуулалтуудыг оруулж өгсөн гэдгийг хэлье.

Ер нь гаалийн байгууллага, тагнуулын байгууллага бол гадаад улсаас Монгол Улсад орж ирж байгаа хууль бусаар нэвтрүүлж байгаа энэ сэтгэц нөлөөт бодисын, бодист хяналт тавих энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүргийг хэрэгжүүлж байгаа. Таслан зогсоох. Сүүлийн жилүүдэд бол бас гаалийн байгууллага дээр лабораторийн хүчин чадал, рентген төхөөрөмжүүдийг бол нэлээн сайн авч, хөрөнгө оруулалт хийж байгаа. Тийм учраас бас энэ төрлийн сэтгэц нөлөөт бодисын олон одоо бид нарын бас нууц, далд аргаар энэ өөрөө бас үндэстэн дамнасан, зохион байгуулалттай, онц ноцтой гэмт хэрэг байдаг учраас нууц далд аргаар нэвтрүүлэх энэ үйл ажиллагаанд хяналт тавихад бол бас техник тоног төхөөрөмжийн хувьд бол бас бэхжүүлж байгаа. Цаашдаа ч тэгэхдээ хөрөнгө оруулалт шаардлагатай байгаа, хүнээ сургах шаардлагатай байгаа. Энэ хүрээнд бас хуулийн төсөл дээр гаалийн байгууллага, тагнуулын байгууллага, хар тамхитай тэмцэх албаа бэхжүүлэх энэ техник, тоног төхөөрөмж хөрөнгө оруулалтын талаар тодорхой саналууд тусгасан байгаа гэдгийг хэлье.

Монгол Улсын хэмжээнд бол 11 аймгийн нутаг дэвсгэр.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Лхагвасүрэнгийн Саранзунболдын урилгаар нийслэлийн ерөнхий боловсролын “Сэнлизэ” сургуулийн 10^а, 11^а, 12^а ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэндээ сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Цааш нь хариулъя 4 дүгээр микрофон.

Д.Мөнх-Эрдэнэ: Монгол улсын нутаг дэвсгэрт 11 аймгийн нутаг дэвсгэрт бол энэ олсны төрлийн ургамал ургаж байгаа Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс өгсөн зөвлөл, чиглэл бидний Хар тамхитай тэмцэх алба, Хууль зүй, дотоод хэргийн яамнаас барьж байгаа гол бодлого бол энэ олсны төрлийн өвс, ургамлыг бол бүрэн устгах ийм зорилт тавьж байгаа. Тэгээд энд бол бас энэ бүрэн устгахад бас бид бас арга ажиллагаагаа өөрчлөхгүй бол бас бидэнд бас ингээд л устгал явагддаг дахиад тэр үр нь хөрсөндөө байгаа учраас ингээд бас үр дүнгүй байгаа тохиолдол байгаа. Тийм учраас энийг бас олон улсын сайн туршлага, аргачлалыг нэвтрүүлж, бид бас энэ олсны төрлийн ургамлыг бүрэн устгах ийм зорилго тавьж ажиллаж байгаа. Энэ талаар ч гэсэн хуулийн төслийн үзэл баримтлал танилцуулахад үзэл баримтлал төсөлд бас тодорхой үүрэгжүүлж тусгасан байгаа гэдгийг хэлье. Баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Алтаншагай гишүүн тодруулъя.

Н.Алтаншагай: Юуг асуусан даа би нөгөө хавдартай хүмүүст хэрэглэдэг эм энэ бас нөгөө хориотой эм бэлдмэлд орчхоод байгаа. Энийг яаж ялгаж ангилж байгаа вэ?

Ж.Бат-Эрдэнэ: 4 номерын микрофон.

Ш.Энхтуяа: Сайн байцгаана уу? Алтаншагай гишүүний асуултад хариулъя. Эрүүл мэндийн яам ахлах шинжээч Энхтуяа байна. Тэгэхээр Монгол Улсад эмнэлгийн тусламж, үйлчилгээнд хэрэглэж байгаа мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн жагсаалтыг Эрүүл мэндийн сайдын тушаалаар баталж, эмнэлгийн тусламж, үйлчилгээнд хэрэглэнэ гэж Эм эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд заасан байдгийн дагуу жагсаалтыг баталдаг.

Жагсаалтыг батлахдаа олон улсын конвенцуудад заасан жагсаалтад орсон эм, бодис, түүний давсуудыг агуулсан бүтээгдэхүүнийг баталдаг. 2025 онд хамгийн сүүлд эрүүл мэндийн сайдын 408 гэдэг тушаалаар энэ жагсаалтаа шинэчилсэн. Энэ жагсаалтад сэтгэцэд нөлөөт эм 36 нэр төрөл олон улсын нэршлээрээ орсон. Мансууруулах эм бол 14 нэрээр орж батлагдсан байж байгаа. Гишүүний асуулт нь асууж байгаа бол зарим нөгөө хавдартын тусламж, үйлчилгээнд хэрэглэдэг олон улсын конвенцид ч ороогүй боловчиг хяналттай хэрэглэх шаардлагатай тухайлах юм бол “трамадол” эм бол сэтгэцэд нөлөөтэй эмийн жагсаалтад ордог, оруулсан байгаа. Энэ яагаад вэ гэхээр энэ эмийг эмчилгээний зориулалтаар бус хууль бусаар авч иргэд амь насаа.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Гүйцээж хариулъя 4 номер.

Ш.Энхтуяа: Өсвөр насны иргэд бу урвуулан ашиглах ийм тохиолдол байдаг учраас энэ жагсаалтад оруулж хяналтыг сайжруулж ажиллаж байгаа. Үүнээс гадна бас та бүхэн мэдэж байгаа сүүлийн үед бас хүүхдүүд мэдрэлийн гаралтай хүчтэй үйлчилгээтэй өвчин намдаах эмийг хууль бусаар авч хэрэглэж гараа тайруулах эрүүл мэндээрээ эрсдэх эрсдэл байгаа. Тэгэхээр энэ шинэчилсэн найруулгын төсөл дээр бол эмнэлгийн тусламж, үйлчилгээнд хэрэглэх олон улсын конвенцын жагсаалтад орсон эмээс гадна бусад зорилгоор урвуулан ашиглах эмийн жагсаалтыг Эрүүл мэндийн сайд батлахаар энэ хуулийн төсөл дээр явж байгаа.

Ингэж жагсаалтыг гаргаж байж энэ хууль бус эргэлтээс сэргийлэх, иргэдийн эрүүл мэндийн хамгаалах, хяналтыг сайжруулах зорилго тавьж байгаа.

Мөн жороор олгох эмийг бол бид нар цаасан болон цахим жороор олгодог. Бид хэд энэ Эрүүл мэндийн сайдын тушаалын шинэчилсэн найруулгаараа бол бас цахим жорын асуудлыг энэ рүү тусгаж оруулж өгч байгаа. Ингэснээрээ хэрэглээг нь хянахаас гадна яг энэ эм хэрэглэх ёстой. өвчтөнүүд маань эмээ авч байна уу хууль бус.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн.

Д.Энхтүвшин: Энэ хуулийн төслийн 57 дугаар зүйлд хэрэглэгчийн эрүүл мэндийн асуудал гэдэг агуулгаар нь, тусламж үзүүлэх гэдэг агуулгаар нь ийм заалт оруулж ирсэн байсан. Энэ нь бас ахиц дэвшил юм шиг харагдаж байгаа. Тэгэхээр 57.4-д нь сайн дурын шинжилгээгээр бодис хэрэглэсэн тогтоогдсон хүний эрх зүйн байдлыг дордуулах, хүний эрх, эрх чөлөөтэй холбоотой сөрөг үр дагавар үүсэхгүй байхаар. 57.5-д нь болохоор мөрдөн шалгах, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулахыг хориглоно гэсэн ийм агуулгатай заалтуудыг оруулж ирсэн байгаа. Тэгээд энэ нь өөрөө хэрэгжих магадлал нь бас бусад хуулиудад дагалдаж байгаа хуулиудтай, уялдах хуулиуд дээр өөрчлөлтүүд ороогүй болохоор хэрэгжих магадлал бас бага харагдаад байгаа юм.

Тухайлбал, Эрүүгийн хуулийн 20.7 дээр энэ өөрөө илрүүлчхэж байна гэдэг чинь олж авсан гэдэг зүйл ангид хамрагдахаар өөрөөр хэлбэл 1-5 жилийн хорих ялтай ийм зүйл, анги байгаад байгаа юм. Нөгөө талаас бас энэ нөгөө эрт илрүүлгийн явцад олж авсан энэ мэдээллийг нь нотлох баримтад ашиглахгүй байх гэсэн тийм Эрүүгийн байцаан шийтгэх хууль дээр ч юм уу тийм зүйл, заалт байхгүй болохоор буцаад энэ 57.4, 5 хоёр маань хэрэгжихгүй байх ийм үндэслэл байж магадгүй. Тэгэхээр энийг хэрэгжүүлдэг болгохын тулд тухайлбал энэ Эрүүгийн хууль дээрээ тэр олж авах гэдэг зүйл, заалтыг нь хасах гэдэг юм уу эсвэл тэр нотлох баримтад ашиглахгүй байх гэдэг иймэрхүү өөрчлөлтүүдийг дагалдаж бусад хуулиудаар оруулж болоогүй юу? Энийг та хэд юу гэж харж байгаа вэ? Энэ талаар асуулт.

Ж.Бат-Эрдэнэ: Хариулт өгье, хариулъя 4 номер.

Д.Мөнх-Эрдэнэ: Энхтүвшин гишүүний асуултад хариулъя. Ер нь олон улсын жишиг сүүлийн үеийн хандлага бол ер нь хэрэглэгчдийг бол ер нь ял шийтгэл энэ ялын бодлогоор айлгахаас илүү урьдчилан эмчлэх, эргэж нийгэмшүүлэх энэ дээр анхаарч байгаа. Манай хуулийн төсөл ч гэсэн яг энэ чиглэлээр боловсруулагдсан. Өөрөөр хэлбэл, хэрэглэгчийг яаж энэ буруу зуршил, донтолтоос анагаах вэ, эргээд нийгэмшүүлэхэд нь туслах вэ гэдэг.

Ер нь бол Зөрчлийн хуульд бас бид өөрчлөлт оруулсан байгаа. Өөрөөр хэлбэл одоо бол хэрэглэгчийг, хэрэглэгчийг бол ер нь албадан эмчлэх, баривчлах, 30 хүртэл хоногоор, 30 хоногоор баривчлах. Ингэж Зөрчлийн хуулиар албадан эмчилж, мөн 30 хоногийн хугацаагаар баривчлах ийм шийтгэл оногдуулахаар өөрөөр хэлбэл Эрүүгийн хууль ялаар бол ял шийтгэл оногдуулахгүй гэсэн ийм байдлаар зохицуулж байгаа.

Сая Эрүүгийн хуулийн өөрчлөлт, Эрүүгийн хуулийн төсөлтэй холбоотой асуудлын хувьд бол ер нь гол концепц нь бол энэ худалдан борлуулах зорилгоор ийм зорилгоор энэ санаа зорилгын хувьд бол өөр байгаа олж авч байгаа этгээдүүдийн хувьд. Худалдан борлуулах, зуучлах ийм зорилгоор олж авч байгаа этгээдүүдийн хувьд бол энэ бол эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ. Яг хэрэглэсэн хүний хувьд бол зөрчлийн ял, шийтгэл хүлээлгэж, албадан эмчлэх ийм зорилго байгаа. Тэгээд манай хууль сахиулах байгууллагуудын хувьд бол дан ганц Эрүүгийн процессын хуулийг хэрэглэхээс гадна энэ холбоотой Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуульд заасан хүний эрхийг хамгаалахтай холбоотой энэ донтсон иргэдийг эмчлэх, эргээд нийгэмшүүлэхтэй холбоотой энэ заалтыг мөн хэрэглэж, хууль сахиулах үйл ажиллагаанд ашиглах ёстой гэж үзэж байгаа. Баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Энхтүвшин гишүүн тодруулъя.

Д.Энхтүвшин: Тийм. Яг энэ оруулж ирж байгаа 57.4, 5, 57 дугаар зүйл чинь бол бас яг хэрэгтэй зөв заалт байгаа. Гэхдээ энийг амьдруулахын тулд 20.7 чинь Эрүүгийн хууль дээр саяын тэр худалдаалах зорилгогүй, энэ 20.7-г уншвал мансууруулах бодисыг худалдаалах зорилгогүйгээр хууль бусаар бэлтгэсэн, хадгалсан, олж авсан нь нотлогдвол 1-5 жилийн хорих ялтай ийм хэвээр байгаад байхгүй юу. Тэр өөрөөр хэлбэл худалдаалах зорилгогүйгээр олж авсан бол өөрөөр хэлбэл энэ шинжилгээгээр хэрэглэсэн ч юм уу ингээд хамааралтай гэдэг нь тогтоогдвол олж авсан гэдэг нотлох баримт болохоор байгаа байхгүй юу. Тэгээд энэ нь өөрөө Эрүүгийн хуулийн зүйл ангиар 1-5 жилийн ялтай учраас энэ сайн дураараа тэрийгээ нотлуулах ч гэдэг юм уу, эсвэл энэ дээр бас хуулийн 5.7.2 дээр эцэг эх, асран хамгаалагч нь басхүсэлт гаргаж болохоор энэ сайн дурын шинжилгээн дээр байгаа.

Тэгэхээр энэ нь өөрөө буцаагаад тэр хүмүүсүүдийг хэрэгт энэ эрүүгийн зүйл, анги энийгээ өөрчлөхгүй бол ял, гэмт хэрэгтэн болох иймэрхүү нөхцөл байдал руу шахах гээд байгаа юм биш үү?

Ж.Бат-Эрдэнэ: Хариулъя 4 номер.

Д.Мөнх-Эрдэнэ: Энхтүвшин гишүүний асуултад хариулъя. Таны болгоомжлолыг бид ойлгож байгаа. Тийм учраас ажлын хэсгийн түвшинд бид энийг илүү тодруулж, үзэл баримтлалын хүрээнд бид бол яг энэ концепцоор боловсруулсан.

Өөрөөр хэлбэл, худалдан борлуулах, цааш нь энэ ашиг олох зорилгоор олж авсан, зуучилсан, дамжуулснаас бусад тохиолдолд бол энэ хэрэглэж байгаа хүмүүсийг бол Зөрчлийн хуулиар шийтгэж албадан эмчлэх энэ зохицуулалтыг гол концепцууд боловсруулсан. Хэрвээ энэ санаа таны болгоомжлолын хүрээнд байгаа асуудлыг бид бас ажлын хэсгийн хүрээнд илүү тодорхой болгож, хууль хэрэглээний хувьд ямар нэг алдаа завхрал гаргахгүй байх энэ түвшинд бас анхаарч ажиллая гэж бодож байна. Тэгээд та бас таны саналыг бид анхаарч ажиллая.

Ж.Бат-Эрдэнэ: Энхтүвшин гишүүн дахин тодруулъя.

Д.Энхтүвшин: Тийм гол нь тэр 20.7 дээр олж авах гэдэг худалдах зорилгогүйгээр энэ мансуурлуудыг олж авах гэдэг энэ Эрүүгийн хуулийн зүйл, заалтыг нь өөрчилчихвөл. Дээр нь энэ нөгөө сайн дураараа энэ шинжилгээнд эрт илрүүлэлтэд хамрагдаж байгаа хүмүүсүүдийн энэ нотлох баримтад эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх энэ нотлох баримтад ашиглах байх гэдэг иймэрхүү агуулгууд л орчихвол энэ 57-гийн энэ заалт чинь зөв хэрэгжих болох юм байна гэж бодож байна. Баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Хассуурийн Ганхуяг гишүүн асуултаа асууя.

Х.Ганхуяг: 4, 5 асуулт байна. Одоогийн байгаа мэдээллээр бол хорих ангиуд дээр голцуу хэрэглэгч мансууруулах бодисын хэрэглэгч нар голцуу байдаг гэж би ойлгоод байгаа юм. Тийм мэдээлэл авсан байна. Тэгээд бид нар энэ шинэчилсэн найруулгаар тэрийгээ бас ялгаж салгаад илүү борлуулдаг тэр сүлжээг нь ил илрүүлэх, ялын бодлогыг нь чангаруулах ийм хуулийн төсөл орж ирж байна гэж би ойлгож байгаа юм. Тэгээд манаачийг хэн манах вэ гэдэг л нэг юу байдаг л үг байдаг л даа. Тэгэхээр өнөөдрийг хүртэл ер нь миний ойлгож байгаа энэ хууль сахиулах байгууллагын нэлээн оролцоо, хууль сахиулах байгууллагад ажилладаг хүмүүсийн оролцоо их байсан гэж би ойлгоод байгаа юм. Өнөөдрийг хүртэл би ямар ч байсан хэвлэл мэдээллээс ийм борлуулалтын ийм сүлжээг илрүүллээ, ингэлээ, тэглээ гэдгээс мэдээлэл ерөөсөө харсангүй.

Тэгэхээр өнөөдрийг хүртэл хэчнээн тийм сүлжээг илрүүлсэн бэ гэдэг нэг асуудлыг асуултыг асуумаар байна. Одоо бол сошиал дээр ч хүртэл яг ний нуугүй хэлэхэд бол борлуулна, авна, яана, ийнэ гэсэн юмнууд бол мэдээлэл явж байдаг. Энд үүнтэй холбоотойгоор өнөөдрийн байдлаар хууль хяналтын байгууллагаас ямар нэгэн байдлаар мэдээлэл өгсөн юм байдаггүй. Том, томоохон хэмжээний аян эд нар зарладаг. Тэгээд тэн дээр бол хэдэн хэрэглэгчийг аваачаад хорьчихдог. Гэтэл яг яг тэр борлуулж байгаа, оруулж ирж байгаа тэр сүлжээтэй холбоотойгоор ямар нэгэн мэдээлэл өнөөдөр бол ил тавигдсан юм байхгүй. Энэ дээр нэг хариулт өгчих.

2 дугаарт, 2022 онд Согтууруулах ундааны хяналтад тавих хуулиуд баталсан. Би өөрөө ажлын хэсэгт нь орж ажилласан. Үүн дээр бол Донтолтын эсрэг сан байгуулаад тус онцгой татвараас тодорхой хэмжээг нь тэр сан руу оруулаад тэгээд энэ донтолтын эсрэг эмчилгээ эд нар хийнэ гээд хууль баталсан байдаг. Өнөөдрийн байдлаар энэ тал дээр ямар нэгэн арга хэмжээ авч байгаа байдал руу бас мэдээлэл авсангүй. Одоо ингээд сүүлдээ Эрүүл мэндийн сайд нь Эрүүл мэндийн даатгалын сангаас энэ архидан согтуурах, тэр донтолтын эсрэг эмчилгээнд мөнгө зарцуулаад явж байгаа гэсэн байдлаар яригдаад байна. Тэгээд энэ тал дээр ямар арга хэмжээ авах талаар бас нэг мэдээлэл авчихмаар байна.

Мөн мансуурах бодис гэдэг маань яг эргээгээд тэр СЭМҮТ-тэй л холбоотой байх л даа. Бас энэ 1 дүгээрт санхүүжилт нь тэр сангаас гарах юм уу? 2 дугаарт манай эмч нарын чадамж, боловсон хүчний нөөц хэрхэн ямар байгаа талаар мэдээлэл авчихмаар байна. Манай эмнэлэг эмнэл зүйн талын түвшин энэ талдаа ер нь хэр ямар түвшинд байгаа талаар бас мэдээлэл авмаар байна.

Дараагийн асуудал бол энэ гадаадад тодорхой хэмжээний энэ мансууруулах бодис эм бол ингээд зөвшөөрөгдсөн байдаг. Тэгээд тэрийг бол

“DHL” болон бусад байдлаар ингээд оруулж ирдэг гэсэн асуудал бас яригддаг. Тэгээд аягүй олон хэлбэрээр тэр мансуурах бодисыг ингээд чихэр, жимс, ундаа сүүлдээ тэр “варе” гээд бас болоод яваад байх шиг байна. Энэ дээр хэрхэн яаж ямар хяналт тавих юм гэдгийг бас нэг асуучихмаар байна. Тэгээд асуучхаад дараа нь тодруулъя.

Ж.Бат-Эрдэнэ: Хэн хариулах вэ? Амарсайхан сайд хариулъя.

С.Амарсайхан: 1 дүгээр асуулт Ганхуяг гишүүний яг ямар ямар илрүүлэлт арга хэмжээ авч байна гэж мэдээлэгдэхгүй байна гэж. Нэг дутагдал бий манайдб Энэ хар тамхи, мансууруулах бодисын талаар ерөөсөө ярьж болохгүй гэсээр байгаад далд хэлбэр рүү шилжсэн. Энэ нь хар тахал болж хувирах хэмжээнд бас суурь нь тавигдсан байна гэж байгаа юм.

Өнөөдөр энэ чиглэлээр хийсэн, илрүүлсэн хэрэг авч шийдэгдсэн гэдэг юм уу, хэрэг бүртгэл үүссэн, шийдвэрлэсэн асуудал үндсэндээ 2000 гарчихсан байна. Үүний 80 хувь нь залуучууд байна. 18-35 насны. 17 нэр төрлийн мансууруулах эм, эмийн бодис ингээд хар тамхины төрлийн бүтээгдэхүүн өнөөдрийн байдлаар албан ёсны тоо баримтаар 510 мянган хүн туныг хурааж авсан байна.

Хэрэглэгч рүү чиглэсэн, донтогч руу чиглэсэн ийм хандлага явж ирсэн бол одоо жинхэнэ нийлүүлэгч, худалдагч, үйлдвэрлэгч, нөгөө зохион байгуулалттай гэмт бүлгүүд рүү чиглэсэн үйл ажиллагаа, цагдаагийн байгууллага, холбогдох мэргэжлийн албад улсын хэмжээнд төдийгүй гадаад улс орнуудтай хамтарсан маягаар зохион байгуулж байна. Хамгийн сүүлд Турк улсаас, Польш улсаас олон жил манай улс руу хар тамхи нийлүүлсэн зохион байгуулалттай бүлэглэлүүдийн заримыг нь барьж саяхан Польш улсаас 1 сарын өмнө баривчилж ирсэн. Энэ чиглэлийн ажил бол нэлээн бас эрчимтэй явж байгаа. 1 дүгээрт.

2 дугаарт бол энэ урьдчилан сэргийлэх ажлууд хийгдэж байгаа боловч ялангуяа энэ нөхөн сэргээх энэ эмчилгээ өөрөө 3-6 сарын хугацаа хамгийн багадаа шаарддаг. Цаашлах юм бол түүнээс ч урт хугацаа шаарддаг учраас нөхөн сэргээх болон энэ донтолтыг эмчлэх бас засах ажлууд хийгдэх ёстой боловч хангалттай хийгдэхгүй байгаа. Орон байрнаас эхлээд төсөв санхүү гээд асуудлууд байна. Энэ хүрээнд түрүүний ярьсан тэр 3 дахь асуулт буюу энэ сангууд байгаа гэдэг шиг ингээд архи донтолтын өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулах сан байдаг боловч энэний зарцуулалт хөрөнгө санхүү, хууль, эрх зүйн орчин тодорхойгүй учраас бас дорвитой ажлууд хийгдэхгүй байгаа асуудлууд байна.

Тийм учраас бид нар энэ хар тамхи мансууруулах бодистой холбоотой асуудлуудыг зөвхөн ярьж болохгүй гээд таг чимээгүй яваад байх биш. Яг бодитой нөхцөл байдал, аюул эрсдэл бий болж байгаа хүндрэлийг бодитойгоор ярьж дэврэхгүйгээр түүнд тохирсон арга хэмжээнүүдийг яаралтай авч хэрэгжүүлэхгүй бол Зүүн өмнөд азийн улс орнууд, тэгээд манай хөрш зэргэлдээ улс орнуудаас эхлээд манай зах зээлийг онилсон, зохион байгуулалттай улс, үндэстэн дамжсан бүлэглэлүүд байна. Энэ чиглэлээр орж ирж байгаа хил гаалийн хяналтууд байгаа боловч бас илүү чангаруулах шаардлага байна гэж байгаа юм. Тэгээд энэ бүхнийг нь.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Ганхуяг гишүүн тодруулъя.

Х.Ганхуяг: Тэр гадаадад тодорхой хэмжээний энэ мансууруулах энэ бодис зөвшөөрөгдсөнийг нь тэр нь импортын талаарх мэдээллийг асуулт дээр хариултаа өгчхөөрэй.

2 дугаарт, одоо ингээд нэлээн олон мянган хүн бол яг донтогч нарыг ингээд бид нар хорих ангиудад оруулчихсан байгаад байна шүү дээ. Тэгэхээр энэ хууль батлагдсанаар ямар арга хэмжээ авах юм? Уг нь бол тэр эмнэлгийн тусламж шаардлагатай ийм хүмүүсийг аваад хорьчихоод байгаа байхгүй юу. Тэгсэн мөртөө яг худалдан борлуулсан зарим манай бүүр дипломат төлөөлөгчийн ажилчид хүртэл зөөвөрлөж байгаад тухайн орноос хөөгдөж байсан хүмүүс байдаг. Тэгээд тийм хүмүүсээс яг одоогийн байдлаар ер нь яг баригдсан, хоригдсон, шалгагдаж байгаа асуудал ер нь байгаа юу, байхгүй юу гэдэг асуултад хариулт авчихмаар байх юм.

Ж.Бат-Эрдэнэ: Ажлын хэсэг 4 номерын микрофон.

Д.Мөнх-Эрдэнэ: Ганхуяг гишүүний асуултад хариулъя. Ер нь энэ Архидан согтуурахтай тэмцэх сан гэж байгаа. Энэ 2023 оноос үйл ажиллагаа явуулсан. Одоогоор 23 тэрбум төгрөг төвлөрчихсөн байгаа. Энэ сангийн үйл ажиллагаанд бол энэ сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөтөлбөр арга хэмжээнд бол энэ мансууруулах энэ эм, донтох эмгэгтэй тэмцэх чиглэлээр бол хамрагдсан зүйл байхгүй. Тэгэхлээр бид бол дагалдуулж боловсруулсан Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд оруулсан өөрчлөлтөөрөө энэ хар тамхи, мансууруулах бодистой тэмцэх энэ бодлого, үйл ажиллагааг энэ сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх энэ тодорхой зохицуулалтыг оруулж өгч байгаа гэдгийг хэлье.

Ер нь гаднаас Монгол улс руу нэвтрүүлж байгаа энэ.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Гүйцээж хариулъя 4 дугаартай микрофон.

Д.Мөнх-Эрдэнэ: Энэ гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр бас гаалийн байгууллага, тагнуулын байгууллагын чиг зүгээс онцгой анхаарч байгаа. Гаалийн байгууллага энэ хяналт шалгалтын тоног төхөөрөмжид зөвхөн 2025 онд гэхэд 11 тэрбумын санхүүжилт тавьж рентген тоног төхөөрөмжөөс авхуулаад олон шинэ төрлийн тоног төхөөрөмжийг худалдан авсан. 2026 оны төсөв дээр бол 9.2 тэрбум төгрөг тавьсан байгаа.

Бид бас хуулийг, шинэ хуулийн төсөл батлагдсан тохиолдолд шаардлагатай санхүүжилтийн хувьд бол бас тодорхой саналууд тусгасан байгаа. Энэний бас дийлэнх нь бол ер нь нийт 8 тэрбум гаруй төгрөгийн 6.6 тэрбум нь бол ер нь цэвэр техник тоног төхөөрөмж, хяналт шалгалтын багаж, шаардлагатай багаж тоног төхөөрөмж энэ сорил, энийг энэ шаардлагатай хөрөнгийг бол тусгасан байгаа. Тэгэхлээр хуулийн төсөл батлагдсан тохиолдолд бид бас улсын төсвийн төсөлд тусгаад ингээд явна.

Ж.Бат-Эрдэнэ: Ганхуяг гишүүн тодруулъя.

Х.Ганхуяг: Асуултад яг гүйцээд хариулбал би ингээд олон тодруулмааргүй л байгаа юм л даа. Яах вэ би нэг сүүлчийн асуултаа л асуучихъя. Шударга ёсны зарчим нийцүүлээд ялын бодлогыг чангаруулна гэсэн байна. Мэдээж хэрэг тэр донтогч нар дээр бол зөөлрүүлэх юм байна. Гэхдээ нөгөө ялын шийтгэлийн бодлого, чанар эрүүгийн эрх зүйн чиг хандлагатайгаа хэрхэн яаж уялдаж байгаа вэ? Тэгээд ийм өндөр зохион байгуулалттай, асар их мөнгөтэй энэ хүмүүсийн ингээд ялын бодлогыг нь чангаруулахаар эргээгээд нөгөө гэрчийг устгах ч гэдэг юм уу энэ хэрэг сөрөг үр дагаврууд нь юу байх вэ гэдгийг нэг тодруулчихмаар байх юм.

Ж.Бат-Эрдэнэ: Хариулт 4 дугаартай индэр.

Д.Мөнх-Эрдэнэ: Энэ Нэгдсэн Үндэсний Байгууллагын үндэстэн дамнасан 4 төрлийн гэмт хэрэг байдаг. Энэний нэг нь энэ хар тамхитай холбоотой гэмт хэрэг байна. Таны хэлж байгаа үнэн. Маш өндөр зохион байгуулалт, маш их мөнгө эргэлддэг ийм гэмт хэрэг. Тийм учраас энэ гэмт хэрэгтэй тэмцэхэд бол тусгай арга ажиллагаа, маш сайн бэлтгэгдсэн хүний нөөц, тусгай алба шаардлагатай. Тийм учраас бас Засгийн газраас энэ Хар тамхитай тэмцэх газрын үйл ажиллагааг өргөжүүлж алба болгосон байгаа. Шаардлагатай санхүүжилт, хөрөнгө оруулалтыг тавьж байгаа. Цаашид бол энэ энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэхэд бол мэдээж энэ алба, энэ гэмт хэрэгтэй тэмцэж байгаа алба, албан хаагчид энэ байгууллагын хүчин чадал, чадавх, хүний нөөцийг бэлтгэх ийм шаардлагатай байгаа олон улсын хамтын ажиллагаа маш чухал. Манай Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хар тамхи гэмт хэрэгтэй тэмцэх албаны суурин төлөөлөгчийн газрыг Монголд байгуулах асуудал Засгийн газрын түвшинд яригдаад Засгийн газрын хуралдаан.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: 4 номер гүйцээж хариулъя.

Д.Мөнх-Эрдэнэ: Ялын бодлогын хувьд бол энэ түрүүн бас хэлж байсан. Энэ хэргийг зохион байгуулж байгаа, худалдан борлуулж байгаа энэ этгээдэд хүлээлгэх ялын бодлогыг чангатгаж байгаа. Энэ бол олон улсын хандлага. Бид бол яг хуулийн төсөл дээрээ одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулиар Эрүүгийн хууль тогтоомжоор бол ерөөсөө энэ худалдан борлуулсан энэ тун хэмжээнээс үл хамаарсан ийм ялын бодлого хэрэгжиж байгаа. Олон улсад бол хэмжээнээс нь хамаараад оногдуулах ял харилцан адилгүй чанга байгаа. Тийм учраас бид яг энэ чиглэлээр хуулийн төслийг боловсруулсан. Байнга давтан үйлдэж байгаа энэ гэмт хэргийг зохион байгуулалттайгаар үйлдэж байгаа, энд оролцож байгаа албан тушаалтнуудад хүлээлгэх ялын бодлогыг чангатгаж ингэж хуулийн төслийг боловсруулсан гэдгийг хэлье.

Та бас түрүүн асууж байсан. Ер нь энд албан хаагч нар оролцож байгаа тохиолдлууд байна уу гэсэн. Байгаа. Сүүлийн.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Энэ дэлгэц дээр минут гарч байгаа шүү дээ. Тэрийгээ харж байгаад хариулаад шаардлагатай бол гараа өргөөд нэмэлт авч хариулаарай.

Саруулсайханы Цэнгүүн гишүүн асуултаа асууя.

С.Цэнгүүн: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. Тэгэхээр дэлхий даяар бол архины хэрэглээ буураад байгаа сайн үзүүлэлт байгаа ч гэсэн дэлхий даяар нөгөөтээгүүр хар тамхины хэрэглээ асар ихээр нэмэгдээд байгаа үзүүлэлтүүд манай улсад ч гэсэн харагдаад байна. Ерөнхийдөө бол энэ хар тамхи, мансууруулах бодисын донтолтоос урьдчилан сэргийлэх зорилгоор манай улс бас хуульдаа өөрчлөлт оруулаад донтолтын эмчилгээний байгууллагатай болох гэж байгаа нь бас зөв гэж миний хувьд бол үзэж байгаа.

Гэхдээ энэ хуулийн төсөл дээр болохоороо 61 дүгээр зүйл дээр Донтох эмнэлгийг сэргээн засах төвийн бүтцийг Хууль зүй, дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлах бөгөөд даргыг мөн тус сайд томилно гэж оруулж ирсэн байна л даа. Тэгэхээр нөгөө Дэлхийн эрүүл мэндий байгууллага, НҮБ-аас бол энэ донтолтын тухай асуудал чинь эрүүл мэндийн асуудал юм гэж бол тодорхойлсон байдаг.

Тэгэхээр одоо яг энэ хуулийн төсөл дээр энийгээ Хууль зүйн сайд нь хариуцаад явна гэдэг агуулгаар оруулж ирж байгаа нь хэр зүйтэй юм бол? Яагаад хуулийн төсөл дээр ингэж оруулсан юм бол гэдгийг нэгд асууя.

Хоёрт болохоор Энхтүвшин гишүүнтэй бас адилхан асуулт байлаа. Тэр маань болохоороо бид нар яг энэ хуулийн агуулгаараа бол сайн дураар эмчилгээнд орох гээд тэгээд шинжилгээ өгөөд өөрөө ингээд хүсэлт гаргасан иргэнийг бол эмчилгээнд хамруулна гээд оруулаад ирсэн хэрнээ яг энэ хууль дээр хамт Зөрчлийн тухай хуульдаа болохоороо бид нар чинь хэр хэрвээ ямар нэгэн байдлаар хар тамхинд хэрэглэсэн гэдэг нь шинжилгээгээр тогтоогдох юм бол энэ хүнийг баривчилна гэхчхэн байгаад байгаа юм.

Тэгэхээр энэ чинь нэг хүн өөрөө эмчилгээндээ хамрагдах юм уу, эсвэл баривчлагдах юм уу гэдэг энэ зүйл, заалтууд нь хоёулаа ямар ч ялгааг нь гаргаж өгөөгүйгээр оруулаад ирчихсэн байгаа учраас энэ маань өөрөө тийм сонин аль ч утгаар нь ойлгож болохоор байдал үүсгээд байна. Тэр утгаараа хууль цаашид хэлэлцэгдээд явахдаа энэний ялгааг гаргаасай гэж хүсэж байна.

Үндсэндээ миний байр суурь бол бид бүхэн хүн сайн дураараа энэ донтолтоосоо гарахыг хичээгээд өөрөө сайн дураараа хэлж байгаа тохиолдолд энийг бол албадан баривчилгаа бол хийх ёсгүй гэж бол харж байгаа. Тэгэхээр тэр талаас нь ажиллаасай гэж хүсэж байна.

Нөгөө талдаа бас ингээд сайн дурын эмчилгээнд хамрагдаж байгаа хүмүүсийн хувьд бол дараагийн ээлжид анхаарал хандуулж байгаа зүйл нь бол хувийн мэдээллийг яг хэрхэн хамгаалах вэ, тухайн хүмүүсүүдийн мэдээлэл маань өөрөө яг хамгаалалттай байж чадах уу гэдэгт нь бас их чухал байна. Яагаад вэ гээд тэгэхээр тухайн нөгөө хувь хүмүүсийн мэдээлэл өөрөө ил тод байх юм бол тухайн хүмүүс өөрсдөө өөрийнхөө нэр усыг гаргаад ингээд явах нь өөрсдөд нь эрсдэлтэй гэж үзээд бас яг сайн дурын эмчилгээнд хамрагдахгүй байгаад байх эрсдэл бас ингээд харагдаж байгаа.

Тэгэхээр бид нар хуулиараа яаж хувь хүний мэдээллийг, аюулгүй байдлыг хангах вэ гэдэг дээрээ нэлээн сайн тусгаж өгөх хэрэгтэй юм болов уу гэж бол хараад байна.

Ерөнхийдөө бол энэ хар тамхи болон энэ донтолттой холбоотой асуудал жил ирэх тусам нэмэгдээд байгаа талаар тоон статистикуудыг Хууль зүйн яамны сайд Амарсайхан бас ингээд танилцуулж байна. Тэгээд та өмнө нь бас 5 жилийн турш онцгой байдлын хариуцсан Шадар сайдаар бас ажиллаж байсан. Тэгээд ер нь яагаад энэ бүх цаг үеийн турш манай энэ гэмт хэрэг, тэгээд энэ онцгой байдалтай холбоотой байгаа асуудлууд ерөөсөө сайжрахгүй дордоод байдаг юм бэ?

Жишээ нь хар тамхитай холбоотой байгаа асуудал дээр энэ дийлэнх нь бол импортоор орж ирж байгаа юм. Тэгэхээр энэ манай гаалийн хэн ажиллаж чадахгүй байгаад байна уу? Таны нүдээр яг асуудал нь хаанаа байгаад байгаа юм бэ? Та өндөр дээд албан тушаал, сайдын суудал дээр олон жил сууж байгаа хүн учраас мэдээлэл маш сайн байгаа болов уу гэж харж байна. Тэгэхээр таны байр суурийг бас сонсмоор байна?

Ж.Бат-Эрдэнэ: Амарсайхан гишүүн, Амарсайхан сайд.

С.Амарсайхан: Цэнгүүн гишүүний асуултад хариулъя 1 дүгээрт хуулийн зорилго бол ер нь аль ч хууль бай бид хорьж, яллах, шийтгэх буруутгах гэхсээ түрүүлээд урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, илрүүлэх, зөвлөх, тэгээд дээрээс нь дэмжлэг, туслалцаа үзүүлэх гэдэг рүү чиглэх ёстой. Тэгэхээр 1 дүгээр зорилго бол урьдчилан сэргийлэх рүү чиглэх ёстой.

Үнэхээр хууль зөрчсөн тэгээд хууль бус үйл ажиллагаа явуулсан ялангуяа хар тамхитай холбоотой энэ дээр нөгөө худалдах, борлуулах, импортлох, тэгээд экспортлох болон ашиглах зорилго, зорилгоор хууль бусаар олж авсан, бусдад дамжуулсан, бэлтгэсэн, тээвэрлэсэн, илгээсэн, хадгалсан ч гэдэг юм уу тэгээд улсын хэл хэлээр хууль бусаар нэвтрүүлсэн, хууль бусаар үйлдвэрлэсэн бол энэ ял шийтгэлийг нь зохих хэмжээгээр нь хууль үйлчлэх ёстой. гэж үзэж байгаа 1 дүгээрт.

2 дугаарт бол мэдээж сайн дураараа эмчлүүлэх эсвэл өөрсдөө хууль бусаар олж авах гэхээсээ түрүүлээд хуулийн дагуу төрөөс үзүүлж байгаа эмчилгээнд хамрагдах, тэгээд урьдчилан сэргийлэх чиглэлээр өөрөө өөрсдөө эмчилгээнд хамрагдах ийм зорилготой бол тэр үнэн ёсыг заавал шийтгэх, яллах гэдэг бодлого, байр суурийг энэ хууль тавихгүй байгаа. Өөрөөр хэлэх юм бол хувь хүний мэдээллийн нууцыг хадгалах ёстой. Хувь хүний мэдээллийн нууцын тухай хууль холбогдох хуулийн хүрээнд мэдээллийг нууцалж, тэгээд зөвлөгөө, туслалцаа, дэмжлэгээ үзүүлж явах нь хуулийн үйлчлэлийн нэг чухал хэсэг.

3 дугаарт бол сая асууж байна манай энэ хил гааль үнэхээр ажлаа хийж байна уу гэж. Мэдээж хууль хяналтын байгууллага хил гаалийнхан ажлаа хийж байгаа. Гэхдээ хар тамхи гэдэг бол 1 дүгээрт манай дотоодод ургадаг ургамлууд байна. Үүнийг устгах, мөн эх үүсвэрийг нь таслан зогсоох асуудлуудаас гадна хил, гааль 2 бол өөрөө энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх хамгийн эхний үүд хаалга. Тийм учраас хил, гаалийн үйл ажиллагаа тэгээд таслан зогсоох асуудлууд илүү чанаржиж байх шаардлагат, энэ чиглэлийн хөрөнгө оруулалтуудыг нэмэгдүүлэх хэрэгтэй. Бүх хилийн боомтууд, хилийн боомтын аюулгүй байдалтай холбоотой хил нэвтэрч байгаа иргэд, зорчигчдын ачаа тээшинд хяналт тавих асуудлуудыг

чирэгдэлгүй. Гэхдээ инновац технологид суурилсан байдлаар илрүүлж, таслан зогсоох ажил хамгийн түрүүнд тавих ёстой. Энэ хүрээнд бол бид хамгийн сүүлийн үеийн техник технологиудыг бас хөрөнгө оруулалт хийж нэмэгдүүлэх шаардлага бий.

Энэ төрлийн гэмт хэргүүд яагаад буурахгүй байна вэ? Мэдээж хууль хяналтын байгууллагад чиглэл чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа юм. Өөр өөрсдийн мэргэшсэн алба.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Цэнгүүн гишүүн тодруулъя.

С.Цэнгүүн: Энэ нөгөө хуультай хамт дагаж орж ирсэн маш олон хуулиуд байна лээ. Тэгээд дагаж орж байгаа хуулиуд дээрээ бид нар Зөрчлийн тухай хууль дээр байгаа заалтаа бас нэлээн анхаарч харах хэрэгтэй харагдаад байгаа юм. Тэгэхээр яг хуулийн үзэл санаа дээрээ бол сайн дураараа эмчилгээнд хамрагдах гэж байгаа хүмүүсээ бид нар хамгаалах гэдэг үзэл баримтлалаа дагаж байгаа бол Зөрчлийн хууль дээрээ дагаж орсон хууль дээрээ бас анхаараарай гэж ажлын хэсэгт бас хэлмээр байна.

Дараагийн юм нь болохоороо бас энэ насанд хүрээгүй хүүхдийг уруу татсан байх юм бол ялын санкц дээр өөрчлөлт орж ирж байгаа ийм зүйл, заалт байгаа. Тэгээд энэ өөрөө бас зайлшгүй байх ёстой. Өмнө нь бол энэ төрлийн насанд хүрээгүй хүүхдүүдийг гэмт хэрэгт уруу татсан байдал дээр бол ялын зүйл, заалт болон санкцууд нь тодорхойгүй байсан юм байна гэж харж байгаа. Тэгэхээр та бүхэн энийг бас тодруулаад надад хэлээд өгч болох уу?

Ж.Бат-Эрдэнэ: Хариулт өгье 4 номерын индэр.

Д.Мөнх-Эрдэнэ: Цэнгүүн гишүүний асуултад хариулъя. Одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Эрүүгийн хуулийн 16.2 дугаар зүйл хүүхдийг согтуурах, мансуурах, тонтох байдалд татан оруулах гэж үйл анги байгаа. Энэ дээр бол ялын санкцын хувьд бол торгох, зорчих эрх хязгаарлах, хорих ийм 3 төрлийн сонгох санкцтай байгаа. Нас барсан тохиолдолд хүлээлгэх хариуцлага бол 5-12 жилийн хорих ялтай. Тэгэхээр бид энийг нийгмээ гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, үр нөлөөг нь харгалзаад энэ согтуурах, мансуурахыг донтоход энийг нь салгаж өгч байгаа. Тийм учраас энэ нийгмийн аюулын шинж чанараар бол энэ хүүхдийг мансуурах байдалд татан оролцуулах нь бол илүү аюултай гэмт хэрэг. Хүнд хор уршигтай учраас энд хүлээлгэх хариуцлагын ялын бодлогыг чангатгаж гэж байгаа юм. Сонгох санкцгүйгээр 2-оос, 2 жилээс 8 жил хорих ял. Эрүүл мэндэд хохирол учирсан бол 5-12 жилийн хорих ял. Энэ төрлийн гэмт хэргийг бага нас.../минут дуусав./

Ж.Бат-Эрдэнэ: Болсон уу? Саруулсайханы Цэнгүүн гишүүн асуулт асууж, хариулт авч дууслаа.

13 цаг болсон тул 14 цаг хүртэл чуулганы хуралдааныг завсарлаж завсарлуулж байна.

13.03 цаг

Пүрэв гараг 04 Зургаадугаар сар 2026

Төрийн ордон “Их хуралдай” танхим 14 цаг 01 минут

ҮДЭЭС ХОЙШИХ НЭГДСЭН ХУРАЛДААН

Ж.Бат-Эрдэнэ: Ажлын хэсгээ оруулъя, гишүүдээ оруулъя. Үдээс хойши чуулганаа эхэлүүлъя. Амарсайхан сайдыг дуудъя. Ажлын хэсэг Хууль зүй, дотоод хэргийн сайд Амарсайхан.

Батын Батбаатар гишүүн асуултаа асууя. Алга байна. Болдын Уянга гишүүн асуултаа асууя.

Б.Уянга: Энэ өдрийн мэнд хүргэе. Тэгэхээр энэ мансууруулах эм болон сэтгэцэд нөлөөлөх энэ бодистой холбоотой хууль 2002 оноос ингээд хэрэгжээд явж байгаа. Тэгээд одоо ингээд шинэчилсэн найруулгаар засагдах гэж байна. Хуулийн төсөлтэй ингээд танилцахад тийм хариуцлага гэдэг үгэнд л хариулт авмаар байгаа юм. 2002 онд яг энэ хууль батлагдах үед энэ мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодистой холбоотой гэмт хэрэг 2 батлагдаад, 2 гараад тэгээд өнөөдөр болохоороо бараг 150 дахин өсчихсөн байгаад байгаа байхгүй юу. Тэгээд энэ хууль гараад л тоонуудыг нь гаргаж ирсэн байдлаараа 150 дахин өсчихсөн. Тэгэхээр магадгүй та хэдийн хариулт нь тийм учраас энэ хуулийг орж ирж байна гэх байх.

Ингээд мэргэжлийн хяналтын байгууллага эргэж байгуулагдах хэрэгтэй байна. Яагаад гэвэл энэ ингээд муудаад байна гээд бас хариулж магадгүй. Тэгвэл мэргэжлийн хяналтын байгууллага энэ үед чинь байгаад байхгүй болсон мөртөө танай энэ хуулийн төсөл дээр байгаа бүх статистик чинь дандаа өсчихсөн байна шүү дээ. Тэгэхээр энэ мэргэжлийн хяналтын байгууллагатай хамаатай зүйл биш байх шиг байгаа юм. Тэгэхээр яг хаана нь алдаа гараад, хаана нь хариуцлагагүй байгаа учраас энэ гэмт хэргийн асуудал нь тогтмол өсөөд байгаа юм? Тэгээд яг энэ хууль дээр яг юу нь энийг засах юм энэ шинэчилсэн найруулгын та хэдийн оруулж оруулж ирсэн дээр? Тэгэхээр энэ хариуцлага алдсан л байгаа шүү дээ. Хариуцлагыг нь яаж хэнд яаж яг яах вэ? Энэ хууль шинэчилж найруулагдсанаараа энэ хариуцлагагүй байдлыг яаж засах вэ? Миний яг үндсэн асуулт энэ байгаад байгаа юм.

Тэгээд ингээд энэ урвуулан хэрэглэх эрсдэлтэй эм бэлдмэл гэдэг нэр томъёог харж байгаа юм. Тэгээд ингээд сүүлийн 8 жилийн хугацаагаар 17 төрлийн мансууруулах сэтгэцэд нөлөөт болон урвуулан хэрэглэх эрсдэлтэй эм бодисыг хүн тунгаар илэрхийлбэл гэж байгаад 419 мянга 293 хүн тунтай тэнцэхээр байна. Тэгээд энэ яг олон улсдаа хаана явж байна гэсэн үг юм? Ингээд абсолют тоогоор өгчих юм. Их юм уу бага юм уу? Энд яг хэрхэн яаж бид нар санаа зовж засаж сайжруулах гэж явах ёстой юм? Тэгээд яг цаашдаа яаж хяналтыг сайжруулах вэ? Хэлэлцэх эсэхээ явж байгаа учраас яг хууль дээрээ яаж тусгасныг нь асууя. Тэгээд цаашдаа яахыг нь мэдээж дараа дараагийн ажлын хэсэгт нь ороод ажиллаж болох байх.

Ингээд 3 дахь асуулт нь болохоороо гэмт хэрэгт холбогдсон иргэд нөгөө 2002 оноос хойш тасралтгүй өсөөд байгаа гэмт хэрэгт холбогдсон этгээдээ та хэд боловсролын түвшнээр нь судалжээ. Дээд боловсролтой хүмүүс нь 22 хувь байна гэж. Ер нь ингээд энэ зан үйлийн хувьд нь урьдчилсан сэргийлэх байдлаар боловсролын байгууллагатай хамтарч ажиллах ёстой юм шиг. Яг энэ боловсролын байгууллагатай хамтарч ажиллах агуулгыг нь энэ хуулийн төсөлд хаана суулгасан юм? Энэ 3 асуултад хариулт авчхаад үргэлжлүүлээд асууя.

Ж.Бат-Эрдэнэ: Ажлын хэсэг хариулъя. Дэд сайд Мөнх-Эрдэнэ.

Д.Мөнх-Эрдэнэ: Уянга гишүүний асуултад хариулъя. Үнэхээр бас энэ хар тамхи бол үнэхээр тахал болсон. Хар тахал болсон. Үндэстэн дамнасан гэмт хэрэг маш нарийн зохион байгуулалттай маш их мөнгө хэрэглэдэг ийм гэмт хэрэг. Энэ гэмт хэргийн гаралт бол анх хууль батлагдсанаас, батлагдаж байх үетэй харьцуулахад бол үнэхээр өссөн. Анх бол 2 гэмт хэрэг үйлдэгдэж байсан гэсэн статистик мэдээлэл байвал өнөөдөр энэ тоо жилд 233 болж дунджаар өссөн ийм сэтгэл эмзэглүүлсэн тоон мэдээлэл байгаа.

Тэгэхлээр энэ гэмт хэрэгтэй тэмцэх гэдэг бол ер нь зөвхөн Хар тамхитай тэмцэх албыг ажиллуулах, цагдаа, хуулийн байгууллага ажиллахаас гадна энэ урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, эцэг эхчүүдийн насанд хүрсэн хүмүүсийн хараа хяналт, энэ талаарх боловсрол, мэдлэгийг дээшлүүлэхээс эхлэх ийм олон цогц ажлаас хамаарч байгаа.

Тэгэхлээр бид бол бас энэ дээр алдсан гэж үзэж байгаа. Өөрөөр хэлбэл энэ аюулыг таниулах, урьдчилан сэргийлэх энэ чиглэлээр хийх ажлууд бол дутуу хийгдэж байсан учраас бас бид бас санаа зовоох ийм түвшинд хүрсэн. Тийм учраас Үндэсний аюулгүй байдлын зүгээс зүгээс ч гэсэн хууль сахиулах байгууллага Хууль зүй, дотоод хэргийн яам Засгийн газарт бол удаа дараа чиглэл өгсний үр дүнд бид бас энэ 1 дүгээрт эрх зүйн орчноо шинэчилье гэж байгаа юм. Цаг үеийн шаардлагад нийцүүлж эрх зүйн орчноо шинэчилье.

2 дугаарт хууль сахиулах байгууллагуудаа бэхжүүлье.

3 дугаарт энэ урьдчилсан сэргийлэх соён гэгээрүүлэх чиглэлээр дараа нь энэ нэгэнт донтсон хүмүүсийг сэргээн засах, нийгэмшүүлэх чиглэлд энэ олон улсын стандартуудыг нутагшуулах, хэрэгжүүлэх чиглэлээр энэ чиглэлээр бас нэгэнт үйл ажиллагаа нь сайжраад жигдрээд явж байгаа төрийн бус байгууллагууд байна. Эд нарыгаа дэмжих энэ цогц талаас нь харахыг аль болох хичээсэн. Тэгж хуулийн төслийг боловсруулсан.

Одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль бол жишээ нь, 4 бүлэг, 18 зүйлтэй. Өөрөөр хэлбэл маш цомхон зохицуулалттай. Ял шийтгэлийн бодлого гэхэд л Эрүүгийн хуулийн 5 зүйл, ангиар ял шийтгэх ийм бодлого хэрэгжиж байгаа. Маш олон нийгэмд аюултай үйлдэл, хүнд хор уршигтай гэмт үйлдлүүд Эрүүгийн хуулиар зохицуул ял шийтгэлийн бодлого нь шийдэгдэхгүй, Зөрчлийн хуулиар торгуулаад өнгөрөх ийм нөхцөл байдал байсан. Тийм учраас энийг бүхэлд нь өөрчлөх ингэж концепцоор боловсруулсан.

Бид нарын боловсруулсан хуулийн төсөл бол 11 бүлэг, 76 зүйлтэй. Бид дагалдуулаад 41 хуулийн төсөл боловсруулсан байгаа. Энэ хууль нь бүгд бол өөрөө бол холбогдох хууль сахиулах байгууллагууд, эрүүл мэнд, боловсролын байгууллага, тагнуул, гааль, цагдаа, Хар тамхитай тэмцэх алба, төрийн захиргааны төв байгууллага. Нөгөө талаасаа энэ бол маш олон байгууллагуудын ажлын.../минут дуусав./

С.Бямбацогт: Уянга гишүүн тодруулж асууя.

Б.Уянга: Тайлбарыг ер нь бол сонслоо. Хуулийн төслийг дэмжиж байгаа л даа. Яг аль хэсэгт нь анхаарах ёстой юм, яг яаж сайжруулах юм, хариуцлагыг нь яах юм гэдэг дээр оноогоод өөрийнхөө асуултад өөрөө хайгаад л нэлээн их ажиллах хэрэгтэй юм байна. Тэгээд ажиллая. Гэхдээ нэг зүйлийг асуумаар байна яг тэрийг хариулахдаа яг хуулийн тэр тэрийг нь хараарай гэж хэлээрэй. Тэгэхээр улсын хэмжээнд гарч байгаа гэмт хэргийг мэдээж илрүүлж байгаа. Миний түрүүний дурдсан тэр 150-д 2022 оноос хойш 150 дахин өссөн статистик бол хамаагүй дарсан тоо байх гэж бодож байгаа. Сайн илрүүлж чадаагүй л байх. Тэгээд яах вэ зүгээр илрүүлнэ гэдгээсээ гадна гарч болзошгүй нөхцөл байдлыг таслан зогсооно гэдэг дээр хуулийн төсөлд тусгагдсан зүйл байна уу? Эрсдэлд орохоос нь сэргийлнэ гэсэн агуулга яг хаана суусан бол?

С.Бямбацогт: Ажлын хэсэг 4 дүгээр микрофон.

Д.Мөнх-Эрдэнэ: Уянгаа гишүүний асуултад хариулъя. Хуулийн төслийн 8 дугаар бүлэг, мөн хуулийн төслийн энэ төрөөс баримтлах бодлоготой холбоотой асуудлыг зохицуулсан. Би заалтыг нь танд хараад хэлье. 2 дугаар бүлэг. Энэ 2 бүлэг дээр бол энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх төрийн байгууллагуудын хүлээх чиг үүрэг, хариуцлага, ажлын уялдаа холбоог сайжруулахтай холбоотой тодорхой заалтууд байгаа. Тэгээд бид бас мэдээж хэн нэгэнд хариуцлагагүй ажилласан гэхээсээ илүү бид цаашдаа яаж энэ ажлыг сайжруулах вэ, эрх зүйн орчны хүрээнд яаж сайжруулах вэ? Энэ байгууллагуудын уялдаа холбоо хангагдаж өгөхгүй байна. Тийм учраас энэ олон байгууллагуудын оролцоо, эрүүл мэнд, боловсрол, хууль сахиулах байгууллагууд энэ сэтгэл.../минут дуусав./

С.Бямбацогт: Отгоншарын Батнайрамдал гишүүн асуултаа асууя. Алга байна. Даваахүүгийн Ганмаа гишүүн асуултаа асууя. Алга байна. Салдангийн Одонтуяа гишүүн асуултаа асууя.

С.Одонтуяа: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Өнгөрсөн 4 жилд бас энэ асуудал дээр Улсын Их Хурал нэлээд анхаарч орж ирсэн төсвүүдийг нь батлаад, бүтэц орон тоог бас шинэчилж өгч байсан. Тэгээд энэ талаар нэлээд сайн үр дүнгүүд гарсан гээд надад бас энэ бид нарт ирсэн энэ хаалттай тайлангуудаар бол гарсан. Сүүлийн үед бас би нэг баярлаж байгаа зүйл юу вэ гэхээр энэ сошиалаар хар тамхины энэ зохион байгуулалттай ийм бүлэглэлийг илрүүллээ, тийм бүлэглэлийг илрүүллээ гээд ингээд гараад байгаа нь надад бол их таашаалтай байгаа. Би бас тэгээд энэ дээр Тагнуулын ерөнхий газар, цагдаа, холбогдох байгууллагуудад бас баяр хүргэх гээд байна л даа.

Өөрөөр хэлбэл, энэ мэдээллүүд ингээд сайн явснаараа энэ өөрөө урьдчилан сэргийлэхэд их чухал юм байгаа. Энэ бол бас ингээд нэлээд тэмцдэг

юм байна, энэ асуудлууд бол их ноцтой явж байна гэдгийг ингээд харахад. Энэ парламентад бол бас жоохон гишүүд хариуцлагатай хандах хэрэгтэй байдаг. Яагаад гэхээр сая сая гишүүд ингээд бүгдээрээ л гоё яриад байна л даа чухамхүү л байдал хүндэрлээ л гээд яриад байдаг. Гэтэл 26 онд орж ирсэн хар тамхитай тэмцэх төсвүүдийг дийлэнхийг нь л хассан шүү дээ. Би бүүр гүйж гүйж нэг хөтөлбөр хэрэгжүүлбэ гээд нэг хэдэн төгрөг тавиулсан бүгдийг нь хассан. Тусгай хяналтын дэд хороон дээр хасагдсан. Төсвийн байнгын хороон дээр хасагдсан. Тэгэхээр иймэрхүү хамаг төсвийг нь хасчхаад өнөөдөр ингээд матрын нулимс унагаагаад байх нь сонин л байна.

Би нэг хэдэн асуулт асуух гэсэн юм. Энэ ашиг олох зорилгоор хууль бус энэ үйл ажиллагаа явуулж байгаа энэ төрийн албан хаагчдад ер нь ямар хариуцлага өнгөрсөн хугацаанд яг ноогдуулж чадсан юм бэ? Та нар бол зохион байгуулалттай нэлээн олон бүлэглэлийг илрүүлсэн. Тэнд чинь цагдаагийнхан ингээд л холбогдох төрийн байгууллагынхан нэлээн байгаа шүү дээ. Тэгэхээр энэ хүмүүстээ яг хэдэн хүнд ямар хариуцлага ямар ял өгсөн юм бэ? Гол эд энэ хүмүүсийг чинь л бид нар ялын бодлогыг чангатгах гээд байгаа. Тэгээд шинэ хуулиар одоо ийм байсан бол бид нар ингэж чангатгаж байгаа юм гэдэг юмыг би сонсох гэсэн юм.

Бас нэг асуудал бол энэ 11.1.7-д заасан энэ заалтыг бол би бол ер нь хасах хэрэгтэй гэж үзэж байгаа. Энийг би бол яах вэ ажлын хэсэгт хэлнэ л дээ. Энэ заалтыг дэмжиж лоббиддог хүмүүс маш их байдаг юм. Энэ юу вэ гэхээр 11.1.7-д заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг зөвхөн энэ хуулийн 11.1-д заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдэд олгож болно гэсэн энэ заалтыг ер нь хасахгүй бол энэ каннабисын төрлийн ургамлыг эрдэм шинжилгээ, үйлдвэрлэлийн зорилгоор тариалах гэсэн асуудал бол гараад байдаг. Тэгээд манайд бол энэ бүрэн хяналтдаа авах боломж ер нь байдаггүй. Тийм учраас энэ асуудал дээр бас хариу авъя.

Бас нэг асуудал юу вэ гэхээр энэ хууль хүчний болон эрүүл мэндийн байгууллагын чиг үүргийг маш тодорхой заачихсан байгаа. Тэгсэн хэрнээ боловсрол шинжлэх ухаа, хөдөө аж ахуйн гээд бусад байгууллагын чиг үүрэг нь огт байхгүй байна. Энийг ингээд нарийвчлан тусгаж болоогүй юм уу? Энэ хувийн хэвшилтэйгээ хамтарна гээд байгаа. Одоо хувийн хэвшлийнхэн чинь бүгд хараад сууж байгаа. Төр яг яаж хамтарч ажиллах юм бэ гээд. Тэгэхээр хууль нь яг яаж хамтарч ажиллах юм, яг яаж дэмжих юм, яаж энэний эсрэг хамтдаа тэмцэх юм энэ төрийн бус байгууллага, иргэний нийгэм, хувийн эмнэлгүүд байна. Сэтгэл зүйчид байна. Энийгээ яах юм бэ? Энэ дэмжлэгийг чинь өгөхгүй бол төр дангаараа энэ ажлыг бол дийлэхгүй гэдэг байна.

Түрүүн бас Амарсайхан сайд хэлсэн. Энийг ярьж болохгүй гэж нуусаар байгаад л тэгээд л хяналтаас гарч байна шүү дээ. Одоо залуучууд тэр байтугай мэдээллийг олж авч байна. Тэгэхээр энэ хүүхэд хамгаа.../минут дуусав./

С.Бямбацогт: Хэн хариулах вэ? Дэд сайд Мөнх-Эрдэнэ 4 дүгээр микрофон индрийн.

Д.Мөнх-Эрдэнэ: Одонтуяа гишүүний асуултад хариулъя. Сүүлийн 10 жилийн статистик тоон мэдээллээс харахад бол яг энэ төрлийн гэмт хэрэгтэй холбогдсон 22 төрийн албан хаагч байна. 22. Үүнээс бол хяналтын прокурор 1,

онцгой байдлын албан хаагч 2, зэвсэгт хүчний албан хаагч 5, эмнэлгийн байгууллагын ажилтан 5, туслах прокурор, прокурорын туслах 1, шүүхийн Тамгын газрын цахилгаанчин 1, төрийн үйлчилгээний ажилтан 4 гээд, төрийн дипломат албан тушаалтан 2 гээд, багш 1 гээд. Тэгээд энэ бол ерөнхий энэ эдгээрт хүмүүст ноогдуулсан ял шийтгэлийн төрлөөс харахад бол хорих ялаар шийтгэгдсэн 6, зорчих эрхийг хязгаарлах ялаар шийтгэгдсэн 4, торгох ял 1, нийтийн албанд томилогдох эрхийг тодорхой хугацаагаар хязгаарласан 3, гадаад улсад шалгагдаж байгаа 2, шалгагдсан 2 гээд тэгээд тэнсэн харгалзсан 7 гээд ийм байгаа.

Тэгэхлээр бас энэ хүмүүсийн хувьд бол зүйл ангийн хувьд бол ийм. Гол нь бол ер нь бол ашиглах 20.7, Эрүүгийн хуулийн 20.7 дугаар зүйлд заасан хууль бусаар ашиглах гэсэн энэ гэмт хэрэг үйлдсэн байгаа.

Ер нь төрийн байгууллагуудын чиг үүрэгтэй холбоотой зүйл, заалтууд бол энэ 8 дугаар бүлэг 43-56 дугаар зүйлд тодорхой тусгасан. Энэ дээр бол эрүүл мэндийн байгууллага, боловсрол, гааль, тагнуул, цагдаа, Хар тамхитай тэмцэх алба, төрийн захиргааны төв байгууллагууд, нутгийн захиргааны байгууллагууд гээд бүх байгууллагуудын хүлээх үүрэг гүйцэтгэх ёстой чиг үүргийг аль болох тодорхой тусгахыг бас бид хичээсэн байгаа.

Тийм учраас бас нөгөө ийм жишээ нь боловсролын байгууллага ямар чиг үүрэг гүйцэтгэх юм бэ хар тамхитай тэмцэх төрийн бодлогын хүрээнд, эрүүл мэндийн байгууллага ямар чиг үүрэг гүйцэтгэх юм бэ. Энэ бүгдийг бол ингэж хуулийн төсөл дээр тодорхой тусгасан байгаа гэдгийг хэлье.

С.Бямбацогт: Даваахүүгийн Ганмаа гишүүн асуултаа асууя.

Д.Ганмаа: Энэ хуулийг нэлээн сайн хийж боловсруулж байсан ажлын хэсэг нь ч гэсэн нэлээн том хэсэг байна. Хэдхэн асуулт асууя. Энэ хууль дээр хороо тайлан, зөвшөөрөл хуульд байгаа байгууллага хяналтын механизмаа сайн тусгасан боловч ийм зорилтот үзүүлэлт дээр ийм судалгаа хийж гаргаж байсан уу? Жишээлбэл, 2030 он гэхэд хар тамхи хэрэглэгчдийн тоо хэдэн хувиар бууруулах вэ, өсвөр үеийнхээ хэрэглээг яаж хэдээр бууруулах вэ, эмчилгээнд хамрагдсан иргэдийн тоо хэ хэд болох вэ, ямар үр дүнгээр шалгуур үзүүлэлт болгох вэ гэдэг нь эхний асуулт.

6.2 дугаар зүйл дээр ингээд төсөлд Үндэсний хороо 2 жил тутамд тандалт судалгаа хийнэ гэж зарласан байна. Яагаад 2 жилд 1 удаа юм? Яагаад жилд 1 удаа ч юм уу, тэрнээс богинохон байж болоогүй юм? Жишээлбэл синтетик мансууруулах бодис сар сараар өөрчлөгдөж орж ирж байгаа. Тэгэхлээр энэ хэтэрхий хоцрогдсон хугацаа биш үү гэж?

3 дугаарт энэ 9 дүгээр бүлэг дээр хүнд тусламж, үйлчилгээ гээд шинээр бүхэл бүтэн бүлэг болоод ороод ирчихсэн гишүүд бас хэлж байна. Их сайжруулштай юм байгаа, дэвшилттэй байна. Үндэсний хорооны дэд дарга нь уул нь эрүүл мэндийн сайд юм байна. Энэ эрүүл мэндийн сайд энд байгаад Хууль зүйн яамны сайдтайгаа хамт энэ асуултад хариулах хэрэгтэй нэлээн энэ чинь чухал энийг чинь архаг өвчин гэж үзэж байгаа донтолт гэдгийг өөрийг нь.

Тэгэхлээр энэ дээр нэг л эмийнхаа мэргэжилтнийг Эрүүл мэндийн яамнаас манай Энхтуяа мэргэжилтэн мундаг сайн мэргэжилтэн. Тэгэхдээ бас сайд энд зайлшгүй байх ёстой. Энэнээс хойш дараачийнхэд нь бас орол цуулах шаардлагатай гэж би бодож байна даргаа. Энэ дондох эмгэгийн эмчилгээний хүчин чадал нь хэр зэрэг сайн байдаг юм бэ гэдгийг би асуумаар байгаа байхгүй юу жишээлбэл сайдаас? Дондох эмгэгийн эмч бид нарт хэд байгаа юм, хэдэн ортой эмчилгээний төв байгаа юм, энэ хууль хэрэгжсэнээрээ хэдэн шинэ төв байгуулах гээд байгаа юм, санхүүжилт нь тэрэндээ хүрч байгаа юу, хүрэхгүй байгаа юу гэх мэтчилэн энэ нэлээн эмчилгээтэй холбоотой асуултууд байгаад байна.

Энэ эмчилгээний дараа сая бас хэд хэдэн удаа хариулж байхдаа энэ нийгэмшүүлэх ажлыг их чухал байдаг. Тэрийг нэлээн оруулсан гэж ярьж байна. Тэгэхлээр энэ донтолтоос гарсан хүнийгээ ажилтай болгох, боловсролтой болгох, гэр бүлийн зөвлөгөө өгөх гэх мэтчилэн эдгээр зохицуулалт нь яаж орж ирж байгаа вэ?

25-аас доош насныхан нь анхны хэрэглэгчдийн дийлэнх нь байна гэсэн мөртөө энэ хуульдаа яагаад сургууль, их сургууль, эцэг эхийн оролцоо, ялангуяа 10 жилийн бас цахим орчны урьдчилан сэргийлэлт гэдэг асуудлуудыг ингээд нэг их тусгагдахгүй гүй явчихсан юм бэ гэдэг асуулт байгаад байна.

Энэ “dark web” гэсэн ойлголт байдаг. Одоо чинь нэг нүүр нүүрээ олоод бие биетэйгээ нэг худалдаж аваад худалдаад аваад зогсоод байх тэр кинон дээр байдаг шиг юм байхаа болиод телеграм ч юм уу электроник сигнал инстаграм энэ тэр хэрэглээд тэгээд худалдагч нь тэр “dark web” дээр дэлгүүрээ нээгээд бараагаа шууд борлуулаад явчихдаг. Кокайн, пентонил гээд бүр эм дээр нэртэйгээр. Тэгээд худалдан авагч нь биткойн юм уу, крипто валютаар төлбөрөө хийгээд явчихдаг, бараагаа шуудангаар илгээчихдэг ийм худалдагч болон худалдан авагч дээр энэ онлайн худалдан авагч, крипто валют ашигласан төлбөр тооцоо, ер нь энэ “dark web”-ээр шилжүүлсэн хар тамхины наймаатай тэмцэх эрх зүйн үндэс нь манайд хэр зэрэг байгаа юм бэ?

Ер нь ийм олон улстай ингээд харьцуулаад үзэх юм бол бид нар бас энэ боомтууд дээр байгаа бэлэн байдал жишээлбэл тэр хэдэн боомтын лаборатори байгаа юм? Мансууруулах бодис илрүүлэх төхөөрөмж нь хэр зэрэг юм, хар тамхи илрүүлдэг нохойны тоо хүртэл, сургалт тэд нарыг ч гэсэн надад жоохон тоо ангиллаар хэлээд өгвөл их сайн байна.

С.Бямбацогт: Хариултаа бэлдэж байгаарай.

Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Одонгийн Цогтгэрэлийн урилгаар нийслэлийн ерөнхий боловсролын 31 дүгээр сургуулийн 8^д ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Төрийн ордонтой танилцаж байгаа сургагч хүүхдүүддээ энэ өдрийн мэндийг хүргэж, сурлагын өндөр амжилт, хамгийн сайн сайхан бүхнийг Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс хүсэн ерөөе. Эрдэм номдоо бас шамдан суралцаж, анги дэвших шалгалтаа бас амжилттай өгөөрэй.

Ажлын хэсэг 4 дүгээр микрофон Мөнх-Эрдэнэ дэд сайд.

Д.Мөнх-Эрдэнэ: Ганмаа гишүүний асуултад хариулъя. Ер нь эрүүгийн нөхцөл байдал, хэрэглээний нөхцөл байдал бол хүнд байгаа. Тийм учраас энэ гэмт хэрэгтэй тэмцэх ялангуяа зохион байгуулалттай гэмт бүлэглэлүүд энэ олон улсын бас сүлжээ манай бас улсыг онилсон. Туркээс, Зүүн хойд, Зүүн өмнөд Азиас ийм шинж тэмдгүүд ажиглагдаж байгаа. Тийм учраас манай хууль сахиулах байгууллага Хар тамхитай тэмцэх газар, алба, Тагнуулын ерөнхий газар гаалийн байгууллага бол нэлээн хүчин чармайлттай ажиллаж байгаа.

Энэ бол олон улсын хамтын ажиллагаа их шаарддаг үндэстэн дамнасан гэмт хэрэг байдаг учраас ингэж ажиллах шаардлага тавигдаж байгаа. 2011 оноос хойш бол манайд энэ нөгөө синтетик бодисын хэрэглээ гаднаас нэвтрэх байдал бол эрс нэмэгдсэн. Хуучин бол дандаа дотроо олсны төрлийн өвс ургамал хэрэглэсэн тохиолдлууд гарч байсан бол онилсон гаднаас чиглэсэн ийм үйлдлүүд давтагдаж байгаа.

Тийм учраас энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэхийн тулд хуульд Хар тамхитай тэмцэх албаа бэхжүүлэх, хилээр орж, гарч байгаа хяналтын тоног төхөөрөмжүүд, рентген, аппаратуудаа бэхжүүлэх энэ чиглэлээр тодорхой ажлууд хийгдэж байгаа.

2025 оны улсын төсөв дээр жишээ нь 11 тэрбум төгрөг тавигдсаны хүчинд бас рентген тоног төхөөрөмж хяналт шалгалтын багажуудаа сайжруулсан. Энэ жил 9.2 тэрбум төгрөг гаалийн байгууллага дээр тавигдсан. Ингээд худалдан авах ажиллагаа нь хийгдээд явж байгаа гэдгийг хэлье.

Тэр хуулийн хэрэгжилт, хөтөлбөрийн хэрэгжилттэй холбоотой 2 жил тутам гэдэг бол бид бас энийг энэнээс илүү гол асуудал бол энэ дотоодын үндэстний жагсаалтын асуудал байгаа. Өөрөөр хэлбэл ял завшуулахгүй байх, энэ төрлийн гэмт хэрэгтэй үр дүнтэй тэмцэхийн тулд шинээр илэрсэн энэ синтетик бодисуудыг мэргэжлийн шинжээчид таньж, олж мэдээд олон улсын байгууллагуудтай хамтарч ажилласны үр дүнд үндэсний жагсаалтдаа шуурхай оруулж, заавал нөгөө олон улсын 61, 71 оны конвенцод орохыг хүлээхгүйгээр, 88 оны конвенцод орохыг хүлээхгүйгээр үндэсний жагсаалтдаа шуурхай оруулж, энэ ял завших энэ гэмт хэрэгт завшуулахгүй байх энэ гэмт хэрэгтэй тэмцэх энэ чиглэлээр үр дүнтэй ажиллах энэ зохицуулалтыг хуулийн төсөлдөө тусгасан байгаа.

Тэгэхлээр заавал 2 жилийг хүлээхгүйгээр тухай бүр шаардлагатай үед шинжээчдийн дүгнэлтийг үндэслэн энэ үндэсний жагсаалтаа шинэчлээд явах боломжтой гэж хэлье.

Манай Сэтгэц эрүүл мэндийн үндэсний төв, гаалийн байгууллага бас таны бас бусад асуудал дээр нэмж хариулна.

С.Бямбацогт: Нэмж хариулъя 4 дүгээр микрофон. Өөрийгөө танилцуулаад хариулъя.

С.Байгальмаа: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн эмч Байгальмаа байна. Ганмаа гишүүний асуултад хариулъя. Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв нь донтох эмгэг судлалын

тусламж үйлчилгээг дараах байдлаар үзүүлдэг. Донтох эмгэг судлалын клиник буюу хэвтэн эмчлүүлдэг тасаг нь 35 ор бүхий хэвтэн эмчлүүлдэг тасаг байна. Мөн өөртөө туслах бүлэг буюу өдрийн эмчилгээг 25 ор бүхий өдрийн эмчилгээг хэрэгжүүлэн ажилладаг.

2025 оны байдлаар архины шалтгаан, сэтгэцийн болон зан төрхийн эмгэгээр 2166 хүн эмчлэгдсэн бол архинаас бусад төрлийн сэтгэц идэвхт эм, бодисын шалтгаант сэтгэцийн ба зан төрхийн эмгэгийн улмаас 191 хүн хэвтэн эмчлүүлсэн тоон үзүүлэлт байна. Энэ байдлаас үзэхэд архинаас бусад төрлийн мансууруулах.../минут дуусав./

С.Бямбацогт: Гүйцээгээд хариулчихъя. 4 дүгээр микрофон.

С.Байгальмаа: Архинаас бусад төрлийн мансууруулах бодисын шалтгаант сэтгэцийн болон зан төрхийн эмгэгтэй хүмүүсийн хандаж, сайн дураараа хандаж тусламж үйлчилгээ авах байдал нь бол ийм цөөн тоотой байдаг байх нь.

Донтох эмгэг судлалын клиникт ихэвчлэн, ихэнх хувь нь архины асуудалтай хүмүүс архины шалтгаан солиоролтой хүмүүс хэвтэн эмчлүүлдэг. Ийм байдлаар тусламж үйлчилгээ үзүүлж байна.

С.Бямбацогт: Ганмаа гишүүн тодруулъя.

Д.Ганмаа: Энэ яг ингээд ямар бөөрөнхий хариулт юм бэ тэгж хэлэхээс дээ. Донтох эмгэгийн яг хэдэн эмч байгаад энэ одоо яг хар тамхи мансуурах бодис өнөөдөртөө хамааралтай л юм асууна шүү дээ би мэдээж. Тэрэнтэй тэмцэх эмчлэх урьдчилан сэргийлэх энэ боломж нь эмч, эмнэлэг, сувилагчийн хувьд ч эмнэлэг тусламж гээд бүхэл бүтэн бүлэг ороод ирчихсэн байгаа юм чинь тэр орны хувьд ч бүгдээрээ та нарт байгаа юм уу байхгүй юу гэдэг асуулт байхгүй юу. Байхгүй бол бид нар яаж тусал болохоор байна гэдгийг л яриад байгаа ухаантай байхгүй юу 1 дүгээрт.

2 дугаарт түрүүн тэр өгсөн хариулт ч гэсэн та яг маш дутуу байгаад байх юм. Тэр “dark web”-тэй та нар яаж тэмцэх гээд байгаа юм гээд асуугаад байна шүү дээ би. Худалдагч, худалдан авагч 2 нүүр нүүрээ тулахгүй шүү дээ. Тэгэхлээр чинь крипто валютаар яваад энэ худалдан авалт шуудангаар хүргэгдээд байгаа энэ асуудлыг яах гээд байгаа юм бэ? Хүүхэд, залуучуудад тусгаарласан бүлэг биш юм гэхэд зүйл, заалтаар энийг чинь нарийвчилж оруулж ирэхгүй юм уу? Тэр яагаад тэр чигээрээ тэр чигээрээ орхигдоод байгаа юм бэ гэдэг асуултууд яригдаад байна шүү дээ.

С.Бямбацогт: Амарсайхан сайд хариулъя.

С.Амарсайхан: Ганмаа гишүүн маш чухал асуудалд хөндөж байна. 1 дүгээрт бол манайд яг энэ чиглэлийн сэтгэл зүйч, эмгэг судлаачид, мэргэшсэн эмч нарын хомсдол байна. Энэ чиглэлийн эмчилгээ, оношилгооны газрууд бүрэн олон улсын стандартад нийцсэн хэлбэрээр байхгүй байна. Өнөөдөр Баянхонгор аймагт нэг төв баригдаж байгаа. Ашиглалтад арай ороогүй байна.

Тэгэхээр энэ чиглэлээр бид юу хийх вэ гэхээр 1 дүгээрт энэ архины согтууруулах ундааны эргэлтээс бий болдог сангийн хөрөнгийг олон улсын стандартад нийцсэн бүсчилсэн байдлаар энэ бол ганц газар бариад нэг газар хийгээд ингээд хэрэгцээ шаналал хангачих асуудал биш. Энэ урьдчилан сэргийлэх, сэргээн засах, эмчлэх, зөвлөх гээд маш олон үе шаттай арга хэмжээнүүд урт хугацаанд явдаг учраас энэ чиглэлийн мэргэжилтнүүдээ бэлдэх шаардлагатай байна. Энэ чиглэлийн дэд бүтэц, байр саваа бэлдэх шаардлагатай байгаа. Тоног төхөөрөмж хэрэгслүүдээ нэмэх шаардлагатай байна 1 дүгээрт.

2 дугаарт, энэ далд сүлжээтэй хэрхэн тэмцэх вэ гэдэг бол манай мэргэжлийн бай.../минут дуусав./

С.Бямбацогт: Гүйцээгээд хариулчихъя Амарсайхан сайд.

С.Амарсайхан: Хар тамхитай тэмцэх албыг илүү бэхжүүлнэ. Энэнээс гадна бол хар тамхитай тэмцэх хамгийн эхний үүд хаалга бол гааль хил. Тэгэхээр энэ хил гаалийн хяналтыг чадавхжуулахаас гадна энэ хүний хяналтаас гарсан өөрөөр хэлэх юм бол өөрийн чинь хэлээд байгаа тэр цахимаар зарагддаг, далд сүлжээгээр борлуулагддаг, олж илрүүлэхэд хүнд, төлбөр тооцоо нь крипто валютаар хийгддэг, цахимаар хийгддэг, байршил нь хүртэл нь нууц далдаар явдаг энэ нарийн аргууд илүү их дэлгэрч байгаа учраас энэ рүү чиглэсэн энэ байгууллагын албадын цагдаа, тагнуулын чадавхыг нэмэгдүүлэх ажлууд дээр бас онцгой анхаарал хандуулж байна. Тусгай ажлын хэсэг байгуулагдаад ажиллаж байна. Гадаад дотоодоос нийлүүлдэг олон суваг сүлжээ бүлэглэлүүд байна. Эхнээсээ байршил, зохион байгуулалттай бүлэглэлүүдийн уг мэдээллүүдийг тогтоож барих авч ир.../минут дуусав./

С.Бямбацогт: Мэндбаярын Мандхай гишүүн асуултаа асууя.

М.Мандхай: Энэ хуулийг оруулж ирж бас сайжруулж оруулж ирэх гэж байгаа бас Хууль зүйн яам сайдад бас талархсанаа илэрхийлье гэж бодож байна. Тэгээд энэ бол ганцхан Монгол Улс гэлтгүй ер нь дэлхий дахинд улс орнуудын толгойны өвчин болсон шийдэж чадахад маш хүндрэлтэй байгаа тулгамдаж байгаа асуудлын нэг. Тэгээд манай Монгол Улс шиг гуравны нэг нь залуучууд. 18-35 насны 10 жилийн өмнө 27 хувьтай байсан хүн ам өөрөө 20 хувь болсон байгаа. Тэгээд ингээд залуу бүлэг дээрээ залуу хүн ам дээрээ түшиж Монгол Улс нүүр царай болж төлөөлж явдаг энэ том бүлэгт сөргөөр нөлөөлж халдаж байгаа маш том асуудал бол энэ яах ч арга байхгүй энэ мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодис юм гэдгийг бас хэлэх нь зүйтэй.

Ерөнхийдөө зүгээр энэ донтолттой хүнийг зөвхөн шийтгээд зогсохгүй илүү энийг өргөн цар хүрээнд эрүүл мэнд, энэ сэтгэцэд нөлөөлөх, сэргээн засах гэсэн ийм өргөн цар хүрээнд нь бас харж байгаад нь бас талархаж нэг ч гэсэн алхам бас ахиж байгаа юм байна гэж бодож байгаа.

Тэгээд хэдэн асуулт байгаа юм. Бид нар яах вэ хэрэглэгч, донтогч гэдэг талаас нь их ярьдаг. Гэтэл энэний цаана байгаа энийг өдөөж байгаа өөрөө нөлөөлөгч, наймаачид, зуучлагч, зохион байгуулагчдын асуудлыг ерөөсөө их сайн ярьдаггүй. Тэгэхээр энэ асуудлыг ер нь энэ хуулиараа хэрхэн зохицуулж, илрүүлж,

энийг энэнтэй тэмцэх арга хэмжээ авах вэ, энэ хуульд ийм заалтууд тусгасан уу гэдгийг нэгд асууя.

2 дугаарт, түрүүн хэлсэн донтогчийг яллах бус илүү эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ болгож шийдэх ийм бодлого шаардлагатай байгаад байгаа. Хуульд бол тодорхой ерөнхий түвшинд нь тусгасан боловч яг цаана хэрэгжүүлэх тэр өөрөө механизм нь өөрөө тодорхой харагдахгүй байгаад байгаа юм. Тэгэхлээр яг энийг бодитой яг хэрэгжүүлээд явах бүтэц, төсөв яг эзэн хариуцагч нь хэн байх юм? Ямар чиг үүрэгтэйгээр хаана хэрэгжүүлэх юм бэ гэдэг бүтцийн ийм том асуудлыг ер нь хэрхэн шийдвэрлэхээр энэ хуульд тусгаж оруулж өгсөн бэ?

3 дугаар асуудал бол түрүүн хэлсэн 18-35 насныхан бол 20 хувийг эзэлж байгаа. Тэгэхээр энэ том хүн амд энэ хүрч байгаа хамгийн аюултай устгах бүүр түвшний ийм бүтээгдэхүүн сурталчлах хэрэглээ өөрөө энэ цахим орчин гэж харж байгаа. Тэгэхлээр энэ мессенжерээр, сошиал платформоор дамжуулаад, дээрээс нь бүүр далд энэ хэлбэрийн network-ийг ашиглаад, үүгээрээ дамжуулсан цахим төлбөр хийгдэж байгаа, цахим хүргэлт түрүүн Ганмаа гишүүний хэлж байгаа крипто валют зэрэг эдгээр энэ цахим орчинтой холбогдох ямар зохицуулалт механизмууд энэ хуульд орж өгч байгаа вэ? Энэ цахим хэрэгсэл ашиглаж үйлдэхээс сэргийлэх, илрүүлэх, дээрээс нь нотлох, энэ платформтай хамтрах энэ ямархуу тэр тусгай процесс хийгдэх шаардлагатай байна, хэрхэн шийдвэрлэж байгаа вэ гэдэг асуултыг асууя.

Дараагийн юм болохоор энэ худалдаалж байгаа газрууд, эмийн сан, дамлан наймаалж байгаа далд худалдаа хэлбэрээр хийгдэж байгаа энэ зэргийг энэ энэ мансууруулах бодист ордог орц, жор, нөгөө эмчийн жортойгоор магадгүй зарим нэг нь химийн түгээмэл хэрэглэгддэг эмийн бүтээгдэхүүнүүд хүртэл байгаа. Тэгэхээр энийг бас эмчийн жортой олгодог ч юм уу ийм зохицуулалтууд энэ хуульд тусгагдаж өгсөн үү гэдгийг бас асууя. Тэгээд хариултаа авчихъя.

С.Бямбацогт: Хариулъя ажлын хэсэг 4 дүгээр микрофон.

Д.Мөнх-Эрдэнэ: Мандхай гишүүний асуултад хариулъя. Ер нь гол хуулийн төслөөр шинээр орж ирэх концепцын асуудал бол энэ зохион байгуулалттай бүлэглэлд байнга тогтвортой энэ төрлийн гэмт хэргийг үйлдэж байгаа этгээдэд хүлээлгэх ял шийтгэлийн бодлогыг чангатгаж байгаа. Тийм учраас энэ үндэстэн дамнасан зохион байгуулалттай онц ноцтой гэмт хэрэгтэй тэмцэх төрөөс ялан шийтгэлийн бодлого, эрүүгийн бодлогод бол ийм өөрчлөлт орно.

Нөгөө талаасаа энэ тэмцэх хууль сахиулах байгууллага гааль, тагнуул, цагдаа, Хар тамхитай тэмцэх албыг бэхжүүлэх асуудал байгаа. Засгийн газар бол Хар тамхитай тэмцэх газрыг Хар тамхитай тэмцэх алба болгон өргөжүүлсэн. Хуулийн төсөл батлагдсан тохиолдолд бид бас зардлын тооцоон дээрээ тусгасан байгаа. Энэ эдгээр байгууллагын хүний нөөцийг тоо тоог нэмэгдүүлэх, 64-өөр нэмэгдүүлэх Хар тамхитай тэмцэх албаа. Цаашид бас шаардлагатай Шүүх шинжилгээний ерөнхий газрын хүрээнд лабораторийн хүчин чадлыг нэмэгдүүлэхэд шаардлагатай 6.6 тэрбум төгрөгийн зардлын тооцоо тусгагдсан байгаа. Тэгээд энэ асуудлуудыг шийднэ.

Гаалийн байгууллага бол тоног төхөөрөмж, хяналт шалгалтын тоног төхөөрөмж, рентген аппаратад шаардлагатай зардлуудаа бол тухай тухайн үед нь тусгагдаад шийдээд ингээд явж байгаа гэдгийг хэлье. Ер нь яах вэ түрүүн бас гишүүд асууж байсан. Нөгөө бид нарын бас гол асууд анхаараад байгаа зүйл бол энэ донтох эмэгтэй хүмүүс, энэ хэрэглээд эндээс салахыг хүссэн хүмүүс сайн дураараа ирж төрд шаардлагатай сайн дураараа эцэг эхийн зүгээс өөрөө болон ирээд энэ эмчлүүлье гэж байгаа тохиолдолд бол Зөрчлийн хуулиар ч шийтгэл оногдуулахаас илүү энэ хүмүүст эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх ял шийтгэл хүлээлгэхгүй байх, тэр хүний хувийн мэдээллийг нь хамгаалах, эрүүл мэндтэй холбоотой энэ мэдээллийг хамгаалах чиглэлээр хуулийн төсөлд тодорхой заалтууд тусгасан байгаа гэдгийг хэлье.

Цахим орчинд үйлдэгдэж байгаа гэмт хэргийн хувьд бол энэ бол бас хүндрүүлэх, Эрүүгийн хуулийн бид бас хуулийн өөрчлөлт тусгасан байгаа. Хүндрүүлэх нөхцөл байдлын нэгээр авч үзэж байгаа. Мэдээж энэ төрлийн гэмт хэрэг бол өөрөө бас маш нарийн зохион байгуулалттай хийгддэг учраас тэмцэх арга, ажиллагааны хувьд бол манай Хар тамхитай тэмцэх алба бол өөрөө болон бусад улсуудад улсуудын хууль сахиулах байгууллагууд, Нэгдсэн Үндэстний Байгуулгыг Хар тамхи гэмт хэрэгтэй тэмцэх албаны хүрээнд хамтын ажиллагааны хүрээнд энэ асуудлыг гэмт хэрэгтэй тэмцэх бодлогод бас тодорхойлж хамтарч ажиллах ийм шаардлагатай. Манай Монгол Улсад бас энэ Нэгдсэн Үндэстний Байгууллагын хар тамхи, гэмт хэрэгтэй тэмцэх албаны суурин төлөөлөгчийг ажиллахаар болж байгаа. Засгийн газрын түвшинд энэ НҮБ-тай хамтарч гэрээ байгуулж суурин төлөөлөгчийн газрыг нээж үйл ажиллагааг нь явуулахаар.../минут дуусав./

С.Бямбацогт: Болсон уу? Тодруулъя Мандхай гишүүн.

М.Мандхай: Яг одоо энэ хууль бодитой хэрэгжээд мансууруулах сэтгэц бодист энэ донтож байгаа иргэдийг илүү нөгөө түрүүн хэлсэн донтож байна гэж нийгмээс тусгаарлаж ялгахдаа биш, эсвэл яллахдаа биш, илүү энэ хүмүүст нь яаж эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг илүү хүртээмжтэй болгох вэ, зөвлөн чиглүүлэх вэ, дахин ингэж энд донтох ийм ашиглах байдлаас нь хязгаарлах вэ гэдэг дээр ганцхан гааль ч гэдэг юм уу, эсвэл энэ холбогдох хууль зүйн энэ яам, цагдаагийн ажил бол биш илүү энэ чинь өөрөө олон байгууллага хоорондын уялдаа холбоотой шууд хамааралтай.

Тэгэхлээр энэ дээр ингээд яг бодитой хэрэгжье гэхлээр процессын хувьд өөрөө энэ бас л тодорхой буугдсан харагдахгүй байгаад байна л даа. Эрүүл мэндийн байгууллага яг энэ дээр нь яг аль дээр нь яаж оролцох юм? Боловсролын байгууллага нь тэгвэл яг яаж?

С.Бямбацогт: Амарсайхан сайд хариулъя.

С.Амарсайхан: Маш зөв. Энэ хуулийн зорилго бол 1 дүгээрт урьдчилан сэргийлэх рүү чиглэж байгаа юм. Яллах, шийтгэх, эсвэл хэрэг хийх орчин нөхцөлийг бүрдүүлэхээс илүүтэй. Тэгээд энэ хүрээнд юу хийгдэх вэ гэхээр 1 дүгээрт энэ нийлүүлэлтийн сүлжээг таслан зогсооё гэж байгаа юм. Улам нарийсаж байгаа, цахимжиж байгаа, шуудангаар явж байгаа, төлбөр тооцоо. Өөрөөр хэлэх

юм бол эзэнгүй мэт боловч цаанаа нарийн зохион байгуулалттай эзэнтэй ийм далд сүлжээнүүдийг илрүүлэхэд чиглэсэн хууль.

2 дугаарт бол энэ зөвхөн цагдаа, хууль хүчний байгууллагын хийх ажил биш эрүүл мэндийн байгууллага, хөдөлмөр, нийгэм хамгааллын салбар, боловсролын салбар гээд энэ салбар бүрийн оролцоотойгоор урьдчилан сэргийлэх, эмчлэн засах, цаашлаад энэ төрлийн гэмт хэргийг бууруулахтай холбоотой нийгмийн чиглэлийн ажлуудыг хийх нь өөрөө хамгийн чухал байгаа юм.

Тийм учраас энэ цахим орчны хяналт, мөрдөн шалгах чадавхыг нэмэгдүүлэх ажил бас энэ чиглэлд явна. Мөн хил боомтын эрсдэлийн хяналтыг шинэ шатанд гаргах боломж бүрдэнэ. Нөгөө тал.../минут дуусав./

С.Бямбацогт: Мандхай гишүүн тодруулж асууя. Тэгээд тодруулж хариулъя.

М.Мандхай: Би бас нэг юм тодорхой асуусан байгаа. Ерөнхийдөө байгууллага хоорондууд бол энэ яг хэрэгжилт дээр бол зохион байгуулалтад ороод бүтэц, төсөв, тэгээд хүний нөөцийн асуудлыг бол шийдэхээр ажиллаж байгаа юм байна гэж ойлголоо.

Дараагийн юм дээр энэ худалдаалах. Энэ чинь химийн болон бусад бодис, эмийн, ургамлын гэсэн олон бүтээгдэхүүнүүд хамрагдаж байгаа. Энийг олон нийтэд худалдаалахаас сэргийлэх ямар урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах юм бэ? Жишээл эсвэл зарим нэгэн эмийн бодис, химийн бодис дээр эмийн жор бичигтэй байх юм уу, эсвэл ургамлын гаралтай, эсвэл олон нийтийн өргөн хэрэглээнд байгаа дэлгүүрээс худалдаж авах тэр бодис хэрэглээг хянах юм уу? Яг энэ дээр ингээд худалдаалах нийтэд ил тод байгаа тэр бүтээгдэхүүнүүдийг олон нийтэд худалдаалахгүй байх, эсвэл хязгаарлах тэр урьдчилан сэргийлэх ямар механизмууд байгаа вэ?

С.Бямбацогт: Дэд сайд Мөнх-Эрдэнэ.

Д.Мөнх-Эрдэнэ: Мандхай гишүүний асуултад хариулъя. Хуулийн төслийн 38 дугаар зүйл дээр энэ эмнэлгийн тусламж, үйлчилгээний байгууллага, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт эмээр үйлчлэх гээд ийм зохицуулалт нэлээн дэлгэрэнгүй орсон байгаа. Энэ нэг талаасаа бол эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд ашигладаг ийм эм бий. Сэтгэцэд нөлөөт бодисууд.

Нөгөө талаасаа хууль бус эргэлт. Тэгэхлээр энэ хууль ёсны эргэлтэд тавигдах хяналтыг бол нэлээн чангатгаж үүрэгжүүлж оруулсан байгаа. Өөрөөр хэлбэл, Хар тамхитай тэмцэх албанд мөн Үндэсний хороонд энэ эрүүл мэндийн байгууллага, эмнэлэг, аптекийн зүгээс худалдан борлуулсан, зарсан, үйлчлүүлсэн, үйлчилсэн энэ эм, сэтгэц нөлөөт бодисын талаарх бүх мэдээллээ

С.Бямбацогт: Гүйцээгээд хариулчих 4 дүгээр микрофон.

Д.Мөнх-Эрдэнэ: Ер нь бол энэ хууль ёсны бол хууль ёсны эргэлтэд тавих хяналтыг зөвшөөрлийн тогтолцоонд оруулсан энэ хэрэглээтэй холбоотой, худалдан борлуулсан, үйлчилгээтэй холбоотой бүх мэдээллүүд манай хууль

сахиулах байгууллагууд очиж байх ёстой. Энэ байгууллагуудын зүгээс байнгын хяналт тавина гэдгийг энэ хуулийн төсөл дээр тодорхой тусгасан байгаа.

Түрүүн бас таны асуултад бид бас нэмж хариулахад энэ нөгөө хуулийн төслийн 9 дүгээр бүлэг дээр эрүүл мэндийн тусламж, үйлчилгээтэй холбоотой нэлээн дэлгэрэнгүй зохицуулалт байгаа. Энэ дээр эмийн болон сэтгэл заслын эмчилгээ, донтох эмгэгийн сэргээн засах тусламж, үйлчилгээ, нийгмийн хамгааллын арга хэмжээ гээд 3 бүлэгт хувааж энэ хүрээнд хуулийн төслийг нарийн зохицуулах гэж оролдсон.

Өөрөөр хэлбэл, донтох эмгэгээс салсан хүнд жишээ нь нийгмийн хамгааллын ямар үйлчилгээ үзүүлэв. Эргээд нийгэмших, ажил төрөлтэй болох энэ тал дээр нь төрийн байгууллагууд.../минут дуусав./

С.Бямбацогт: Зочин танилцуулъя Улсын Их Хурлын гишүүн Цэвэгдоржийн Тувааны урилгаар Төв аймгийн Эрдэнэ сумын Политехникийн коллежийн 2025-аас 26 оны олон улсын тэмцээн, уралдаанд тэргүүлсэн багш, оюутнууд Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Шилдэг оюутнууд болсон та бүхэндээ Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс аз жаргал, эрүүл энх, сурлагын өндөр амжилтыг хүсье. Туваан гишүүн маань энд сууж байна.

Равжихын Эрдэнэбүрэн гишүүн асуултаа асууя. Алга байна. Лувсаннямын Гантөмөр гишүүн асуултаа асууя.

Л.Гантөмөр: Ажлын хэсгийн танилцуулгаас бид нар бол нэг зүйлийг маш сайн ойлгож байгаа. Хар тамхи бол одоо халдварт өвчин болсон, гамшиг болсон. Үнэхээр Монголын ирээдүйг бол асар ихээр бохирдуулж байгаа. Яг үндэсний аюулгүй байдалд бол заналхийлж байгаа. Тэгээд яг үндэсний аюулгүй байдалд заналхийлж байгаа асуудалтай, халдварт өвчинтэй гамшигтай бид нар бол ингэж тэмцэхгүй л дээ. Тодорхойлолтоо их өндөр өгчхөөд тэмцэх ажлаа бол ус шиг урсгачхаж байгаа юм. Тэгээд баахан хүмүүсийг хамруулаад.

Тэгэхээр би зүгээр Амарсайхан сайдаас асуух гэж байгаа нь яг энэ хар тамхитай тэмцье гэж байгаа бол энэ хууль дээр та өөрөө суухгүй юм уу? Хууль гэдэг бол бодлого. Бодлого бол байгаа байдлыг өөрчлөхийн төлөө гардаг. Байгаа байдлыг яаж өөрчлөх юм бэ та нар гээд гишүүд асуухаар өөрчлөлтийн тодорхой хариулт бол байхгүй. Өөрчлөлт яг ингэж явна гэдэг хариултгүйгээр энэ хуулийн шинэчилсэн найруулга явж болохгүй.

Ялангуяа Хар тамхитай тэмцэх албыг яаж хүчирхэг болгох вэ гэдгийг маш тодорхой хэлэх хэрэгтэй. Тоо нь хэд байх юм, цалин хэд байх юм, ажиллах орчин ямар байх юм. Тэмцэх албаны дарга бол энэ дээр өнөөгийн нөхцөл байдлыг ний нуугүй бидэнд ярьж өгөх хэрэгтэй одоо. Хэдэн цаг ажиллаж байгаа юм, Танайд ажиллах залуу хүн байгаа юу? Шөнөжингөө явдаг. Өдөр болгон ямар ч илүү цагийн мөнгө байхгүй, ямар ч тусламж дэмжлэг байхгүй. Халширч байна шүү дээ. Хар тамхитай тэмцэх хэлтэс дээр ажил хийдэг залуучууд өнөөдөр олдохгүй байна шүү дээ. Ийм болчихсон.

Тэгэхээр Амарсайхан бол Мөнх-Эрдэнэд энийг ацаглаж болохгүй. Мөнх-Эрдэнэ, Учрал 2 энийг чадахгүй. Өөрөө Амарсайхан амлаж авах хэрэгтэй. Үнэхээр гамшиг юм бол, үнэхээр халдварт өвчин юм бол, үнэхээр аюулгүй байдалд заналхийлж байгаа юм болбол. Энэ болгон үнэн шүү дээ.

Гэтэл оруулж ирсэн хуулиа хар л даа. Юу өөрчлөгдөх юм? Хэрвээ хар тамхитай хар тамхины худалдаанд цагдаа оролцвол ямар ял өгөх юм, гаалийн байцаагч оролцвол ямар ял өгөх юм, хилийн цэрэг оролцвол ямар ял өгөх юм, прокурор оролцвол ямар ял өгөх юм, мэргэжлийн хүмүүс хар тамхины худалдаанд оролцвол 20-25 жилийн ял өгнө гэдгийг тодорхой хэлэх хэрэгтэй. Эргэлт буцалтгүйгээр. Хар тамхитай тэмцэх албанд ажилласан хүмүүсийн урамшуулал тодорхой байх ёстой. Энэ улсууд амь насаа эрсдэлд оруулж том мафиин өмнөөс босож ирнэ. Амьдралын баталгааг нь хангаж өгөх хэрэгтэй. Хууль зүйн сайд Хар тамхитай тэмцэх албаны даргыг өөрөө томилдог байх хэрэгтэй. Цагдаагаас тусад нь гаргана. Үгүй ингэж тодорхой явахгүй бол хэдүүлээ баахан юм өөрчилсөн нэртэй юу ч өөрчлөгдөхгүй яг хэвээрээ. Асар их мөнгөний хэмжээ нэмэгдэнэ, эргэлтийн хэмжээ нэмэгдэнэ.

С.Бямбацогт: Амарсайхан сайд хариулья.

С.Амарсайхан: Гантөмөр сайдтай санал нэг байгаа. Ялт ч үгүй бол үндэсний аюулгүй байдалд заналхийлж, заналхийх битгий хэл бүүр аюул учруулах хэмжээнд явж байна. Энэ зүг рүү орчихсон байна 1 дүгээрт.

2 дугаарт, энэ улс орны хойч үе болсон үр хүүхдүүд, залуучуудын хувь заяаг боомилж байна.

3 дугаарт энэ хууль батлаад бүх юм сайхан болчихгүй. Бид олон хууль. Өнөөдөр Монгол Улсад 930 гаруй хууль байна. Хууль баталснаараа сайхан болдог бол бүгд ямар ч асуудалгүй сайхан сууж байх ёстой. Харин гарсан хуулийг хэрэгжүүлэх энэ хэрэгжилтийн явцад, хэлэлцүүлгийн явцад дутуу илүү дутуу байгаа асуудлуудыг нь цэгцлээд өшөө тодорхой болгох ёстой гэдэгтэй тантай санал нэг байгаа.

Нөгөө талаараа бид энэ төсөв хөрөнгө оруулалтаа тавьж өгөхгүй бол Хар тамхитай тэмцэх алба өнөөдөр хүчин чадал хангалтгүй байна. Хаанаа ч хүрэхгүй байна. Хар шөнөөр, өглөө үүрээр яваад үндсэндээ бидний хэлдэг Монгол аргаар шахуу энэ хэрэгтэй тэмцэж байгаа. Тоног төхөөрөмж, техник хэрэгсэл нь хангалтгүй, цалин хөлс, хувцас, нийгмийн асуудлууд нь шийдэгддэггүй. Өнөөдөр 2 сая төгрөгийн цалин өгчхөөд бид энэ яаж хэдэн их наядаар хэмжигддэг хэдэн зуун тэрбумаар хэмжигддэг хар тамхитай тэмц ээ гээд гар нүцгэн, хөл нүцгэн энэ хүмүүсийг гүйлгээд юунд ч хүрэхгүй.

Тийм учраас энэ хууль батлагдсанаар юун дээр чиглэх вэ гэхээр 1 дүгээрт урьдчилсан сэргийлэх, 2 дугаарт энэ хууль хүчний байгууллагуудын бааз суурийг бэхжүүлэх, 3 дугаарт энэ төсөв хөрөнгийг улсын төсвийг батлахдаа Улсын Их Хурлаас өөрсдөө гаалийнхаа тоног төхөөрөмжөөс эхлээд, хяналт шалгалтыг эхлээд, энэ тусгай хэрэгсэл, цахим залилан, цахим энэ гэмт хэрэг гээд энэ хар тамхи чинь хил хязгааргүй болчихсон. Тийм учраас энэ бүх асуудлуудыг шийдвэрлэхэд зөвхөн энэ хууль батлагдаад сайхан болчих зүйл ерөөсөө огт

байхгүй учраас хууль батлах ёстой хүнд дагасан орчин нөхцөлийг бүрдүүлэх, хөрөнгө оруулалтуудыг нэмэгдүүлэх ёстой, хуулийн санкцыг ялангуяа албан тушаалтан өөрөө тэр устгах ёстой хар тамхийг хэрэглэсэн, худалдсан, энэ наймаанд оролцсон ийм байвал хамгийн хатуу ялыг авдаг байх энэ зохицуулалт энэ хууль дээр орох ёстой. Энэ 4, 5 чиг ангилал юугаар бид энэ ялын бодлогыг оруулж ирсэн байгаа. Хамгийн дээд хатуу ял нь хүртэл байна. Хамгийн бага ял шийтгэл, торгууль нь хүртэл байна. Ингээд зохих түвшнийх нь зохицуулалтын хүрээнд тэр зөвлөмж, зөвлөгөө, урьдчилан сэргийлэх ажлуудаас эхлээд таслан зогсоох, урьдчилан сэргийлэх, тэр ялын бодлогоо хэрэгжүүлэх бүх хувилбар энэ хууль дээр явж байгаа. Мэдээж энэ хууль төгс болчихсон гэж хэлэхгүй. Энэ төсөл. Энэ хэлэлцүүлгийн явцад оруулах, засах, өөрчлөх саналууд гишүүдээс нэлээн гарч байна. Тэгээд энэ одоо.../минут дуусав./

С.Бямбацогт: Хар тамхитай тэмцэх албаа тусдаа гаргаж болох уу л гээд асуусан. Тэрийг гүйцээгээд хариулчихъя.

С.Амарсайхан: Хар тамхитай тэмцэх алба Цагдаагийн ерөний газар дээр байна. Энэ албаны хүчин чадлыг нэмэгдүүлэх ёстой. Цагдаагийн байгууллага Хууль зүйн сайдын харьяа агентлаг учраас энэ зохион байгуулалттай холбоотой асуудал дээр нэг их тийм хүндрэлтэй зүйл гарахгүй байх гэж бодож байгаа. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөл өөрөө Хууль зүйн сайдын ахалдаг ийм зөвлөл байдаг.

Тийм учраас энэ хар тахалтай тэмцэх зохион байгуулалттай тусгай ажиллагаануудыг эрчимжүүлэх, ингэхийн тулд мэдээж сая ярьсан хөрөнгө оруулалт, техник хэрэгслүүд, хүчин чадлыг нэмэгдүүлэх асуудлууд маш чухал.

С.Бямбацогт: Гантөмөр гишүүн тодруулж асууя.

Л.Гантөмөр: Амарсайхан сайд аа өөрчлөлт хийхгүйгээр та бол ямар ч тэмцэл хийж чадахгүй. Өөрчлөлт хий. Хар тамхитай тэмцэх албыг Хууль зүйн сайдын дэргэд байгуул, ав. Энэ улсуудаа тусгай орчинд вакумжиж ажил хийлгэ, мөнгийг нь хэл, засгаараа шийдүүл. Юун орон сууцын банк байгуулаад та нар суугаад байгаа юм. Тэр банк байгуулж байгаа банкны хүмүүст өгөх гэж байгаа мөнгөөрөө энэ хүмүүсээ цалинжуул л даа. Үгүй ээ үнэхээр гамшиг юм бол би хэлээд байна шүү дээ. Гамшиг, тахал, халдварт өвчин, урьдчилан сэргийлэх гэдэг худлаа юм руу заахаа болих хэрэгтэй шүү дээ. Энийг муухай хортой гэдгийг мэдэхгүй ямар Монгол хүн байх юм. Энэ амьдралд нь гай болно гэдгийг мэдэхгүй ямар Монгол хүүхэд байх юм. Зүгээр энэ зохион.../минут дуусав./

С.Бямбацогт: Амарсайхан сайд хариулъя.

С.Амарсайхан: Бүтэц, зохион байгуулалттай холбоотой асуудлууд хийгдэнэ. Гантөмөр сайдын хэлж байгаа олон саналуудтай би санал нэг байна. Ер нь бол энэ дээр дорвитой арга хэмжээ авахгүй бол Засгийн газрын түвшинд, Их Хурлын түвшинд, үндэсний хэмжээнд, бүр цаашаа Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн түвшинд ярих ёстой ийм асуудлууд бий. Тэгээд энэ хууль сахиулах байгууллагуудын бүтэц, зохион байгуулалттай холбоотой, дээрээс нь илүү бүтээмж өндөртэй, энэ гэмт хэрэгтэй тэмцэх улам нарийн зохион байгуулалттай болж байгаа төрөл бүрийн гэмт хэргүүдтэй тэмцэх, хар тамхитай нь цаашлах юм

бол энэ нийгмийн ажил, амьдралыг сүйтгэж байгаа цахим гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр тусгай бүтэц, зохион байгуулалтуудыг хийж ажиллана.

С.Бямбацогт: Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Хассуурийн Ганхуягийн урилгаар нийслэлийн ерөнхий боловсролын “Эрдмийн өргөө” сургуулийн Оюунгэрэл багштай 12^ж ангийн сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Төрийн ордонтой танилцаж байгаа сургагч хүүхдүүддээ сурлагын өндөр амжилтыг хүсье. Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс хүсье. Удахгүй элсэлтийн шалгалтаа амжилттай өгч, хүссэн сургуульдаа хүссэн мэргэжлээрээ суралцаж төгсөж эх орондоо бас ихийг хийж бүтээх бүтээлч хуулиа дээдэлдэг иргэн болохыг хүсэн ерөөе.

Манай Их Хурлын гишүүн Далайн Батбаярын төгссөн сургууль юм байна шүү. Батбаяр гишүүн энд байна. Та хэд бас нэг энэ сургуулиа төгсөөд энэ гишүүнтэй адилхан бас гишүүн болох боломж байна шүү. Энэ Хассуурийн Ганхуяг гишүүн энд зогсож байгаа шүү бас. Сайн ажиллаж байгаа.

Гантөмөр гишүүн тодруулж асууя.

Л.Гантөмөр: Би уг нь Болдбаатар билүү хар тэмцэгтэй юу газрын дарга нь тасгийн дарга Болдоо тээ, хэн гэнэ ээ? Товуудорж. Товуудорж хурандаа бол Их Хуралд үгээ хэлмээр байхгүй юу. Энийг л бид нар хүсээд байгаа юм л даа. Бодит байдлаа яримаар байна шүү дээ. Тэгээд дээр нь энэ цагдаагаас салга гээд байгаа нь цагдаагийнхан бол хуучин хулгайч нар мэдээлэгч байсан бол хар тамхичид мэдээлэгч болчихсон. Хамгийн буруу хүмүүсээ мэдээлэгчээр авч байгаа юм. Хар тамхичдын толгойг илээд мэдээлэгч болгох юм бол энэ үндэстэн сүйрнэ шүү. Энэ дээр цагдаагийн дарга нар онцгой анхаарах хэрэгтэй. Хар тамхичдыг бол ямар ч цагдаагийн офицертой харилцаанд оруулж ерөөсөө болохгүй. Толгойг нь илээд явуулахаар тэд нар чинь хаан, хатан болчихоод байна.../минут дуусав./

С.Бямбацогт: Үг хэлчихлээ. Улсын Их Хурлын гишүүн Амгаланбаатарын Ганбаатар гишүүн асуултаа асууя.

А.Ганбаатар: Хар тамхи бол цагаан тахал болсон. Ний нуугүй хэлэхэд Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс юм уу одоо энэ ажлын хэсэг бол Их Хурлыг гишүүдийг бүрэн цуглуулжхаалттай мэдээлэл өгөх хэрэгтэй. Дам сонссон яриа зарим нэг Фокс группийн ярианаас харахад бол төрөл төрлөөр нь дагнасан ийм бүлэглэлүүд бүүр гарчихсан байна. Тэгээд бараг цолтой цэрэг цагдаагийн ийм үүрэг, функцтэй ийм бүлэглэлүүд бол тодорхой байж байгаа.

Тэгэхээр энэ хуульд хамгийн түрүүнд тэр хэрэглэгчийг нь бол бас наанатай цаанатай харж үзэж болох юм. Энэ нийлүүлж байгаа, зарж байгаа хүмүүсийн ялын бодлого арай зөөлдөж байгаа юм биш үү гэсэн ийм байдал ажиглагдаж байна. Тухайлбал, хар тамхи худалдсан, импортолсон бол 1 жил зорчих эрхийг нь хязгаарлана. Тарималжуулсан бол 5400 нэгжээр торгоно гээд. Энэ бол бас ялын бодлогод бол багадна л даа. Энийг ялын бодлогоо яаж барих юм бэ хамгийн гол нийлүүлээд байгаа тэр бүлэглэлийн толгой нарыг? Одоо бүүр Америк, Тайландын жишээг яриад хар тамхи хэрэглэхийг зөвшөөрсөн орнуудын жишээг яриад хуулийн төсөл лоббидох хэмжээнд хүрсэн байна лээ шүү дээ.

Тэгэхээр миний бодлоор бол энэ ялын бодлого чинь болж байгаа юм уу гэж нэгдүгээр асуулт.

Хоёрдугаарх нь энэ хуулийн 51 дүгээр зүйл дээр хар тамхитай тэмцэх албаны чиг үүргийг хуульчилсан байж байгаа. Тэгээд сая Гантөмөр гишүүний асуугаад байгаа асуудлууд нь тодорхой биш. Миний санал бол Авилгатай тэмцэх газар шиг тийм хэмжээнд Хар тамхитай тэмцэх газар гэж тусад нь гаргаж ирээд эрүүл мэндийн чиглэлээр, урьдчилан сэргийлэх чиглэлээр, ял шийтгэх чиглэлээр үүрэг функцээ нэгтгэсэн ийм нэгжтэй болж тэмцэхгүй бол Монгол Улс, залуучууд энэ цагаан тахалд нэрвэгдчихсэн байгаа. Манай албаны хүмүүс бүгд мэдэж байгаа шүү дээ.

Тэр матдаг гэдэг юм уу, хэргээ илчлэх юм бол хэргээс чөлөөлж байгаа гэж хэлж байгаа. Тэнд хохирогч хамгаалах Тахарын алба гэж байсан тэр маань байхгүй болчихсон. Ийм хуультайгаа уясан юм уу? Тэр хүн чинь гадагшаа гарахгүй л бол эндээ бол маш том дарамтад ордог юм байна лээ шүү дээ. Тэгээд энэ хуульд байгаа юу?

Хамгийн сүүлд нь Хууль зүйн сайд бас хариулчих байх. Энэ газрыг гаргах хэрэгтэй. Тусад нь гаргаж байж тэмцэнэ. Энийг та зөвшөөрч байна уу? Тэгвэл Их Хуралд хаалттай мэдээллээ хийгээд, Их Хурлын дэмжлэгийг аваад, төсөв мөнгийг нь тавиад ингэж тэмцэхгүй бол болохгүй байна. Ийм 2 асуултад хариулт авъя.

С.Бямбацогт: Хэн хариулах вэ? Амарсайхан сайд хариулъя.

С.Амарсайхан: Ялын бодлого ялгаатай байх ёстой. Хууль дээр бас 4, 5 чиглэлээр ялыг ангилж тусгасан байгаа юм 1 дүгээрт.

2 дугаарт бол ойрын хугацаанд би өнөөдөр бас Цагдаагийн ерөний газар дээр очиж ажилласан. Тодорхой үүрэг даалгаврууд өгсөн. Ажил аваад бас хугацаатай үүрэг даалгавар өгсө. Зарим ахиц дэвшлүүд гарч байгаа. Яах вэ цагдаагийн алба хаагчид бол өөрсдийнхөө түвшинд бүх нөөц бололцоогоо дайчилж ажиллаж байгаа. Түрүүн би хэлсэн үнэхээр өөрсдийнхөө боломж, нөөцийг дайчилж ажиллаж байгаа. Хүндрэл, бэрхшээлтэй асуудлууд байна. Хөрөнгө санхүүтэй хүндрэлүүд байна холбоотой. Дутагдаж байгаа, гачигдаж байгаа асуудлууд байна.

Тэгэхээр ойрын хугацаанд би Засгийн газарт бас хаалттай мэдээлэл хийе гэж байгаа 1 дүгээрт.

2 дугаарт, Их Хурлын гишүүд та бүхэн, Их Хурлын дарга одоо яриад Их Хурал дээр ер нь хаалттай мэдээлэл хийж, яг нүцгэн үнэнээ бид ярилцах ёстой гэж. Яг энэ танхимд хэвлэл мэдээллийн өмнө ярих асуудлууд байна. Ярьж болохгүй асуудлууд байна. Мэдээж бид бодит нөхцөл байдлыг ярьж гэж байгаа боловч бас энэ дотор ялгаж салгаж хандах асуудлууд, нарийн төвөгтэй асуудлууд ихээхэн байгаа учраас хаалттай мэдээлэл хийнэ гэдэгтэй санал нэг байна.

3 дугаарт, энэ хар тамхитай тэмцэх албыг бол илүү хүчирхэг, илүү инновац технологид суурилсан олон улсын түвшний үйл ажиллагаа явуулах хэмжээнд

бэхжүүлэхгүйгээр бид энэ хар тамхитай тэмцэнэ гэдэг үг бол агаарт хаясан, хийсгэсэн цаастай адил болно.

Тийм учраас энэ төсөв санхүүтэй холбоотой асуудлууд, энэ байгууллагыг бие дааж илүү бие даасан хараат бус үйл ажиллагаа явуулах боломж нөхцөлийг бүрдүүлэхэд ирэх жилийн төсөв санхүү дээр Хууль зүй, дотоод хэргийн яамнаас орж ирэх асуудал дээр та бүхэн бүрэн хэмжээгээр дэмжиж өгөөрэй гэж бас хүсье.

Өнөөдөр цагдаагийн байгууллагын албан хаагчдын орон тоо хүрэлцэхгүй байна. 100 хүн тутмын 50 нь цалин хүрэлцэхгүй учраас ажил төрлөөсөө гарна, өргөдөл чирэгдлээ өгнө гэсэн ийм судалгаанууд хүртэл байж байна. Тийм учраас энэ хууль сахиулах байгууллагынхаа бас хүчин чадлыг нэмэгдүүлэх, алба хаагчдынхаа ажил хийх итгэл үнэмшлийг төрүүлэх, тэр цалин хөлс, нийгмийн асуудлууд, орон байр, ажил хийх, арагшаа санаа зовохгүй байх боломж нөхцөлийг бүрдүүлэхгүйгээр бид цахим энэ хар тамхи, дээрээс нь цахим гэмт хэрэг гэдэг бол бүр хил хязгааргүй болсон учраас энэ цахим гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлийн чадавхыг хүртэл дээшлүүлэхгүй бол энэ өөрөө үндэсний аюулгүй байдал цаашлах юм бол энэ кибер халдлага, төрийн сангууд байна, банк санхүүгийн байгууллагууд байна, улсын онцгой объектууд байна. Ямар ч хэлбэрээр яаж ч халдах ийм боломж нөхцөл бүрдчихсэн ийм дэлхий ертөнцөд бид ажиллаж амьдарч байгаа учраас энэ дотоод хэргийн.../минут дуусав./

С.Бямбацогт: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Би бас Хууль зүй, дотоод хэргийн сайдаар ажиллаж байсан. 17 онд бас Цагдаагийн албаны тухай хуулийг батлуулж энэ цагдаагийн албан хаагчдын нийгмийн асуудал, ажил амьдралын баталгааны асуудлыг бол шийдэж байсан.

20 жилийн өмнөх, 30 жилийн өмнөх цагдаагийн албан хаагчийн нөхцөл байдал өнөөдрийн нөхцөл байдал 2 бас нэлээн өөр болсон шүү. Одоо манайхан ерөөсөө л орон тоо хүрэхгүй байна гэж яриад байдаг. Орон тоо бол хангалттай болсон. Орон тоо бол хангалттай байгаа. Одоо ганцхан дотор нь яаж зохион байгуулах вэ, яаж ажил ачаалал зөв хуваарилах вэ гэдэг дээр анхаарах ёстой.

20 жилийн өмнө гар утасгүй, харанхуй гудамжинд гэрэлтүүлэг байхгүй, зам байхгүй гудамд цагдаа нар явган эргүүл хийдэг байсан. Тэр үед үнэхээр ачаалалтай байсан. Одоо бол бүх гудмууд гэрэлтүүлэгтэй болсон, бүх гудмууд автомашин хатуу хучилттай замтай болсон, камертай болсон, гар утастай болсон. Тийм болохоор ихэнхдээ үндсэндээ бол камераа хяналтаа хийгээд байх бололцоотой болчихсон байгаа. Тийм болохоор хаана ачаалалтай байна, ачаалалтай газар руугаа, тэр гудамд харанхуй гудамд явган гар утасгүй эргүүл гэдэг байсан нөхцөл байдал өөрчлөгдсөнтэй холбоотой илүү гарч байгаа орон тоогоо шилжүүлэх тиймэрхүү зохицуулалтууд бас хийх ёстой шүү.

Одоо дэмжсэн, дэмжээгүй гишүүд үг хэлнэ. Дэмжсэн, дэмжээгүй нам, эвслийн бүлэг төлөөлж үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү.

Даваахүүгийн Ганмаа гишүүн. Эхэлчихсэн үү? Энэ доороо индрээс.

Д.Ганмаа: Бид нар өнөөдөр маш чухал хууль хэлэлцэж байна. Тэгээд салбар дамнасан Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын асуудал. Хэд хэдэн санал байгаа юм надад. Энэ асуултад бас бүрэн хариулт авч чадахгүй учраас 1 дүгээрт энэ олон улсын туршлагатай ингээд харьцуулаад үзэхээр зэрэг Исланд Улс гэж 98 онд Европт хамгийн өндөр хэрэглээтэй улс байж байгаад хамгийн бага хэрэглээтэй болсон улс байгаа.

Тэрэн дээр хамгийн гол нь нөгөө урьдчилан сэргийлэлт, хүүхдийн чөлөөт цаг, спортын санхүүжилт, эцэг эхийн оролцоо, жил бүрийн үндэсний бүүр судалгаа хийдэг болчихсон юм байна лээ хар тамхин дээр.

Сингапур болохоор, зэрэг хилийн өндөр хамгаалалттай, заавал сэргээн засах хөтөлбөртэй тэгээд бүүр тусгай тагнуул гаргаж ажиллуулсан юм байна.

Өмнөд Солонгос дээр болохоор сүүлийн жилүүдэд сая бас хариулж байсан нөгөө синтетик мансууруулах бодис өсөлттэй холбоотой Cyber Narcotics Units бүүр нэгж байгуулсан. Тэгээд тэр “dark web”-ийн бүтэн мөрдөн шалгах процесстой болсон юм байна лээ. Онлайн худалдан авалт дээр тусгайлан бүүр хяналт тавьдаг.

Тэгэхлээр бид нар энэ урьдчилан сэргийлэлт, хүүхэд, залуучуудын хамгаалалт, сэтгэцийн эрүүл мэнд, эмчилгээ, урьдчилан нийгэм шүүлтийн ажлууд дээрээ ярихдаа хэд хэд хэдэн санал байна.

1 дүгээрт, бид нар энийг урьдчилан сэргийлэлт гээд 25-аас доош насныхан анхны хэрэглэгч байдаг. Ялангуяа 10 жилийн хүүхдийнх гээд бүүр заагаад судалгаа нь байгаад байхад хүүхэд, залуучуудын урьдчилан сэргийлэлт гээд тусгайлан бүүр бүлэг нэмээд энэ дээр тусгайлан ажиллаад оролцуулж, оруулж өгөөч гэдэг санал байна.

2 дугаарт, жил болгон Улсын Их Хурал дээр бүүр доорх үзүүлэлтээр тайлан тавьдаг болмоор байна. Хэрэглэгчдийн тоо, нас баралт, эмчилгээнд хамрагдсан хүний тоо, дахин хэрэглэж байгаа хувь, өсвөр үеийнхний хэрэглээ ч гэдэг юм уу яг ийм түрүүн би зорилтот бүлэг нь хувь нь хэд байна гээд асуугаад байсан. Яг энэ байдлаар.

3 дугаарт, энэ наркотик болон сэтгэцэд нөлөөлөлт эмийн цахим жорын нэгдсэн тийм системтэй болмоор байна. Хүүхдүүд бол ер нь эмээс эхлээд байдаг гэж нэлээн юмнууд байна шүү дээ энэ дээр. Тэгээд эмчилгээ хийлгэсэн хүмүүсээ нийгэмжүүлдэг ийм тусгайлсан бас нэг хөтөлбөртэй болмоор байна. Түрүүн ярьсан тандалт судалгааг яах аргагүй 2 жил дутамд биш бүүр жил болгон зайлшгүй хийх, шинэ төрлийн мансууруулах бодисын эрт сэрэмжлүүлэх тийм үндэсний системийг бий болгох ийм хэдэн саналыг зайлшгүй хуульдаа тусгаж өгөөч гэсэн саналуудыг хэлэх гэсэн юм. Баярлалаа.

С.Бямбацогт: Баярлалаа. Пүрэвжавын Сайнзориг гишүүн үгээ хэлье.

П.Сайнзориг: Баярлалаа. Би бас давхардахгүйгээр бас хэдэн санаа хэлье. Уг нь бас Байнгын хороон дээр бас хэлсэн. Тэгээд энэ хуулийг бол яаралтайгаар, цаг алдалгүй хэлэлцээд энэ амьдралд энэ хар тахал болсон энэ хар тамхи,

мансууруулах бодистой тэмцэх энэ үйл ажиллагааг цаг алдалгүй бас үр дүнтэй явуулах тал дээр энэ хууль эрх зүйн талаасаа дэмжээд өгөх хэрэгтэй гэж үзэж байгаа юм.

Тэгэхээр энийг Хууль зүйн байнгын хороон дээр мэдээж ажлын хэсэг гарах байх. Бас энийг нэг дараад байлгаад байхгүйгээр бас нэг идэвхтэй ажиллаад явах хүнээр бас ажлын хэсгийг ахлуулаад яваасай гэдэг 1 дүгээрт ийм хүсэлт байна.

2 дугаарт энэ хар тамхичдын хэрэглэгчдийн нас, хүйсийг энэ судалгаануудаас харахаар их залуу байгаа. Энэ Монгол Улсын тусгаар тогтнол, хүн ам зүйн бодлого, цаашдаа ер нь оршин тогтнох уу үгүй юу гэдэг дээр ч бас нөлөө үзүүлэхүйц л хэмжээнд сөрөг үр дагаврууд гарах магадлалтай байна.

Тийм учраас энэ чиглэлийн бодлогыг илүү их тэр ял шийтгэлийн бодлого мэдээж тэр supply chain буюу нийлүүлэлт худалдах энэнээс ашиг хонжоо олж байгаа этгээдүүд дээр хатуу хариуцлага байхаасаа гадна энэ донтолт гэдэг зүйлүүд дээр эмчлэх тэр дэд бүтцийг Монгол Улсад яаралтай сайжруулж, хүний нөөцөө бэлдэх хэрэгтэй байна. Яг үнэндээ хэлэхэд шүүхийн шийдвэрийн харьяа болоод СЭМҮТ гээд цөөхөн хэдэн газар цөөхөн ортой байгаа. Тэгээд энэ бол цэвэр цаашдаа зүгээр архины донтолтын л эмчилгээг явуулж байгаа болохоос биш яг энэ мансууруулах, хар тамхитай чиглэл дээр бол арга зүй талаасаа, хүний нөөц талаасаа, төсөв мөнгө талаасаа байхгүй байгаа байхгүй юу.

Тийм учраас энэ чиглэлийн бодлогыг уг нь миний бие бас Хууль зүй, дотоод хэргийн яаманд байж байхдаа энэ хуулийг боловсруулчих гэж оролцож байсан. Энэ Архины сан гэдэг зүйлийг байгуулсан юм. Энэ архи үйлдвэрлэж байгаа, импортолж байгаа хүмүүсүүдтэйгээ бас ойлголцож байж энэ өндөр градустай архиас 300 төгрөгийг тодорхой тусгай санд оруулаад үүгээрээ дэлгэцийн дон, архины дон, мансууруулах, энэ хар тамхи, мөрийтэй тоглоомын донгуудыг эмчлэх энэ төрөлжсөн эмнэлгүүдийг байгуулах, төвүүдийг байгуулах асуудлыг л ярьж байсан юм.

Түүнээс биш ээж аав, эцэг эхчүүд, асран хамгаалах харгалзан дэмжигч нар, эсвэл залуучууд хаана хандахаа мэдэхгүй байгаа байхгүй юу. Тэгээд л яваад байна. Энэ чинь өөрөө зүгээр 1, 2 хоногийн эмчилгээ биш дор хаяж жилийн эмчилгээ шаарддаг. Эрүүл мэндийн тэр хордлого тайлахаасаа гадна сэтгэл зүйтэй нь ажиллана. Тэр сэтгэл зүйг нь тогтворжуулна. Өөрийгөө давах тэр тэвчээрийг нь суулгаж өгнө. Маш олон зардал, мөнгө шаарддаг.

Тэгээд ийм зүйлүүд дээр ингээд архины сан дээр 23 тэрбум төгрөг байгаад байхад Сангийн яам маань хэрэглүүлэхгүй байгаад л харамсаад байгаа юм. Энийг нэг бодлогын түвшинд Засгийн газар маань анхаарч өгөөч ээ. Хэзээ хар тамхитай тэмцэх юман дээр 23 тэрбум төгрөг тавьж байсан юм бэ? Тэгээд ийм донтолтын эсрэг юман дээр мөнгө байгаад байхад ашиглаж чадахгүй байна гэдгийг бол бид нарын муухай харамсалтай зүйл байгаа байхгүй юу. Тэгэхээр энийг бас анхааръя гэдэг зүйл байна.

2 дугаарт энэ үндэсний жагсаалтыг яаралтай бий болгох хэрэгтэй. Ингэж хурдан ямар төрлийн бодисыг энэ хар тамхи, мансууруулах байдлын бодис, түүнтэй адилтгах бодист оруулах юм. Дээрээс нь энэ синтетик төрлийн бодисын

хэрэглээг л аль болохоор хумьж бүүр таслан зогсоох ёстой. Энийгээ оруулж ирж байгаа хүмүүс дээр бүүр ял, хариуцлагыг нь өндөрсгөх ёстой. Синтетик бүүр лабораторийн аргаар гаргаж авч байгаа. Тэгэхээр энэ чиглэл рүүгээ ял, хариуцлагыг бас чангатгамаар байна.

Тэгээд ер нь энэ Монгол Улсын иргэд ч гэсэн гадаад, дотоодод зорчихдоо бас энэ төрлийн гэмт хэргийн хавханд орох, зөөвөрлөж яваад, тээвэрлэж яваад маш олон иргэд маань хилийн чанадад хохирч байгаа. Дийлэнх нь БНХАУ-д байж байна. Тэгэхээр бид хэд энийг л бас цаашдаа бүр анхаарах хэрэгтэй байна. Түрүүн Ганмаа.../минут дуусав./

С.Бямбацогт: Салдангийн Одонтуяа гишүүн үгээ хэлье.

С.Одонтуяа: Өнөөдрөөс хэдэн жилийн дараа энэ хууль батлагдаад нэг бага зэрэг буусан, өссөн гэдэг үгийг бол сонсмооргүй байна. Өнөөдөр иргэд, аргаа яачихсан ээж аавууд, хүүхдийнхээ төлөө сэтгэл зовниж байгаа хүмүүс бол бүгд л маш их хүлээлттэй байна. Тэгэхээр энэ 26 онд батлагдсан хуулиар мөн Улсын Их Хурал Засгийн газар дорвитой арга хэмжээ авч чадсанаар хар тамхины асуудлыг нэг тэр үед нам дарж билээ гэдэг ийм үгийг л иргэд, ээж аавууд сонсохыг хүсэж байгаа. Тийм учраас энэ дээр дорвитой алхам хиймээр байна.

Сүүлийн жилүүдэд энэ хар тамхи тарьж, ургуулсан, худалдаалж наймаалсан, бусдад дамжуулсан гээд энэ зөрчлийн хэрэг бол маш их болсон. Өмнө нь бид нар барууны байлдаантай киноноос л олж хардаг байсан нөгөө хар нэртэй цагаан хор бол Монголчуудад заналхийлэх болоод удсан байгаа. Тэгэхээр энэ Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас зарласан судалгаагаар хар тамхи, сэтгэцэд нөлөөлөх бодист донтоно гэдэг нь архинд донтохоос 60 дахин хүчтэй байдаг гэдгийг зарласан.

Тийм учраас энэ бол л маш аюултай гэдгийг өнөөдөр гишүүд хэллээ. Ер нь хүний бүх мөрөөдлийг л нэг дор устгаж байгаа ийм зүйл байгаа. Би Их Хурлын гишүүддээ хандаад нэг зүйлийг бас дахин хэлмээр байна. Энэ юу вэ гэхээр бүгдээрээ сая ингээд онцгой анхаарах ёстой тахал боллоо гээд яриад байгаа юм. Гэтэл нөгөө гараараа бид нар 26 оны хар тамхитай тэмцэх төсвүүдийг бүгдийг хассан. Тийм учраас одоо 27 оны орж ирж байгаа энэ төсвийг нь бүгдээрээ дэмжиж хасахгүй байх, дэмжиж баталж өгөх хэрэгтэй. Ерөөсөө төсөв хөрөнгөгүй бол энэ техник технологи, орчин үеийн арга хэрэглэхгүй бол энэтэй бол дорвитой тэмцэж чадахгүй байгаа. Тийм учраас энэ дээр гишүүдийгээ бас уриалж байна.

Төрийн албан хаагчийн ялыг чангаруулах хэрэгтэй гээд бүгд хэлж байна. Тэгэхээр сая тоо баримтаар бол ерөөсөө 6-хан хүн л нэг ял авсан юм байна шүү дээ эрүүгийн хоригдох ял. Тэгэхээр энэ бол энэ хууль хүчний байгууллагад ажиллаж байгаа хүмүүс бол энэ хэрэгт оролцчихоод, зохион байгуулалттай гэмт хэрэгт оролцчихоод тэгээд ер нь дандаа арын хаалгаар мултардаг юм байна. Энэ хүмүүс ерөөсөө ял авдаггүй юм байна. Тийм учраас энэ асуудал дээр онцгой анхаарах хэрэгтэй.

Урьдчилан сэргийлэх хөтөлбөрт бас хөрөнгө мөнгө төсөвлөх ёстой. Бид нар чинь энэ хүүхэд, залуучуудад энэ хөтөлбөрийн хүрээнд маш олон зүйлийг бол хийж болно. Цахим орчныг онцгой хяналтдаа авах хэрэгтэй. Мөн Улсын Их Хурал

дээр сая Элчин сайдууд үүрэг даалгавар аваад явахад бид нар онцгойлон үүрэг өгсөн. Энэ улс орнууд энэ хар тамхитайгаа яаж тэмцдэг юм бэ, ямар хууль эрх зүйн орчин байдаг юм бэ гээд. Тэгэхээр Засгийн газар энийгээ нэгтгэж аваад ажлын хэсэгт ирүүлэх ёстой.

Мэргэжилтэй боловсон хүчнээ яаралтай бэлдэхгүй бол Монгол Улс дэндүү өрөвдмөөр юм байна лээ шүү. Сэтгэл зүйчид байхгүй, мэргэжилтэн байхгүй үнэхээр инээдэмтэй байгаа. Тэр хүүхэд нь хар тамхи хэрэглэж байсан гээд эмэгтэй л өөрөө зоригтой гарч ирээд тэр Сүхболд гээд эмч эмэгтэй энэнээс би хүүхдүүдийг энэнээс холдуулмаар байна гээд л гэрээрээ хөөрхий байнга ингээд зөвлөгөө өгдөг. Хүмүүс тэр хүн рүү л хандаад байдаг. Тэгэхээр энэ бүхэл бүтэн улс байна. Энийг чадавхжуулах ёстой.

Тэгэхээр бүх оронд бол асуудал байгаа юу байгаа. Тэрийг шийдэж чадах, хариу үйлдэл үзүүлэх нь л өөрөө Монголчууд энэ дээр бид нар сайн ажиллая гээд энэ хуулийг оруулж ирсэн байгаа. Тийм учраа бас энэ дээр бүгдээрээ сайн ажиллах хэрэгтэй. Ер нь энэ ганц төрийн байгууллага тэмцээд бол дийлэхгүй. Бид нийтээрээ л тэмцэж байж энэ тахлын ард гарна. Энэ аюулыг устгана гэж хэлмээр байна. Баярлалаа.

С.Бямбацогт: Одонтуяа гишүүнд баярлалаа. Гишүүд үг хэлж дууслаа. Санал хураалтыг 16 цагаас үдээс хойш явуулна.

15.22 цаг.

Дараагийн асуудалдаа орёе. Энэ чинь нэлээн олон дагасан хуультай юм байна шүү дээ. 42 хуультай. 40 хэдэн санал хураалттай юм байна шүү. Дараагийн асуудалдаа орёе.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрдлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн танилцуулна. Таныг индэрт урьж байна.

Д.Энхтүвшин: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрдлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын гишүүн Лхагвасүрэнгийн Соронзонболд, Оюунсайханы Алтангэрэл, Гончигдоржийн Уянгахишиг, Даваахүүгийн Пүрэвдаваа, Ринчиндоржийн Батболд, Дашзэгвийн Энхтүвшин нарын 6 гишүүн 2024 оны 04 сарын 30-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн.

Манай улс 2014 оноос өмнө зөвхөн хувь хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг байсан бол 2015 оны Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгаар хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага оногдуулах зарчмыг анх хуульчилсан.

Улмаар 2017 оны Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зорилгод гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг олж тогтоон шударгаар ял оногдуулах гэж тусгасан. Мөн хуулийн 20 дугаар бүлгээр хуулийн этгээдэд холбогдох

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой тусгайлсан бүлэг оруулж, хуулийн этгээдийн гэм бурууг тогтоож, түүнд эрүүгийн хариуцлага оногдуулах асуудлыг процессын хувьд тодорхой хэмжээнд зохицуулагдсан.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрдлэх тухай хуульд оролцогч гэж сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч хуулийн этгээд, тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийг хэлнэ гэж заасан бөгөөд хуулийн этгээдийг сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчээс хэргийн оролцогчийн хувьд ялгамжтай авч үзсэн.

Хэдий тийм боловч Эрүүгийн хэрэг хянан шийдвэрдлэх тухай хуульд сэжигтэн, яллагдагчид хамаарах зарим зохицуулалтыг хуулийн этгээдэд нэгэн адил хэрэглэх байдлаар ерөнхийлөн тусгасан ба хуулийн этгээдийн онцлогт тохирсон журам бүрэн тусгагдаагүй.

Тэдгээрийн нэг нь хуулийн этгээдэд авах таслан сэргийлэх арга хэмжээний зохицуулалт юм. Түүнчлэн мөрдөн шалгах ажиллагааны журамд ч хуулийн этгээдийн субъектийн онцлогт тохирсон нарийвчилсан зохицуулалт дутмаг байна.

Тодруулбал, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрдлэх тухай хуульд заасан хуулийн этгээдэд тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг түдгэлзүүлэх, таслан сэргийлэх арга хэмжээ авахтай холбоотой журамд таслан сэргийлэх арга хэмжээ авахдаа харгалзах нөхцөл, хугацаа, үндэслэлд таслан сэргийлэх арга хэмжээг хүчингүй болгох, хугацаа сунгах журам зохицуулагдаагүй байна.

Мөрдөн шалгах ажиллагааны хувьд хуулийн этгээдэд голчлон хийгддэг ажиллагааны нэг бол хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хянах, хязгаарлах ажиллагаа юм. Гэвч эдгээр ажиллагааг хэрэгжүүлэх нөхцөл шаардлага, хугацааны зохицуулалт мөн л тодорхой бус байна. Бизнесийн байгууллагуудын хувьд үйл ажиллагаа түр зогсох доголдол, тасалдал үүсэх зэрэг тохиолдолд жижиг бизнесүүд санхүүгийн дарамт, эрэлт буурах зэрэгт хамгийн хурдан буюу дунджаар 1-3 сарын дотор хямралд ордог бол дунд том бизнесүүдийн хувьд 3-6 сарын дотор санхүү үйл ажиллагааны хүндрэл мэдрэгдэж улмаар дампуурах хүртэл эрсдэлд ордог талаар судалгаанууд бий.

Иймд энэ үр дагаварт хүргэж болзошгүй хуулийн этгээдийн үйл ажиллагааг түдгэлзүүлэх, хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах зэрэг арга хэмжээ авахдаа хуулийн этгээдэд үзүүлэх үр нөлөөг харгалзан үзэж эдийн засгийн тогтвортой байдлыг дэмжих үүднээс хуульд шалгагдах зарчмын журмын зохицуулалтыг оновчтой болгох зайлшгүй шаардлагатай байна.

Эрх хязгаарлах арга хэмжээний процессын тодорхой байдлыг хангах нь Монгол Улсын Үндсэн хууль болоод Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зарчимд бүрнээ нийцэх ба хэм хэмжээний бус байдлаар иргэн хуулийн этгээдийн эрх зүйн байдлыг дордуулахаас урьдчилан сэргийлэх, шударга шүүхээр шүүлгэх эрхийн биелэлтийг хангах суурь болно.

Энэ зорилгоор Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийг баталгаажуулж, шүүхийн шийдвэргүйгээр баривчлах, цагдан хорих, иргэний эрхийг хязгаарлах ажиллагааг зогсоон, хүний

эрхийг хамгаалах, процессын шударга ёсыг хангах, мэргэжлийн байлгах чиглэлд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль болон холбогдох хуулиудыг бүрэн процессжуулан хуульчлахаар тусгасан.

Түүнчлэн Монгол Улсын Үндсэн хуулий цэцийн 2025 оны 07 дугаар дүгнэлтээр цагдан хорих, таслан сэргийлэх арга хэмжээний талаар авч ирэх хэмжээний талаар авч хэлэлцэхдээ хүний эрхийг хязгаарлах зохицуулалтын үндэслэл, журам хуульд тодорхой тусгагдаагүйгээс төр хуулийг процессын тодорхой байдлыг хангах Үндсэн хуульд заасан үүргээ биелүүлээгүй байна гэж дүгнэсэн.

Эдгээр практик хэрэгцээ, шаардлагад үндэслэн хууль хяналтын байгууллагууд болон иргэний нийгэм, судалгаа, хувийн хэвшлийн төлөөллийн байгууллагуудаас ирүүлсэн санал, мэдээлэл болон бусад улсын сайн туршлага зэргийг харгалзан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрдлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Хуулийн төсөлд Хууль тогтоомжийн тухай хуульд заасан хуулийг хэрэгжүүлэх хяналт тавих, чиг үүрэг бүхий байгууллагууд болох Цагдаагийн ерөнхий газар, Улсын ерөнхий прокурорын газар, Монгол Улсын Дээд шүүх, Авилгатай тэмцэх газрын саналыг авсан бөгөөд хуулийн төслийн олон нийтийн хэлэлцүүлэгт хууль хэрэгжүүлэх байгууллагуудаас гадна Хүний эрхийн Үндэсний комисс, Өмгөөлөгчдийн холбоо, Хуульчдын холбоо, Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим болон аж ахуйн нэгжүүдийн төлөөллийг хамруулсан болно.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрдлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлд дараах нэмэлтийг оруулахаар тусгасан болно.

1 дүгээрт, хуулийн этгээдэд тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрхийг түдгэлзүүлэх, таслан сэргийлэх арга хэмжээ авахад харгалзах нөхцөл;

2 дугаарт, хуулийн этгээдийн тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрхийг түдгэлзүүлэх, таслан сэргийлэх арга хэмжээ авах үндсэн болон нэмэлт, нийт хугацаа, хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах мөрдөн шалгах ажиллагааг явуулахад харгалзах нөхцөл.

Хуулийн төсөл батлагдсанаар хуулийн этгээд таслан сэргийлэх арга хэмжээ авах, хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах ажиллагаанд харгалзах нөхцөл, хугацаа тодорхой болох бөгөөд ажиллагааны процессыг хуульчилснаар хуулийн этгээдийн шударга шүүхээр шүүлгэх эрх процессын тодорхой байдал, пропорциональ зарчмыг хангах суурь болно.

Ийнхүү хууль зүйн орчныг тодорхойгүй байдлыг бууруулснаар эдийн засгийн гол хөшүүрэг болох хувийн хэвшил, бизнесийн байгууллагуудын үйл ажиллагааны тасалдлын эрсдэл болон жижиг хувьцаа эзэмшигч, ажилчид, зээлдэгч, дам нөлөөгөөр хохирох эрсдэлийг бууруулах эерэг үр дагавартай гэж үзэж байна.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Хуулийн төслийн хэлэлцэх хэсгийг шийдвэрлэж өгнө үү. Баярлалаа.

С.Бямбацогт: Энхтүвшин гишүүнд баярлалаа.

Төслийн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Баярмагнайн Баярбаатар танилцуулна. Индэрт урьж байна.

Б.Баярбаатар: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн Энхтүвшин нарын 6 гишүүнээс 2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрдлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Хууль зүйн байнгын хорооны 2026 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн хуралдаанаар хэлэлцлээ.

Хууль санаачлагч хуулийн этгээдэд хөрөнгийн шилжилт хөдөлгөөн хязгаарлах, тодорхой үйл ажиллагааг эрхлэх эрхийг түдгэлзүүлэх, таслан сэргийлэх арга хэмжээ авахтай холбогдон үүсдэг зохицуулалтын дутагдлыг арилгах, эрх зүйн орчныг сайжруулах зорилгоор хуулийн төслийг боловсруулсан байна.

Хууль санаачлагч хуулийн төсөл батлагдсанаар иргэн, хуулийн этгээд болон төрийн байгууллагад нэмэлт зардал үүсэхгүй гэж үзсэн бөгөөд хуулийн төслийг d.parliament.mn цахим сайтад байршуулж, иргэд олон нийтийн саналыг авч байгаа болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Баасанжаргал Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журамтай холбогдсон хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах зохицуулалт бүхий хуулийн төсөлд Улсын Дээд шүүх болон Улсын ерөнхий прокуророос санал авсан, авах зохицуулалтын хүрээнд дээрх байгууллагуудаас ирүүлсэн төслийг дэмжээгүй талаарх саналын үндэслэл, тайлбарыг судлан үзэж, тэдгээрийг хуулийн төсөлд тусгасан эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Цогтбаатар Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу Хүний эрхийн Үндэсний комиссоос авсан санал авсан эсэх талаар тус тус асуулт асууж, хариулт авсан болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Сайнзориг Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу Улсын дээд шүүх Улсын ерөнхий прокуророос авсан саналыг өргөн мэдүүлсэн хуулийн төсөлд хавсаргаж, холбогдох үндэслэл, мэдээллийг тусгах шаардлагатай талаар, мөн Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн болон хэлэлцүүлгийн шатад байгаа Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй нэгтгэн хэлэлцэх нь зүйтэй талаар, Улсын Их Хурлын гишүүн Амарсайхан Хууль зүй, дотоод хэргийн яамнаас уг хуулийн төслийн зохицуулалт хэт ерөнхий, тодорхой бус байна гэсэн санал өгсөнтэй холбогдуулан төслийн агуулга, хамрах хүрээ, эрх зүйн үр дагаврыг илүү нарийвчлан тодорхой болгож, хэрэгжилтийг хангахуйц байдлаар боловсронгуй болгох шаардлагатай талаар, мөн Улсын Их Хурал өргөн мэдүүлсэн эрүүгийн болон процессын хуулийн төслүүдийн уялдааг хангаж, давхардал, зөрчлийг арилгах зорилгоор нэгтгэн хэлэлцэх нь зүйтэй талаар, Улсын

Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар хуулийн төслийн зарчмын хувьд дэмжиж байгаа бөгөөд цаашид Эрүүгийн болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хууль тогтоомжийг боловсронгуй болгох асуудлыг Засгийн газраас системтэйгээр боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх нь зүйтэй талаар тус тус үг хэлж, байр суурь илэрхийллээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.11 дэх хэсэгт заасны дагуу санал хураалт явуулахад Эрүүгийн хэрэг хянан шийдвэрдлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 66.7 хувиар дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрдлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулсан талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье.

С.Бямбацогт: Баярбаатар гишүүнд баярлалаа. Ажлын хэсэг танилцуулъя. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрдлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл Энхтүвшин нарын 6 гишүүн санаачилсан. Баавгайн Эрхбаяр хуульч, Бат-Эрдэнийн Батбаяр өмгөөлөгч ийм хүмүүс Их Хуралд хүрэлцэн ирсэн байна. Улсын Их Хурлын гишүүдийн асуултад үнэн зөв, бодитой мэдээлэл хэлж, хариулт өгөх ёстой. Улсын Их Хуралд хүндэтгэлтэй хандах ёстойг та бүхэндээ сануулъя. Ингээд асуултаа асууцгаая гишүүд.

Пүрэвжавын Сайнзориг гишүүн асуултаа асууя. Больсон байна. Хассуурийн Ганхуяг гишүүн алга байна. Батын Батбаатар гишүүн алга байна. Ганзоригийн Лувсанжамц гишүүн.

Г.Лувсанжамц: Өдрийн мэнд хүргэе. Бизнес эрхэлж байгаа, ажлын байр, нэмэгдүүлж байгаа, нэмүү өртөг үүсгэж байгаа хувь хүн байна уу, аж ахуйн нэгж байна уу бүгдийг нь Монголын төр бол дэмжиж ажиллаж байх ёстой. Хамгийн гол нь төрийн аливаа үйл ажиллагаа, арга хэмжээ тодорхой байх ёстой. Тодорхойгүй байдал гэдэг бол бизнес эрхэлж байгаа хүнд бол хамгийн төвөгтэй зүйл байдаг. Тэгэхлээр одоо яг манай энэ Эрүүгийн хууль ч байдаг юм уу, эсвэл татварын орчин энэ зүйлүүд маань яг бизнес эрхэлж байгаа хүмүүстээ тодорхой байдлыг бүрэн дүүрэн өгч чадаж байна уу? Эндээ бол эргэлзээ байгаа. Бизнес эрхлэхэд нь тогтвортой орчноор хангаж өгөх нь төрийн хувийн хэвшлээ дэмжих хамгийн том арга хэрэгсэл болов уу гэж бодож байна.

2002 оны Эрүүгийн хэргийн хянан шийдвэрлэх тухай хуулиар уг нь бол зөвхөн хувь хүнд хариуцлага хүлээлгэдэг байсныг энэ 2014 оны өөрчлөлтөөр хуулийн этгээдэд бас хариуцлага хүлээлгэдэг больё гэж өөрчилсөн боловч зохицуулалт нь тодорхой бус байгаа буюу сая хэлсэн төрийн тодорхой байдлыг байхгүй болгоод байгаа. Хэзээ асуудал шийдэгдэх юм, таслан сэргийлэх арга хэмжээ авах юм бол ямар хугацаанд авах юм, ямар арга хэмжээ авах юм, хэзээ

шалгагдаж дуусдаг байх юм бэ гэсэн ийм зүйлүүд нь тодорхойгүй болчхоод байгаа.

Тэгээд энийг залруулах зорилготой хуулийн төсөл гэж бодож байна. Хуулийн төслийг бол дэмжиж байгаа. Одоо тулгарч байгаа асуудлууд бол хянаж шалгаж байна гээд цагдаагийн байгууллага дээр байдаг юм уу, Авилгатай тэмцэх газар, Прокурор гэсэн байгууллагууд маань аж ахуйн нэгжтэй сая хэлсэн тодорхойгүй нөхцөл байдлыг үүсгэчихдэг. Тэгээд таслан сэргийлэх арга хэмжээг үзэмжээр хийгээд байдаг тийм. Яг мөрдөн шалгах ажлаа явж байгаа албан хаагчаас хамаараад, эсвэл тухайн аж ахуйн нэгжээсээ хамаараад өөр өөр зохицуулалтуудыг хийгээд байдаг. Тэгэхлээр энэ зүйлүүдийг зохицуулах ёстой. болов уу гэж бодож байна.

Дээрээс нь нэмээд бас хугацаа сунжирдаг асуудал байгаа. Хамгийн чухал нь дансыг нь хаачихдаг. Энэ чинь дансыг нь хаахлаар тэнд тэр байгууллагад ажиллаж байгаа хүмүүс, тэр байгууллагатай хамтарч ажилладаг, бэлтгэн нийлүүлдэг ч байдаг юм уу, худалдаж авдаг, магадгүй захиалга гүйцэтгэж байгаа компани байж болно. Тэр бүх оролцогч талуудын амьжиргаагаа залгуулж явах боломжийг нь ганц дансыг нь хааснаараа л таслаад хаячихдаг. Тэгэхлээр энэ зүйлүүдийг шийдэх ёстой байгаа. Тэгээд энийг яаж зохицуулж байгаа вэ гэдэг эхний асуулт байна.

2 дахь нь энэ эрүүгийн хянан шалгах, хэрэг хянан шалгах, хянан шийдвэрлэх хуулийг өөрчилснөөрөө яг хамгийн чухал ямар асуудлууд шийдэгдчихэж байгаа вэ? 2, 3-н яг үндсэн зорилгоо та бүхэн маань хариулж өгөхийг хүсье.

3 дугаарт нь олон улсад бас жишгүүд байдаг болов уу? Манайхтай адилхан бас хуулийн этгээдэд хариуцлага тооцдог улсууд бас байгаа байх. Эсвэл зөвхөн хувь хүн дээр хариуцлага тооцдог хуультай улсад ч байгаа. Ийм улсуудтай харьцуулаад тэдний туршлагаас авсан зүйл, заалтууд энд байна уу гэсэн ийм 3 асуултад хариулт авъя.

С.Бямбацогт: Хууль санаачлагч Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн хариулъя.

Д.Энхтүвшин: Лувсанжамц гишүүний асуултад хариулъя. Ер нь бол бизнесийн байгууллагуудын эрсдэлүүдийн жагсаалтыг судалгаанууд хийсэн байдаг. Тэрний хамгийн том эхнээсээ 2-т ордог. эрсдэл бол бизнесийн тасалдал үйл ажиллагааны тасалдал байгаа. Тэгэхээр мэдээж гэмт хэргийн зориулалттай, сэдэлтэйгээр үүсгэн байгуулагдсан компаниудаас гадна гэм буруугүй яг энэ хэрэг хянан шийдвэрлэх явцад бас гэм буруугүй этгээдүүд хохирч болзошгүй иймэрхүү нөхцөл байдлууд байдаг. Хувь хүн дээр бол шууд эрүүгийн хариуцлага хүлээхээр яг эцсийн тодорхой сэдэлтэй учраас энэ нь илүү ойлгомжтой байдаг.

Хуулийн этгээдийн хувьд бол тодорхой субъектив сэдэлгүй энэ этгээдийн хувьд бол үйл ажиллагааг нь түдгэлзүүлэх, хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг нь хязгаарлахаар цаана нь дан байдлаар, шууд бус байдлаар гэм буруугүй этгээдүүд хохирох бас ийм эрсдэлүүд байдаг. Тэгэхээр энийг тодорхой болгох зайлшгүй шаардлага байгаа. Энэ хуулийн төсөл маань ер нь бол шинэ зүйл гэхээсээ илүү

жоохон процесс нэмж байгаа, процессыг л сайжруулж байгаа ийм зүйл, заалт байгаа.

Өөрөөр хэлбэл, хувь хүнийг жишээлбэл цагдан хориход 1 сарын хугацаатайгаар тодорхой нөхцөлүүдийг харгалзаж үзэж шийддэг бол хуулийн этгээд дээр ийм юм байхгүй болохоор жишээлбэл дансыг нь хаагаад, үйл ажиллагааг нь зогсоогоод 2 жил алга болчихдог. Тэр хооронд жишээлбэл тухайн компани ингээд дампуур эрсдэлд ордог. Хувь хүнээр бол хэрэг хянан шийдвэрлэх явцдаа бараг цаазаар авч байгаа гэсэн иймэрхүү үр дүн, нөлөө байгаа учраас энэ процессуудыг нь сайжруулж байгаа юм.

Эрүүгийн энэ хуулийн тусгай зүйлээр бол нийтдээ 34 төрлийн хэрэгт энэ хуулийн этгээдийг хариуцлага ногдуулахаар байгаа. Тэгэхээр энэний 4 нь жишээлбэл тухайн компанийг татан буулгах, бусад зүйлүүд нь бол тодорхой хэмжээний торгууль болон тодорхой үйл ажиллагаануудын түдгэлзүүлэх, зогсоох гэсэн иймэрхүү арга хэмжээнүүд авдаг.

Тэгэхээр өөрөөр хэлбэл гэмт хэргийн нөхцөл байдлын хувьд бол харьцангуй хөнгөн төрлийн ийм гэмт хэргийн шинжтэй мөртөө хэрэг хянан шийдвэрлэх процесс нь тодорхойгүй байгаа нь өөрөө энэ процесс нь ял болох ийм нөхцөл байдлыг бүрдүүлж байгаа. Энийг сайжруулж байгаа юм.

Олон улсын нөхцөл байдал дээр бол энэ таслан сэргийлэх арга хэмжээ, энэ хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах, мөрдөн шалгах үйл ажиллагаанууд дээр бол шүүхийн зөвшөөрөл авсан хууль ёсны зарчимд нийцсэн байх ёстой гэдэг ийм зарчмууд байдаг. Тэгэхээр Эрүүгийн хууль дээр энэ хуулийн этгээдэд хариуцлага ногдуулж байгаа энэ харилцаа маань өөрөө харьцангуй шинэ учраас яг энэнтэй холбоотой зохицуулалтыг тодорхой оруулаагүйгээс болоод энэ хууль ёсны зарчимд нийцсэн гэдэг энэ шаардлагыг хангаж чадахгүй иймэрхүү нөхцөл байдал үүсээд байгаа учраас энэ процессыг нь илүү тодорхой олгож байгаа.

Дээр нь нэмээд ажлын хэсгээс нэмж хариулт өгөх үү.

С.Бямбацогт: Ажлын хэсгийн 4 дүгээр микрофон хариулъя.

Б.Батбаяр: Өмгөөлөгч Батбаяр. Ер нь энэ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14 дүгээр бүлгээр таслан сэргийлэх арга хэмжээг зохицуулдаг. Гэтэл энэ таслан сэргийлэх арга хэмжээ зохицуулж байгаа 14 дүгээр бүлэг маань бүхэлдээ хувь хүнд зориулагдсан шинжтэй, доторх зохицуулалтууд нь тийм агуулгатай байдаг.

Гэтэл хуулийн этгээдийг эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг болсон хуулиас хойшоо энэ хууль дээр ганцхан үг өгүүлбэр нэмэгдсэн нь 14.4 дүгээр зүйл дээр байгаа хуулийн этгээдэд албан үүргийг түдгэлзүүлэх, таслан сэргийлэх арга хэмжээ авч болно гээд заачихсан. Ямар шалгуураар, хэзээ, хэн, яаж авах вэ, ямар харгалзан үзэх нөхцөлүүдийг авч үзэх вэ гэдэг бол огт орхигдсон. Тэр чигээрээ зохицуулалтгүй орхигдсон ийм нөхцөл байдалтай байгаа.

Тэгэхээр зэрэг энэ хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр тэр хуулийн этгээдийн таслан сэргийлэх хэмжээг авдаг процессыг илүү тодорхой болгоё гэж ингэж хүсэж

байгаа. Яагаад гэхээр зэрэг Үндсэн хуулийн тэр шударга шүүхээр шүүлгэх зарчим гэдэг бол өөрөө процессын шударга ёсны зарчмыг ойлгодог. Тэгэхээр процессын шударга ёсны зарчим гэдэг маань өөрөө процесс тодорхой байх тухай ойлголт. Тэгэхээр процесс тодорхой байхаар талуудын мэтгэлцээний.../минут дуусав./

С.Бямбацогт: Лувсанжамц гишүүн тодруулж асууя.

Г.Лувсанжамц: Баярлалаа. Энэ тодорхойгүй зүйл, заалтуудыг нь илүү нарийвчилж өгөөд засаж, залруулж байгаа юм байна. Тэгэхлээр илүү ерөнхий байсан зүйлийг процессыг нь тодорхой болгож өглөө гэж ойлгож байна. Та бүхэн маань энэ хуулийн төслөө өргөн барихдаа бас одоогийн байгаа нөхцөл байдлын хэрэгжилтийн үр дагаврын судалгааг хийсэн болов уу гэж бодож байна.

2014 онд хуулийн этгээдэд ийм таслан сэргийлэх арга хэмжээ, хянан шийдвэрлэх арга хэмжээ авдаг болсноос хойш яг энэ арга хэмжээ авч байх хугацаандаа тодорхойгүй байдлын улмаас бизнесийн үйл ажиллагаа нь дампуурсан, зогссон тийм судалгаа хийсэн болов уу? Тэрний үр дүнд ажлын байр хэдээр цөөрсөн ч байдаг юм уу тийм дата судалгаа байгаа болов уу?

С.Бямбацогт: Ажлын хэсэг хариулъя. 4 дүгээр микрофон.

Б.Батбаяр: Энэ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.4 дүгээр зүйл дээр байгаа тодорхой төрлийн үйл ажиллагааг түдгэлзүүлэх, таслан сэргийлэх арга хэмжээ нь хуулийн этгээдэд авдаг цорын ганц таслан сэргийлэх арга хэмжээ. Тэгэхээр хуулийн этгээд хянан шалгагдсан би 19 оноос хойш 25 оныг хүртэлх судалгааг ингээд харж байхаар жилд 10-15 хэрэг шүүхээр ордог. Таслан хувь нь бол гэм буруутайд тооцогддог.

Гэтэл энэ дээр нь бүгдэн дээр нь таслан сэргийлэх арга хэмжээ авсан байдаг. Тэгэхээр энэ таслан сэргийлэх арга хэмжээ бол ерөөсөө мөрдөн шалгах ажиллагааны явцад авагдаж байгаа ингээд хуулийн этгээдийн үйл ажиллагаа бол зогсож байгаа. Гэтэл хуулийн этгээдийн маань ял шийтгэл нь торгуулийн ялтай байдаг. Бараг бүгд. Гэтэл үйл ажиллагаагаа 2 жилийн хугацаанд зогсоолгочхоод шүүх дээр очоод 2 сая юм уу, 20 сая төгрөгөөр торгуулдаг. Тэгэхээр зэрэг энэ 2 хоорондоо авцалдаагүй буюу таслан сэргийлэх арга хэмжээ нь ял шиг хэрэгжээд, шийтгэл нь торгууль болж хувирдаг. Тэгэхээр энэ маш их хохиролтой гэдэг нь Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс гаргасан жил болгоны гэмт хэргийн статистикаас харагддаг. Прокурорын байгууллагын жил болгоны тайлан дээр таслан сэр.../минут дуусав./

С.Бямбацогт: Лувсанжамц гишүүн тодруулж дахиж нэмэлт асуулт.

Г.Лувсанжамц: Баярлалаа. Таны хариултад байсан нэг чухал зүйл байна шүү дээ жилд 10-15 аж ахуйн нэгжийг шалгадаг юм байна. Тэгэхдээ 70 хувь нь бол гэм буруутай гэж тооцогдоод торгуулийн арга хэмжээ авагддаг юм байна. Гэтэл нөгөө талдаа үлдэж байгаа нөгөө 30 хувь буюу жилд ойролцоогоор 5 компани байна шүү дээ 5 аж ахуйн нэгж таслан сэргийлүүлчихдэг, тэгсэн хэр нь гэм буруугүй болгоод тогтоочихдог, тэр хугацаанд нь үйл ажиллагааг нь зогсоочихсон байдаг гэдэг. Тэгэхлээр энэ зүйлүүдийг засаж өгч байгаа юм байна гэж ойлголоо.

Тэгэхлээр энэ хуулийг дэмжиж байна. Бусад гишүүд маань ч гэсэн дэмжихийг хүсэж байна.

С.Бямбацогт: Үг хэлчихлээ. Батбаярын Жаргалан гишүүн алга байна. Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн асуултаа асууя.

Х.Баасанжаргал: Миний асуулт Хууль зүйн байнгын хороон дээр асуусан боловч тодорхой хариултаа авч чадаагүй асуултыг бас энд асууж хуралдааны тэмдэглэлд үлдээе. Яагаад гэвэл Хууль тогтоомжийн тухай хууль шинэчлэгдээд эрүүгийн процессын хуулиудад энэ мэт ийм өөрчлөлтийг оруулах гэж байгаа бол Улсын дээд шүүхээс, Улсын ерөнхий прокуророос, дээрээс нь хүний эрх эрх чөлөөг хязгаарлахтай холбоотой зохицуулалт хуулийн төсөл дээр Хүний эрхийн Үндэсний Комиссоос санал авахаар манай энэ парламент хуульчилсан.

Тэгэхээр эдгээр байгууллагуудаас санал авсан уу? Санал нь ямар агуулгатай товчхон агуулга нь дэмжиж байгаа юм уу, дэмжихгүй байгаа юм уу? Дэмжихгүй байгаа үндэслэл нь ямар үндэслэлээр дэмжихгүй гэж байгаа юм. Яг энэ эрх бүхий байгууллагуудын яг мөрдөн байцаах ажиллагаа, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд бүрэн эрхтэй оролцдог эдгээр байгууллагуудын хэлээд байгаа үндэслэл яг хуулийн төсөл дээрээ арилж орж ирсэн үү, хуулийн төслөөрөө зассан уу гэдэг ийм асуултыг 1 дүгээрт асууя.

2 дугаарт гэвэл энэ аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг зогсоодог, мөрдөн байцаалтын ажиллагааны явцад хязгаарладаг энэ зөвхөн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцаас гадна иргэний хэрэг хянан шийдвэрлэх бас процесс хуулиуд дээр байдаг. Бид нарын мэддэг 69-ийн арга хэмжээ гэж явдаг.

Гэхдээ иргэний процессын үед бол энэ нь өөрөө тодорхой хэмжээгээр хяналттай, хязгаарлалттай, тайлбартай шүүхийн өмнө талууд мэтгэлцдэг онцлогтой. Гэтэл эрүүгийн процессын хувьд энэ мэтгэлцэх зарчим хэр хангагддаг юм бэ? 2 дугаар асуулт нь.

Хамгийн сүүлд юу вэ гэвэл та хэд сая 10 гаруй аж ахуйн нэгж шалгагдаад шүүхээр ордог юм байна гэж байна. Шүүхээр орохгүй мөрдөн байцаалт, прокурорын шатдаа бас шалгагдаж байгаа. Тэгсэн хэр нь хэрэг нь 2 сар, 3 сар, 1 жил шалгагдаж байгаад хэрэгсэхгүй болчихдог ийм тохи тохиолдлууд маш олон байдаг. Энэ тохиолдол тоонууд бас саяын энэ 10 хэд гэдэг тоон дээр чинь нэмэгдэх үү гэдэг ийм асуулт байна. Энэ хуулиар дамжуулаад бид нар энэ удаагийн энэ өөрчлөлтөөр дамжуулаад ер нь энэ аж ахуйн нэгж, бизнесийнхний үйл ажиллагаанд хуулиар дамжуулж хязгаарлалт үүсгэдэг энэ зүйлүүдээ ер нь бид нар нэг эргэж харах цаг нь болсон байх гэж бодож байна. Бид нарын хамгийн сайн мэддэг нэг тохиолдол юу вэ гэвэл жилийн эцэст аж ахуйн нэгжүүдийн дансыг хаачихдаг татвар цуглуулах нэрийдлээр, төсөв бүрдүүлэх нэрийдлээр. Тэгэхээр энэ асуудлыг ер нь бид нар бас Энхтүвшин гишүүнийг ч гэсэндээ бас энэ асуудалд анхаарлаа хандуулаасай гэж бодож байгаагаа бас энэ ташрамд бас хэлчихье. Тэгээд асуултдаа хариулт авъя.

С.Бямбацогт: Ажлын хэсэг хариулъя 4 дүгээр микрофон.

Б.Эрхбаяр: Хуульч Эрхбаяр. Гишүүний асуултад хариулъя. Хуулийн төслийг боловсруулахдаа Хууль тогтоомжийн тухай хуулийн 21.1-д заасны дагуу Засгийн газрын саналыг авсан байгаа. Дээрээс нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 39.1-д заасны дагуу хуулийг хэрэгжүүлэх, хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллагуудаас санал авсан. Энэ дээр болохоор Цагдаагийн ерөний газар, Авилгатай тэмцэх газар, Ерөнхий прокурорын газраас санал ирүүлсэн байгаа. Дээрээс нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 39.3-д заасны дагуу Хүний эрхийн Үндэсний Комисс, Улсын дээд шүүхээс санал авахаар бичиг явуулсан. Энэ дээр санал ирүүлээгүй байгаа. Энэ саналыг хуулийн төсөлд тусгасан асуудлаар төсөл бол Батбаяр нэмээд хариулчих уу ажлын хэсгээс.

С.Бямбацогт: Нэмээд хариулчихъя.

Б.Батбаяр: Тэгэхээр зэрэг тодорхой саналууд ирсэн саналуудаас заримыг жишээлбэл тэр 26.2-т байгаа данс битүүмжлэхтэй холбоотой асуудал дээр хугацааг бол хуулийн төсөл дээрээ өөрчлөлт оруулсан. Энэ Улсын дээд шүүхээс ирүүлсэн санал бол манай ажлын хэсгээс, ажлын албанаас 10 сар, 11 сарын 07-нд яваад 30 хоногийн дотор бол хариугаа ирүүлээгүй. Харин Засгийн газар луу явуулсан саналыг цааш нь Дээд шүүх рүү хуваарилж явуулаад тэрэн дээр 2 сарын дараа хариу ирүүлсэн байсан. Тэгэхдээ бол энэ дээр санал өгөхгүй гэдэг ийм зүйл ирүүлсэн ийм нөхцөл байдалтай байгаа.

2 дахь асуултад хариулъя. Тэр юу вэ гэхээр зэрэг ер нь бол хэрэг бүртгэлд мөрдөн байцаалтын ажиллагааны явцад бол хуулийн этгээдийн дансыг хаах, таслан сэргийлэх арга хэмжээ авах тохиолдлууд байгаа. 25 оных сүүлийн байдлаар гэхэд 68 хэрэг дээр одоогийн байдлаар яллагчаар татсан хэрэг үүссэн ийм шалгагдаж байгаа гэдэг статистиктай байгаа. Таслан сэргийлэх хэмжээ авагдсан. Хөрөнгө хамгаалах ажиллагаа ямархуу хэмжээнд авагдсан бэ гэдэг нь нөгөө яг хуулийн этгээдийг нь тусад нь салгаж тэгж тооцоолсон тооцоолол байдаггүй юм байна лээ.

Энэ иргэний процесс болон эрүүгийн энэ заалт хоёрын уялдаа холбооны талаар асууж байна. Тэгэхээр иргэний процесс дээр бол хориглосон хэм хэмжээ байдаг. Өөрөөр хэлэх юм бол байгууллагын түргэн муудах бараа, бүтээгдэхүүн 69-ийн арга хэмжээ авах юм бол ийм тохиолдолд авч болохгүй. гээд зохицуулчихсан байдаг.

Эрүүгийн процесс дээр тэрийг хориглох боломж байхгүй. Харин харгалзах нөхцөлийг заавал тусгаж өгөх ёстой. Жишээлэх юм бол хувь хүн дээр цагдан хорих, таслан сэргийлэх хэмжээ авахад ар гэр бүлийн байдал, хувийн байдал, эрүүл мэнд зүйлийг харгалздаг. Гэтэл хуулийн этгээд дээр ямар ч харгалзан үзэх нөхцөл байдал хууль дээр байхгүй байж байгаа. Өнөөдөр тэгэхээр хуулийн этгээд чинь ард талдаа өчнөөн олон хүмүүсийн татвар төлөгч нар, ажилтнууд гээд олон эрх ашиг байж байдаг. Гэтэл энийг бол харгалзаж үзэхгүйгээр, ямар нэгэн нөхцөлгүйгээр, ямар нэгэн хугацаагүйгээр хэрэг дуустал таслан сэргийлэх хэмжээ авдаг ийм практиктай байгаа. Тэгэхээр энийг залруулах, энийг процесстой болгох ийм хуулийн төсөл байгаа.

С.Бямбацогт: Зочин танилцуулъя. Нийслэлийн ерөнхий боловсролын “Эрдмийн өргөө” сургуулийн Оюунгэрэл багштай 12 дугаар ангийн сурагчид Улсын

Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Төрийн ордонтой танилцаж байгаа сургагч хүүхдүүддээ энэ өдрийн мэнд хүргэж, сурлагын өндөр амжилт, хамгийн сайн сайхан бүхнийг Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс хүсэн ерөөе. Удахгүй болох элсэлтийн шалгалтаа амжилттай өгч, хүссэн мэргэжлээр хүссэн сургуульдаа элсэн орж, улс эх орондоо ихийг хийж бүтээсэн бүтээлч, хуулиа дээдэлдэг иргэн болоорой.

Баасанжаргал гишүүн тодруулж асууя.

Х.Баасанжаргал: Энэ мөрдөн байцаалтын шатанд таслан сэргийлэх арга хэмжээ авах буюу үйл ажиллагааг нь зогсоосон атлаа тэгээд эргээд хэрэг нь цагаадсан, хэрэгсэхгүй болсон ийм тохиолдолд аж ахуйн нэгжүүд өөрсдийнхөө өөрт учирсан хохирлоо буцаагаад нэхэмжилж, хохирлоо барагдуулж байсан тохиолдолд тийм хэрэг, тийм кэйс тохиолдол ер нь байдаг юм болов уу гэсэн нэг тодруулга байна.

2 дугаарт Улсын дээд шүүхээс гадна Улсын ерөнхий прокурор, Хүний эрхийн Үндэсний Комиссоос хариу ирээгүй юм уу, эсвэл тодорхой үндэслэлтэй хариу ирэхэд нь тэр хариу нь үндэслэл нь бол та бүхний энэ хуулийн төслийн үндэслэл, үзэл баримтлалтай нийцээгүй ч гэдэг юм уу эсвэл ийм үндэслэл байгаа юм уу гэдэг дээр жоохон тодруулаад өгөөч. Тэгэхгүй бол яг нөгөө хариу ирээгүй юм шиг, огт эсвэл юу гэдэг юм тайлбар аваагүй юм шиг л ийм процесс явагдах гээд байна л даа. Тэгэхээр хэдүүлээ үнэн, зөв тайлбар энд өгөхгүй бол дараа нь бас асуудал үүсэх магадлалтай.

С.Бямбацогт: 4 дүгээр микрофон хариулъя.

Б.Батбаяр: Улсын дээд шүүхээс ирсэн хариу болохоор зэрэг бидний явуулсан бичигт хариу ирүүлээгүй хуульд заасан хугацааны дотор. Засгийн газрын Засгийн газар харьяа байгууллагуудаас авсан саналын хүрээнд хариу ирүүлсэн. Ингэж ирүүлэхдээ Улсын дээд шүүх бол Засгийн газрын харьяа байгууллага биш ээ ийм учраас энэ дээр бид нар санал өгөхгүй гэдэг ийм хариулт ирүүлсэн. Тэгэхээр энэ хуулийн төсөл дээр санал ирүүлээгүй гэж үзэж болно. Яг л тийм хариу ирүүлсэн.

Хүний эрхийн Үндэсний Комисс руу бичиг явуулсан боловч хариу ирүүлээгүй. Гэхдээ хэлэлцүүлэг зохион байгуулахад ирээд хурлын тэмдэглэл дээр энэ хуулийн төслийг агуулгын хувьд бүхэлд нь дэмжиж байгаа гэдэг саналаа хэлсэн нь энэ тэмдэглэлд тусгагдаад бичиг баримт дотор орсон байгаа ийм юутай.

С.Бямбацогт: Баярлалаа. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Хохирлоо нэхэмжилж байсан тохиолдол бий юү гэнэ. Ер нь Дээд шүүх бол юу шүү дээ, хууль санаачлагч бол Засгийн газраас санал авах хуулийн зохицуулалттай. Сарын хугацаанд. Сарын хугацаанд санал өгөөгүй бол саналгүй тооцоод цаашаа процесс явдаг. Бусад байгууллагаас заавал санал авах ёстой гэсэн зохицуулалт байхгүй. Яах вэ санал авах гэж үзсэн юм байна. Тэгээд саналаа ирүүлсэн зарим нь. Зарим нь ирүүлээгүй юм байна гэж ойлголоо. Нэмээд хариулчихъя тэр хохирлоо барагдуулж байсан, нэхэмжилж байсан тохиолдлууд бий юү гэж.

Б.Батбаяр: Тэгэхээр энэ жишээлбэл таслан сэргийлэх арга хэмжээний хохирол, эвэл хөрөнгө хамгаалах ажиллагааны хохирол хоёр бол хоорондоо хоёр өөр юм байгаад байгаа юм. Хоёр өөр зохицуулалт байна.

Нэг нь мөрдөн шалгах бусад ажиллагаа, нөгөөдөх нь бол таслан сэргийлэх арга хэмжээ. Тэгэхээр энэ хоёр дээр аль алин дээр нь ямар хэмжээний хохирол учруулсан бэ гэдэг тийм тооцоолол бол байдаггүй судалгаагаар. Гэхдээ энэ хоёр арга хэмжээг бол дандаа л авч хэрэгжүүлж байдаг. Аж ахуйн нэгжүүд бол маш их гомдолтой, саналтай байна гэдгээ бол ил цагаан сошиалаар ч юм уу олон нийтэд дандаа л мэдээлж байдаг. Яг ингээд тоо тооцооллыг нь гаргачихсан зүйл бол байхгүй юм байна лээ.

С.Бямбацогт: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Одоо дэмжсэн, дэмжээгүй байр сууриа илэрхийлж гишүүд үг хэлнэ. Үг хэлэх гишүүд нэрээ өгнө үү.

Байхгүй юм байна.

15.53 цаг.

Нийслэлийн ерөнхий боловсролын “Гурвантамир” сургуулийн Хосбаяр багштай 12^а ангийн сурагчид их Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Төрийн ордонтой танилцаж байгаа нийт хүүхэд багачууддаа, сурагчдадаа сурлагын өндөр амжилтыг нийт Их Хурлынхаа гишүүдийн нэрийн өмнөөс хүсэн ерөөе. Амьдралд нь аз жаргалыг хүсэн ерөөе. Хүссэн мэргэжлээрээ хүссэн сургуульдаа элсэн орж, улс эх орондоо хэрэгтэй, бүтээлч, хуулиа дээдэлдэг иргэн болоорой.

Гишүүд үг хэлж дууслаа. Санал хураалтыг удахгүй явуулъя. Гишүүдийг танхимд цуглаж байх хооронд Сайнзориг гишүүний хуулийг явуулж байх уу? Тэгье. Дараагийн асуудалдаа оръё.

Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг явуулна.

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Пүрэвжавын Сайнзориг танилцуулна. Индэрт урьж байна.

П.Сайнзориг: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн Алтаншагай, Амарбаясгалан, Мандхай, Мөнхбаатар, Тэмүүжин, Уянгахишиг нартай хамтран Монгол Улсын Үндсэн хуульд заасны дагуу Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт оруулах хуулийн төслийг боловсрууллаа.

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорьдугаар зүйлийн 1 дэх хэсэгт Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хурал хадгална гэж, Хорин тавдугаар зүйлийн 1 дэх

хэсэгт Улсын Их Хурал нь төрийн дотоод, гадаад бодлогын аль ч асуудлыг санаачлан хэлэлцэж болох бөгөөд дараах асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэнэ гэж гэж зааж, мөн хэсгийн 1 дэх заалтад хууль батлах нэмэлт, өөрчлөлт оруулах гэж тус тус заасан байдаг.

Түүнчлэн Монгол Улсын Засгийн газрын 20-оос 28 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.1.1.14-д хүний эрх чөлөөг хамгаалах, зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, үндэсний хууль тогтоомжийг хүний эрхийн олон улсын гэрээ конвенцод нийцүүлэх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх, хуулиас давсан зохицуулалт бүхий дүрэм, журмуудад дүн шинжилгээ хийж цэгцлэх арга хэмжээ авна гэж заасан.

Парламент нь хэм хэмжээ тогтоох эрхийг бусад албан тушаалтан байгууллага буюу нийтлэгээрээ гүйцэтгэх эрсдэлийн байгууллагад шилжүүлэх нь олон улсын жишиг төдийгүй манай улсын хууль зүйн тогтолцоонд хэвшиж буй ойлголт болно.

Парламент нь хэм хэмжээ тогтоох эрхийг бусад албан тушаалтан байгууллага зөвхөн хуулиар шилжүүлдэг бөгөөд хуулиар эрх олгогдсоны дагуу батлах эрх зүйн дэд актын агуулга хүрээ хязгаарыг хуульд тодорхой тусгах шаардлагатай байдаг.

Энэхүү эрх зүйн дэд актын зарим тодорхой хэсгийг захиргааны хэмжээний акт гэсэн нэршлийн хүрээнд Хууль тогтоомжийн тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн хүрээнд зохицуулж байна.

Захиргааны ерөнхий хуулийг 2016 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхлэхээс өмнө захиргааны хэмжээний акттай холбоотой харилцааг Засгийн газрын тогтоолоор баталсан журмын хүрээнд зохицуулж байсан байдаг.

Харин Захиргааны ерөнхий хууль батлагдах хуульд захиргааны хэмжээний актыг батлах эх сурвалж, үндэслэл, актад тавигдах шаардлага, хүчин төгөлдөр болох нөхцөл, түүнийг хянаж бүртгэх, мэдээллийн сан үүсгэх, мэдээллийн сангаас сонирхогч этгээдийг мэдээллээр хангах зэрэг харилцааг тодорхой тусгасан хэдий ч захиргааны хэмжээний актыг батлах субъектийг захиргааны байгууллага гэсэн нэр томъёоны хүрээнд ерөнхий шинжээр тусган зохицуулсан байдаг.

Монгол Улсын хэмжээнд 2025 оны 9 дүгээр сарын байдлаар 2400 орчим захиргааны хэмжээний акт улсын нэгдсэн бүртгэлд бүртгэлтэй байх бөгөөд Захиргааны ерөнхий хуулийн 64.2-т зааснаар Монгол Улсын Ерөнхийлөгч Засгийн газрын баталсан захиргаа хэмжээний акт нь Улсын Их Хуралд хүргүүлдэг зохицуулалттай. Мөн энэхүү захиргаа хэмжээний акт нь хууль тогтоомжид зааснаар нийтлэг байдлаараа дээд шатын байгууллага, захиргааны шүүхийн хяналтад зарим субъектийн баталсан захиргаа хэмжээний акт нь Үндсэн хуулий цэцээр хянагдах боломжтой байдаг.

Эрх бүхий этгээдийн шийдвэр үйл ажиллагаа нь шүүх болн Үндсэн хуулийн цэц буюу шүүх эрх мэдлийн байгууллагын хяналт байх нь Монгол Улсын Үндсэн хуулийн суурь үзэл баристлал, зарчим төдийгүй хууль дээдлэх зарчим, хүний эрхийг хамгаалахад өндөр ач холбогдолтой.

Гэвч Захиргааны ерөнхий хуулийг хэрэгжиж эхлэхээс өмнө хууль тогтоох практикт нийтээр заавал дагаж мөрдөх үйлчлэн, байнга давтагдах шинжтэй эрх зүйн хэм хэмжээг бий болгох, тогтоох эрх мэдлийг байгууллагын дотоод бүтцийн нэгжид шилжүүлэх явдал бий болсон байдаг.

Тухайлбал, Улсын Их Хурлын Байнгын хороо, дэд хороо нь захиргааны хэмжээний актын шинжийг агуулсан шийдвэр гаргах эрх мэдлийг шилжүүлсэн цөөнгүй хуулийн зохицуулалтууд өнөөдөр ч үйлчилж байна.

Улсын Их Хурлын Байнгын хороо, дэд хороо нь Улсын Их Хурлын үйл ажиллагааны зохих салбар чиглэлээр байгуулагддаг хуулийн этгээдийн эрхгүй дотоод бүтцийн нэгж төдийгүй шийдвэр нь шүүх болон Үндсэн хуулий цэцэд хяналтад байдаггүй. Түүнчлэн баталсан шийдвэрийн бүртгэлийн сан байхгүй, лавлагаа мэдээллээр иргэд, хуулийн этгээдийг хангах нэгдсэн зохицуулалт байдаггүй болно.

Нөгөөтээгүүр Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлд зааснаар Улсын Их Хурал нь хууль тогтоох онцгой бүрэн эрхийг эдэлдэг бөгөөд Улсын Их Хурлын тухай хуулийн 22.5-д хуульд өөрөөр заагаагүй бол Байнгын хороо нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон дүрэм, журам батлахгүй гэж заасан хэдий ч дээрх заалт, зохицуулалтын хуульд өөрөө заагаагүй бол гэж заасан нь нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээг Байнгын хорооны түвшинд батлах эрхийг олгосон явдал болоод байна.

Энэ нь Улсын Их Хурлын 126 гишүүнд хадгалагдах хууль тогтоох эрх мэдэл Байнгын хорооны түвшинд шилжиж, Байнгын хорооны гарсан шийдвэр нь шүүх, Үндсэн хуулий цэцийн хяналтад байхгүй байгаа нь Монгол Улсын Үндсэн хуулиар заасан суурь зарчим, эрх мэдлийн тэнцэл, ашиг сонирхол хөндөгдсөн тохиолдолд шүүхэд хандаж эрхээ сэргээлгэх эрхийг зөрчих үр дагаврыг үүсгээд байна.

Иймд Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг Хууль тогтоомжийн хуулийн дагуу боловсруулсан бөгөөд хуулийн төсөлтэй холбогдуулан Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Авлигалын эсрэг хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Их Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан болно.

Хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төслийг хэлэлцэхийг дэмжиж өгөхийг дэмжиж өгөхийг та бүхнээсээ хүсье.

Анхаарал тавьсан явдалд баярлалаа.

С.Бямбацогт: Сайнзориг гишүүнд баярлалаа. Төслүүдийн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Буяагийн Тулга танилцуулна. Таныг индэрт урьж байна.

Б.Тулга: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг нарын 7 гишүүнээс 2026 оны 05 дугаар сарын 14-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг Хууль зүйн байнгын хорооны 2026 оны 06 сарын 02-ны өдрийн хуралдаанаар хэлэлцлээ.

Хууль санаачлагч захиргааны хэм хэмжээний акт батлах тухай эрхийг тухайн байгууллагын дотоод бүтцийн нэгжид олгохыг хориглох, эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгоор хуулийн төслийг боловсруулсан бөгөөд хууль санаачлагч хуулийн төсөл батлагдсанаар иргэн хуулийн этгээд болон төрийн байгууллагад нэмэлт зардал үүсэхгүй гэж үзсэн байна.

Уг төслийг www.d.parliament.mn цахим сайтад байршуулж иргэд, олон нийтийн саналыг авч байгаа болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг хуулийн төслийг зарчмын хувьд дэмжиж байгаа боловч Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт оруулахгүйгээр Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22.5 дахь хэсэгт өөрчлөлт оруулах замаар уг асуудлыг зохицуулах боломжтой байсан эсэх талаар, мөн Байнгын хороодын журам батлах эрхийг Улсын Их Хуралд шилжүүлэхдээ зарим зохицуулалтыг орхигдуулсан эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар Хууль тогтоомжийн тухай хуулийн төслөөр журмыг цэгцлэх бодлогыг дэмжиж байгаа боловч зарим байгууллагын эрх хэмжээнд батлагдах ёстой журмыг холбогдох дээд шатын байгууллагад шилжүүлж байгаа эсэх талаар тус тус асуулт асууж, хариулт авсан болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.11 дэх хэсэгт заасны дагуу санал хураалт явуулахад Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 55 хувиар дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Авлигын эсрэг хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэхийг хэлэлцүүлгийг явуулсан талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

С.Бямбацогт: Тулга гишүүнд баярлалаа. Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлт болон хууль санаачлагчийн илтгэл болон хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан асуулт асууна. Урьдчилсан ирүүлсэн нэрсийн дагуу.

Баатаржав Мөнхсоёл гишүүн нэрээ татлаа. Амгаланбаатар гишүүн алга байна. Батын Батбаатар гишүүн алга байна. Цэндийн Баатархүү гишүүн алга байна. Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн нэрээ татлаа.

Гишүүд ээ 16 цаг болж байна санал хураалтдаа хүрэлцэн ирнэ үү. 16 цагаас санал хураалттай гэсэн.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Хуулийн төслүүдийн талаар байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг дэмжсэн эсрэг байр суурьтай гишүүд үгээ хэлнэ үү.

Амгаланбаатар гишүүн алга байна.

Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Банзрагчийн Түвшиний урилгаар Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институцийн Хан-Уул дүүргийн салбарын гишүүд Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Төрийн ордонтой танилцаж байгаа та бүхэндээ Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс ажилд нь амжилт, амьдралд нь эрүүл энх, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Түвшин гишүүн маань тэнд сууж байна. Их сайн гишүүн байгаа юм.

Үг хэлэх гишүүн алга байна. Гишүүд үг хэлж дууслаа.

16.04 цаг.

Гишүүд танхимдаа ирцгээнэ үү. Танхимдаа гишүүдийг санал хураахад бэлэн болтол дараагийн асуудлаа хэлэлцэж байя. Энэ чинь юу билээ? Тэрийг жоохон байж байя. Энд олон их олон хүн ярих байх. Саналаа хураачихъя. Гишүүд танхимдаа хүрэлцэн ирнэ үү. Өнөөдөр өглөөнийхөөс явсан асуудлууд дээрээс саналаа хураачихъя тэгээд дараачийн асуудал руугаа оръё.

Одоо Замын хөдөлгөөний аюулгүй байдлаасаа эхэлье санал хураалтуудыг.

Зарчмын зөрүүтэй 2 санал байна. Гишүүд санал хураалтдаа бэлтгэе. Гишүүдийг танхимдаа санал хураалтдаа бэлдээд хурууны хээг уншуулаарай гишүүд ээ. Засгийн газрын гишүүдийг бас урьж байна танхимдаа хүрэлцэн ирэхийг. Бүлгийн дарга нар, бүлгийн дэд дарга нар Улсын Их Хурлын хуралдаан зохион байгуулах газар Улсын Их Хурал дахь намын бүлгүүдийн ажлын алба, Улсын Их Хурлын гишүүдийн зөвлөх, туслахууд гишүүдээ танхимдаа санал хураалтад ирүүлъя. Өнгөрсөн долоо хоногт Их Хурлын парламентын үйл ажиллагаа

сурвалжилдаг сэтгүүлч нар сургалтууд орсон. Ирэх долоо хоногт гишүүдийн зөвлөхүүдэд сургалт орно. Түүний дараад нь гишүүдийн туслахуудад бас тодорхой сургалт, мэдээлэл өгнө. Бас үе шаттайгаар гишүүдийнхээ бас ажлын албыг хийж чанаржуулах, чадавхжуулах ажлуудыг бид бас зохион байгуулж байгаа.

Орж ирж байгаа гишүүд хурууны хээг уншуулаад байгаарай санал хураалтдаа бэлтгээд. 52 гишүүн болж байна. Гишүүд суугаарай, суудлаа эзлээ. Ирээгүй гишүүд танхимдаа хүрэлцэн ирье. Ирц бүртгэлийн санал хураалт.

Ирц бүртгэлийн санал хураалтаар татгалзсанд гарч байгаа гишүүд бол үндсэндээ ажилдаа байхгүй байна л гэсэн үг шүү дээ нөхөд өө. Тийм болохоор дэмжиж байгаа нөхдүүд бол энэ танхимдаа суугаад ажлаа хийж байгаа хүмүүс гэж ойлгоно. Ирц бүртгэлийн санал хураалт.

Энэ татгалзсанаар гарч байгаа гишүүд танхимдаа хүрэлцэн ирнэ үү. Ажилдаа ажлаа хийцгээнэ үү. 50 гишүүн зөвшөөрч байгаа гишүүд бол танхимд сууж байгаа гишүүд. Татгалзсан гарч байгаа гишүүд бол чуулганы танхимд арай хараахан хүрэлцэн ирээгүй байна. Урьж байна. Гишүүдийн зөвлөх, туслахууд гишүүдээ явуулаарай. Энд өрөөнүүдээр нэрс гарч байгаа байх. Энэ байхгүй гишүүдийг гишүүдийн зөвлөх, туслахууд ажлаа хийнэ үү. Санал хураалтыг явуулъя.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалтыг үндэслэн гүйцээн боловсруулахаар өгсөн чиглэлийн дагуу санал хурааж дэмжсэн санал.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 13¹ дүгээр зүйлийн 13¹.2.9 дэх заалтын “, цахилгаан дугуй, цахилгаан скүүтерийг зүй зохистой ашиглах хэрэглээний соёлыг эзэмшүүлэх” гэснийг, 13¹.2.5 дахь заалтын “оршуулгын газар,” гэснийг болон 13¹.2.3, 13¹.2.4, 13¹.2.6 дахь заалтыг тус тус хасах. Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо. Дэмжсэн, дэмжээгүй байр сууриа илэрхийлж үг хэлэх гишүүд энэ дээр байхгүй юу. Дараагийнх дээр нь үү? Санал хураалтын ирц 59 гишүүн болчихсон байна. Гишүүдээ санал хураалтдаа бэлтгэе. Энхнасан гишүүн. Санал хураалт.

Санал хураалтад 97 гишүүн оролцсоноос 57 гишүүн буюу 58.8 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 59, 60, 61, 64 дэх хэсэг болон 63.2, 63.3, 63.4 дэх заалтыг хасаж, 63.5 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, дугаарыг “62” болгон өөрчлөх:

“62.Нийтийн хэрэгцээний мопед, түүний төрөлд хамаарах скүүтер, тэдгээртэй адилтгах үзүүлэлт бүхий тээврийн хэрэгслийн үйлчилгээ үзүүлэгч хуулийн этгээд нь эрх бүхий этгээдээс тогтоосон зогсоолын байршлаас бусад нийтийн эзэмшлийн зам, гудамж, талбай, нийтийн амралт, зугаалга, биеийн

тамирын зориулалттай газар, цэцэрлэгт хүрээлэн, авто зогсоол, ногоон байгууламж, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн орчны газрын ногоон зүлэг, хүүхдийн тоглоомын талбай, эдгээртэй адилтгах газарт тээврийн хэрэгслээ байршуулсан бол тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”. Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо. Дэмжье гэсэн томьёоллоор санал, Лувсанжамц гишүүн үг хэлье.

Г.Лувсанжамц: Гишүүддээ өдрийн мэнд хүргэе. Энэ скүүтер, цахилгаан дугуйны асуудал бол өнгөрсөн жилээс, уржнангаас эхлээд маш том асуудал болоод байгаа. Тэгээд энийг зохицуулах зорилгоор Батчимэг гишүүнээр ахлуулсан ажлын хэсэг энэ хуулийн төслийг жилийн өмнө өргөн барьсан. Маш олон зүйл, заалтуудыг зохицуулаад явган зорчигчдынхоо аюулгүй байдлыг хангая гэсэн байдлаар хуулийн төслийг өргөн барьсан.

Уянгахишиг гишүүнээр ахлуулсан ажлын хэсэг бол маш нямбай ажилласан гэж үзэж байна. Бидний өргөн барьсан хувилбараас илүү хатуу, чанга зохицуулалттай болгоод оруулж ирж байгааг нь бол дэмжиж байна. Хэрэгжүүлж үзээд боломж бололцоо, дахиж засах засаж сайжруулах зүйл байвал тэрнийгээ тухайн цаг үед нь засаад явахад болно гэж бодож байна.

Товчхон та бүхэндээ бас дэмжихийг хүсээд хэдэн зүйлийг тодорхойлж хэлье. 18 нас хүрсэн жолооны үнэмлэхтэй хүн, эсвэл сургалтад хамрагдсан хүн цахилгаан дугуй, скүүтер унадаг болно. Явган замаар зорчихыг хориглоно. Тэгэхлээр авто замынхаа 1 дүгээр эгнээгээр зорчдог болно гэсэн үг.

Дээрээс нь хаа хамаагүй газар скүүтер, цахилгаан дугуйгаа тавих юм бол, явган гарцаар жолоодож явах юм бол, согтуугаар жолоодвол торгохоор зохицуулалтыг тусгаж өгсөн байгаа. Энийг бол дэмжиж байна.

Тэгэхээр скүүтер болон цахилгаан дугуй унаж байгаа хэрэглэгч нар маань замын хөдөлгөөнд оролцохдоо илүү хариуцлагатай ордог болох хэрэгтэй байна. Бүрэн хориглохгүйгээр оновчтой зохицуулалтыг хийхээр тусгаж байгаа.

2 дугаарт, эцэг эх нарт бас хүсэлт байна аа. Өнгөрсөн жил ажлын хэсэг ажиллаж байхад аж ахуйн нэгжүүдтэй ярилцаад 16 нас хүрсэн иргэн E-Mongolia ашиглаад, иргэний үнэмлэх нь уншигдаад тэгээд скүүтер, цахилгаан дугуй ашиглах боломжтой болох зохицуулалтыг хийсэн. Харамсалтай нь зарим хүүхдүүд унасан хэвээрээ байна. Яагаад вэ гэхлээр эцэг эх нь өөрсдөө боломжийг нь нээж өгөөд байгаа гэсэн үг. Та бүхэн маань бүгдээрээ харж байгаа хоёр, гурвуулаа сундалчхаад замаар, явган замаар хурдтай давхиад байгаа.

Дээрээс нь нэмээд зарим аав ээж нар хүүхэдтэйгээ цуг хүүхдээ урдаа тэвэрдэг ч юм уу, ардаа суулгачхаад бас сундлаад яваад байгаа. Битгий ингэж өөрийгөө болон хүүхдийгээ эрсдэлд оруулаач ээ гэж хүсэж байна. Тэгэхлээр хэрэглэгч нар маань ч гэсэн өөрсдөө хариуцлагатай баймаар байна гэдэг зүйлийг хэлж байгаа.

Энэ хууль дээр бас нэг зүйл тусгаж байгаа. Хэрвээ 18 нас хүрээгүй хүүхэд унаж байх юм бол эцэг эхэд нь торгуулах зохицуулалт, торгууль оногдуулах

зохицуулалт бас тусаж байгаа шүү гэдгийг анхааруулж хэлье. Тэгэхлээр энэ зүйл, заалтуудыг дэмжээд, хуулийн төслийг дэмжиж өгөхийг хүсэж байна.

С.Бямбацогт: Баярлалаа маш тодорхой бас хуулийн төслийг тайлбарлалаа. Дээрээс нь хүүхдүүдэд скүүтер, суроныг түрээсэлсэн байгууллага бас арга хэмжээ авах болно. Эцэг эхээс гадна. Тийм болохоор үндсэндээ бол хүүхдүүд сурон, скүүтер унаж замын хөдөлгөөнд оролцохыг хориглож байгаа. Үүнтэй холбоотойгоор хүүхдүүдийн амь нас, эрүүл мэнд эндэх тохиолдлууд эрс буурна гэж үзэж байгаа. Ийм бас чухал хуулиудыг манай гишүүд санаачилсан. Ажлын хэсэг ажилласан.

Сая томьёоллыг уншиж танилцуулсан. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 97 гишүүн оролцсоноос 65 гишүүн буюу 67 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулж дууслаа.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Хууль зүйн байнгын хороонд шилжүүллээ.

16.17 цаг.

Энэ санал хураалт уу тээ. Дараагийн санал хураалт.

Байнгын хорооноос “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг анхны хэлэлцүүлгээр нь батлах горимын санал гаргасныг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад бэлтгэхгүй билүү? Санал хураалтдаа бэлтгэе. Өөр асуудал учраас. Гишүүд санал хураалтдаа бэлтгээрэй. Санал хураалтыг явуулъя.

Байнгын хорооноос “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг анхны хэлэлцүүлгээр нь батлах горимын санал гаргасныг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 97 гишүүн оролцсоноос 65 гишүүн буюу 67 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гаргасан горимын саналыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүд олонх дэмжсэн тул “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалтыг Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт оруулах

тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалттай хамтатган явуулахаар Хууль зүйн байнгын хороонд шилжүүллээ. Дараагийн санал хураалт.

16.19 цаг.

Байнгын хорооноос гаргасан Төсвийн хөрөнгө оруулалттай холбоотой Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёолол санал хураалт явуулна.

Зарчмын зөрүүтэй, саналыг дэмжсэн, эсрэг байр суурьтай намын бүлгийг төлөөлж аль нэг нам, эвслийн бүлэг, харьяалалд тус бүр 2 гишүүн үг хэлж болно. Зарчмын зөрүүтэй 3 санал байна. Санал хураалтад бэлтгэе гишүүд ээ. Санал хураалтад бэлдлээ гишүүд.

“Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар Төсвийн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалтыг үндэслэн хураалгасан Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал.

1.Тогтоолын төслийн нэрийн “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх талаар” гэснийг “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний талаар” гэж өргөтгөсөн байна. Төслийн 1 дэх заалтын “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар” гэснийг “Улс, орон нутгийн төсөв, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө оруулалт /цаашид “төсвийн хөрөнгө оруулалт” гэх/-аар” гэж тус тус өөрчилж, төслийн тэмдэглэх хэсгийн “Хууль тогтоомжийн тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2, 14.3 дахь хэсэг, 25 дугаар зүйлийн 25.4, 25.5 дахь хэсэг,” гэснийг тус тус хасах. Улсын Их Хурлын санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн, Төсвийн байнгын хорооны дарга Наранбаатар. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 97 гишүүн оролцсоноос 67 гишүүн буюу 69.1 хувийн саналаар дэмжигдлээ. Татгалзсаныг нь хараад уначхав уу гэж санаа зовлоо шүү дээ. Энэ чухал санал хураалт. Дэмжигдлээ.

2.Тогтоолын төслийн 1.1 дэх дэд заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1/төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж эхэлсэн боловч бүрэн дуусаагүй зогссон төсөл, арга хэмжээний ашиглалтад ороогүй шалтгаан, төсөвт үзүүлж байгаа үр дагавар, нөлөөллийг төсөл, арга хэмжээ нэг бүрээр судалж, холбогдох тайлан болон цаашид төсвийн хөрөнгө оруулалтаар үргэлжлүүлэх, эсхүл өмчлөлийн өөр хэлбэрт шилжүүлэх зэрэг асуудлаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналаа 2026 оны 09 дүгээр сарын 15-ны дотор Улсын Их Хуралд

танилцуулах;”. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн, Төсвийн байнгын хорооны дарга Наранбаатар. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт.

Санал хураалтад 97 гишүүн орсноос 65 гишүүн буюу 67 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

3.Тогтоолын төслийн 1 дэх заалтын “хэрэгжүүлж байгаа” гэсний өмнө “болон Засгийн газрын гадаад зээлийн эх үүсвэрээр” гэж нэмж, төслийн 1.2 дахь дэд заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2/Засгийн газрын гадаад зээлийн эх үүсвэрээр хэрэгжүүлж эхэлсэн боловч зээлийн хэлэлцээрийн хугацаанд бүрэн дуусах боломжгүй зогссон төсөл, арга хэмжээний талаарх мэдээллийг энэ тогтоолын 1.1-д заасан тайланд тусгах.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн, Төсвийн байнгын хорооны дарга Наранбаатар. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт.

Санал хураалтад 97 гишүүн оролцсоноос 66 гишүүн 68 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дууслаа.

“Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтад бэлтгэе. Санал хураалтдаа бэлтгэсэн үү гишүүд. Санал хураалт.

“Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа төсөл арга хэмжээний талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

97 гишүүн санал хураалтад оролцсоноос 62 гишүүн буюу 63.9 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Тогтоолын төслийг баталлаа.

Тогтоолын төслийг санаачилсан Пунсалмаа нарын гишүүддээ, мөн баталсан Их Хурлын гишүүддээ талархъя. Зөвхөн улсын төсвийн хөрөнгө оруулалт биш улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар, дээрээс нь ТӨК-удын бас их хөрөнгө оруулалт хийгдэж байгаа бүх төслүүдийг нэгдсэн байдлаар хяналтад авах илүү үр ашигтай, үр өгөөжтэй байлгах агуулга бүхий тогтоол батлагдсан.

Цэнгүүн гишүүн. Цэнгүүн гишүүнийг дэмжсэнээр бүртгэе. Мөнхтуяа гишүүнийг дэмжсэнээр авъя.

16.25 цаг.

Дараагийн асуудалдаа оръё. Дараагийн санал хураалтдаа.

Байнгын хорооны саналаар Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн

төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх санал хураалт явуулъя.

Гишүүд санал хураалтад бэлтгэе санал. Хураалтыг явуулъя.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 97 гишүүн оролцсоноос 66 гишүүн буюу 68 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 97 гишүүн оролцсоноос 65 гишүүн буюу 67 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

3.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрдлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэгдэж дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 97 гишүүн оролцсоноос 64 гишүүн буюу 66 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

4.Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт

Санал хураалтад 97 гишүүн оролцсоноос 65 гишүүн буюу 67 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

5.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

97 гишүүнээс 63 гишүүн буюу 64.9 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

6.Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

97 гишүүнээс 64 гишүүн буюу 66 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

7.Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

97 гишүүнээс 63 гишүүн буюу 64.9 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ

8.Эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

97 гишүүнээс 62 гишүүн буюу 63.9 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Энэ зочны нэрс байна уу? Зочин танилцуулъя. Нийслэлийн ерөнхий боловсролын “Эрхэт эрдэм” сургуулийн 12 дугаар ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Төрийн ордонтой танилцаж байгаа сурагч хүүхэд, багачууддаа сурлагын өндөр амжилтыг хүсье. Улсын Их Хурлын нийт гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

9 дэх нь үү. Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

97 гишүүнээс 62 гишүүн буюу 63.9 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

10.Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

97 гишүүнээс 60 гишүүн буюу 61.9 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

11.Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхэд дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

97 гишүүнээс 64 гишүүн буюу 66 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

12.Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

97 гишүүнээс 64 гишүүн буюу 66 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

13.Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

97-гоос 62 гишүүн буюу 63.9 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

14.Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

97 гишүүнээс 59 гишүүн буюу 60.8 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

15.Байгалийн ургамлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

97 гишүүнээс 59 гишүүн буюу 60.8 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

16.Гаалийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

97 гишүүнээс 61 гишүүн буюу 62.9 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

17.Гадаад иргэний эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

97 гишүүнээс 61 гишүүн буюу 62.9 хувийн саналаар шинэ санал дэмжигдлээ.

18.Гүйцэтгэх ажлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

97 гишүүнээс 62 гишүүн буюу 63.9 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

19.Гэр бүлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

97 гишүүнээс 62 буюу 63.9 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

20.Жагсаал, цуглаан журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлал баримт хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

97 гишүүнээс 58 буюу 59.8 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

21.Жолоочийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

97 гишүүнээс 62 гишүүн буюу 63.9 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

22.Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

97 гишүүнээс 60 гишүүн буюу 61.9 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

23.Зар сурталчилгааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

97 гишүүнээс 60 гишүүн буюу 61.9 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

24.Ирээдүй өв сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

97 гишүүнээс 65 буюу 67 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

25.Монгол Улсын Төрийн ордны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

97 гишүүнээс 62 буюу 63.9 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

26.Нотариатын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

97 гишүүнээс 63 буюу 64.9 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

27.Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхэд дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

97-гоос 60 гишүүн буюу 61.9 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

28.Сэжигтэн, яллагдагч баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

97-гоос 62 буюу 63.9 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

29.Тагнуулын байгууллагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

97-гоос 65 буюу 67 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

30.Усан замын тээврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

97-гоос 65 буюу 67 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

30.Усан замын тээврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай.

31 үү? Харьяатын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт.

97-гоос 63 буюу 64.9 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

32.Цагдаагийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

97-гоос 63 буюу 64.9 хувийн саналаар санал дэмжигдлээ

33.Цэргийн алба хаагчийн эд хөрөнгийн хариуцлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

97-гоос 63 буюу 64.9 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

34.Шуудангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

97-гоос 63 буюу 64.9 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

35.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

97-гоос 65 буюу 67 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

36.Тариалангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

97-гоос 63 буюу 64.9-ийн хувийн саналаар санал дэмжигдлээ.

37.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийг хүчингүй болсонд тооцогдох хуулийн төслийг үзэл баримтлалыг хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

97-гоос 65 буюу 67 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

38.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг үзэл баримт баримтлалын хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

97-гоос 65 буюу 67 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

39.Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт.

97-гоос 65 буюу 67 хувийн саналаар санал дэмжигдлээ.

40.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрдлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт.

97-гоос 65 буюу 67 хувийн саналаар санал дэмжигдлээ.

41.Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

97-гоос 64 буюу 66 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

42.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

97-гоос 63 буюу 64.9-ийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтын хүрээнд хэлэлцэхийг санал хураалтад оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүллээ.

16.41 цаг.

Дараагийн асуудалдаа оръё. Санал хураалтууд байгаа.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрдлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалын хувьд хэлэлцэхийг дэмжих эсэх асуудлаар санал хураалт явуулна.

Гишүүд санал хураалтад бэлтгэе. Санал хураалт явуулъя. Гишүүд ээ санал хураалтдаа бэлтгэе. Бас гишүүд ороогүй байна шүү. Бат-Эрдэнэ дарга хуруугаа уншуулаарай гэж байна. Санал хураалт явуулъя. Шижир гишүүн нэг газар суучих уу. Нэг газар гэж байгаа шүү бас.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрдлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 97 гишүүн оролцсоноос 67 гишүүн буюу 69.1 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрдлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг санал хураалтад оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүллээ.

16.43 цаг.

Дараагийн асуудал дахиад 1 санал хураалт байгаа.

Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх асуудлаар санал хураалт явуулна.

Гишүүд санал хураалтад бэлтгэе. Санал хураалтыг явуулъя. Гишүүд анхааралтай байгаарай.

Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

97 гишүүнээс 65 гишүүн буюу 67 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

2.Хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

97 гишүүнээс 60 гишүүн буюу 61.9 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

3.Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

97 гишүүнээс 65 буюу 67 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

4.Авлигын эсрэг хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

97 гишүүнээс 59 гишүүн буюу 60.8 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

5.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

97 гишүүнээс 58 буюу 59.8 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

6.Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхэд дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

97-гоос 60 гишүүн буюу 61.9 хувийн саналын санал дэмжигдлээ.

7.Нийгмийн даатгалын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхэд дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

97-гоос 60 буюу 61.9 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

8.Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

97-гоос 60 буюу 61.9 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Төрийн албаны хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

97-гоос 62 буюу 63.9 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Хууль тогтоомжийн хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Хууль зүйн байнгын хороонд шилжүүллээ. Дараагийн асуудалдаа оръё.

16.47 цаг.

Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг явуулна.

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Пүрэвжавын Сайнзориг танилцуулна. Таныг индэрт урьж байна.

П.Сайнзориг: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн оршил хэсэгт Монголын ард түмэн бид улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататган бэхжүүлж, хүний эрх чөлөө, шударга ёс, үндэсний эв нэгдлийг эрхэмлэн дээдэлж, төрт ёс, түүх соёлынхоо уламжлалыг нандигнан өвлөж, хүн төрөлхтний соёл, иргэншлийн ололтыг хүндэтгэж, эх орноо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлоон хөгжүүлэхийг эрхэм зорилго болгоно.

Үүний учир Монгол Улсын Үндсэн хуулийг даяараа олноор зарлан тунхаглаж байна гэж тунхаглан зарлаж, мөн хуулийн 7 дугаар зүйлийн нэг дэх хэсэгт Монголын ард түмний түүх бол төрийн хамгаалалтад байна гэж хуульчилжээ.

Үндэсний их баяр наадам нь Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, үндэсний эв нэгдэл, төрт ёс, түүх, соёл, өв уламжлал, зан заншлыг бэлгэдсэн үндэсний уламжлалт баяр бөгөөд 2003 оны 06 дугаар сарын 19-ний

өдөр баталсан Үндэсний их баяр наадмын тухай хуулиар баяр наадмыг зохион байгуулах харилцааг хуульчлан зохицуулж байна.

Үндэсний их баяр наадмын тухай хуулийг 2022 онд шинэчлэн найруулсан бөгөөд Үндэсний их баяр наадмын хүрээнд үндэсний бөхийн барилдаан, сурын харваа, үндэсний хурдан морины уралдаан шагайн харвааг зохион байгуулж байгаа бөгөөд Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 9.1 дэх хэсэгт улсын баяр наадам 10 жил тутам Их Монгол Улс байгуулагдсаны болон Ардын хувьсгалын тэг шоог давхцуулан 1024 бөх8 бусад баяр наадамд 512 бөх барилдана гэж заасан.

Энэхүү зохицуулалт нь 10 жил тутам 1024 бөхийн барилдааныг үндэсний их баяр наадмаар барилдуулж, цолны үнэлэмжийг дээшлүүлэх зорилготойтой боловч Ардын хувьсгалын тэгш ойд тохиогоогүй боловч Их Монгол Улс байгуулагдсаны тэгш ой, жилүүдэд 1024 бөх барилдах боломжгүй болгосон зохицуулалт юм.

Уг зохицуулалтыг эргэн харж Их Монгол Улс байгуулагдсаны тэгш ойг тохиолдох жилүүдэд 1024 бөх барилдах зохион байгуулах асуудлыг Монгол Улсын төрийн тэргүүн, Монголын ард түмний эв нэгдлийг илэрхийлэгч Монгол Улсын төрийн тэргүүн Ерөнхийлөгч тухай бүр шийдвэрлэдэг байх зохицуулалтыг бий болгохоор хуулийн төслийг боловсрууллаа.

Энэ нь Монгол Улсын Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн нэг дэх хэсэгт Монгол Улсын Ерөнхийлөгч бол төрийн тэргүүн, Монголын ард түмний эв нэгдлийг илэрхийлэгч мөн гучин гуравдугаар зүйлийн нэг дэх хэсгийн 7 дахь заалтын улсын цол, цэргийн дээд цол хүртээх, одон медаль шагнах гэж Ерөнхийлөгчийн бүрэн эрх, мөн зүйлийн 4 дэх хэсэгт заасан Ерөнхийлөгчид тодорхой бүрэн эрхийг энэ зүйлд заасан хүрээнд олгож болно гэсэн зохицуулалттай нийцэж байгаа болно.

Түүнчлэн Монгол Улсын тулгын чулууг Их Эзэн Богд Чингис хаанд тавьж дэлхийн түүхэнд газар нутгийн хэмжээгээрээ 2 дахь том гүрнийг бий болгож, өнөөдрийн Ази, Европын 20 гаруй улсын нутаг дэвсгэрийг хамарсан эзэнт гүрнийг эрхшээн байгуулж байсан.

Энэ түүхэн цаг үеийг бас тодотгож Их Монгол Улсын тэгш ойг энэ жил ёслол төгөлдөр өргөн тэмдэглэх агуулгаар хуулийн төслийг боловсруулсан.

Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 9.9 дэх хэсэгт бөх, цэргийн баяр наадмыг жилд 1 удаа Засгийн газрын шийдвэрээр 256 хүртэлх бөх барилдуулахаар зохион байгуулж болно. Зургаа давсан бөхөд “цэргийн харцага” цол олно гэж “цэргийн харцага” цол олгоно гэж заасан бөгөөд мөн зүйлийн 9.5 дахь хэсэгт аймгийн наадамд зургаа давсан бөхөд “аймгийн харцага” цол олгох асуудал орхигдсон байгааг нэмж оруулах шаардлагатай байна.

Түүнчлэн үндэсний бөхийн спортоор хичээллэж буй хүүхэд, залуучуудын тоо тогтмол өсөж байгаа бөгөөд аймгийн баяр наадамд 16 нас хүрсэн 128 хүртэлх бөх, аймгийн тэгш ойгоор баяр наадамд 256 хүртэлх бөх, сумын наадамд 64 хүртэлх бөх барилдахаар хуульчилсан байдаг.

Энэхүү барилдах бөхийн тоог багаар тогтоосон нь үндэсний бөхийн спортоор хичээллэж буй хүүхэд, залуучууд Үндэсний их баяр наадмаар бүртгүүлж чадахгүй үлдэх, хасагдах, бүртгэл дагасан авлигал, ашиг сонирхол, талцал, ялгаварлал гарах зэрэг шалтгаан болж байна.

Иймд энэхүү хуулийн төслийг дээрх алдааг зассан хуулийн зохицуулалтыг мөн тусгалаа.

Үндэсний их баяр наадмын тухай хуулийн шинэчилсэн найрууллыг дагаж мөрдөх журмын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг мөн боловсруулсан болно.

Хуулийн төслийн үзэл баримтлал хуулийн төслийг хэлэлцэхийг дэмжиж өгөхийг та бүхнээсээ хүсье. Анхаарал тавьсан явдалд баярлалаа.

С.Бямбацогт: Сайнзориг гишүүнд баярлалаа. Төслүүдийн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Сархадын Зулпхар танилцуулна. Таныг индэрт урьж байна.

С.Зулпхар: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн Сайнзориг нарын 19 гишүүнээс 2026 оны 05 дугаар сарын 28-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.8 дахь хэсэгт заасны дагуу Төрийн байгуулалтын байнгын хороо 2026 оны 006 дугаар сарын 2-ны өдрийн хуралдаанаараа явууллаа.

Хууль санаачлагч 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдөр баталсан Үндэсний их баяр наадмын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 1 дүгээр зүйлд Ардын хувьсгалын 100, 101 жилийн ойг тохиолдуулан үндэсний бөхийн цолын маргаантай асуудлыг Монголын үндэсний бөхийн холбооны саналыг үндэслэн нэг зарчим, нэгдсэн журмаар холбогдох хууль тогтоомжийн дагуу эрх бүхий этгээд шийдвэрлэж болно гэж заасан боловч тус зохицуулалт нь ерөнхий, хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байгаа, үндэсний бөхөөр барилдаж байсан зарим тамирчин, тэдгээрийн гэр бүлийн гишүүдээс удаа дараа өргөдөл, хүсэлт гаргаж байгаа тул зарим маргаантай асуудлыг шийдвэрлэж зохицуулах шаардлагатай гэж үзэн хуулийн төслийг боловсруулсан болно.

Хуулийн төсөлд иргэдийн оролцоог хангах, санал авах зорилгоор Улсын Их Хурлын d.parliament.mn цахим системд байршуулсан болно.

Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Ц.Туваан “аймгийн харцага” цолны талаар болон цол өгөх нөхөн олгох зохицуулалтын тухай, Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа аль ойн баярыг тэгш хэмээн онцлон барилдах бүхийг тоог нэмэгдүүлж байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Ч.Лодойсамбуу цол нөхөн олгох нь нийгэмд талцал үүсгэх, бөхийн эрэмбэд

өөрчлөлт орон маргаан дагуулах эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хуулиар олгосон Ерөнхийлөгчийн бүрэн эрхтэй нийцэж байгаа эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Л.Гантөмөр тэгш ойгоор бөхийн тоог нэмэх бус, шагнал урамшууллыг нэмэгдүүлэх, допингийн хяналтыг сайжруулж, байнгын шинжилгээ хийх, хариуцлагыг чангаруулахтай холбогдох асуудлаар асуулт асууж, хариулт авлаа.

Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулахад Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг нарын 19 гишүүнээс өргөн мэдүүлсэн Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Үндэсний их баяр наадмын тухай хууль шинэчилсэн найруулгыг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

С.Бямбацогт: Зулпхар гишүүнд баярлалаа.

Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлт, хууль санаачлагчийн илтгэл болон хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулж урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна.

Лутаагийн энхрийнасан гишүүн асуултаа асууя.

Л.Энхнасан: Энэ Үндэсний их баяр наадмын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийг бол дэмжиж байгаа. Ялангуяа энэ ахмад бөхчүүдийн цолыг нөхөн олгох зохицуулалтыг бол дэмжиж байна. 2023 оны энэ хууль хэрэгжиж эхлэхээс өмнө үеийн энэ амжилт гаргасан, тэгээд өнөөдөр амьд сэрүүн байгаа энэ ахмад бөхчүүдийн амжилтыг бол үнэлээд ингээд хүртэх ёстой байсан цолыг нь нөхөж олох нь зүйтэй гэж бодож байна.

Ер нь бол тамирчны энэ оргил амжилт бол хэдхэн ийм агшинд байдаг. Түүнд харин хүрэх зам нь бол олон жилийн энэ хичээл зүтгэлээр бол бас хэмжигддэг. Тийм учраас энэ тамирчдын амжилт, амжилтын цаг тухайд нь үнэлж энэ цолыг нь хүртэх нь зүйтэй гэж бодож байна. Энэ 17 хүн цол хүртэхээр хүсэлтээ ирүүлсэн гэж байгаа. Тэгээд тэнд бас Монгол Улсын гарди Пунцагийн Сүхбат агсанд бас “Улсын арслан” цолыг нь нөхж олгох энэ асуудлыг нь дэмжиж байгаа. Амьд ахуй цагтаа бол энэ цолыг бол бас хүртэх гавьяа, энэ амжилтыг үзүүлсэн.

Мөн тухайн үед энэ асуудалтай адилхан эрх нь зөрчигдсөн энэ бөхчүүдийн бас асуудлыг бодит үндэслэлтэй нь харж байгаад, шалтгааныг нь харж байгаад энэ цолыг нь өгөөсэй гэж хүсэж байна. Тухайлбал, Эрхэмбаяр начин, мөн Монгол

Улсын гарди Бат-Өлзий нарын энэ холбогдох асуудлыг нь бас шийдвэрлээд өгөөсэй гэж хүсэж байна.

Харин энэ ганц нэг анхаарах юм нь болохлоороо орон даяар нэгэн зэрэг аймаг, сумын наадам ингээд зэрэг болохлоор аймагт 256, сумд 128 бөх яагаад ч юм барилдах ийм тоо хүрэхгүй шүү. Яагаад бол нэгийн даваад унасан хүүхдүүдийг ингээд дахиж гаргаад л сум дээр бол тэгдэг шүү дээ. Тэгээд энэ тоо нь хүрэхгүй учраас аймаг, сумын наадмыг улсын наадамтай давхардуулахгүй энэ цагийг нь, хуваарийг нь бас авч үзээсэй гэж хүсэж байна. Ийм санал байгаа юм.

С.Бямбацогт: Сайнзориг гишүүн хууль санаачлагч хариулъя.

П.Сайнзориг: Энхнасан гишүүндээ бас баярлалаа. Хуулийн төслийг дэмжиж байгаа юм байна. Таны бас энэ анхааруулж хэлж байгаа зүйлийг бас ойлгож байна. Энэ хууль маань нөгөө яг харах юм бол нөгөө хүртэлх гэж байгаа. Тэгэхээр сумын наадамд 64-өөрөө ч барилдаж болно. Аймаг дээр 128 бөхийг ч барилдуулж болно. Хүн ам ...-той ер нь бас зарим аймгуудад бол бөхчүүд нь багталцахгүй ийм зүйлүүд бол байдаг юм байна лээ.

Тэгээд бас энэ үндэсний өв соёл болсон үндэсний бөхөөр олон залуучууд хичээллэж бас үндэсний энэ баяр наадамдаа зодоглож бүгд тэр түрүүлэе гэдэг гэхээсээ илүү тэр оролцоотой байя, энэ өв соёлоороо сайхан бахархаж бас хичээллэдэг байя л гэдэг байдлаар залуучууд бас ханддаг юм байна лээ. Тэгээд эндээс мэдээж эр бяраа нь тэгширсэн ийм л залуучууд бас цөөн залуучууд нь цолоо өртөөд явдаг. Тэгээд энийг бол бас цаашдаа анхааръя. Ер нь зүгээр боломжийг нь нээж өгч байгаа. Тэгээд бас хүн ам болоод тухайн жилийнхээ онцлогоос шалтгаалаад энэ аймаг, сумууд нь өөрсдөө шийдээд явах энэ бололцоог нь өгч байгаа юм. Танд баярлалаа.

С.Бямбацогт: Батын Батбаатар гишүүн асуултаа асууя. Алга байна. Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн асуултаа асууя.

С.Эрдэнэбат: Хуулийн төслийг бол дэмжиж байгаа. Ялангуяа бөхчүүдийн чансаа бас нэлээн нэмэгдсэн, бөхийн спортоор хичээллэж байгаа залуучууд маш олон болсон. Харахад амжилт гаргаж байгаа бөхчүүд нь бас харьцангуй ажил, амьдрал дажгүй ингээд явчихдаг харагддаг боловчиг маш олон залуучууд бүтэн жилийн хөдөлмөрийн асуудал байж байгаа. Амжилт гаргахгүй ч гэсэн бөхийн спорт гэдэг тэдний гэр бүл, найз нөхөд, дэмжигч нар нь л их илүү их ойлгодог. Тэр утгаараа энэ тэгш их 2 ой байгаа. Их Монгол Улс байгуулагдсаны болон Ардын хувьсгал ялсны давхцах дандаа зөрдөг учраас 10 жилдээ үндсэндээ бараг 2 удаа 1024-ийг барилдуулъя гэдэг үндсэн санаа явж байгаа гэж бол ойлгож байгаа.

Тэгэхээр хуулийн юун дээр бол болон гэдэг нэг үг байгаа тийм үү? Тэгэхээр энийг давхцахгүй байдлаар гэхээр 10 жилд 2 удаа гэсэн 1024-ийг барилдуулж болохоор бол эрх зүйг нь нээж өгч байна гэж ойлгож байгаа гэдгийг бол тодруулж асууя. Мөн дээрээс нь сум бол нэг үеэ бодох юм бол суманд ялангуяа ойтой суманд, тухайлбал энэ жил манай Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сум гэхэд 100 жилийн ойтой. Өөр сумдууд бараг байхгүй. Маш олон бөхчүүдийн барилдахаа илэрхийлсэн. Тэгэхээр маш олон цолтой бөхчүүд хүрээд ирэхээр хөөрхий нөгөө сумынх нь байдаг нөгөө сумын цолтой бөхчүүд нь бараг багтах уу үгүй юу болчих

гээд байгаа асуудал байгаа. Тэгэхээр хүртэлх гэж байгаа учраас сумыг аймагтай нь ижил тэгш ойтой үедээ тэр 120 наймаа барилдуулах ийм боломж бололцоо нь бол нээгдэж байгаа гэж хэлж болж байгаа.

Нийтдээ 21 оны наадамтай холбоотой хүмүүс бас ингээд нэлээн маш их саналууд ирж байгаа. Миний хувьд бол хуулийн төслийг харж байхад бол энэ боломж нь бол нээлттэй байгаа гэж ойлгож байгаа. Тэгэхээр нөгөө эрх бүхий байгууллага гэдэг нь яг хэн бэ гэдэг дээрээ маргаан дэгдээд байгаа гэж ойлгож байгаа. Тэгэхээр энэ тал дээрээ Бөхийн холбоо ер нь хууль санаачлагчтай холбоотойгоор манай Сайнзориг гишүүн уулзсан уу? Бөхийн холбоо өөрөө яг юу гэж үздэг юм бэ? 21 онд хэдийгээр нөгөө КОВИД-ын үзэгчгүй гэдэг байдлаар зохион байгуулсан боловчиг бөхчүүдийн оролцоо бүгд л цол авна гэдэг байдлаар ойлгож ийм болзолтойгоор бол барилдсан гэж бол өөрсдөө ярьцгаадаг.

Тийм учраас бол энэ 21 оны бөхийн барилдаан 512 бөхийн барилдаанд нь бол тэр цолыг нь бол нөхөөд олох нь бол миний хувьд бол зүйтэй байх гэдэг бүхэл бүтэн бүтэн жилийн бөхийн хөдөлмөрийн асуудал учраас, Монгол наадмын энэ залгамж, түүхэн залгамж үе бол тасрах ёсгүй гэдэг ийм бол байр суурьтай байгаа. Тэгэхээр бас магадгүй бөх сонирхдогийн хувьд миний хувьд олон бөхчүүдээс бас ингээд асуухад бол ямар ч байсан бүгдээрээ л бол цол олгоно гэж бодоод бид нар бол бүгдээрээ очсон. Бусад наадмуудтай ижилхэн бүх л арслан, заан, аваргууд бол бүгд оролцсон. Начин юунууд оролцсон.

Тийм учраас энэ тал дээр яг тийм эсэргүүцээд байгаа гэдэг юм уу тийм байгууллага ч гэдэг юм уу хүмүүс байгаа юм уу, үгүй юм уу, тэр тал дээр тодорхой мэдээлэл танд ирсэн үү гэдгийг тодруулж асуумаар байна.

С.Бямбацогт: Сайнзориг гишүүн хууль санаачлагчид хариулъя.

П.Сайнзориг: Эрдэнэбат гишүүнд бас баярлалаа. Тэгээд ер нь 10 жил тутамд л 1024 бөх барилдуулах энэ нь өөрөө эргээд цолны үнэлэмжийг хадгалах гэдэг агуулгаар 22 онд бас энэ хуулийн зохицуулалт батлагдаж байсан юм. Тэгээд наадам гэдэг бол Монголын, Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, үндэсний эв нэгдэл, төрт ёс, түүх соёл, өв уламжлал заншил, ер нь бол бидний тэр бусдаас ялгарах ондоошил юм байгаа юм. Тэгээд энийгээ бас ямар нэгэн байдлаар, хэрүүл уруулгүй, гомдол талцалгүй асуудлууд үүссэн бол тухайн үедээ шийдээд л явах ёстой байсан. Тэгэхээр энэ хүрээндээ л энэ хуулиудыг бас оруулж ирж байгаа юм.

Мэдээж энэ жилийн Их Монгол Улс байгуулагдсаны түүхтэйгаараа бас өргөн дэлгэр наадъя, 1024 барилдуулах энийг төрийн тэргүүн бас тухай бүр зарим ийм онцлог жилүүд д бас зарлиг буулгаж бас барилдуулж болох энэ зохицуулалтыг оруулж өгч байгаа. Сумын наадмын хувьд бол 64 хүртэлх гэж байгаа, хүртэл. Тэгэхээр 128 болгоод өгөхөөр 64-өөрөө барилдуулж болно, эсвэл яг таны хэлж байгаа шиг 128-аараа барилдуулах энэ бололцоог нь энэ хуулиар бас нээж өгч байгаа юм.

Нэгэн зэрэг наадмууд зохион байгуулахад хүн, барилдах хүн олдох уу үгүй юу гэж байгаа юм. Тэгэхээр ер нь зарим залуучууд бол нэлээн мэргэжлийн мэргэжлийн гэдэг юм уу байнгын бэлтгэл сургуулилттай боловч сумын наадамд

бол тэгээд л бүгд л зодог, шуудгаа өмсөөд л сайхан гардаг, оролцдог. Тэгээд л бас тэр наадмын чимэг болоод явдаг ийм л зүйл байдаг. Энэ бол Монгол Улс яг нийтээрээ хөдөө орон нутгаараа тэмдэглээд явахад их л сайхан оролцоотой байдаг шүү дээ. Тэр бүгдээрээ бол энэ бас тоог нь бас хэт их хязгаарлаад доор тавьж өгөөд байгаа нь буруу юм. Тэгээд бүртгэлээсээ эхлээд наадмын уур амьсгалаа эвдэж болохгүй, багталцахгүй хасчихдаг. Ингээд ялгаварлан гадуурхах гараад эхэлдэг. Тэгээд нутаг усны талцлууд ч гэдэг юм уу ийм бие биедээ хатуу хөтүү үг чулуудсан зүйлүүд ингээд эхлэхээсээ наадам эхлэхээсээ эхлээд явчхаад байгаа. Энийг л засаж залруулъя гэдэг байдлаар орж байгаа гэдэг зүйлийг хэлье.

21 оны хувьд бол Монголын үндэсний бахийн холбоотой би ярилцсан, саналыг нь авсан, дэмжсэн. Хууль тогтоомжийн хуулийн дагуу угаасаа эрх ашиг нь хөндөгдөж байгаа этгээдүүд, түүнийг төлөөлж байгаа мэргэжлийн холбооноос нь л санал авах авах энэ зохицуулалтын хүрээнд авсан.

22 оны 07 сарын 01-ний өдөр энэ Үндэсний их баяр наадмын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг дагаж мөрдөх журмын хуулийг л Бөхийн холбоо хэрэгжүүлэх гээд үзээд байгаа юм. Энэ зүйл, хуулийн 1 дүгээр зүйл дээр Ардын хувьсгалын 100, 101 жилийн ойг тохиолдуулан үндэсний бөхийн цолын маргаантай асуудлыг Монголын үндэсний бахийн холбооны саналыг үндэслэн нэг зарчим, нэгдсэн журмаар холбогдох хууль тогтоомжийн дагуу эрх бүхий этгээд шийдвэрлэж болно гээд заачихсан. Энийг бөхчүүд нь Бөхийн холбоог хэрэгжүүлээч ээ л гэж шаардаад байгаа юм.

Бөхийн холбоо бол саналаа хэнд гаргахаа мэдэхгүй байгаа юм. Эрх бүхий этгээдэд гэхихээр аль институт юм бэ гэдэг байдлаар ингээд хууль өөрөө ингээд тодорхойгүй гарчхаад байна гэдэг зүйлийг л хэлээд байгаа байхгүй юу. Энэ парламент ч гэж үү бид нар бас энэ асуудлыг.../минут дуусав./

С.Бямбацогт: Өлзийхүүгийн Шижир гишүүн асуултаа асууя. Алга байна. Цэвэгдоржийн Туваан гишүүн асуултаа асууя.

Ц.Туваан: Энэ хуулийг дэмжиж байгаа. Тэгээд доторх заалтууд, өөрчилж байгаа заалтууд нь бас цөөхөн хэд боловчиг бас маш чухал ийм заалтууд байгаа. Ялангуяа тэр сумын наадам, аймгийн наадамтай холбоотой барилдах бөхийн тоо, дээрээс нь энэ тэгш ойн жил 1024 бөх барилдуулах зохицуулалтыг бас Монгол Улсын Ерөнхийлөгчид эрхийг нь, боломжийг нь гаргаж өгөх. Мөн энэ бид нар бүгдээрээ л мэддэг шүү дээ Монгол бол бөхчүүдийн, бөхийн орон. Тэгээд 100 жилийнхээ ойн наадмаар барилдсан бөхчүүдийн цолыг ингээд л бүгд л нэхэж байдаг. Энэ хүмүүс цолыг нь өгчихвөл яадаг юм бэ гээд ингээд ярьж байдаг учраас энэ хуулийг бол дэмжиж байгаа.

Мэдээж бөхчүүдийн хөдөлмөр бол залуу насны маш хүнд, маш богино хугацааны гэр бүл, хамт олны ийм хүнд хөдөлмөр байдаг. Тэгэхээр энэ хөдөлмөрөө яг тэр оргил цаг үедээ үнэлүүлнэ гэдэг асуудал бол бас маш чухал асуудал. Тэгэхээр энэ асуудлыг орхигдуулж болохгүй.

Бид бүхэн бол энэ шударга зарчмыг бас ингээд баримталж байх ёстой. Тэгээд би бас энд энд нэг зүйлийг хэлье гэж бодож байгаа. Тэр нь юу гэхээр Төв аймгийн Мөнгөнморьт сум гэж байна. Мөнгөнморьтын Төмөр хөлт гэж нэртэй

улсын начин Нагнайдорж гэж хүн байлаа. Сайхан бөх байлаа. Мөн Мөнгөнморьтын нэрээрээ нэршсэн Лувсанмөрийн Чимэд гэж “Монгол улсын арслан” цолтой хүн байна. Энэ хүн 1934 онд 9 давж, 1935 онд 10 даван түрүүлж, 1936 онд 9 давж байсан ийм амжилтыг үзүүлсэн бөх байгаа юм. Тэгээд энэ хүн арслан цолтой үлдчихсэн.

Тэгэхээр би шударга байх ёстой гэдэг нь юу хэлж байна гэхлээр энэ хүн яг одоогийн цол олгодог байдлаараа бол 34 онд 9 давж “Арслан” цолоо аваад, 35 онд 9 давж “Аварга” авчхаад дахин түрүүлсэн дээрээ “Даян” цол аваад дээрээс нь 35 онд дахин 9 давсан дээрээ ингээд “Даян” юм уу “Дархан аварга” цол авах ийм болзол хангачихсан хүн байхгүй юу. Тэгэхээр энэ хүний талаар хууль санаачлагчид мэдээлэл байгаа юу? Энэ тал дээр бас та юу гэж бодож байна гэдэг ийм асуулт байгаа юм.

Тэгээд энэ 21 оны наадам дээр чинь тэгээд л бөхчүүдээс авсан ярилцлага энэ тэр дээр байна лээ. Дэмжиж л байна лээ бүгдээрээ. Хуваагдана, талцана гээд байгаа манай бөхчүүд чинь бас уужуу сэтгэлтэй, дэмжинэ, нэгнийгээ амжилтад бас баярлана, шударга. Тэгээд энэ дээр Бат-Өлзий заан байна. Ууганбаяр гээд хүчит харцага байна. Энэ жилийнхээ наадмын дараагаар бас харамсалтай хүнд бэртэл аваад ингээд л тэрнээс хойш бас өндөр амжилтыг үзүүлэх боломжгүй болоод явчихсан. Тэгэхээр энэ үедээ бас цолыг нь өгчихсөн бол гэж ингэж бас ярьдаг юм. Тэгэхээр энэ дээр бас таны хууль санаачлагчийн байр суурийг сонсьё.

Дээрээс нь энэ нэгэнтээ Үндэсний баяр наадмын тухай хууль ярьж байгаа учраас бас хөндөгдөөгүй ч гэсэн энд энэ эрийн 3 наадам сүүлийн үед бол бас шагайг оролцуулж улсын цолыг нь Ерөнхийлөгчийн зарлигаар олгодог болсон. Тэгээд энэ дээр “Дархан” гэдэг энэ цолыг авчихсан нөгөө 3 төрөл нь байгаа “Дархан мэргэн”, “Дархан аварга” гээд сур, шагай ялгаагүй. Тэгтэл манай мориныхон дээр бас энэ “Дархан” гэдэг цол байхгүй байна гэдэг асуудлыг нэлээн хөндөж тавьсан. Энэ ч зүй ёсны хэрэг байх. “Дархан тод манлай” гэдэг ийм цолтой байх гэдэг ийм асуудлууд байгаа. Тэгэхээр энэ дээр бас та нэг цаг гарвал байр сууриа илэрхийлээч.

Дээрээс нь уг нь бол энэ мөрдөгдөж байгаа хууль дотор цаг хугацааны заалт оруулаад ингээд цаг хугацааны хувьд бол хэрэгжээгүй даваад явчихсан зүйлүүдийг нь уг нь нэгмөсөн бас засаад явчихсан бол ямар байх бол байсан юм бол гэдэг ийм асуултуудыг асууя.

С.Бямбацогт: Сайнзориг гишүүн хариулъя.

П.Сайнзориг: Бид хэд энэ үндэсний их баяр наадмын асуудлуудыг ер нь юу гэдэг юм цагийн үед их сайхан тэмдэглэж ирсэн. Даншиг наадмууд, 10 хошуу наадам гээд. Сүүлд энийг нэгтгээд Ардын хувьсгалын ойн жилүүдэд Ардын хувьсгалын ой ингээд Монгол улсын ер нь тусгаар тогтнол үндэсний эв нэгдлийн бэлгэдэл болгоод ингээд зуны дэлгэр цагт ингээд тэмдэглээд явдаг ийм сайхан уламжлалтай болсон. Тулгар төрийн ойгоо, Их Монгол Улсын ойгоо, ингээд Үндэсний эрх чөлөө тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны ойгоо, Ардын хувьсгалын ойгоо, Ардчилсан хувьсгалын ойгоо ингээд хамаатуулж энэ баяр нэгдлээ бас цэнгэж, баясаж байгаа ийм ард түмэн байгаа.

Ер нь зүгээр энэ Ардын хувьсгалын 105 жилийн ойн түүхэнд бол маш олон хүмүүс зарим талаараа бас эрх нь зөрчигдсөн юм байна лээ. Ялгаварлан гадуурхахад өртсөн юм билээ. Үзэл суртлын тэр хайчин дунд орсон юм билээ. Энэний нэгийг нь манай Туваан гишүүн 2 хүнийг нь бас дурдлаа л даа. Ер нь бол өгчих ёстой зүйлүүдийг нь өгөөгүй маш олон ийм кэйс, гомдлууд байдаг. Яг нарийн энэ 105 жилийн түүхийг явахаар ингээд 90-ээд хүний асуудал байдаг. Энэний 90-ээд хүний 2 асуудлыг энэ та дурдлаа. Төв аймгийн Мөнгөнморьт сумын хүчит ийм бөхчүүд байдаг.

Зарим тохиолдлууд бүүр ингээд “Арслан” цолыг нь ч өгөөгүй аймаг руугаа буцаж очоод ард түмэн нь бас тухайн үеийн манай төрийн тэргүүн хөдөө орон нутагт ажиллаж байх хугацаанд хүртэл хандаж хурал, зөвлөгөөн дээр нь бас нэлээн асуудлыг тавьж байсан тохиолдол ч байдаг юм байна лээ. Баянхонгор аймагт болсон кэйс л дээ. Тэгээд Цэдэнбал дарга тухайн үедээ энэ “Арслан” цолыг нь би өгье. Дараа жилийн наадам дээр хүрэлцэж ирээрэй гээд би одоо энэ цаг үе дээр нөгөө Баянхонгор аймгийнхаа арслангийн нэрийг нь мартагдчихаад байна уучлаарай. Тэгээд тэр бөх маань наадамдаа хүрэлцэж ирээд 2 билүү 3-ын даваан дээр барилдаад унасан. Тэгээд Цэдэнбал дарга өмнөх жилийнх нь тэр амжилтыг нь үнэлээд цолыг нь зүүж өгөөд ингээд нутаг буцааж байсан тохиолдлууд ч байдаг. Тэгээд маш олон ийм зүгээр кэйсүүд бас байгаад байгаа юм. Энэ асуудал маань 2003 онд хуульчлагдчихсан. Тэгээд өмнөх асуудал шийдэх гарцгүй ингээд мухардалд орчихоод ингээд л байж байгаа.

Миний хувьд бол амьд сэрүүн байгаа Үндсэн хууль болон Үндсэн хуульд заасны дагуу өргөдөл, гомдол яваад байгаа хүмүүсүүдийнхээ асуудлыг л шийдчихье гэдэг байдлаар орсон юм байгаа юм. Энэ үндэсний бөхийн талбар дээр хүний эрхийн зөрчил, ялгаварлал ерөөсөө байж болохгүй. Нутаг усны талцлаасаа болоод эсвэл спорт хороонд харьяалагдаж байсан, жоохон хувийн зөрчлөөсөө болоод хүртэл ийм зүйлүүд болчихсон, цолуудын үнэмлэх, батламжийг нь өгчхөөд буцаагаад авчихсан ийм л зүйлүүд байдаг. Тэгэхээр ийм зүйлүүд байх юм.

21 оны наадмын асуудлыг би түрүүн бас хариултдаа хэлсэн. Өмнөх парламент дээр дагаж мөрдөх журмын хуулиар тооцно гэдэг зүйлийг энийг шийдээч ээ гэдэг зүйлийг ингээд чиглэл болгочхоод байдаг. Хэрэгжүүлэх процесс болон субъект дээрээ ингээд тодорхойгүй ерөнхий болчхоод байгаа учраас бас гацчихаад байгаа юм.

Морины асуудал дээр бол би бас.../минут дуусав./

С.Бямбацогт: Туваан гишүүн тодруулж асууя.

Ц.Туваан: Ойлголоо. Тэгэхээр улс Монгол Улс бол парламентын засаглалтай орон. Улсын Их Хурал бол эрх барих дээд байгууллага хууль батлах тийм ээ. тэгэхээр нэгэнт энэ хууль орж ирж байгаа. Дээрээс нь энэ жил Их Монгол Улс байгуулагдсаны 820 жилийн ой маш том ой. Тэгэхээр хэдүүлээ энэний өмнө энэ асуудлаа нэг улс төржилгүй ярьж байгаад цэгцэлчихвэл яасан юм бэ гэдэг ийм бодол байгаа. Тэгэхээр амьд сэрүүн гээд явчихаар нөгөө манай баавгай Сүхбат гарди, гардийн маань асуудал ингээд бас яах вэ өргөдөл? Тэгээд энэ түрүүний миний хэлсэн Мөнгөнморьтын Чимэд арслангийн асуудал гээд энэ асуудлаа ер нь нэг ингээд хэдүүлээ ярьж байгаад нэг мөсөн шийдчихвэл яасан юм бэ? Бид нар

өмнө нь тэгш ой, том ойн тэгш ойн жилүүд дээр бид нар бас Өршөөлийн хууль хүртэл гаргаад ингээд асуудлуудыг яриад, шийдээд явдаг шиг энэ Их Монголын 820 жилийн ойтойгоо холбоотой асуудал дээрээ энэ хүмүүсийн асуудлыг бүрэн эцэслээд дуусгачихвал яасан юм бэ гэдэг санал.

С.Бямбацогт: Санал хэллээ. Нэг асуулт дотор нь байгаа гэж байна шүү хариуларай.

П.Сайнзориг: Туваан гишүүндээ бас баярлалаа. Тэгээд энэ бол дөнгөж хэлэлцэх эсэхээ л шийдэж байгаа. Хэлэлцэх эсэхээ шийдвэл Төрийн байгуулалтын байнгын хорооны бүрэн эрхийн асуудал болно. Би бол бас боломжит хувилбараар энэ асуудлыг шийдье л гэсэн П.Сүхбат Гарди агсны хувьд бол өөрөө амьд сэрүүндээ бас энэ асуудлаа хандаж өргөдөл, гомдлоо, хүсэлтээ өгч байсан. Бурхан болсных нь дараа ч гэсэн ар гэр нь Пунцагийн Сүхбат агсанд цолыг нь олгуулаач гээд Захиргааны шүүхэд хүртэл ингээд хандаад явж байгаа ийм шүүхийн процесстой байхгүй юу. Энэ хүрээндээ би бас бусад бөхчүүд маань барьцахгүй байх гэж бас найдаж байгаа.

Яагаад гэхээр өөрийн бие амьд сэрүүндээ биечлээд бас энэ асуудлаараа Бөхийн холбоонд хандаж байсан учраас энэ өргөдөл, гомдлын хэрэндээ бас асуудлыг шийдэж болох юм л гэж үзэж байгаа. Тэгээд энэ бол зөвхөн хэлэлцэх эсэхээ шийдэх гэж байгаа шүү. Тэгээд Төрийн байгуулалтын байнгын хороон дээрээ гишүүдийн бүрэн эрхийн асуудал байгаа юм.

С.Бямбацогт: Жуковын Алдаржавхлан гишүүн асуултаа асууя. Алга байна. Равжихын Эрдэнэбүрэн гишүүн асуултаа асууя.

Р.Эрдэнэбүрэн: Баярлалаа. Ер нь энэ үндэсний их баяр наадам бол нийт Монгол үндэстний энэ гал голомтдоо ирээд баярладаг тийм хэмжээний баяр наадам болох байх. Их Эзэн Чингис хааны анхны Их Монгол Улс байгуулагдсаны ойгоо тэмдэглэдэг ийм л том баяр болох ёстой л гэж ингэж боддог юм. Сүүлийн үед бол ялангуяа би энэ Ерөнхийлөгч Гадаад харилцааны яаманд бол бас баярлаж талархсанаа илэрхийлмээр байна. Баяр хүргэмээр байна. Дандаа энэ том улсуудын хаадууд ирдэг болсон манай энэ Үндэсний баяр наадамд оролцохоор, үзэхээр.

Тэгэхлээр бид нар энэ концепцын хувьд ийм өргөн дэлгэр дэлхийн хэмжээний Монголчууд Монгол туургатны хэмжээний баяраа тэмдэглэдэг энэ чиглэл чиглэл рүү л энэ хуулийн концепцыг уул нь явуулмаар байгаа юм. Мэдээж тэр бөхийн тоо, цол гээд ингээд яахлаар жоохон жижгэрээд байгаа юм шиг л санагддаг юм. Тэгээд ийм хэмжээний дэлхийн Монгол туургатны наадам болохын тулд цаашдаа анхаарч явах ёстой юм байна л гэж ингэж миний хувьд бодож байгаа юм.

Юу вэ гэхлээр 1 дүгээрт бол жоохон улс төржсөн юмнууд байдаг. Энийг бол арилгах хэрэгтэй. Дээр нь дандаа наадмын дараа яг булхай боллоо, тийм ч юм боллоо гээд заримдаа бүүр шүүхддэг ийм юм руу явж байгаа. Тэгээд энэ зүйлээсээ гарах ёстой гэж бодоод 2, 3 асуулт, санал асуух гэсэн юм. Ер нь хууль санаачлагчийн хувьд энэний асуудлыг ямар бодож байгаа юм?

1 дүгээрт бол би энэ бүх шатын Засаг дарга энэ наадмын нээлт, хаалтыг хийж байгаа эрх мэдэлтэй хүмүүс бол зөвхөн Их Монгол Улс байгуулагдсаны ойг л дурддаг болъё гэдэг санал хэлмээр байна. Тэгэхгүй бол ингээд маргаан үүсдэг. Зарим үед Ардчилсан хувьсгалын ой гээд л хэлдэг. Зарим үед Ардчилсан хувьсгалын ой нь байхгүй болчихдог. Тийм учраас алийг нь ч яахгүйгээр ингээд зөвхөн Их Монгол Улсын байгуулагдсаны ойг л хэлдэг болъё гэдэг зүйлийг хэлмээр байгаа юм.

Хоёрт бол бүх шатны сум, аймгийн энэ наадам, улсын наадмууд дээр намуудын гэр барьдгаа больё. Сонгууль болж байгаа юм уу, наадам болж байгаа нь мэдэгдэхгүй нөгөө ирж байгаа гадна, дотноос ирэх улсууд чинь бас энэ юм чинь ойлгох юм уу ойлгохгүй юм уу?

Гуравт бол Зарим Их Хурлын гишүүд жаахан дургүйцэж магадгүй. Бүх шатны Засаг дарга, Их Хурлын гишүүд бол өөрийнхөө нэр дээр морь уралдуулахыг хориглоё. Монгол төрийн наадам учраас төр энэ наадмыг зохион байгуулдаг. Тэгээд зохион байгуулагч нар нь өөрснүүдээ уралдаад байхлаар янз бүрийн ийм луйвар, булхай яригдахаас өөр аргагүй болно.

Тийм учраас энэнээсээ бол гарах хэрэгтэй гэж ингэж бодож байгаа. Тэгээд ийм хэдэн саналуудыг хууль санаачлагчийн хувьд юу гэж бодож байна? Боломжтой гэж үзэж байна уу? Үзэхгүй байна уу? Хэрэвзээ ийм саналууд дээр санал нэгдэхээр бол дэмжмээр байна.

Дөрөвд бол одоо ингээд наадмын үеэр бүр амралтын өдрийг ч уртасгая гэдэг саналууд яригдаж байгаа. Ер нь тэгээд 6, 7, 8 сар сумдууд ч ойгоо хийдэг, аймгууд ч ойгоо хийдэг. Ажил хийх хүн байхгүй болдог юм. Тэгээд эхний цаснаар бол шугам сүлжээгээ янзлаад сууцгааж байдаг ийм л улс болсон. Ийм байдалтай байгаа.

Тийм учраас энэ зуны 3 сард гаднын ажиллах хүчний, ажиллах ажлын гадаад ажилчдаас авдаг татварыг тэглэх хэрэгтэй. Тэгээд өөрснөө наадамаа хийгээд амраад явцгааж байя. Тэр тэр үедээ энэ ажил чинь бүтээн байгуулалтын ажлууд чинь явж байх хэрэгтэй. Ийм боломж байх уу ийм юуг нэмээд ороод оруулаад ирэх тийм боломж байна уу үгүй юу гэдэг ийм 4 асуулт, санал хэлэх гэсэн юм.

С.Бямбацогт: Пүрэвжавын Сайнзориг гишүүн, хууль санаачлагч хариулъя.

П.Сайнзориг: Эрдэнэбүрэн гишүүний асуултад хариулъя. Ер нь асуултын сүүлээс нь хариулъя. Би энэ хуулийн өргөн барьсан хуулийн хүрээнд ажиллах хүчний асуудал ч юм уу зохицуулах боломжгүй байгаа. Өнөөдөр бас харин Засгийн газраас Бизнесийн эрх чөлөөний хууль боловсруулж байгаа. Энэ хүрээндээ бас энэ ажиллах хүчтэй холбоотой асуудлыг хөндөж байгаа гэж би хэвлэлийн мэдээлэл авсан. Тэгээд энэ дээр ярья. Би бас тантай ч гэсэн энэ бүтээн байгуулалтын хугацааг зөв ашиглая гэдэгтэй бол би үргэлж санал нэг байдаг. Энэ улирлын чанартай бүтээн байгуулалтуудыг бид нар цаг хугацаанд нь оруулахгүй бол нөгөө төсөв таргалдаг, он дамнадаг, ингээд хариуцлага нь алдагддаг ч гэдэг юм уу ийм үр дагаврууд гардаг зүйлүүд байгаа. Тийм учраас тантай бол бүрэн санал нэгдэж байна. Энэ бол зүгээр төрийн, төсвийн хөрөнгө оруулалтаар ч биш

ялгаагүй хувийн хэвшил дээр ч тулгардаг зовлон болчихсон байна лээ. Энийг бол зүгээр зарчмын хувьд тантай ижилхэн байр суурьтай байна. Тэгэхдээ энэ хуулийн хүрээнд бол шийдэх боломжгүй байгаа юм гэдэг зүйлийг хэлье.

Ер нь нийтээрээ Монголчууд нэг жилд 16 өдрийг нийтээр амарч байх шиг байна. Баяр ёслол гээд. Ер нь би бас Цагаан сар, Наадмаараа жоохон нэг уужуу тайван амраад явчихвал энэ зам тээврийн ослоос ч буурна, эргээд энэ бусад амралтуудаа харин цөөлчихмөөр юм шиг байгаа юм. Тэгээд ядаж наадам цагаан сар гэдэг бол ураг төрлөөрөө нэг уулзаад, ах дүүгээрээ мэнд усаа мэдэлцээд ер нь зүгээр хэний хүүхэд хаана яваа гэдэг юм уу энэ байдлаараа бас ах, дүү нар ч гэсэн уулзах бололцоотой баяр юм болов уу л гэж боддог. Заримдаа бас аав хүний хувьд ч гэсэн санаа зовдог байхгүй юу яг сайн ах, дүүгээ бас үр хүүхдээ танилцуулж явахгүй байж байтал бас хоорондоо танилцаад суух хэмжээнд хүртэл хүрчих вий гэдэг болгоомжлол хүртэл манай үндэсний аюулгүй байдлын хүрээнд хүртэл яригдаж байгаа шүү дээ.

Тэгэхээр энэ Наадам, Цагаан сараараа бас нэг уужуу тайвуухан амаря гэдэг амардаг байгаад бусад харин амралтын өдрүүдээ харин цөөрүүлчих нь зүйтэй л бодож байгаа. Жилдээ 16 өдөр амарч байгаагаа бас наадам Цагаан сардаа хуваагаад зохицуулалтыг хийхэд бол зарчмын хувьд дэмжиж байгаа. Тэгэхдээ энэ удаад энэ асуудал хөндөгдөж орж ирээгүй гэдэг зүйлийг би бас танд хэлье. Ер нь зүгээр зарчмын хувьд бас санал нэг байдаг.

Төр түшилцэж яваа хүмүүс нэр дээрээ морь уралдуулж энэ асуудлыг бас энэ хуулиар одоогоор бол оруулж ирж бололцоогүй байна. Энэ ашиг сонирхлын хууль дээр ч юм уу байх нь нэг талдаа зөв ч юм болов уу. Ер нь зүгээр бас бас ард түмний наадам биш, дарга нарын наадам болчих гээд байгаа гэдэг ийм шүүмжүүд бас ард иргэдийн дунд явдаг. Энийг бол бас ойлгож хүлээж авч байна.

Тэгэхдээ бас Монгол сайхан уламжлалаараа бас ямар албан тушаал хашиж байгаагаас үл хамаараад уг нь оролцдог, цэнгэдэг, бас л энэнийхээ нэг хэсэг байх нь бас цэнгэлийн жаргал юм болов уу л гэж хувьдаа бодож явдаг. Тэгээд энэ асуудал бас ойлгож байна. Намууддаа бас тантай адилхан уриалж байна. Энэ намуудын гэр ч гэдэг юм уу энэ зочин хүлээж авдаг энэ зүйлүүд бас заримдаа ингээд хавтгайрчихсан, бараг сонгуулийн сурталчилгааны дайтай л юм болоод явж байдаг. Энэнтэй бол санал нэг байна. Энийг зүгээр уриалгын чанартай гэж би зүгээр ойлгож байна. Монгол туургатны наадам.../минут дуусав./

С.Бямбацогт: Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурлын Гадаад бодлого, аюулгүй байдлын байдлын байнгын хорооны дарга Ганзоригийн Тэмүүлэнгийн урилгаар АНУ-ын иргэд Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Манай Тэмүүлэн гишүүн найз нартайгаа хүрэлцэн ирсэн байна. Тэмүүлэн гишүүндээ болон найз нарт нь Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс ажлын өндөр амжилтыг, амьдралын сайн сайхныг хүсэн ерөөе.

Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн асуултаа асууя.

Х.Баасанжаргал: Сая хэлсэн санал дээр нэмээд миний яг асуулт яг урган гарч байгаа. Энэ ер нь цолны асуудлыг, одоо цолыг яг тухайн бөхчүүдэд өөрсдөд

нь олгож байна. Тэрнээс ивээн тэтгэсэн компанид нь бөхийн цол олгодоггүй. Гэтэл хурдан морь уралдахаар уяачид нь гэхээс илүү морины эздэд энэ уяачдын цол очоод байдаг. Энэ ер нь хэр оновчтой зөв юм бэ? Та бас хэд хэдэн удаа энэ баяр наадмын комиссыг ахалж ажиллаж байсан хүний хувьд энэ талын асуудал ер нь судлагдаж байсан, хөндөгдөж байсан зүйл байдаг уу? Түүхэн баримт бичиг, янз бүрийн түүхэн эх сурвалжуудаас үзэхээр ер нь сүүлийн үед ялангуяа 90-ээд оноос хойш л яг энэ морины эздэд энэ цол олгодог явдал бол нэлээн хавтгайрсан ийм зүйл бол түүхийн баримт бичгүүдээс бол харагддаг. Энэ тал дээр та бас нэг байр сууриа илэрхийлээч гэдэг нэг ийм асуулт байна.

2 дугаарт энэ баяр, наадмын комиссын зохион байгуулалт дотор энэ хүүхэд хамгааллын хүмүүс ямар бүтэц, бүрэлдэхүүнтэй ордог юм, хүүхэдтэй холбоотой, хүүхдийн аюулгүй байдлыг хангаагүйтэй холбоотой асуудал гарвал хариуцлага хүлээж байсан төрийн албан тушаалтан ер нь байна уу гэсэн ийм 2 асуулт байна.

С.Бямбацогт: Сайнзориг гишүүн хариулъя.

П.Сайнзориг: Хэлэлцэж байгаа хуулийн төслийн агуулгатай бол шууд өнөөдрийн түвшинд бол уялдахгүй л байна. Тэгэхдээ яах вэ би бас бололцооны хэмжээнд танд хариулъя. Энэ морины гэдэг юм уу, бөх ч байдаг юм уу нэг их цол бол би хавтгайрсан гэж бас яг хувьдаа нэг их боддоггүй. Бөхийн хувьд бол өнөөдөр “Дархан аварга” цолтой ид барилдаж байгаа бөх гэвэл ганцхан л байгаа. “Даян аварга” цолтой бөх алга байна. Улсын аваргуудаас гэхэд Санжаадамба аварга маань барилдахаа больчихсон байна. Мөнхбат аварга, Эрхэмбаяр аварга үндсэндээ зарим л томоохон барилдаанууд барилдаж байна. Ер нь заал, танхимын барилдаанд гарч ирж байгаа нь Бүрэнтөгс, Хангай хоёр л байх шиг байна. Яг үнэндээ хэлэхэд энэ үндэсний бөхийн оргил цолд хүрээд байгаа бас залуучууд нэг их тийм олшроод байгаа зүйл бол харагдахгүй л байдаг.

Морины хувьд бол бас зарим шүүмжлэлүүд бол байсан. Зүгээр Баяр, наадмын хуулийг хийж байхад энэ нөгөө уяачдын хоорондоо нөгөө давхар нэр бичүүлж уралдах, хамтарсан гэдгээр ч юм уу дээрээс нь түрүүлж ирсэн тэр асуудал дээр хамт бас дараа нь нэрээ тоочуулаад цолны болзлыг хангах ч гэдэг юм уу ийм зүгээр шүүмжлэлүүд бол бас уяачдын дунд гарч байсан. Энийг нуугаад яах вэ тэгээд энийгээ бол аль аль наадмуудыг яаж тооцох вэ? Бүртгэлээсээ эхлээд зөв болох ёстой гэдэг л байдлаар ингээд зохион байгуулалтын арга хэмжээ талаасаа анхаарч байгаа юм.

Ер нь бол Монгол төрийн наадам гэдэг бол өргөн дэлгэр болдог л бол хүн болгон л оролцоосой. Би болдог бол ингээд хүн болгон эрчүүд нь барилдаж, онч мэргэн харваачид нь бүгд харваж, болдог бол бүгд л ингээд морь, мал уяж ахуйтайгаа ойрхон тэгээд хот суурин газар амьдардаг ч гэсэн одоо зуны дэлгэр цагт бол бас нэг сайхан Монгол ахуйгаа бэлгэдээд, бэлгэшээгээд оролцоод, дээл хувцас, гоёлоо өмсөөд ингээд наадам юундаа оролцоод явна гэдэг л бол бид нарын цаашдын л ондоошил өв соёл бахархаж явах зүйл л гэж би бодож байгаа. Тэгээд гэр бүлийн ч гэсэн гоё үнэтэй цаг л байдаг.

Энэ хүрээндээ мэдээж зохион байгуулалтын асуудал дээр зарим зүйлүүд бол эрсдэлтэй байдаг. Тэгэхээр Баяр наадмын хуулийг 22 онд шинэчлэн батлахдаа жишээ нь бага насны хүүхдүүдийг үндэсний бөхийн барилдаанд

барилдаанд барилдуулж болохгүй шүү, өсвөр насны хүүхдүүдийг дор хаяж 16 хүрсэн байх ёстой шүү гэдэг зүйлийг тавьж өгч байсан. 14, 15-тай хүүхдүүд гараад бэртэж гэмтэж байсан тохиолдлууд бол гарч байсан юм байна лээ барилдаан дээр бас жин харгалзахгүй барилддаг учраас, нас харгалзахгүй барилддаг учраас бас ийм зүйлүүд болж байсан. Тэгээд энийг бол хязгаарлаж өгсөн. Морь унах хүүхдүүдийн насны хязгаарыг бат өмнөх хуульд бас бодвол өсгөж өгсөн. Даатгалд хамрагдах аюулгүй байдлын хангах, гарааны зурхай дээр нэгдсэн байдлаар бас техник хэрэгсэлийн тусламжтайгаар морийг гараанаас гаргах гэдэг ч юм уу ийм зүгээр аюулгүй байдлын талаас нь бүх зүйлүүдийг бол бас хангаж өгөхийг л хичээж байгаа.

Нэг талдаа бид нарын бас өв соёл боловч нөгөө.../минут дуусав./

С.Бямбацогт: Шижир гишүүн асуултаа асууя.

Ө.Шижир: Оройн мэнд. 1921 оноос хойш тасралтгүй зохион байгуулагдаж байсан Монгол төрийн наадам 100 жилийнхээ ой дээр “No naadam” гэдэг эсэргүүцлээс үүдэн тасалдсан л даа. Тэгээд хойтон жил нь 100, 101 жил хамт байсан. Тэнд 2 ой 1 жил давхацсан ч гэж юу байх вэ. Нэг талаасаа нэг хүүхдийнхээ төрсөн өдрийг нөхөж хийж өгч байгаа юм шиг ийм юм хийгээд өнгөрсөн. Ер нь бол төрийн наадам тасалдана гэдэг бол эмгэнэл. 1921 оноос дэлхийн 2 дугаар дайны үед ч тэр тасралтгүй үйл ажиллагаа манайх төрийн наадмаа хийж л байлаа. Цолоо олгодоороо бөхчүүд нь барилдаад, харваачид нь харваад, морь нь морио уралдуулаад цэнгэн нааддаг байсан. Энэ уламжлал ингээд тасалдсан.

Ер нь бол Үндэсний их баяр наадам гэдэг бол бидний бусад үндэстнээс ялгарах ондоошил нь юм байгаа юм. Өв соёл л юм байгаа юм. Үүх түүх, бас бахархал юм байгаа юм. Тэгэхээр ингээд өв соёл, үүх түүх бахархлаа бид нар нэг мөчир тасдаж авч байгаа юм шиг одоо бөхийн асуудлыг нэг ярья, дараа нь сурыг нь ярья8 тэгээд морийг нь ярья гэдэг байдлаар хандаж болохгүй. 2, 3 юм хуулийн төсөл орж ирж байгаа юм. Ер нь нэгтгээд бас Их Хурлын даргын захирамжаар бас Их Хурлын даргын захирамжаар ч юм уу нэгтгээд Үндэсний их баяр наадмын хуулийг хармаар байгаа бол шинэчилсэн найруулга байдлаар хармаар байгаа юм. Нэмэлт, өөрчлөлт хэлбэрээр биш.

Тэгэхгүй бол эхлээд хөлийг нь яриад, дараа нь гарыг нь ярья гэдэг шиг л нэг ийм болчиход байна л даа. Тэгээд төрийн наадамд явж байгаа морь, бөх, сур, шагай гээд ингээд эрийн 3 наадам нь 3 өөр үнэлэмжтэй яг үнэнийг хэлэхэд. 3 өөрөөр цол олгодог. Төрийн наадамд шагнал нь бол ялгаа, спонсоруудын ялгаа хүртэл өөр, оролцогчдын ялгаа хүртэл өөр, санхүүгийн ялгаанууд нь өөр.

Тэгэхээр нэгэнт Монгол төрийн наадам бол төрийн наадмын морь, бөх, сур харваа, шагай бүгдийг нь ижил үнэлэмжтэй болгоё. Төр өөрөө ижил хандъя. Цол олгохдоо хүртэл ижилхэн хандъя. Жишээ нь бөхчүүд бол зөвхөн улсын наадмаар барилдаж цол авч байгаа шүү дээ. Морь бол Засгийн газрын тогтоолтой бүсийн уралдаанаар нэмж цол авдаг. Ингээд ялгавартай байдлыг ингээд төр нь өөрөө бий болгож өгөөд байгаа юм. Тэгэхээр бид нар ижил тэгш хандах хандах ёстой гэж байгаа юм.

Тэгээд улсын наадам сайхан болоод өнгөрнө араас нь бөөн хэрүүл, допингтой допинггүй гээд л. Энэ өөрөө үндэсний баяр наадмыг үзэж сонирхох, хурдан морь бөхөөр хичээллэх хүүхэд, залууст сонирхлыг бол бага багаар бууруулаад байгаа юм. Тэгэхээр энэ допингийн асуудал бараг явцын шинжилгээ авдаг бол. Нэг.

Морь болно. 0.1мм-ээр хасагдлаа миний морь, тэр даргын морь 1см өндөр байж мордчихлоо гэдэг ийм гомдолд наадмын дараа битүү. Энийг та бид нар бүгдээрээ мэдэж байгаа. Бүгдээрээ л уяачдын гэрээр ороод л гардаг, юм яриад л суудаг. Хэний морь хэмжээнд орох, хэний морь хэмжээнд орохгүй уяачид нь өөрсдөө бүгд мэддэг. Тэнд нь дандаа будилаан ордог, дандаа зохион байгуулалт ордог. Энэ өөрөө Монгол төрийн наадмыг 1 дүгээрт бас үнэ цэнгүй, нэр хүндгүй болгоод байна.

2 дугаарт, энэ хуулийн төслөөс нэг юмыг ойлгохгүй байх юм. Үндэсний бөхийн цолыг нэхэн, нөхөн олгоно гээд Монгол төр өөрөө төрийн наадмаа зохион байгуулаад, баяр наадмын комисс гараад, гарсан үр дүнгээр нь Ерөнхийлөгчийн зарлиг гараад, тухайн хүнийг шагнаж урамшуулаад улсын цолыг нь олгодог.

Нэг үгээр хэлбэл Монголын төр, Монголын Засгийн газар өөрсдөө зохион байгуулаад баяр наадмын үндэсний зохион байгуулалтад оролцдог гэсэн үг. Тэгтэл Монголын залуучуудын холбоо бол төрийн бус байгууллага. Төрийн бус байгууллагын зохион байгуулсан наадмыг төрийн наадамтай адилтган үзээд цол олгоно гэдэг чинь ямар үйл явдал вэ? Монголд 32 мянган төрийн бус байгууллага байгаа. Монголын залуучууд бол нэг л төрийн бус байгууллагын нэг нь. Засгийн газрын тогтоолтой, шийдвэртэй 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэхгүй гээд ингээд шийдвэр нь гарчхаад байхад төрийн бус байгууллагын хийсэн наадмыг төрийн наадамтай адилхан үзэж болж байгаа юм уу? Ийм үнэлэмж байдаг юм уу? Ийм хэмжилт бас байдаг юм уу?

Тэгвэл Үндэсний бөхийн холбоо өөрсдөө дахиад тусдаа наадмыг барилдуулж болох юм уу? 100 жилийн ойгоор чинь морь давхиагүй шүү дээ, сур харваагүй шүү дээ. Ганцхан бөх барилдсан гэдэг Залуучуудын холбооны. Тэгээд яагаад.../минут дуусав./

С.Бямбацогт: Шижир гишүүний асуултад хариулъя. Допингийн асуудал дээр бол тантай бас санал нэг байна. Үндэсний бөх дээр допинг авна, авахгүй гэдэг зүйл ер нь бол бид хэд энэ яриагаа болих хэрэгтэй. Авахаас өөр арга байхгүй. Нөгөө их спортоор хичээллэж байгаа залуучууд чинь үндэсний бөхөөрөө хичээллэхээ болино гэсэн үг. Сая би бас спортын сайдтай санал солилцоод сууж байхад олон улсын бас WADA-гийн холбооны удирдлагуудтэй уулзсан юм байна. Сүмо шиг үндэсний бөхийг допинггүй болгох асуудлыг хөндөж тавихад Монгол Улс цаашдаа тэгвэл олон улсын бусад тэмцээн, уралдаан дээр цагаан дуган дээр орно шүү, хориглолтод орно шүү гэдэг зүйлийг анхааруулсан байна лээ. Бүх уламжлалт улс орнуудын үндэсний бөх, спортууд бүгд допингийн шинжилгээнд орж байгаа шүү гэдэг зүйлийг манай сайдад бас хэлсэн байна лээ. Сүмо л ганцаараа үлдчихсэн. Үүнтэй барьцах хэрэггүй гэдэг зүйлүүдийг өгсөн байна.

Дээрээс нь би төрийн бус байгууллага байсан уу, байгаагүй юу тэр үеийн нөхцөл байдлыг та ч мэдэж байгаа. Та бас төрд ажиллаж л байсан. КОВИД-ын

үеийн жил наадам зохион байгуулалт, бэлтгэл хийгээд явж байсан. Ингээд “No naadam” энэ тэр гээд хөдөлгөөн, жагсаал цуглаан гээд л. Ер нь бол КОВИД-ын дараах нийгмээрээ л сэтгэл зүйн асуудал тийм тогтворгүй л байсан шүү дээ. Тэгээд энэ зүйлүүд дээрээ л бас Засгийн газрын шийдвэр гарсан. Би Засгийн газрын шийдвэрийг ойлгож байна, хүндэтгэж байна. Тэр цаг үе дээр би Засгийн газар ч байсан. Засгийн газрын түвшний яаманд нь ажиллаж байсан учраас ойлгож байна.

Гэхдээ Шижир гишүүн ээ энэ төрийн бас хууль бас гарчихсан байхгүй юу даа. 22 оны Үндэсний их баяр наадмын тухай хуулийн дагаж мөрдөх журмын тухай хуулийн 1 дүгээр зүйлээр энэ асуудлуудыгаа шийдвэрлээч гэдэг зүйлийг л хуульчлаад өгчихсөн. Засгийн газрын тогтоол, хууль хоёрын эрэмбэ гэдэг юм уу аль нь хүчинтэй дээд эрэмбийгээ хуулиа л бид нар ярина шүү дээ.

Тэгэхээр нэгэнт энэ асуудлыг хуулийн хүрээнд шийдвэрлэ гэдэг зүйлийг бас тухайн үеийн парламент Үндэсний их баяр наадмын хуулийг дагаж мөрдөх шинэчилсэн найруулгыг батлахдаа дагаж мөрдөх журмын зохицуулалтаар хийчихсэн юм. Бөхийн холбооноос нь энэ асуудлыг хэрэгжүүлээч ээ гэдэг зүйлийг бөхчүүд нь тавьдаг юм байна. Би таны нэг тэр тодруулахдаа бас ойлгож байна. Пунцагийн Сүхбат гарди агсан нь байгаа. Тэгэхдээ энэ хүн бол бас яг амьд ахуй сэрүүндээ тэр өргөдөл нь цагаан дээр ингээд байдаг чинь одоо хүртэл шийдэгдээгүй ийм хариутай л байж байдаг ийм л зүйл. Яах вэ энэ хүрээндээ л энэ асуудлыг онцгойлон бас шийдчихье л гэдэг ийм зүйл байсан шүү. Тэгээд би бас яах вэ таны хэлж байгаа зүйлүүдийг ойлгож байна. Засгийн газар шийдсэн. Засгийн газрын дараа хууль тогтоох бид хэд чинь парламентын засаглалтай шүү дээ. Хуулиараа энэ асуудлыг Монгол бөхийн холбооны саналыг үндэслэн эрх бүхий этгээд шийдвэрлэнэ гэхсэн. Эрх бүхий этгээд нь хэн бай гэдэг вэ? Тодорхой бус байгаад байгаа учраас энэ дагаж мөрдөх журмын тухай хууль хэрэгжихгүй өнөөдрийг хүрээд бид хэд бас нэг.../минут дуусав./

С.Бямбацогт: Шижир гишүүн тодруулъя.

Ө.Шижир: Сайнзориг гишүүн 100, 101 жилийг хамт хийсэн юмтай хольж яриад байна. Санаатай яриад байгаа юм уу, эсвэл төөрүүлж яриад байгаа юм уу? Мэдэхгүй байна. Нэг.

2 дугаарт ер нь бол энэ Монгол төрийн өв уламжлал, түүх, өв соёл эртнээс уламжилж ирсэн бидний энэ үнэт зүйл. Энийг бага хөнд өө. Энийг битгий оролд. Ердөө оролцмоор байгаа бол бүтнээр нь хар. Баяр наадмын хуулиа бүтнээр нь шинэчилсэн найруулга хэлбэрээр ярья. Хэлээд байна шүү дээ бөхийг нь тусад нь ялгаж хаячхаад морь, сур хоёрыг нь яаа гээд байгаа юм, шагайг нь яаяа гээд байгаа юм? Төр яагаад өөрөө ингэж ялгаатай хандаад байгаа юм? Тэр төрийн бус байгууллагын хийсэн наадмаар төрийн цол олгож болдог юм бол төрийн бус байгууллага наадмаа хийе л дээ, зохион байгуулъя л даа. Тусад нь морь уралдуулъя л даа. Нэг төрийн бус байгууллага нь.

Тэгээд тэр жил чинь Монгол наадам чинь энэ хуулиар чинь байгаа шүү дээ. Морь, бөх, сур, шагай гэж байгаа шүү дээ энэ хууль дээр чинь. Тэгээд ганцхан үндэсний бөхийг нь сугалж авчраад ингээд яриад байж болохгүй ээ. Энэ ялгавартай хандаж бас болохгүй.

С.Бямбацогт: Сайнзориг гишүүн хариулъя.

П.Сайнзориг: Ойлгож байна гишүүн ээ. Танд ч бас бүрэн эрх нь байгаа хууль санаачлах. Би бас өөрийнхөө бүрэн эрхийн хүрээнд би бас судалсан зүйлийнхээ хүрээнд л энэ хуулийн төслийг боловсруулж өргөн барьж хэлэлцүүлж байгаа юм аа. Иж бүрнээр нь ер нь цаашдаа бас ялгаварлалгүй хандах гэдэг дээр зарчмын хувьд тантай санал нэг байна. Бай, шагнал нь ч гэсэн ижил түвшинд очмоор байгаа гэдэгтэй санал нэг байна. Энийг би бас, би бол бөхийн салбар, хороог удирдаж байсан. Бөхийн салбар хорооны дарга байхдаа ч гэсэн бай, шагнал нь бүүр инээдтэй юм байсан юм шүү дээ. Бид нар бас төрт ёсоо бодсон ч тэр, төрийн наадмын үнэлэмжийг бодсон ч тэр гээд бас л энэ асуудлыг бас асуудал болгоод тухайн үед шийдэж байлаа. Тэрнээс биш энэ залуучууд яг төрийн наадмын бай, шагнал гээд сүртэй өндөр бай, шагнал авдаггүй юм авдаггүй байсан.

Одоо 20 сая төгрөг л авч байгаа. Татвараа хасагдаад л явдаг ийм л зүйл байгаа. Би андуурчихсан байж магадгүй шүү. Ийм л зүйл байдаг. Тэгээд би энэ дээр бол тантай санал нэг байна. Ер нь цаашдаа Үндэсний спортын тухай хуулийг.../минут дуусав./

С.Бямбацогт: Дахиад тодруулъя.

Ө.Шижир: Яагаад энийг яриад байна вэ гэхээр таны гарын үсэгтэй үзэл баримтлал дээр чинь Үндэсний их баяр наадмын хүрээнд үндэсний бөхийн барилдаан, сурын харваа, үндэсний хурдан морины уралдаан, шагайн харваа зохион байгуулна гэж байгаа юм. Тэгээд үндэсний их баяр наадмаас нь ганцхан үндэсний бөхийг нь битгий салгаж аваад мөчлөөд байгаач гэж байгаа шүү дээ.

Тэгээд та миний нэг асуултыг ерөөсөө бас ойлгохгүй байна. Төрийн, төр өөрөө баяр наадмын комисс гаргаад Засгийн газар нь, төр нь өөрөө зохион байгуулаад гаргасан амжилттай нь төр нь дүгнээд, үнэлээд, шагнаад Ерөнхийлөгч нь зарлиг гаргаад ингээд олгодог энэ цолуудыг төрийн бус байгууллагын хийсэн арга хэмжээгээр үнэлэх юм уу?

Жишээ нь би нэг юм асууя танаас. Төрийн бус байгууллагын хийсэн тэмцээн уралдааны шагнал, үр дүнг нь хараад Ерөнхийлөгч зарлиг гаргаад байх юм уу? Логикийг нь та бод доо. Төрийн бус байгууллагын хийсэн баяр наадам дээр Монгол Улсын Ерөнхийлөгч төрийн цол олгох гээд зарлиг гаргаад байж байх уу? Би ер нь Ерөнхийлөгчийн Тамгын дарга ажиллаж байсан учраас энэ харилцааг аягүй сайн мэдээд байна л даа. Та логикийг нь бод доо жишээ нь.

С.Бямбацогт: Хариулъя Сайнзориг гишүүн.

П.Сайнзориг: Хариулъя. Энэ дагаж мөрдөх журмын хуулийг би ямар нэгэн мушгих, гуйвуулахгүйгээр хэрэгжих боломжтой болгож өгье л гэж байгаа юм. Энэ хуулийн хэлэлцэх протоколыг та үзэж болно. Улсын Их Хурлын Тамгын газар архивд нь байж байгаа. Яг л энэ асуудлыг ярьсан. Би тодоос тод санаж байна.

Энэ 21 оны наадам дараа жил нь 22 онд л Улсын Их Хурал дээр яригдаж тооцох уу үгүй юү гэдгийг шийдсэн байхгүй юу. Тооцно гэдгийг шийдээд дагаж мөрдөх журмыг бол баталж өгсөн юм.

2 дугаарт Шижир гишүүн ээ зөвхөн улсын наадмын энэ асуудал дээр зүгээр асуудал нь үүссэн боловч аймаг, сумын наадмын бөхийн барилдааны цолууд нь аль хэзээний бөхийн холбоо хүлээн зөвшөөрөөд аймгийн Засаг дарга нар захирамжаа гаргаад өгчихсөн. Тэгээд тэр жилийн цолыг ашиглаад дараагийн цолдоо хүрчихсэн ч залуучууд байна. Тэгээд энэ зүйлүүд яах вэ гэдэг байгаа.

Дээрээс нь сур, бөхийнхөн бас тодорхой хэмжээнд шийдэгдчихсэн. Сур дээр бол Үндэсний баяр наадам дээр бол бас тооцогдоогүй байгаа гээд зүйл байгаа. Энэ зүйлүүд чинь явчихсан юм шүү. Та бас ч өөрөө мэдээлэл.../минут дуусав./

С.Бямбацогт: Хуулийн төсөлтэй холбогдуулж гишүүд асуулт асууж дууслаа.

Хуулийн төслүүдийн талаар Байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг дэмжсэн, эсрэг байр суурьтай гишүүд урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу үг хэлнэ.

Отгоны Саранчулуун гишүүн алга байна. Эрдэнэбилэгийн Одбаяр гишүүн алга байна. Гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа.

Санал хураалтыг явуулах боломжгүй байна. Тийм учраас санал хураалтыг маргааш өглөө “Баасан” гаргийн 10 цаг болгож хойшлууллаа.

17.41 цаг.

Явуулах юм уу? Дараагийн асуудалдаа оръё.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Очирбатын Амгаланбаатар танилцуулна.

Монгол Ардын намын бүлгийн дарга Жигжидийн Батжаргал гишүүний микрофон өгье.

Ж.Батжаргал: Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон дагаж өргөн мэдүүлсэн хуулиуд дээр Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлэг ажлын 5 хоногийн завсарлага хүсэж байна.

Уг хуулийн төслүүдийг дахин нягтлан үзэж, бас энэ хуулиуд батлагдсанаар ямар үр дүн, ямар үр дагавар дагуулах вэ гэдэг асуудлыг дахин нягтлах, байр сууриа нэгтгэх ийм шаардлага байгаа учраас завсарлага хүсэж байна.

С.Бямбацогт: Монгол Ардын намын бүлэгт 5 хоногийн завсарлага өглөө.

Өнөөдрийн дуусаж байгаа. Өнөөдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлаа амжилттай хэлэлцэж дууслаа.

Чуулганы хуралдаандаа идэвхтэй оролцсон гишүүд, ажлын хэсэг, Тамгын газрынхандаа баярлалаа. Чуулганы хуралдаан хаасныг мэдэгдье.

17.43 цаг.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ*

Д.ОТГОНДЭЛГЭР